



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүл

Цуврал 3 (94)

Улаанбаатар хот
2023 он

Сэтгүүлд нийтэлсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Эх бэлтгэгч, дизайнер: Б.Заяа

Хэвлэсэн газар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хэвлэх үйлдвэр

Улсын бүртгэлийн дугаар: 279
ISSN:2226-9185
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс
эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Бага тойруу /15160/,
Хуульчдын гудамж 1,
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр
Утас: +(976)-11-315735
Факс: 315735
Вэб хуудас: www.nli.gov.mn
Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

- Ерөнхий эрхлэгч: **Х.Эрдэм-Ундрах** Хууль зүйн ухааны доктор (*Dr.jur.*),
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
- Эрхлэгч: **М.Түвшинжаргал** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*),
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга
- Гишүүд:
- С.Нарангэрэл** Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (*Sc.D.*),
МУИС-ийн эмерит профессор
- Ц.Сарантуяа** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (*Sc.D.*), профессор
- Г. Банзрагч** Хууль зүйн ухааны доктор, УДШ-ийн шүүгч
- Н.Баярмаа** Хууль зүйн ухааны доктор, УДШ-ийн шүүгч
- Э.Батбаяр** Хууль зүйн ухааны доктор, профессор, ДХИС-ийн
ШШГАС-ийн Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны
тэнхимийн эрхлэгч
- С.Болормаа** МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвийн
эрхлэгч, хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор
- Б.Буянхишиг** Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн
Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш
- Ц.Давхарбаяр** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор,
Шүүхийн сахилгын хорооны гишүүн
- Д.Зүмбэрэлхам** Хууль зүйн ухааны доктор, профессор,
ШЕЗ-ийн гишүүн
- Г.Нарантуяа** Хууль зүйн ухааны доктор, ХЭҮК-ын гишүүн
- Д.Сүнжид** Хууль зүйн ухааны доктор (*Dr.jur.*), дэд профессор
ХЭҮК-ын гишүүн.
- С.Сүхбаатар** Хууль зүйн ухааны доктор
- Б.Улаанбаатар** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор,
МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- М.Уянга** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор МУИС-ийн
ХЗС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
- Ц.Цогт** Хууль зүйн ухааны доктор (*LL.D.*), УДШ-ийн шүүгч
- Д.Эрдэнэчимэг** Хууль зүйн ухааны доктор, дэд профессор,
ШССМХ-ийн захирал
- Ж.Эрхэсулан** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), дэд профессор,
МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- Д.Янжинхорлоо** Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор
- Анна Тумурова** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), ОХУ-ын Буриадын
Улсын их сургуулийн Төр, эрх зүйн онол, түүхийн тэнхимийн профессор
- Накамура Масаки** Хууль зүйн ухааны доктор (*Ph.D.*), Япон Улсын
Нагоягийн их сургуулийн Эдийн засгийн сургуулийн дэд профессор

Ким Габ Сок Хууль зүйн ухааны доктор, Жүнбү Их сургуулийн Цагдаагийн сургуулийн профессор

Пак Жеон Вон Хууль зүйн ухааны доктор (Ph.D.), БНСУ-ын Кукмины их сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор

Сарпеков Р.К. БНКаЗУ-ын Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн хүрээлэнгийн захирал, БНКаЗУ-ын Гавьяат ажилтан

Том Гинсбург Хууль зүйн ухааны доктор (Ph.D.), АНУ-ын Чикагогийн их сургуулийн профессор

Хариуцлагатай нарийн
бичгийн дарга:

Э.Сэлэнгэ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан

Тус дугаарын өгүүллийг хянасан:

С.Нарангэрэл (Sc.D.)

Х.Эрдэм-Ундрах (Dr.jur)

Д.Сүнжид (Dr.jur)

Д.Зүмбэрэлхам (Ph.D)

Э.Батбаяр (Ph.D)

Ц.Давхарбаяр (Ph.D)

С.Сүхбаатар (LL.D)

Б.Буянхишиг (Ph.D)

EDITORIAL BOARD

EDITOR-IN-CHIEF

ERDEM-UNDRAKH Khurelbaatar *Doctor of Jurisprudence (Dr.jur.), Director,
The National Legal Institute of Mongolia*

MANAGING EDITOR

TUVSHINJARGAL Moyor *Doctor of law (Ph.D.), Academic Secretary,
The National Legal Institute of Mongolia*

MEMBERS

NARANGEREL Sodovsuren *Member of the Academy of Sciences, Science
doctor of law (Sc.D.), Emeritus Professor,
National University of Mongolia*

SARANTUYA Tserenbaltav *Science doctor of law (Sc.D.), Professor, School of
Law, National University of Mongolia*

BANZRAGCH Gochoo *Doctor of Jurisprudence (Dr.jur.), Justice, The
Supreme Court of Mongolia*

BAYARMAA Nyamdoo *Doctor of law (LL.D.), Justice, The Supreme
Court of Mongolia*

BATBAYAR Enkhee *Ph.D., Professor, Department Head, Court order
enforcement college, University of Internal Affairs
of Mongolia*

BOLORMAA Soloon *Ph.D., Associate Professor, Head of Legal Clinic
Center, School of Law, National University of
Mongolia*

BUYANKHISHIG Bat-Erdene *Ph.D., Senior Lecturer, Private Law Department,
School of Law, National University of Mongolia*

DAVKHARBAYAR Tseveensuren *Doctor of Law (Ph.D.), Member, The Judicial
Disciplinary Committee of Mongolia*

ERDENECHIMEG Dashpuntsag *Ph.D., Associate professor, Director, Judicial
Training, Research and Information Institute*

ERKHESKHULAN Jambaajultem *Doctor of law (Ph.D.), Head of the Public Law
Department, School of Law, National University
of Mongolia*

NARANTUYA Ganbat *Ph.D, Commissioner, The National Human Rights
Commission of Mongolia*

SUNJID Dugar *Doctor of Jurisprudence (Dr.jur.), Commissioner,
The National Human Rights Commission of
Mongolia*

SUKHBAATAR Sumiya *Doctor of law (LL.D.)*

TSOGT Tsend *Doctor of law (LL.D.), Justice, The Supreme
Court of Mongolia*

ULAANBAATAR Byambajav *Doctor of law (Ph.D.), Head of the Private Law
Department, School of Law, National University
of Mongolia*

UYANGA Myagmar *Doctor of law (Ph.D.), Academic Secretary,
School of Law, National University of Mongolia*

YANJINKHORLOO Dambadarjaa	<i>Ph.D., Associate professor, Private Law Department, School of Law, National University of Mongolia</i>
ZUMBERELKHAM Dorjdamba	<i>Doctor of law (Ph.D.), Chairman, The Judicial General Council of Mongolia</i>
ANNA TUMUROVA	<i>Doctor of law (Ph.D.), Professor, Buryat State University, Russian Federation</i>
MASAKI NAKAMURA	<i>Doctor of law (Ph.D.), Professor, Nagoya University of Economics, Japan</i>
GIM, GAB-SEOK	<i>Ph.D., Professor, Department of Police, Joongbu University</i>
PARK JEON WONG	<i>Doctor of law (Ph.D.), College of Law and Graduate School of Legal Affairs, Kookmin University, Republic of Korea</i>
RAMAZAN K.SARPEKOV	<i>Doctor of law (Ph.D.), Director, The Institute of Legislation and Legal Information, Republic of Kazakhstan</i>
TOM GINSBURG	<i>Doctor of law (Ph.D.), Professor, The University of Chicago, USA</i>

STAFF:

SELENGE Enkhzorigt	<i>Researcher, The National Legal Institute of Mongolia</i>
---------------------------	---

The papers of the series reviewed by:

NARANGEREL.S (Sc.D.)
ERDEM-UNDRAKH.KH (Dr.jur)
SUNJID.D (Dr.jur)
BATBAYAR.E (Ph.D)
ZUMBERELKHAM.D (Ph.D)
DAVKHARBAYAR.TS (Ph.D)
SUKHBAATAR.S (Ph.D)
BUYANKHISHIG.B (Ph.D)

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute publishes
Mongolian Journal of Law five times
per year.

Address: 4th Khoroo, Chingeltei District,
Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia
Phone:+(976)-11-315735
Fax: 315735
Website: www.nli.gov.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

АГУУЛГА

ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Рах Mongolica буюу Монголын амар амгаланг тодотгон эргэцүүлэхүй 12

Монгол Улсын Их Сургуулийн Эмерит Профессор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх, Академич С.Нарангэрэл

Хууль тогтоомжийн уялдаа холбоог судлах арга зүйг сайжруулах тухайд 21

*Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (PhD), дэд профессор А.Алтанзул
Удирдлагын академийн багш, доктор (PhD), дэд профессор Ж. Нарантуяа*

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

Татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм, журмын зохицуулалт 32

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш О. Чулуунцэцэг
МУИС-ийн Бизнесийн сургуулийн ахлах багш С.Рэнцэндорж*

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явц дахь талуудын хүсэлт, үр дагавар 44

ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, ахмад Б.Замбага

ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ , ҮР ДҮН

Монгол Улсын өрсөлдөөний эрх зүй дэх картелийн тодорхойлолт: Онол, үзэл баримтлал, шүүмж 56

СЭЗИС-ийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Л.Отгонбаяр (LL.M)

Мөнгө угаах гэмт хэрэгт нөлөөлөх хүчин зүйлс 81

*СЭЗИС-ийн багш Г. Дагвасүрэн (MSc & MBA)
СЭЗИС-ийн оюутан Ц.Анужин*

Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи гэж юу вэ? 96

“Ворд Медиа” ХХК-ийн “Өрөг.мн”-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Монголын Криминологичдын холбооны гэрээт судлаач Э.Тамир (LL.B)

Монголын Криминологичдын холбооны ахлах судлаач, МУИС-ийн ШУС-ийн Нийгмийн ухааны салбарын антропологийн хөтөлбөрийн докторант, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант С.Номынбаясгалан (BBA)

Гэм буруугийн асуудлыг гэмт хэргийн субъектив талын ойлголтоос ялгамжтайгаар авч үзэхийн ач холбогдол 121

МУИС-ийн ХЗС-ийн магистрант, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач З.Янжинлхам

Ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг харгалзан ял оногдуулах нь (Польш, Герман, Монгол Улсын жишээн дээр) 130

МУИС-ийн ХЗС-ийн магистрант, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач Э.Баасанбямба

Мөнгө зээлж, хүүнд нь орон сууц хөлслүүлэх агуулга бүхий гэрээний харилцаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам 141

МУИС-ийн ХЗС-ийн магистрант, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач Б.Батбаяр

CONTENT

LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

- Considering Pax Mongolica** 12
Narangerel.S, Member of the Academy of Sciences, Professor Emeritus of the National University of Mongolia, Advisor to the Minister of Justice and Home Affairs of Mongolia
- Methodology for improving the study of legal coherence** 21
Altanzul.A, Associate professor; Head of the Department of Law of the National Academy of Governance (Ph.D)
Narantuya.J, Associate professor; Lecturer of the National Academy of Governance (Ph.D)

IMPLEMENTATION AND EFFICIENCY OF LAW

- Tax anti-avoidance rules and procedures** 32
Chuluuntsetseg.O, Senior Lecturer at School of Law, NUM
Rentsendorj.S, Senior Lecturer at Business School, NUM
- Requests of the parties in the decision execution process and its consequences** 44
Zambaga.B, Lecturer at the Department of Civil Decision Execution of the University of Internal Affairs, Captain

LEGAL RESEARCH OVERVIEW

- Cartel definition in competition law of Mongolia: Theories, concepts and critical analysis** 56
Otgonbayar.Lkh, Senior Lecturer; Department of Legal Studies, The University of Finance and Economics, Mongolia, Ph.D student, School of Law, NUM (LL.M)
- Factors affecting money laundering** 81
Dagvasuren.G, Lecturer at the University of Finance and Economics, Mongolia (MSc & MBA)
Anujin.Ts, Student, The University of Finance and Economics, Mongolia
- What is the anthropology of Media law?** 96
Tamir.E, Cooperation director of "Urug.mn" of "Word Media" LLC (LL.B)
Nomynbayasgalan.S, Ph.D student, School of Arts and Sciences, NUM, Ph.D student, School of Law, NUM, Senior researcher of Mongolian Criminological Society (BBA)
- The importance of distinguishing between blameworthiness and subjective elements of crime** 121
Yanjinkham.Z, Master's student, School of Law, NUM, Legal researcher at Judicial Training, Research, and Information Institute of Mongolia
- Consideration of preventive functions in sentencing** 130
Baasanbyamba.E, Master's student, School of Law, NUM, Legal researcher at Judicial Training, Research, and Information Institute of Mongolia

The facing challenges in Mongolian socio-economic life due to the contract for apartment leasing (right to registered lease on a deposit basis) and solutions **141**

Batbayar.B, Master's student, School of Law, NUM, Legal researcher at Judicial Training, Research, and Information Institute of Mongolia

NOTES

News

151

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийг 21 дэх жилдээ тасралтгүй эрхлэн гаргасаар өдгөө 94 дэх дугаарыг уншигч Та бүхэндээ өргөн барьж байна.

Энэ удаагийн дугаарт нийтлэгдэж буй “Хууль тогтоомжийн уялдаа холбоог судлах арга зүйг сайжруулах тухайд” бүтээлээр хууль зүйн салбарт өргөн хэрэглэгддэг уламжлалт доктринал аргыг доктринал бус эмпирик судалгааны аргаас

ялгаж, тэдгээрийн онцлогийг тодорхой илэрхийлсэн байх тул хууль зүйн салбарт судалгаа шинжилгээ хийж буй залуу эрдэмтэн, судлаачдад уншихыг зөвлөж байна. Түүнчлэн хэвлэл мэдээллийн антропологи, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явц дахь талуудын хүсэлт, үр дагаврын талаар хөндсөн туршлагатай судлаачдын бүтээлүүд мөн багтсан байгааг дуулгахад таатай байна.


Эрхэм уншигч Та бүхэн сэтгүүлийн “Эрх зүйн судалгаа, тойм, үр дүн” булангаас өрсөлдөөний эрх зүй дэх картел, мөнгө угаах гэмт хэрэг болон татвараас зайлсхийхийн эсрэг арга хэмжээ, зохицуулалт зэрэг асуудлыг гагцхүү хууль зүйн талаас бус эдийн засгийн өнцгөөс харж дүгнэсэн сонирхолтой бүтээлүүдтэй таарах болно.

Мөн тус хэсгээс гэм буруугийн асуудлыг гэмт хэргийн субъектив талын ойлголтоос ялгах асуудал болон ялын урьдчилан сэргийлэх зорилгыг харгалзан ял оногдуулах асуудал, түүнчлэн мөнгө зээлсний хариуд орон сууц хөлслүүлэх агуулгатай гэрээний зохицуулалттай холбоотойгоор илэрхийлсэн залуу судлаачдын байр суурьтай танилцах боломжтой.

Энэхүү дугаарт нийтлэгдсэн бүтээлүүд нь уншигч Та бүхний хууль зүйн салбарын онол, практикийн мэдлэгийг зузаатгана гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,

ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР  Х.ЭРДЭМ-УНДРАХ (Dr.jur)

PAХ MONGOLICA БУЮУ МОНГОЛЫН АМАР АМГАЛАНГ ТОДОТГОН ЭРГЭЦҮҮЛЭХҮЙ *



Академич С.Нарангэрэл

*Монгол Улсын Их Сургуулийн Эмерит Профессор,
Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх*

Их эзэн Чингис хаан эрхэмбээрийг шууд залгамжлагчид XIII зуунд дэлхий дахинд хоёр жарны туршид “байлдан дагуулалт хийсэн” эсхүл “амар амгаланг тогтоосон” гэсэн эсрэг тэсрэг хоёр бодрол дүгнэлтийн чухам аль нь лавтай үндэслэгээтэй болохыг харьцуулан шинжлэн судлах зорилгыг эл илтгэлийг бэлтгэх явцад дэвшүүлэн тавьсан юм. Энэ учраас илтгэлийн бүтэц Монголын амар амгаланг тогтоох урьдач нөхцөл, түүний уг сурвалж, эдүгээ үед Монгол Улсад болон дэлхий дахинд ач холбогдол бүхий зарим сургамж гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

Түүхэн сурвалж, хөлгөн судар (Монголын нууц товчоо, Судрын чуулган зэрэг), эрдэмтэн мэргэдийн бүтээл туурвил нь эл итгэлийн үндсэн эх сурвалж болсон бөгөөд илтгэгч дэвшүүлж буй санаагаа судалгааныхаа ажлын явцад нийтийн хүртээл болгосон бүтээлдээ¹ дэлгэрэнгүй хөндсөн болно. Гадаадын монголч эрдэмтэн судлаачдад хандаж хэлэхэд миний дэвшүүлж буй зарим санаа англи² болон орос³ хэлээр хэвлэгдсэн юм.

Монголын амар амгалангийн урьдач нөхцөл

Үнэнийг үнэнээр нь хойч үедээ үлдээгүйгээс болж, үнэн биш худал мэдээлэл үүрд үргэлжилдэг жамтай байдаг ажгуу. Хэрэв Чингис хаан эрхэмбээрийг залгамжлагчид эзлэн түрэмгийлсэн байлдан дагуулалт (аян дайн) хийсэн бол хохирсон, зовж зүдэрсэн, өшөө хорсол нь буцалсан улс түмнүүд заавал өс авч, дахин эргэж өс авалт ээлжлэн үргэлжилсээр дэлхий дахинд хоёр жарны туршид буюу 140 жил амар амгаланг яагаад ч тогтоож чадахгүй, монголчуудын амар заяаг үзүүлэхгүй байсан билээ. Алдарт Марко Пологийн бичсэнчлэн⁴ Чингис хааны засаглал шулуун шударга болохыг үзсэн бусад орны хүн ард түүнтэй өөрсдөө

* Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулагдсан Монголч эрдэмтний 12 дугаар Их хурлын хүндэтгэлийн чуулганд академич С.Нарангэрэлийн тавьсан “Монголын энх тайван ба түүхэн туршлага” сэдэвт үндсэн илтгэл

¹ С.Нарангэрэл Монголчуудын зан суртахууны гарваль. Улаанбаатар, 2010; С.Нарангэрэл Чингис хааны сүр хүч. Улаанбаатар, 2013; С.Нарангэрэл Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир Улаанбаатар, 2014; С.Нарангэрэл Ёс суртахууны монгол цагаан толгой. Улаанбаатар, 2015, 2018; С.Нарангэрэл Хуулийн амин сүнс буюу буюу Чингис хаан, Монголчууд нэмж засварласан гурав дахь хэвлэлт.. Улаанбаатар, 2018; С.Нарангэрэл Бурхан Халдун - Монголчуудын гал голомт. Улаанбаатар, 2019; С.Нарангэрэл Монголчуудын ёс суртахуун: сэргэлт, ялзрал, эргэн сэргээлт. Улаанбаатар, 2020 зэрэг.

² S.Narangerel The Spirit of Laws or Chinggis khan and the Mongols. Ulaanbaatar, 2018.

³ С.Нарангэрэл В поисках духа закона, завещание Чингисхана. РФ., Улан-Удэ., Издательство Бурятского госуниверситета, 2019.

⁴ Рональд Лейтхим Марко Поло аялал..., Англи хэлнээс орчуулсан О.Бүрэнжаргал., Улаанбаатар., 2012, 147 дахь талыг үзнэ үү.

ирж нийлэн нэгдсээр нэг мэдэхэд түүнийг дагалдагсад, дэмжин талархагсад газар дэлхийг хүчин бүрхсэн үй түмэн болжээ. Үүнийг Хамаг Монгол Улсад нэлээд улс орон (Уйгар⁵, Хар Кидан /Хятаг/⁶, Карлук /Харлаг/⁷, Солонгос зэрэг) дагаар орсон явдал нотолно.

Их эзэн Чингис хаан Хэрэйд⁸, Мэргид⁹, Найман¹⁰, Ойрад¹¹ зэрэг өөр хоорондоо эвдрэлцэж, өсөрхөн тэмцэлдэж ирсэн 31¹² монгол овог аймгуудын¹³ эв эсийн хүчирхэг нэгдлийг буй болгон, эсгий туургатны Хамаг Монгол Улсыг¹⁴ өргөн уудам тал хээр нутагт¹⁵ дахин цогцлоож, цөөхөн монголчуудаа¹⁶ амар жимэр, сэтгэл тэнүүн, аз жаргалтай аж төрөх нөхцөлийг бүрдүүлэв. Гэвч түүнд учруулсан ноцтой саад тотгорыг даван туулахгүйгээр Хамаг Монгол Улсын цаашдын ирээдүй нэн бүрхэг болжээ.

Хамаг Монгол Улс дахин сэргэн бадарсанд хонзогносон дотоодын хүчнийхэн тухайлбал, Сэнгүм¹⁷, Тогтога бэхэ¹⁸, Хүчүлүг¹⁹ нар Тангуд, Алтан, Уйгар зэрэг харийн улсад дүрвэн гарсныг тэдгээр улсууд орогнуулан ивээлдээ авч, хүчийг нь зузаатган Хамаг Монголын эсрэг өдөөн турхирав. Дотоодын эдгээр дайсагнагч хүчин болон тэдгээрийг ивээлдээ авагчдын хорон явуулгыг саармагжуулах явдал Чингис хааны өмнө тэргүүн зэргийн зорилт болон тулгарчээ.

Ази, Европоор нүүдэллэн тархсан Кипчакууд²⁰ монголчуудын дотоод ба гадаадын өштнийг өмгөөлөн Чингис хааны дайчидтай амь бие хайргүй дайтсан тул тэднийг элдэн хөөсөөр Карпатын²¹ нуруу давуулахад ар талд нь Азербайжан, Гүрж, Армен, Умард Кавказ, Орос, Европын тэгш тал үлдсэн байжээ. Оросын нэрд гарсан эрдэмтэн В.Н.Гумилев “монголчуудын дайсан мэргидийг половчууд өмгөөлж байсан аж. Онон²² мөрнөөс Днепр²³ хүрэх хийгээд Днепрээс Онон хүрэх тал хээрийн зам нэг²⁴ бөгөөд хил хязгаараа дайсан этгээдэд нээж үлдээх нь учир утгагүй хэрэг байв. Монголчуудад половецтэй дайтсан шалтгаан чухам үүнд орших бөгөөд тэднийг Карпатын чанад руу хөөн гаргах зорилгоор монголчууд Русийн гүн рүү нэвтэрсэн юм”²⁵ гэж бичсэнтэй санал нийлэхгүй байхын аргагүй.

⁵ Эдүгээгийн БНХАУ-ын Шинжаан-Уйгарын Өөртөө Засах орон хавьд төвлөрч байжээ.

⁶ Эдүгээгийн Шинжаан болон түүнээс баруун тийшхи нутаг дэвсгэрийг эзэмшиж байжээ.

⁷ Эдүгээгийн Казахстаны зүүн өмнөд хавь оршин тогтнож байжээ.

⁸ Хэрэйд нь зүүн зүгт Хэнтий нуруу, урд зүгт их элсэн говь, баруун зүгт Хангайн нуруу, хойд зүгт Сэлэнгэ мөрөн хүрсэн нутаг дэвсгэртэй монгол хэлтэн аймаг байсан ажээ.

⁹ Мэргид нь Орхон, Сэлэнгэ мөрний сав нутгаар нүүдэллэсэн монгол хэлтэн аймаг байсан ажээ.

¹⁰ Найман нь Алтай ба Хангайн нурууны хооронд нутаглаж ирсэн, хүн амын тоогоор харьцангуй олон монгол хэлтэн аймаг байсан ажээ. Зарим судлаач найманчуудыг монголжсон түрэгүүд хэмээн үздэг.

¹¹ XII зуунаас өмнө Байгаль нуурын баруун талын ой хөвчид нутаглаж ирсэн монгол овог аймаг.

¹² Сайшаал, Чингис хааны товчоон (дээд дэвтэр). Улаанбаатар., 2010, 322 дахь талыг үзнэ үү.

¹³ Тал нутгийн 23 монгол овог, аймгийн язгууртнууд харьяат албад иргэдийн хамт Чингис хаантай сайн дураараа нийлж нэгджээ. – Үз.: Сайшаал, Чингис хааны товчоон (дээд дэвтэр). Улаанбаатар., 2010, 157 дахь тал.

¹⁴ Хамаг Монгол Улсыг Чингис хаанаас өмнө эрхэмбээрийн өвөг дээдэс – Хабул, Хотула хаад цогцлоож байжээ.

¹⁵ Энэ үед Хамаг Монгол Улсын нутаг дэвсгэр нь зүүн зүгт Хянганы нуруу (эдүгээгийн БНХАУ-ын нутаг дэвсгэрт оршиж буй), баруун зүгт Алтайн цаадах Эрчис мөрөн (эдүгээгийн ОХУ-ын Сибирийн нутгаар урсаж буй Обь мөрний цутгал мөрөн), өмнөд зүгт Хятадын цагаан хэрэм, хойд зүгт умард Сибирь хүрч байв.

¹⁶ Судлаачид Хамаг Монгол Улсын хүн амыг 700-800 мянга хэмээн тооцоолжээ.

¹⁷ Сүүлдээ бусадтай хуйвалдан нэгдэж, Тэмүжинг алахыг нэг бус удаа завдаж байсан Хэрэйдийн Ван ханы хөвүүн Сэнгүмийн толгойлсон Хэрэйдүүдийн зарим хэсэг.

¹⁸ Чингис хаанд эцгийнх нь үеэс өсөрхөн Мэргидийн хан Тогтога бэхийн тэргүүлсэн Мэргидийн үлдэгдэл.

¹⁹ Найман аймгийн Таян ханы хөвүүн Хүчүлүгийн тэргүүлсэн Найманы үлдэгдэл.

²⁰ Кипчакууд түрэг хэлтэн улс үндэстэн. МЭӨ VI зуунд Монголоос Хар тэнгис хүртэлх нутаг дэвсгэрийг хамарсан эзэнт гүрнийг байгуулсан, мал аж ахуй ба гар урлал эрхэлдэг нүүдэлчин ард түмэн. Кипчакууд нь Монгол, Баруун Сибириэс Оросын өмнө зүгийн ба Евразийн тал нутаг, Хар тэнгис, Кавказын уулс, Каспийн тэнгис орчим, Дунай мөрөн хүртэлх өргөн уудам газар нутагт суурьшсан. Орост тэднийг половчууд буюу тал нутгийнхан, Европт куманууд хэмээн нэрлэдэг ажээ.

²¹ ОХУ, Украин улсын нутаг дэвсгэрээр урсаж, Хар тэнгист цутгадаг мөрөн.

²² Монгол Улсын Их Хэнтий нурууны араас эх авч урсадаг гол.

²³ Европ тив дэх уулт тогтолцоо. Чех, Польш, Унгар, Украин, Румын улсын нутаг дэвсгэрт орших 1500 км урт урсадаг.

²⁴ Онон мөрний хөндийгөөс Днепр хүрэх замд дундад Сибирийн таймырын нам доор газар, баруун Сибирийн тэгш тал, дорнод Европын тэгш тал үргэлжилдэг ажээ.

²⁵ Л.Н.Гумилев Эртний Орос ба агуу уудам тал нутаг. Орчуулагч Ч.Алтангэрэл., Улаанбаатар., 2017, 69 дэх тал.

Хөрш улсуудтайгаа амар жимэр аж төрөхийг туйлаас хүсэмжилж байсан боловч Алтан улс олон жилийн туршид монгол овог аймгуудыг өөр хооронд нь дайсагнуулан эвдрэлцүүлж, “бие биенээр нь нухчин дарах” харгис бодлого явуулж, татар овог аймгийг ашиглан Чингис хааны өвөг дээдэс Амбагай хаан²⁶, Охин Бархаг²⁷ нарыг бариулан хэрцгийгээр амь насыг нь бүрэлгүүлсэн, эрхэмбээрийн аав Есүхэй баатар татаруудад хорлогдсон. Алтан улсын цаашдаа үргэлжлэх энэ харгис бодлогыг таслан зогсоогоогүй тохиолдолд цөөхөн монголчууд амар амгалан аж төрөхөд нэн хүнд нөхцөл байдал үүсжээ.

Удаа дараагийн энхийн гэрээнээсээ эргэж буцсан (Тангуд, Алтан болон Өмнөд Сүн, Оросын вант улс²⁸ зэрэг) улмаар Монголын эсрэг цэргийн нэгдэл байгуулсан (Тангуд, Алтан улс) зэрэг нь Хамаг Монгол Улсын гадаад аюулгүй байдалд шууд аюул занал учруулж эхэлжээ.

Хамаг Монгол улсын дотоодын дайсагнагч хүчний зарим нь тухайлбал, харьд дүрвэн гарсан Найманы Таян ханы хүү Хүчлүг Хар Киданы засгийн эрхийг булаан авч, лалын мөргөлтнүүдийг элдвээр харгислаж, тэр ч атугай хамба лам Ала-ал-Динийг сүмийн хаалганд тэлж хадан амь насыг нь бүрэлгэн тэндэхийн ард иргэдийг тэвчихийн аргагүй байдалд оруулсан тул Чингис хаан Зэв жанжинаар удирдуулсан цэргээ илгээж, шударга ёсыг тогтоолгосон учир Хорезм улстай²⁹ Хамаг Монгол Улс хил залгах болжээ.

Өрнө ба Дорныг холбож, хөгжил дэвшилд хүргэх худалдааны (торгоны) их замын³⁰ аюулгүй байдлыг хангасан байтал Хорезмын шахад явуулсан Чингис хааны илгээлт³¹ авч явсан монголын элч, худалдаачдыг³² толгой дараалан хүйс тэмтэрч, эд хөрөнгийг нь тонон дээрэмдсэн аймшигт явуулгад яагаад ч хүлцэнгүй хандах аргагүй болжээ. Энэ учраас Хорезмын зүг Чингис хаан өөрөө оройлон цэргээ хөдөлгөж, тэнд шударга ёсыг тогтоосон билээ. Сөргөлдөн тэмцэлдсэн Хорезмын султаныг нэхэн хөөсөн монгол дайчид бүр Энэтхэг хүрсэн гэдэг. Энэ бүхэн нь шударга ёс ба энхийг тогтоох тодорхой тодорхой “ажиллагаа (операц)” байснаас биш эзлэн түрэмгийлэх байлдан дагуулалт байгаагүй ажээ.

Хамаг Монгол Улс ийнхүү Их Монгол Улс болон өргөжин тэлж, дэлхий дахины цаашдын хөгжилд их хариуцлага хүлээх болжээ. Яагаад дэлхийн талд гэхгүй дэлхий дахинд гэж бичив гэвэл XIII зуунд даян дэлхий зөвхөн Европ, Ази тивээр төсөөлөгдөж байжээ. Африк тивийн баруун эргийг л XV зуунаас португальчууд анх нээжээ. Европтой харьцуулахад дорно, өрнийг холбосон Монголын эрин үе нэгэнт улиран одсон боловч Өрнийнхөн - Европчууд Марко Поло³³-гийн аян замын тэмдэглэлийг бие биеэсээ өрсөн уншицгаажээ. Марко Пологийн аян замын тэмдэглэл³⁴ бүхэлдээ шинэ газар, шинэ нэрс, шинэ бараа таваар, баялаг, шинэ адал явдал, шинэ нээлтүүдэд уриалсан нэг ёсны дуудлага болж байжээ. Марко Пологийн аян замын тэмдэглэлийг баримжаа болгосон Испанийн далайч Х.Колумб XVI зуунд монголын эзэнт гүрэн байсан нутаг орныг зорих аян замдаа төөрч будилан бүр эсрэг зүгт далийхдаа Америк тивийг нээсэн. Австрал тивийг XVII зууны үеэс мэдэх болжээ. Өөрөөр хэлбэл, Монголын эрин үед Африк, Америк, Австрали

²⁶ Чингис хааны 6 дахь үеийн өвөг.

²⁷ Чингис хааны их өвөг.

²⁸ Л.Н.Гумилев Эртний Орос ба агуу уудам тал нутаг. Орчуулагч Ч.Алтангэрэл., Улаанбаатар., 2017, 554 дэх талыг үзнэ үү.

²⁹ Энэ улсад Дундад Азийн ихэнх нутаг дэвсгэр, эдүгээгийн Афганистан, Ираны нутаг дэвсгэр хамаарагдаж байжээ.

³⁰ Торгоны зам (Silk Road) нь МЭӨ 100 оны орчимд Хятадын Сианаас (Sian буюу өмнөд Хятадын Шаньси мужийн төвөөс) эхлэн Их цагаан хэрмийг даган хойд зүг рүү явсаар Памирын уул руу өгсөж, Афганистаныг дайран өнгөрч, Газрын дундын тэнгисийн зүүн эрэг хүрдэг байжээ. Тэндээсээ бараагаа усан онгоцод ачаалж, Ромд зөвөрлөн аваачдаг аваачдаг байжээ. Энэ зам эртний Ром уналтад орсны улмаас их аюултай болж, улмаар хаагджээ.

³¹ Хорезмын шахад явуулсан илгээлтдээ Чингис хаан “Бидний хил хязгаар ойртож, өштөн дайснаас цэвэршээд, бүгд даган захирагдаж, хоёр тал айлсан буйх нь хөдөлбөргүй болсон ажгуу. Хоёр тал эелдэх зам мөрийг гаргаж, таагүй явдал тохиолдоход нэг нэгэндээ тусламжийн гараа сунгаж, их замаар зорчин явахад айх аюулгүй болгон, дэлхийг цэцэглүүлэн хөгжүүлэх гол үүрэг бүхий худалдаачдыг айван тайван ирж очиж байдаг болгохыг оюун ухаан, сайн санаа шаардах боловой. Чингэж хэлэлцэн тохирч чадваас айж зовох шалтгаан үгүй болоод хахууль, зөрчил, зөрөлдөөн дэврэх шалтаг устгах болмуй за” гэж бичсэн байдаг.

³² Зарим судлаач 400 орчим элч төлөөлөгч хэмээн үздэг.

³³ Венецийн Марко Поло Хубилай хааны дэргэд 20 жил алба хаажээ.

³⁴ Үз.: Рональд Лэйтхэм Марко Поло аялал. Англи хэлнээс орчуулсан О.Бүрэнжаргал., Улаанбаатар, 2012.

тив нээгдээгүй байжээ. Ингэхлээр дэлхий дахиныг монголчууд бүхэлд нь элбэн тохинуулж байсан учраас Рах Mongolica буюу Монголын амар амгалан гэсэн нэр томъёо буй болсныг монгол болон иран судлаач Д.Морган³⁵, дорно дахин судлаач Жон Боль³⁶, монгол судлаач Удо Б.Баркманн³⁷, монголын эзэнт гүрний судлаач, японы Сүгияма Масааки³⁸ нарын зэрэг гадаадын цөөнгүй судлаачдын бүтээлээс олж үзэж болно.

Энэ бүхнээс үзэхэд Чингис хаан дотооддоо төдийгүй харийн улс гүрэнд шударга ёс, амар амгаланг тогтоосон бөгөөд энэ нь эрхэмбээрийн “Эдүгээ Мөнх тэнгэрийн хүчинд тэнгэр, газраа хүч аугаа нэмэгдэж, гүр³⁹ улсыг шударгадаж, гагц жолоондоо оруулсан”⁴⁰ гэсэн айлдвараар шууд батлагдана. Судрын чуулганд “Дэлхийг нэгэн зүгт оруулж, нэгэн бус элэгтний элгийг нэгтгэж, олон улс орныг харгис хэрцгий дарангуйлагч, ёсон бус эзэрхэг түрэмгий нарын савраас салгаснаараа Чингис хаан эдгээрийг алдартай үр сад, хүчтэй удам судрынхандаа өвлүүлсэн бүлгээ”⁴¹ хэмээн бичсэн байдаг.

Монголын амар амгалангийн уг сурвалж

Монголын амар амгалангийн оюун санааны уг сурвалж нь ёс суртахуун байжээ. Ёс суртахуун хүмүүний хувьд үүсмэл (итгэл үнэмшил, зарчим) бус харин Байгалиас заяагдмал болохыг агуу Аристотелиос⁴² эхлээд суут сэтгэгчид нээж, орчин үеийн байгалийн шинжлэх ухаан тухайлбал, квантын физик, энергийн таталцлын хууль, эсийн биологи (ДНК), биофотон судлалын ололтоор нотлогдсоор байгаа билээ. Тухайлбал, ёс суртахууны физик (fiscal moral) нь Сансарын доторх хүмүүн ухаж ойлгосон болон сайн дурын үндсэн дээр оюун ухаанаараа ухамсраа дээд түвшинд хөгжүүлэх замаар туйлын өндөр амжилт ба аз жаргалд хүрэх чадвартай гэсэн гаргалгаанд үндэслэдэг юм.

Чингис хааны ер бусын ололт амжилтын уг сурвалж ёс суртахуунд⁴³ нь байсан бөгөөд түүнийгээ эрхэмбээр ямагт эцэг Тэнгэртэй холбож үздэг байжээ. Жишээлбэл, Монголын нууц товчоонд Чингис хаанаас “Эрэмгий сайнаар, Эзэн эс боллоо би. Эрхт Тэнгэр Эцгийн хайраар Эзэн боллоо би. Хамрагч сайнаар Хаан эс боллоо би. Хан Тэнгэр эцгийн Хайраар эзэн боллоо би”⁴⁴ гэж айлдсаныг тэмдэглэсэн байдаг. Хутагт⁴⁵ арш⁴⁶ Чанчунь бомбо Чингис хаан шавьдаа “хаан Та агуу гавьяат үйлсийг бүтээн Тэнгэрээс оноосон цаг хугацааг дүүргэвээс Тэнгэрт эргэж морилон одны суудалдаан залрах болно”⁴⁷ хэмээн айлдсан ажээ. Академич Ш.Бира “Эртний монголчууд тэнгэрийг ихэд тахин шүтэж, аливаа нандин бүхнээ, үүний дотор төр улсаа дээдлэн өргөмжлөхдөө юуны өмнө Тэнгэр бурхантай шууд холбон үзэж, энэ талаар улс төрийн бүхэл бүтэн сургаалыг буй болгосон бөгөөд түүнийг нь бид Тэнгэрийн үзэл буюу Тэнгэрзм хэмээн нэрлэж байгаа юм”⁴⁸ хэмээн бичсэн нь утгаа

³⁵ D.Morgan The Mongols (The Peoples of Europe), Blackwell, 1999.

³⁶ Жон Эндрью Бойль Дэлхийн Монгол гүрэн. Улаанбаатар., 2015, 17 дахь тал.

³⁷ Рах Mongolica-гийн талаарх зарим эргэцүүлэл – Удо Б.Баркманн Монголын түүх, улс төрийн асуудлын тухай өгүүллүүд. Улаанбаатар., 2013, 109 дэх тал.

³⁸ Сүгияма Масааки Монголын эзэнт гүрний мандал буурал. Япон хэлнээс орчуулсан Ц.Цэрэндорж., Улаанбаатар, 2015.

³⁹ Монгол хэлний сурагчийн тайлбар тольд “гүр” хэмээх үгийг 3 утгаар тайлбарласны нэг дэхийг хуучирсан үг гэсэн утгаар “Хамаг, бүгд” гэсэн байна. - Монгол хэлний сурагчийн тайлбар толь. Улаанбаатар., 2017, 186 дахь 89 тал.

⁴⁰ Монголын нууц товчооны 224 дүгээр зүйл.

⁴¹ Рашидадин Шашдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршивой. Англи хэлнээс орчуулж, уялга үг бичиж, тайлбар зүүлт үйлдсэн Г.Аким., хоёр дахь хэвлэл., Улаанбаатар., 2013, 26 дахь тал.

⁴² Суут сэтгэгч Аристотель одоогоос 2500 жилийн өмнө ёс суртахуун нь “ал ч хүнд зайлшгүй байхаар заяагдсан, тэгэхдээ адил илжээр бус” гэж бичжээ. – Үз.: Аристотель Улс төр. Дөрөв дэх хэвлэл., Орчуулсан Б.Даш-Ёндон., Улаанбаатар, 2015, 48 дахь тал.

⁴³ Чингис хааны ёс суртахууны талаар С.Нарангэрэл Чингис хааны ёсуртахуун-эрх зүйн шастир. Улаанбаатар, 2014. номоос тодруулж үзнэ үү.

⁴⁴ Үз.: Монголын нууц товчооны 149 дүгээр зүйл (Академич Ц.Дамдинсүрэнгийн орчуулга).

⁴⁵ Шашны ёсны сайн хутаг олсон хувилгаанд олгодог цол.

⁴⁶ Аглагт сууж, шашны ёсны бясалгал хийгч даяанч.

⁴⁷ Ли Жичан Чанчунь бомбын өрнө этгээдэл зорчсон тэмдэглэл. Орчуулж тайлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар., Улаанбаатар., 2010, 99 дэх тал.

⁴⁸ Бира Ш. Их Монгол Улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд., Улаанбаатар., 2008, 127 дахь тал.

Байгалийн хууль⁴⁹ - ёс суртахуун юм. Энэ хуулийг ноцтой зөрчсөн хүмүүнийг Ертөнц хэзээ нэгэн цагт заавал шийтгэдэг, түүний дагуу амьдарсан хүмүүнийг шагнаж урамшуулдаг жамтай ажгуу.

Чингис хаан хүмүүсийн хоорондын хүйтэн цэвдэг болсон харьцааг эелдэг найрсаг (монголчуудын хувьд зочломтгой) ёс; шударга бусыг цэх шударга; аймхай, хулчгар занг эр зориг; хэмжээ хязгааргүй шунал, хэрээсээ хэтэрсэн тансаглалыг эс шунахуй; эрээ цээргүй, ичгүүр сонжуургүй ааш авирыг ичих ба эмээх мэдрэмж; цалгар назгай, хариуцлагагүй явдлыг үүрэг ба хариуцлагаа ухамсарлаж биелүүлэх; хүний мөсгүй чанарыг жудаг; харгис хэрцгий, балмад үйлийг нинжин сэтгэл; хууран мэхлэх, итгэл эвдэх, хулхидах явдлыг итгэл даах; нэр нүүрээ барах явдлыг нэр төрөө эрхэмлэх; хагарал, талцал, үзэн ядалт, дайсагналцлыг эв эе; урван тэрслэлтийг үнэнч зан; атаархал, хорсол, атгаг сэтгэл, өс хонзон, хорон муу санаархлыг сайхан сэтгэл болгоход онцгой хувь нэмэр оруулжээ. Ингэснээр хорвоо ертөнцөд амар амгалан буюу Рах Mongolica-г тогтоож чаджээ. Жишээлэхэд “Иран Тураны хоорондох бүх улс орон гайхалтай амар жимэр амьдрах болов. Алтан цар толгой дээрээ тавиад Ливантаанаас Кушант хүртэл өөдгүй хүнтэй тааралдалгүй сэтгэл түвшин явдаг болжээ”⁵⁰. Тайванийн түүхчийн бичсэнээр Монголын Юань гүрний үед Хятадад Дундад Ази, Баруун Ази, Өмнөд Орос, Европоос маш олон тооны шашин номлогч, соёлыг түгээгч иргэд, худалдаачид ирж улмаар Хятад урд хожид байгаагүй олон үндэстэн, соёлоос бүрдсэн нийгэм болон хувирсан ажээ⁵¹. Монголчуудын удирдлагад байх үедээ Руссийн олон хот суурин ямар ч хохирол амсаагүйгээр барахгүй Алтан орд улсын үед хүчирхэгжин хөгжиж байсныг Оросын түүхчид өөрсдөө нотлон бичих болжээ⁵². Японы эрдэмтэн Сүгияма Масааки “Монголоор төвлөрсөн улс төрийн олон бүтэц олон туйлтай болох үйл явц”⁵³ явагдсан гэж бичсэн нь дэлхий дахинд өнөө үед буй болгох гэж зорьж буй олон туйлт үйл явцыг монголчууд XIII зуунд буй болгосныг хэлээд байгаа юм биш үү?

XIII зуун буюу Монголын амар амгалангийн эрин үед урьд өмнө хаагдсан торгоны замыг дахин нээж, Евразийн их худалдааны бүсийг цэцэглүүлэн хөгжүүлж, улс хооронд соёлын харилцаа тогтоож, Газрын дундад тэнгисийн Венеци, Генуягаас Их Монгол Улсын дундуур дайрч, Хятад хүрэх замын нутаг дэвсгэрийн аюулгүй, найдвартай байдлыг хангаж, тэдгээрийг нуггийн голч шударга хүмүүсээр удирдуулснаар Дорно, Өрнө хоёрыг нягт холбож өгчээ. Түүний үр шимийг Европчууд, Төв Азийн лалынхан, еврейчүүд, хятадууд, Азийн бусад улс түмэн хүртжээ. Энэ бүхэнд хүргэсэн шалтгааны тухай Чингис хаан багшдаа бичсэн захидалдаа “Хаан миний бие умар зүгийн их хээр талд аж төрөн сууж, чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод, бүрэлгэн сүйтгэхийг хориглон зогсоож, өмсөх хувцас, идэх хоолоон адуучин үхэрчинтэйгээ хуваалцан, ард иргэдийг хүүхэдтэйгээ адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээн мэт хүндэлж, эе эвийг сахиулж, энэрэл хишгээ түгээмүй”⁵⁴ гэсэн байдаг билээ. Энд шударга ёс (чигч шударгыг эрхэмлэн тогтоосон), нинжин өгөөмөр сэтгэл (өмсөх хувцас, идэх хоолоон адуучин үхэрчинтэйгээ хуваалцан, ард иргэдийг хүүхэдтэйгээ адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгээн мэт хүндэлсэн), эв нэгдэл (эв эеийг сахиулсан), энэрэхүй (энэрэл хишгээ түгээсэн) зэрэг ёс суртахууны эрхэм нандин гол өгөгдлийг багтаасан ажээ. Үүнээс үзэхэд монголын амар амгалангийн үзэл санааны уг сурвалж нь ёс суртахуун байжээ.

⁴⁹ Судлаачид ёс суртахууныг Байгалийн хууль хэмээн үзэх хандлага сүүлийн үед түгээмэлжиж байна. – Үз.: Жишээлбэл, Дарио Салас Соммэр Мораль XXI века (Moral para el siglo XXI) перевод с испанского..., Москва., Издательство “Кодекс”, 2020.

⁵⁰ Чингис хааныхны Монголчууд. Франц хэлнээс орчуулсан Л.Баг-Очир., Улаанбаатар., 2004, 109 дэх тал.

⁵¹ Н.Ариунгуа Тайвань дахь Монголын түүх судлал. Улаанбаатар., 2018, 55 дахь тал.

⁵² Үз.: А.Ю.Якубовский “К вопросу о происхождении ремесленной промышленности Сарая Берке”, Известия ГАИМК, 1931, VII; мөн түүний “Самарканд при Тимуре и Тимуридах”, Гос Эрмитаж, 1933; мөн түүний “Феодализм на востоке. Столица Золотой Орды-Сарай Берке”, ГАИМК, 1932.

⁵³ Сүгияма Масааки Монголын эзэнт гүрний мандал буурал. Япон хэлнээс орчуулсан Ц.Цэрэндорж., Улаанбаатар., 2015, 170 дахь тал.

⁵⁴ Ли Жичан Чанчунь бомбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл. Орчуулж тайлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар., Улаанбаатар., 2010, 18 дахь тал.

Монголын амар амгалангийн хууль зүйн үндэс нь Чингис хаан эрхэмбээрийг залгамжлагчид дэлхий дахиныг элбэн тохинуулсан “Засаг” (Yasag) бөгөөд энэ нь амин сүнс нь болсон ёс суртахууныг “хууль” хэмээн үзэж, ягштал мөрдүүлж байжээ⁵⁵. “Засаг”⁵⁶ хэмээх үг нь Монголын нууц товчоонд хэдэнтээ (Үз.: 74, 81, 153, 189, 193, 197, 199, 227, 240, 257, 278 дугаар зүйл) давтагдсан байх бөгөөд бүр эртнээс хууль, засаглах, засан тохинуулах, шийтгэх гэсэн утга санааг илэрхийлж иржээ. Өөрөөр хэлбэл, хуулийг одооных шиг хууль тогтоогчдын баталсан хэм хэмжээ бус харин ёс суртахууны жам ёсны өгөгдлийг ноцтой гажуудуулсан үйлд тохирох цээрлэл зэмлэл үзүүлэх явдал хэмээн үзэж байсан ажээ. Монголчууд XIII зуунд орчин үеийнх шиг хуулийг хэм хэмжээний бүрдүүлбэр хэмээн үзэж, түүнд онцгой ач холбогдол өгч байгаагүй юм.

Төрийнх нь байгууламж орших ба эс орших эсэхийг ёс суртахуунтай салшгүй уялдуулж зангидсан (хаант) засаглалыг түлхэн унагах замаар засгийн эрх авсан улс төрийн шинэ хүчин энэ дэлхийд ёс суртахуун ба хууль хоёрыг зааглан тусгаарлаж, хуулийг хууль тогтоогчдын дур зоргын хэрэг болгон мөнгө, ашиг ба элдэв янзын хэрээс хэтэрсэн тансаглалыг голчлон чухалчилж, хүн төрөлхтөн ёс суртахуунаа тэргүүн зэрэгт тавихаа больсноос хойш элдэв янзын олон хүндрэл бэрхшээлтэй байнга нүүр тулах болжээ. Ний нуугүй хэлэхэд эдүгээ шударга үнэнч нь тэнэгийн шинж харин зальхай, шунамхай байх нь ухаантайн гэж олонх боддог болсоноос болж хүн төрөлхтөн соёл иргэншилээ сүйрүүлэхэд нэгэнт тулж очоод байна.

Монголын амар амгалангаас үүдсэн зарим сургамж

Судрын чуулганд “Ямар ч атугай тэнгэрийн элбэрлээр шигшигдэн шалгарсан шилдэг үрс, онцгой хойчис л эцэг өвгөдийн сайн нэрийг сэргээн амилуулж, дээд удмынхныхаа үг хийгээд үйл хэргийнх нь тухай дурсамжийг сөхөн амьдруулж чадах болой.

Үр хүүхэд нь л эцгийн нэрийг амьдруулж,

Үр хүүхэд нь эцгийн үйлийг залгамжламуй хэмээжээ”⁵⁷ хэмээсэн захиасыг ирээдүй үедээ үлдээжээ. Гэтэл өвөг дээдсийнхээ гайхамшигт үүх түүхийг монголчууд сайн нэгийг нь мөнхөлж, өөрсдөө нягтлан шүүн тунгааж, сургамжийг нь хойч үедээ авч үлдээхийн оронд элэг буруутны бичсэнийг механикаар хуулбарлаж “байлдан дагуулагч”, “аян дайнч” гэх мэтээр нэр төрийг нь муутгах байдалд хүрснээ засамжлах цаг болсон. Швейцар Улсын иргэн Вальтер Босшард (Walter Bosshard) 1938 онд хэвлүүлсэн “Сэтгэл булаам Монгол орон мину” (Kuhles Grasland Mongolei) хэмээн нэрлэсэн аян замын тэмдэглэлдээ “Монголчуудыг дандаа буруугаар ойлгодог, яагаад гэвэл, тэд нар түүхээ хэзээ ч өөрсдөө бичиж байгаагүй, хэзээ ямагт эсрэг тоглогч нар нь бичсэн байдаг”⁵⁸ хэмээн бичсэн нь өмнө өгүүлснийг баталж байгаа юм биш үү?

Өнөөгийн Монгол Улсын хувьд улс үндэстнийхээ оршин буй Байгалиас заяамал нөхцөл байдалтай шүтэлцэн барилдсан аж төрөх ёсны өвөрмөц онцлог, түүнээс үүдэлтэй үүх түүх, уламжлал, соёл, сэтгэлгээний хэв маяг, өөрийгөө хамгаалах чадварыг дэлхий нийтийн ёс суртахуунлаг ололт амжилттай нэгтгэн зангидсан өөрийн гэсэн нэгдмэл язгуур цогц ҮЗЭЛ САНАА-ны загварыг буй болгож хөгжүүлснээр монголын өнөөгийн нийгэм, эдийн засаг, оюуны санааны гүн хямралыг амжилттай даван туулах боломжтой болохыг Монголын амар амгалангийн түүхэн сургамж харуулж байна. Дан ганц харийн үзэл суртлыг

⁵⁵ Ёс суртахуун хуулийн амин сүнс болох талаар дараах бүтээлээс тодруулж үзнэ үү: С.Нарангэрэл Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Улаанбаатар, 2018; S.Narangerel The spirit of Laws or Chinggis Khan and the Mongols. Ulaanbaatar, 2018; С.Нарангэрэл В поисках духа закона (Завещание Чингисхана). Изд-во Бурятского государственного университета..., Россия., Улан-Удэ, 2019.

⁵⁶ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд “Засаг” хэмээх үгийг 4 утгаар тайлбарласны нэг дэх утгыг “Хууль цааз, эрүү ял” гэсэн байна. - Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь (таван боть). Улаанбаатар., 2008, 989 дэх тал.

⁵⁷ Рашидадин Шашдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршивой. Англи хэлнээс орчуулж, уялга үг бичиж, тайлбар зүүлт үйлдсэн Г.Аким., хоёр дахь хэвлэл., Улаанбаатар., 2013, 30 дахь тал.

⁵⁸ Вальтер Босшард Сэтгэл булаам Монгол орон мину. Герман хэлнээс орчуулсан Б.Баярсайхан., Улаанбаатар., 2014, 50 дахь тал.

хуулбарлан авч, (марксист-ленинист онолыг⁵⁹) төрийнх⁶⁰ болгосон үед гайхамшигт өвөг дээдсийнхээ өв сургаалыг хөсөрдүүлж байсан үеэ дахин давтах ёсгүй.

Их Монгол Улсын эрин үед ямар ч ард түмэн, улс үндэстний аж төрөх ёс, хэл, арьсны өнгө, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, соёл, уламжлалд хүндэтгэлтэй хандаж, тэдгээрт хөндлөнгөөс бүдүүлгээр халдаагүй, ямар ч улс үндэстнийг уугуул нутаг уснаас нь хөөн зайлуулаагүй, хүйс тэмтрээгүй, улс түмнийг бие биеэ үзэн ядаж дайсагналцахад хүргээгүй, түүнчлэн монголчууд үндэснийхээ ямар нэгэн өвөрмөгц онцлогийг бусад ард түмэнд тулган хүлээлгээгүйгээр тогтоосон Монголын амар амгалангийн түүхэн сургамжийг дахин эргэцүүлэх шаардлага дэлхий дахинд буй болжээ. Эдүгээ хүртэл Их эзэн Чингис хааны гал голомт – Монгол Улсын нутаг дэвсгэрээс XIII зууны үед харийн гүрнээс тонон дээрэмдэж эх нутагтаа авчирсан гэх нэг ширхэг ч үнэт эд зүйл олдоогүй нь бусдын эд баялагт шүлэнгэтсэн байлдан дагуулалтыг Их эзэн Чингис хаан эрхэмбээрийг залгамжлагчид хийгээгүй болохыг нотлон харуулна.

Чингис хааны үед төрийг одоогийнхон шиг биш харин биологийн бус амьд организмтай адилтган зүйрлэж байсан түүхэн сургамж өнөө үед ач холбогдлоо алдаагүй байна. Төрийн дээд удирдлагад хэн нэгнийг цэх шударга байдал, эр зориг, нэр төр, итгэл дааж чадах эсэх, эрдэм чадал зэрэг ёс суртахууны шалгуураар тавьдаг байжээ. Германы монгол судлаач Б.Баркманн профессор “Чингис хааны цусан төрлийнхөн удирдах албан тушаал бараг хашиж байсангүй. Тэгэхлээр орчин үеийн боловсон хүчний бодлогод ч гэсэн Чингис хаанаас суралцууштай юм бас байх шиг”⁶¹ хэмээн тэмдэглэжээ.

Хүн төрөлхтний өмнө асуу дэлхийн III дайны аймшигт аюулыг зайлуулах цорын ганц арга зам нь хүн төрөлхтний ёс суртахуунд л байгаа бөгөөд Чингис хааны “Хорт могойн хэл, Хооронд минь хутгаж, Хов жив оруулбал, Холдож салалгүй, харин Хоёр нүүрээр учирч, Хор хөнөөлийг тасалж байя”⁶² гэсэн айлдвар нь сөргөлдөгч талуудыг хэлэлцээний ширээнд нүүр тулан сууж, нүд нүдээ ширтэлцэн, муу сайнаа цээжээ онгойтол илэн далангүй ярилцаж, болзошгүй хор аюулыг холтгох арга замыг сүвэгчлэхээс өөр замгүй гэдгийг нотлон харуулж байгаа юм биш үү?

Судрын чуулганд⁶³ “Хожим таван зуу, мянга, арван мянган жилд ч нарт хорвоод төрж, хаан төр⁶⁴ барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэж болох Чингис хааны ёс суртахуун, Засагийг өөрчлөхгүйгээр сахивал мөнх Тэнгэр хишгээ хүртээж, тэд маань өнө мөнхөд гэр хотлоороо амар амгалан, аз жаргалтай байх болмуй за”⁶⁵ гэж бичсэнээр илтгэлээ өндөрлөе.

Хорвоо ертөнц үүрд амар амгалан байх болтугай.

⁵⁹ Тухайлбал К.Маркс “Татарын дарлал 1237-1462 он буюу хоёр зуунаас илүү хугацаанд үргэлжилжээ. Энэ бол зүгээр нэг сүйрэл биш, харин хүмүүсийн нэр төр, сэтгэл зүрхийг гундаан золиослосон дарлал байв. Татар монголчууд аймшиглан заналхийлэх, цөлмөх, үй олноор хядах байгууламж бүхий системийг буй болгосон байлаа. Татар монголчууд тоо томшгүй олон газрыг эзэлж байсан боловч өөрсдөө тооны хувьд цөөн тул булаан эзэлсэн газруудад тэдний араар бослого хөдөлгөөн гарахаас сэргийлэн айдас хүйдэс төрүүлэх, хүмүүсийг нь хядаж цөөрүүлэхийг боддог байв. Татар монголын цөлийн маягийн тогтолцоонд Шотландын өндөрлөг, Кампанья де Римаг эзэнгүй болгосонтой адил эдийн засгийн зарчим үйлчилж байсан ба тэд хүнийг хонь болгож, үржил шимтэй газар, олон хүнтэй суурин газруудыг малын бэлчээр болгон хувиргаж байлаа” гэж бичжээ. - Үз.: Marks K., Secret diplomatic history of the eighteenth century. London: Swa Sonnenschein. 1899. P.78.

⁶⁰ БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн удиртгалыг үзнэ үү.

⁶¹ Удо Б.Баркманн Монголын түүх, улс төрийн асуудлын тухай өгүүллүүд. Улаанбаатар., 2013, 423 дахь тал.

⁶² Үз.: Монголын нууц товчооны 163 дугаар зүйл.

⁶³ Судрын чуулган нь персийн их бичгийн хүмүүн Рашид-Ад-Диний хувийн бүтээл биш харин Чингис хааны отгон хөвүүн Тулуйгийн гуравдугаар хөвүүн Хүлэгэг залгамжилсан Ил хаант улсын бага хаадууд зарлиг гаргаж, Монголын албан ёсны түүх бичлэгийг перс хэлээр бүтээлжээ. Энэ талаар дараах бүтээлээс тодруулж үзнэ үү: С.Нарангэрэл Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд. Нэмж засварласан гурав дахь хэвлэл. Улаанбаатар., 2018, 56-72 тал; S.Narangerel The spirit of Laws or Chinggis Khan and the Mongols. Ulaanbaatar., 2018, P. 55-72; С.Нарангэрэл В поисках духа закона (Завещание Чингисхана). Изд-во Бурятского госуниверситета..., Россия., Улан-Удэ, 2019, СТР. 53-79.

⁶⁴ Энэ эрин цаг үед хаант засаглал оршин тогтнож байсан.

⁶⁵ Рашидадин Шаддирин чуулган хэмээх Монголчуудын түүх оршивой. Англи хэлнээс орчуулж, уялга үг бичиж, тайлбар зүүлт үйлдсэн Г.Аким., хоёр дахь хэвлэл., Улаанбаатар., 2013, 448 дахь тал.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. С.Нарангэрэл Монголчуудын зан суртахууны гарваль. Улаанбаатар, 2010.
2. С.Нарангэрэл Чингис хааны сүр хүч. Улаанбаатар, 2013.
3. С.Нарангэрэл Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир Улаанбаатар, 2014.
4. С.Нарангэрэл Ёс суртахууны монгол цагаан толгой. Улаанбаатар, 2015, 2018.
5. С.Нарангэрэл Хуулийн амин сүнс буюу буюу Чингис хаан, Монголчууд. нэмж засварласан гурав дахь хэвлэлт., Улаанбаатар., 2018.
6. С.Нарангэрэл Бурхан Халдун - Монголчуудын гал голомт. Улаанбаатар, 2019;
7. С.Нарангэрэл Монголчуудын ёс суртахуун: сэргэлт, ялзрал, эргэн сэргээлт. Улаанбаатар, 2020.
8. Рональд Лейтхим Марко Поло аялал..., Англи хэлнээс орчуулсан О.Бүрэнжаргал., Улаанбаатар., 2012.
9. Сайшаал, Чингис хааны товчоон (дээд дэвтэр). Улаанбаатар., 2010.
10. Л.Н.Гумилев Эртний Орос ба агуу уудам тал нутаг. Орчуулагч Ч.Алтангэрэл., Улаанбаатар., 2017.
11. Жон Эндрию Бойль Дэлхийн Монгол гүрэн. Улаанбаатар., 2015.
12. Рах Mongolica-гийн талаарх зарим эргэцүүлэл – Удо Б.Баркманн Монголын түүх, улс төрийн асуудлын тухай өгүүллүүд. Улаанбаатар., 2013.
13. Сүгияма Масааки Монголын эзэнт гүрний мандал буурал. Япон хэлнээс орчуулсан Ц.Цэрэндорж., Улаанбаатар, 2015.
14. Рашидадин Шашдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршивой. Англи хэлнээс орчуулж, уялга үг бичиж, тайлбар зүүлт үйлдсэн Г.Аким., хоёр дахь хэвлэл., Улаанбаатар., 2013.
15. Аристотель Улс төр. Дөрөв дэх хэвлэл., Орчуулсан Б.Даш-Ёндон., Улаанбаатар, 2015.
16. Монголын нууц товчоо (Академич Ц.Дамдинсүрэнгийн орчуулга).
17. Ли Жичан Чанчунь бомбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл. Орчуулж тайлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар., Улаанбаатар., 2010.
18. Бира Ш. Их Монгол Улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд., Улаанбаатар., 2008.
19. Чингис хааныхны Монголчууд. Франц хэлнээс орчуулсан Л.Бат-Очир., Улаанбаатар., 2004.
20. Н.Ариунгуа Тайвань дахь Монголын түүх судлал. Улаанбаатар., 2018.
21. Сүгияма Масааки Монголын эзэнт гүрний мандал буурал. Япон хэлнээс орчуулсан Ц.Цэрэндорж., Улаанбаатар., 2015.
22. Вальтер Боссхард Сэтгэл булаам Монгол орон мину. Герман хэлнээс орчуулсан Б.Баярсайхан., Улаанбаатар., 2014.
23. Удо Б.Баркманн Монголын түүх, улс төрийн асуудлын тухай өгүүллүүд. Улаанбаатар., 2013.

Гадаад хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. S.Narangerel The Spirit of Laws or Chinggis khan and the Mongols. Ulaanbaatar, 2018.

2. С.Нарангэрэл В поисках духа закона, завещание Чингисхана. РФ., Улан-Удэ., Издательство Бурятского госуниверситета, 2019.
3. D.Morgan The Mongols (The Peoples of Europe), Blackwell, 1999.
4. Дарио Салас Соммэр Мораль XXI века (Moral para el siglo XXI) перевод с испанского., Москва., Издательство “Кодекс”, 2020.
5. А.Ю.Якубовский “К вопросу о происхождении ремесленной промышленности Сарая Берке”, Известия ГАИМК, 1931, VII.
6. А.Ю.Якубовский “Самарканд при Тимуре и Тимуридах”, Гос Эрмитаж, 1933.
7. А.Ю.Якубовский “Феодализм на востоке. Столица Золотой Орды-Сарай Берке”, ГАИМК, 1932.
8. Marks K., Secret diplomatic history of the eighteenth century. London: Swa Sonnenschein. 1899.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН УЯЛДАА ХОЛБООГ СУДЛАХ АРГА ЗҮЙГ САЙЖРУУЛАХ ТУХАЙД



А. Алтанзул

*Удирдлагын академийн Эрх зүйн
тэнхимийн эрхлэгч доктор (PhD), дэд
профессор*



Ж.Нарантуяа

*Удирдлагын академийн багш, доктор
(PhD), дэд профессор*

ТОВЧЛОЛ:

Энэ өгүүлэлд хууль тогтоомжийн уялдаа холбоог, ялангуяа хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг судлахад нийгмийн шинжлэх ухааны чанарын судалгааны аргад тулгуурлан таван үе шаттайгаар контент шинжилгээний аргаар судлах боломж буй тухай санал дэвшүүлээ. Ийнхүү шинжлэхэд Хууль зүй, дотоод хэргийн яамны боловсруулсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал”-д заасан нэр томъёоны тодорхойлолтуудад суурилан, контент шинжилгээний аргыг ашиглан хэрхэн шүүн тунгаахыг боловсруулж матрицлан харуулж, давхардал, зөрчил, хийдлийг тус бүрт нь шинжлэхийг санал болгож байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

Хууль тогтоомж, нийгмийн шинжлэх ухааны арга, судалгааны арга зүй, хуулийн доктринал ба доктринал бус дүн шинжилгээ.

НЭГ. ОРШИЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд “хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх” зохицуулалтыг тусгасан. Үүний дагуу Засгийн газраас 2016 онд Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалыг баталсан. Уг аргачлалын зорилго нь хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг тогтоох шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, энэ дагуу үнэлнэ.

Английн Лондон дахь Квийн Мари Их сургуулийн хуулийн профессор Рожер Коттерел /Roger Cotterrell/ ¹: “Хэдэн зуун жилийн түүхтэй хуулийн цэвэр доктринал бичвэрүүд нь орчин үеийн хэдэн аравхан жилийн түүхтэй нарийн нягт, нийгэм-эрхзүйн эмпирик судлалын бүтээлүүдтэй харьцуулахад хууль гэж нийгмийн үзэгдлийнхээ хувьд юу юм, юу бүтээдэг юм гэдэг утгаараа үнэ цэн багатай мэдлэг бүтээсэн” гэж шүүмжилжээ. Энэ утгаараа уламжлалт хуулийн шинжилгээний арга нь хуулийн мэргэжилтнүүд болоод оюутнуудыг судалгаа хийхэд бэлтгэж чадахгүй байна гэж Мак Конвил, Хонг Чуй нар 2007

¹ Research Methods for Law, Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007, p.5.

онд “Хуулийн судалгааны аргууд” гэдэг номондоо тэмдэглэсэн байдаг. Манай улсын хууль тогтоомжийн судалгааны арга зүйн үндсэн аргад гадаад улс орны хуулиудтай харьцуулах, түүхчлэх арга голчлон хэрэглэгдэж байна. Харин эмпирик судалгааны аргуудыг цөөн хэрэглэдэг нь хуулийг зөвхөн хууль боловсруулагчийн эсхүл хуулийн доктринал судалгаа хийсэн хүний хийсвэр дүгнэлтэд суурилах сөрөг үр дагаврыг бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг.

“Өнөөдөр нэг хууль баталлаа, маргааш тэр хууль нь бусад хуулиудтайгаа зөрчилдөх, нийгмийн харилцаанд гарсан сөрөг асуудлыг бүрэн зохицуулж чадахгүй, эсхүл саад болдог. Энэ нь зөвхөн хүний ч эрх ашиг бус, амьтны, байгалийн тэнцвэртэй байдалд ч сөргөөр нөлөөлдөг. Жишээлбэл: Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчин, Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн хуулиуд хэр харилцан уялдаа бүхий системтэй байдаг вэ? гэдэг асуулт байнга гарч ирж байна” (Алтанзул А, Эрх зүй бүтээх ажиллагаа ба системийн сэтгэлгээ).

Иймээс өнөө үед хуулийн баримт бичгийн шинжилгээ, хууль, эрх зүйн чиглэлээр судалгаа хийхдээ шинжлэх ухааны системтэй аргазүй, аргад суурилан хийх хэрэгцээ шаардлага тулгараад байна. Энэ өгүүлэлд “Хууль тогтоомжийн уялдаа холбоог судлахдаа ямар аргазүй, аргад тулгуурлан шинжилж, сайжруулах боломжтой вэ?” гэсэн судалгааны асуулт тавилаа.

Асуултандаа хариулахын тулд “Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”, Засгийн газрын 2010 оны 68 дугаар тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн яамны 2010 оны 84-р тогтоолын 2 дахь хэсгийн “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”-д төвлөрөн шинжлэхийг зорилоо.

Хоёр. Хуулийн салбарт хийгдэж буй судалгааны орчин үеийн хандлага

Улс орон хөгжихийн хирээр хууль эрх зүйн зохицуулалт нь нийгэмд гарч буй өөрчлөлтийн дагуу амьдралд хэрэгтэй, нийцтэй байхын тулд тухайн цаг үеэ даган өөрчлөгдөх хэрэгцээ гардаг. Олон улсад сүүлийн үед хууль зүйн салбарт хийгдэж буй судалгааны мөн чанарт нэлээд өөрчлөлт орж, энэ чиглэлийн эрдэмтэн судлаачид хууль эрх зүйн чиглэлээр судалгааг шинжлэх ухаанч арга барилд суурилахыг сануулан бичсээр байна. Үүний тулд хууль, эрх зүйн чиглэлийн судалгаанд нийгмийн судалгааны арга зүйг түлхүү ашиглаж, нийгмийн үзэгдлүүдтэй холбохыг чухалчлах хандлага давамгайлж байна.

Өнөөдрийн байдлаар олон улсад хууль, эрх зүйн хүрээнд хийгдэж буй судалгааг хуулийн уламжлалт доктринал (doctrinal²) бичвэр буюу уламжлалт доктринал критицизмын (traditional doctrinal criticism) дүн шинжилгээ, доктринал бус эмпирик судалгаа болон олон улсын харьцуулсан хуулийн судалгаа (international and comparative legal research) гэж гурав ангилж байна.³

Хуулийн уламжлалт доктринал критицизмын тухай Пендлетоны тайлбарласнаар “Энэ нь ихэнх тохиолдолд хууль эрх зүйн асуудлыг эргэцүүлэн тунгааж, хуулийн мөн чанарын тухай хувь хүний өөрийнх нь төсөөлөл байдаг. Хуулийн доктринал критицизмаар бичиж байгаа хүн нь социологич, шашин судлаач, философичтой төстэй. Тэдний ажил нь хувь хүний ертөнцийг харах өнцөг ба нийгмийн харилцааг зохицуулахад хүсүүштэй юу байж болох тухай төсөөлөл юм” хэмээжээ.⁴ Өөрөөр хэлбэл, доктринал шинжилгээ гэдэг нь хүчин төгөлдөр хэрэгжиж буй эрх зүйн акт, хууль, шүүхтэй холбоотой заалт зэргийг шинжлэхдээ логик болон эргэцүүлэн бодох учир шалтгааны ухааныг ашиглан дүгнэлт гаргахыг хэлнэ.

² *Doctrinal* – номлол, зарчим гэсэн энэ нэр томъёог энэ судалгаанд цаашид *доктринал* гэж хэрэглэх ба илүү оновчтой монгол нэр томъёогоор орчуулах боломжийг салбарын судлаачдад үлдээж байна.

³ Soren, Chunuram, *Legal Research Methodology: An Overview*. JETIR, Volume 8, Issue 10, 2021; Dobinson, Ian & Johns, Francis, “Qualitative Legal Research” in *Research Methods for Law*. Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007.

⁴ Pendleton, Michael, “Non-empirical Discovery in Legal Scholarship – Choosing, Researching and Writing a Traditional Scholarly Article” in *Research Methods for Law*. Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007, p.162.

Иймээс ч уламжлалт хуулийн “судалгаа” нь онолын шинжилгээ гэхээсээ илүүтэй зөвхөн судалж буй хуульдаа л бүрэн анхаарлаа төвлөрүүлж, гадаад ертөнцөөс тасархай байдлаар ангилан эрэмбэлэх, цэгцлэн индуктив замаар системчилж, дедукц хийх дүн шинжилгээ гэж үздэг байна.⁵ Гэхдээ “Хуулийн тогтолцооны үйл ажиллагаа болон хуулийг ойлгуулахаар судалж буй цэвэр доктринал шинжилгээг сүүлийн үед оюуны сэтгэлгээний хувьд хэтэрхий хөшүүн, уян хатан бус, дотогш чиглэсэн хандлагатай гэж үзэн нэлээд шүүмжлэлд өртөж байна”.⁶

Харин 1960-аад оны сүүлээс нэвтэрч эхэлсэн хуулийн доктринал бус эмпирик судалгааг “контексттэй судалгаа” гэж үздэг⁷ ба “ийм судалгаа нь нийгэм, улс төр болон бусад факт баримтуудын нөхцөл байдлыг системтэйгээр судлах замаар бие даасан хууль дүрэм болон эдгээр хууль дүрмийн нийгэм, улс төрийн болоод бусад үр нөлөөг нь шалгах шалтгаан нь болдог” гэж аль 1920-д онд Америкийн хуульч Артур Насбаум бичсэн байна.⁸ МакКонвил болон Хонг Чуй нарын үзсэнээр энэ тохиолдолд хууль нь хоёр янзын асуудалтай тулгардаг. Нэг талаас, хууль нь нийгмийн асуудлыг үүсгэгч шалтгаан нь болох боломжтой. Нөгөө талаас, хууль нь улс төр болоод нийгмийн өөрчлөлтөд бүрэн болон хагас шийдэл өгөх боломжтой аж.⁹ Энэ утгаараа, доктринал бус судалгаа нь хуулийг нийгэм, улс төрийн контекстэнд нь нийгмийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны аргуудаас ашиглан судлах тухай ойлголт юм.

Олон улсын хуулийн харьцуулсан судалгаа нь олон улсын хуулийг үндэсний хууль, Европын холбооны хууль зэрэгтэй холбож, хуулийн уламжлалт категориос хальж, харьцуулах аргыг ашигладаг. Энэ төрлийн судалгаа нь даяарчлалаас харилцан хамааралтай болсон эринд олон улсын хууль болон хуулийн тогтолцооны үйл ажиллагаа, тэдгээрийн төрийн бодлого боловсруулахад нөлөөлөх үр нөлөөг танин мэдэхэд туслах үүрэгтэй гэж үздэг.

Ийнхүү дүгнэн үзэхэд, хуулийн доктринал шинжилгээ гэж зөвхөн хууль тогтоомжийг шинжлэх дор дурдах гурван зорилгын хүрээнд хийгдэж буй тухайн хуулийн мэргэжилтний логик сэтгэлгээний аргад суурилсан дүн шинжилгээг нэрлэдэг бол хуулийн доктринал бус судалгааг нийгмийн шинжлэх ухааны арга зүйд суурилан, нийгмийн шинжлэх ухааны арга, аргачлалыг ашиглан хийсэн эмпирик судалгааг хэлдэг байна.

Уламжлалт доктринал гэж нэрлэгддэг зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд хийгддэг судалгааны үндсэн зорилгыг дараах гурван чиглэлд тодорхойлж болох юм.¹⁰ Үүнд:

- нэгдүгээрт, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид байгаа дутагдал, доголдлыг судлан илрүүлж, тэдгээрийг арилгах боломжийг эрэлхийлж, сайжруулах арга хэмжээг санал болгоход оршдог.

- хоёрдугаарт, хэрвээ ямар нэг салбар, чиглэлд тохирсон хуулийн зохицуулалт байхгүй бол судалгааны зорилго нь тухайн салбар чиглэлд нийцэхүйц хууль тогтоомжийн төслийг санал болгохуйцаар түвшинд байвал зохистой.

- гуравдугаарт, тухайн салбар чиглэлд хууль эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч ямар нэг шалтгаанаар хэрэгжихгүй байгаа бол судалгааны зорилго нь хүчин төгөлдөр буй хууль тогтоомжийг хэрхэн хэрэгждэг болгох тухай реформыг санал болгоход чиглэгдвэл зүйтэй гэж үздэг.

⁵ Research Methods for Law, Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007, p.1.

⁶ Research Methods for Law, Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007, p.4.

⁷ Research Methods for Law, Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007, p.1.

⁸ Soren, Chunuram, Legal Research Methodology: An Overview. JETIR, Volume 8, Issue 10, 2021, p.445.

⁹ Research Methods for Law, Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007, p.5.

¹⁰ Soren, Chunuram, Legal Research Methodology: An Overview. JETIR, Volume 8, Issue 10, 2021, p.445.

Судлаач Сорен, Добинсон болон Жонс нар¹¹ уламжлалт хууль, эрх зүйн доктринал шинжилгээг хийхдээ нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүйг баримтлан хийхийг санал болгоод, ингэснээр түүнийг хууль, эрх зүйн чанарын судалгаа гэж нэрлэж болох тухай өөрсдийн бүтээлдээ тодорхой санал дэвшүүлэн тайлбарласан байдаг.

Тэгвэл доктринал дүн шинжилгээг чанарын судалгааны арга зүйгээр хийхийн тулд судалж буй хууль тогтоомжид шинжлэх ухааны системтэй аргыг хэрэглэх явдал юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл судлаач хүн тухайн хууль, эрх зүйн баримт бичгийг шинжлэхдээ шинжлэх ухааны тодорхой аргыг хэрэглэснээр илүү системтэй болох боломжтой гэж гадны судлаачид бичиж байна.¹² Хууль, эрх зүй нь ерөнхийдөө тухайн нийгэм, соёлын ёс зүй, үнэлэмжид өөрчлөлт хийж, хэлбэржүүлэхийг, өнөө цагийн нийгэм дэх хүн амын зан үйлийн харилцааг зохицуулахыг зорьдог тул түүнийг системтэйгээр судалснаар одоо хүчин төгөлдөр байгаа болон шинээр төрөх хууль тогтоомж, хууль, эрх зүйн бодлого, тэдгээрийн нийгэмд тохирох үр нөлөө зэргийг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үздэг. Тиймээс ч хуулийн судалгаа нь мэдээллийг зорилготойгоор цуглуулдаг ба эл зорилгоос шалтгаалан ямар төрлийн судалгааг хэрхэн хийх вэ гэдэг нь тодорхой болдог. Энэ өнцгөөс авч үзвэл тодорхой хууль, шүүхийн кейс болон бусад хоёрдогч эх сурвалжийг ашиглаж байгаа нь өөрөө нийгмийн шинжлэх ухааны судлагдсан байдлын тойм хийж байгаатай дүйхүйц гэж үзэж болно хэмээн дээрх судлаачид тэмдэглэсэн.¹³ Иймээс хуулийн доктринал судалгааны арга зүй нь нэлээд өвөрмөц байх ба судлагдсан байдлын тойм болон арга зүйг Добинсон, Жонс нар дараах 5 шатлалтайгаар боловсруулж болохыг санал болгосон.¹⁴ Үүнд:

1. Судалгааны асуулт томъёолох. Энэ нь сонгосон хуулийн чиглэлээс шалтгаална.

2. Ном зүйн мэдээллийн сангаа бүрдүүлэх. Энэ бол доктринал судалгаанд хамгийн чухал алхам гэж тооцдог. Учир нь доктринал хууль нь хууль тогтоомжийн хүчин чадал, эрэмбээс хамаардаг тул анхдагч буюу хамгийн дээд хүчин чадалтай хууль болон интерпретаци өгөхөд ашиглах өгүүллүүд, сурах бичиг гэх мэт хоёрдогч эх сурвалжуудаас бүрддэг. Гэхдээ үндсэн зорилго нь академик өнцгөөс судлахад анхаарах ёстой тул нягт нямбай, системтэйгээр, зөвтгөж болохуйц арга зүйг баримтлах ёстой. Эрх зүйн судалгааны зорилго нь эрх зүйн асуудлыг шийдэхэд туслахуйц “эх сурвалж”-ийг олоход оршино. Анхдагч эх сурвалжид шүүх, төр засгийн байгууллага, хувь хүмүүсийн заавал биелүүлэх эрх зүйн хэм хэмжээнүүд орно. Үүнд, хууль тогтоомж, дүрэм журам, шүүхийн тушаал, шийдвэрүүд байж болно. Эдгээрийг хууль тогтоох байгууллага, шүүх, захиргааны байгууллагуудаас гаргадаг. Хоёрдогч эх сурвалжид заавал биелүүлэхгүй байж болох хуулийн тайлбарууд багтах бөгөөд эдгээр нь хууль гэж юу юм, ямар байх ёстой вэ гэдгийг тайлбарлахад тусална.¹⁵

3. Нэр томъёоны хайлт хийж, сонгох. Итгэж болохуйц хуулийн судалгааны арга зүйг боловсруулахад нэр томъёог оновчтой хайна гэдэг нь маш чухал.

4. Практик ач холбогдол талаас нь шүүн шалгах шалгуур болон арга зүйн талаас нь шүүн хянах шалгуур үзүүлэлтийг ашиглах. Хуулийн бүтээл нь өвөрмөц тул хамаарах баримт бичгүүдийн эрэмбэ дарааллыг харгалзах хэрэгтэй болно.

5. Шүүн тунгаалтыг хийсний дараа үр дүнг нь нэгтгэх. Ийнхүү эдгээр алхмуудын дагуу хуулийн баримт бичгийг системтэйгээр нягт шүүн тунгааж, нэгтгэх үйл явц нь индуктив оюун тунгаалтын логик үйл явц бөгөөд үр дүнд нь илүү итгэж болохуйц болно. Үүгээрээ хуучин уламжлалт аргаасаа ялгаатай юм. Хууль, эрх зүйн судалгааны судлагдсан байдлын тоймд суурь эх сурвалжийн хууль, мөн хоёрдогч эх сурвалжуудад үндэслэн

¹¹ Soren, C., 2021; Dobinson, I., & Johns, F., 2007.

¹² Simion, K., 2016; Van Hoecke, M., 2015; Soren, C., 2021; Dobinson, I., & Johns, F., 2007.

¹³ Dobinson, Ian & Johns, Francis, “Qualitative Legal Research” in Research Methods for Law. Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007, p.40.

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ Soren, Chunuram, Legal Research Methodology: An Overview. JETIR, Volume 8, Issue 10, 2021, p.444.

хуулийг шинжилж, ерөнхий зарчмыг дэвшүүлдэг.

Хэдийгээр эдгээр алхам нь эцсийн арга зүй биш боловч хуулийн салбарт мэргэжлийн судалгааны чиглэлийг хөгжүүлэх өөрчлөлтийн эхлэл байж болох юм хэмээн Добинсон, Жонс нар¹⁶ аль 2007 онд бичиж байжээ.

Гурав. Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах одоо хэрэглэж буй аргачлал, түүний судалгааны аргазүйг сайжруулах боломж

Хууль тогтоомжийн уялдаа холбоог судалж шинжлэхтэй холбоотойгоор 2010 онд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдын “Аргачлал батлах тухай” 84-р тушаалд “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал”-ыг хавсралтаар баталсан. Эл хавсралтад тайлбарласан аргачлал нь 10 хэсэг бүхий зүйлээс бүрдсэн ба түүнд давхардал, зөрчил, хийдэл гэсэн нэр томъёоны ойлголтуудыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

-“давхардал” гэж хуулиар нэгэнт зохицуулсан харилцааг хэлзүйн хувь хувьд хуулбарласан, эсхүл тэдгээрийн зохицуулалтын агуулга, зорилго нь ижил байхыг;

-“зөрчил” гэж нэг этгээдийн зан үйлийг ижил нөхцөлд өөрөөр журамласан, Үндсэн хууль болон хууль тогтоомжийн эрэмбэллийн аргын дагуу хамгийн дээд хүчин чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд заасан журмаас өөр зохицуулалтыг тусгасан, өөр нэр томъёо хэрэглэсэн, зохицуулалтын агуулга нь тухайн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн байхыг;

-“хийдэл” гэж тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан, эсхүл зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утгатай байхыг хэлнэ гэж тус тус тодорхойлсон байна.

Энэ аргачлал нь орчин үеийн хуулийн шинжлэх ухааны арга зүйн шаардлагыг хангахгүй байгаа нь хуулиудад буй зүйл заалтуудын давхардал, зөрчил, хийдлийг хэмжихүйц шинжтэй бус субъектив хандлагаар шалгаж, тухайн хуулийн заалтын үр нөлөөг объектив байдлаар үнэлж чадахгүй байна.

Дөрөв. Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах судалгааны аргазүйг сайжруулах санал

19 дүгээр зуунаас эхлэн кодификацид хийдэлгүй байх гэсэн зарчим орж ирсэн. Кодификацжуулах гэдгийг тодорхой салбар эрх зүйн хууль тогтоомжийг системчлэх ба өөр хооронд нь нийцүүлэх гэсэн утгаар нь хэрэглэх нь зүйтэй.¹⁷

Хууль тогтоомжийн давхардал, хийдэл зөрчилд хийх судалгаа нь чанарын судалгаанд хамаарна хэмээн үзэн судалгааны процесс нь энэ өгүүллийн хоёрдугаар хэсэгт тайлбарласан Добинсон, Жонс¹⁸ нарын санал болгосон 5 шатлалд үндэслэн дараах үе шаттайгаар судлах боломжтой. Үүнд,

Нэгдүгээрт, судлах асуудлын хүрээнд яг ямар асуултанд хариулт авахыг зорьж буйгаа тодорхойлсон судалгааг чиглүүлэх асуултаа дэвшүүлнэ;

Хоёрдугаарт, тухайн асуудлаарх анхдагч болон хоёрдогч эх сурвалжуудад хамаарах хууль эрх зүйн баримтуудыг цуглуулж өгөгдлөө бэлэн болгоно.

Гуравдугаарт, итгэж болохуйц хуулийн судалгааны арга зүйг боловсруулахад нэр томъёог оновчтой хайна гэдэг хамгийн чухал. Иймд шинжилгээ хийх гол үзэл баримтлал нь энэ өгүүллийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны боловсруулсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал”-д заасан нэр томъёоны тодорхойлолтуудад суурилна.

¹⁶ Dobinson, Ian & Johns, Francis, “Qualitative Legal Research” in Research Methods for Law. Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007, p.23.

¹⁷ Б.Буянхшиг, Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт, 2021.

¹⁸ Dobinson, Ian & Johns, Francis, “Qualitative Legal Research” in Research Methods for Law. Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007, p.26.

Дөрөвдүгээрт, цуглуулсан өгөгдлөө ямар шинжилгээний аргаар системтэйгээр шинжлэх вэ гэдэг нь маш чухал. Энэ тохиолдолд контент буюу агуулгын шинжилгээний арга хамгийн тохиромжтой гэж үзэж байгаа тул чанарын судалгааны контент шинжилгээний аргыг ашиглан нарийвчлан шүүн тунгааж, шинжлэх боломжтой. Эл зарчмаар бид дараах Хүснэгт 1, 2, 3-г харуулж байгаа матрицын хүрээнд давхардал, зөрчил, хийдлийг тус бүрт нь шинжлэхийг санал болгож байна.

Эцэст нь, тавдугаарт, шинжилгээний үр дүнг давхардал, зөрчил, хийдэл нь хэмжих үзүүлэлт тус бүрээр хэр давтамжтай, хуулийн ямар эрэмбэд ямар үзүүлэлтүүд зөрчигдсөн болохыг дэвшүүлсэн асуултын хүрээнд нэгтгэн дүгнэж хариултыг өгч гаргана.

Хүснэгт 7. Хууль тогтоомжийн “давхардал”-ыг харьцуулах матриц

Шалгуур үзүүлэлт			Харьцуулах эрх зүйн актууд			Код үүсгэх
Ойлголтын тодорхойлолт	Ойлголтыг хэмжих үзүүлэлт, түүний тодорхойлолт	Хэмжих үзүүлэлтийг шалгах асуулт	Ерөнхий зохицуулалттай хууль	Нийтлэг зохицуулалттай хууль, дүрэм	Нарийвчилсан зохицуулалттай хууль, дүрэм	Давхардал-1
“Давхардал” гэж хуулиар нэгэнт зохицуулсан харилцааг хэл зүйн болон агуулгын хуулбарласан байхыг хэлнэ	1.1 Хэл зүйн хувьд хуулбарласан байх	1.1.1. Тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хууль, захиргааны хэм хэмжээний актад шууд давтан хуулбарласан байна уу?				1.1.1
	1.2. Зохицуулалтын агуулга ижил байх	1.2.1. Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хууль, захиргааны хэм хэмжээний актад бичвэрийн, эсхүл агуулгын хувьд өөрөө найруулсан байна уу ?				1.2.1
	1.3. Өөр нэр томьёо хэрэглэсэн байх	1.3.1. Хуульд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томьёотой зөрчилдөж байна уу?				1.3.1

Хүснэгт 8. Хууль тогтоомжийн “зөрчлийн”-ийг харьцуулах матриц

Шалгуур үзүүлэлт			Харьцуулах эрх зүйн актууд			Код үүсгэх
Ойлголтын тодорхойлолт	Ойлголтыг хэмжих үзүүлэлт, түүний тодорхойлолт	Хэмжих үзүүлэлтийг шалгах асуулт	Ерөнхий зохицуулалттай хууль	Нийтлэг зохицуулалттай хууль, дүрэм	Нарийвчилсан зохицуулалттай хууль, дүрэм	Зөрчил-2

“Зөрчил” гэж нэг этгээдийн зан үйлийг ижил нөхцөлд өөрөөр журамласан, Үндсэн хууль болон хууль тогтоомжийн эрэмбэллийн аргын дагуу хамгийн дээд хүчин чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд заасан журмаас өөр зохицуулалтыг тусгасан, өөр нэр томьёо хэрэглэсэн, зохицуулалтын агуулга нь тухайн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн байхыг хэлнэ	2.1. Хуулийн зорилтыг хангасан байх	2.1.1 Тухайн зохицуулалт нь Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцэж байна уу?				2.1.1
		2.1.2. Урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж байна уу ?				2.1.2.
		2.1.3. Суурь харилцааг зохицуулж хуулийн зохицуулалтын агуулгатай нийцэж буй эсэх ?				2.1.3
		2.1.4. Төсөвт үр ашиггүй зардал өсөж байна уу?				2.1.4.
	2.2. Нэг этгээдийн зан үйлийг ижил нөхцөлд өөрөөр журамласан байх	2.2.1. Тодорхой асуудлыг тухайн хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар өөр хууль, захиргааны хэм хэмжээний акт болон тухайн хуульдаа өөр журмаар зохицуулахаар заасан байна уу?				2.2.1.

Хүснэгт 9. Хууль тогтоомжийн “хийдлийн ”-ийг харьцуулах матриц

Шалгуур үзүүлэлт			Харьцуулах эрх зүйн актууд			Код үүсгэх
Ойлголтын тодорхойлолт	Ойлголтыг хэмжих үзүүлэлт, түүний тодорхойлолт	Хэмжих үзүүлэлтийг шалгах асуулт	Ерөнхий зохицуулалттай хууль	Нийтлэг зохицуулалттай хууль, дүрэм	Нарийвчилсан зохицуулалттай хууль, дүрэм	Хийдэл-3

“Хийдэл” гэж тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан, эсхүл зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утгатай байхыг хэлнэ	3.1. Тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга замыг заагаагүй байх	3.1.1. тухайн хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн эрхээ эдлэх боломж, үүргээ хүлээх үйлдэл, хариуцлага оногдуулах үндэслэл, шийтгэлийн хэлбэрийг тодорхой заасан эсэх ?				3.1.1
	3.2 Хуулийн заалт нь хэмжихүйц байх	3.2.1 хуулийн заалт, зохицуулалт нь практикт хоёрдмол утгыг илэрхийлж байгаа эсэх ?				3.2.1
		3.2.2. хуулийн заалт нь тунхаглалын буюу хийсвэр шинжтэй бус бодитой хэрэгжих эсэх ?				3.2.2.

Дээрх хүснэгтэд заасан шалгуурыг төрийн бодлогыг алдааг илрүүлдэг, хэрэгжилтийн үр нөлөөг тодорхойлдог Гая Питерсийн¹⁹ болон Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хөгжлийн тусламжийн хорооны боловсруулсан (OECD-DAC) үнэлгээний аргачлалыг харьцуулж гаргасан болно.

Гая Питерсийн шалгуур үзүүлэлт :	DAC-ийн шалгуур үзүүлэлт:
1. Давхцал	1. /Relevance/
2. Зөрчил	2. /Coherence/
3. Хийдэл,	3. /Effectiveness/
4. Удирдлага, зохион байгуулалтын асуудал	4. /Efficiency/
5. Эрэлт хэрэгцээний өөрчлөлт	5./Impact /
6. Салбар хоорондын асуудал	6.Тогтвортой байдал /sustainability/
7. Хялбар цэгцлэлт	

¹⁹ Цахим засаглалын хөгжлийн бодлого, зохицуулалтын шинжилгээ. Удирдлагын академи, судалгааны тайлан.

ТАВ. ДҮГНЭЛТ

Хуулийн салбарт өнөө үед эрх зүйн чиглэлээр судалгаа хийхэд шинжлэх ухааны системтэй аргазүйд суурилсан эмпирик судалгаа хийх хэрэгцээ шаардлага тулгараад байгаа нь Монгол Улсад төдийгүй олон улсад яригдаж бичигдсээр ирлээ. Иймээс энэ өгүүлэлд дээрх асуудлын хүрээнд “Хууль тогтоомжийн уялдаа холбоог судлахдаа ямар аргазүй, аргад тулгуурлан шинжилж, сайжруулах боломж байна вэ?” гэсэн судалгааны асуултыг дэвшүүлэн олон улсын орчин үеийн хандлагад суурилан хуулиудад буй зүйл заалтуудын давхардал, зөрчил, хийдлийг нийгмийн шинжлэх ухааны аргазүйн өнцгөөс хэмжихүйц ямар шийдэл байж болохыг судалж, тодорхой хариултыг эрэлхийллээ.

Ийнхүү судлаач хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг судалж шинжлэхдээ Добинсон, Жонс нарын санал болгосон 5 шатлалд үндэслэн тодорхой үе шаттайгаар, судалгааны тодорхой үзэл баримтлалыг боловсруулан, чанарын судалгааны контент буюу агуулгын шинжилгээний аргаар шүүн тунгааж, шинжлэх саналыг дэвшүүллээ. Эл зарчимд үндэслэн бид давхардал, зөрчил, хийдлийг энэ өгүүллийн Дөрөвдүгээр хэсэгт санал болгосон Хүснэгт 1, 2, 3-т боловсруулсан матрицын хүрээнд тус бүрт нь контент шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэх санал дэвшүүллээ. Эдгээр матрицын дагуу агуулгын шинжилгээ хийх нь хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг системтэйгээр, нэг стандартаар судлах боломж буй болох ба цаашид сайжруулах арга зам нь нээлттэй юм. Эцэст нь тэмдэглэхэд, хууль тогтоомжийн судалгаа хийж буй судлаачид, хуульчид өөрсдийн судалгааг аль болох нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүйд суурилан илүү системтэй, үндэслэлтэй, субъектив бус өнцгөөс судлах нь урт хугацаандаа нийгмийн харилцааг зохицуулах хамгийн үр дүнтэй эрх зүйн хэм хэмжээг бүрдүүлж, хуулийн тогтолцоог сайжруулахад чухал үүрэгтэй болохыг анхаарах цаг болжээ.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль тогтоомж***

1. Хууль тогтоомжийн тухай хууль, 2017.
2. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх аргачлал”.
3. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 68 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

4. А.Алтанзул, Эрх зүй бүтээх ажиллагаа ба системийн сэтгэлгээ, Удирдлагын академи, 2018.
5. Б.Буянхишиг, Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт, 2021.
6. Цахим засаглалын хөгжлийн бодлого, зохицуулалтын шинжилгээ. Удирдлагын академи, судалгааны тайлан.

Гадаад хэл дээрх***Ном, өгүүлэл, судалгааны тайлан***

1. Soren, Chunuram, Legal Research Methodology: An Overview. JETIR, Volume 8, Issue 10, 2021.
2. Dobinson, Ian & Johns, Francis, “Qualitative Legal Research” in Research Methods for Law. Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007.
3. Research Methods for Law, Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007.
4. Simion, Kristina, Practitioner’s guide: Qualitative and Quantitative Approaches to Rule of Law Research. INPROL—International Network to Promote the Rule of Law, 2016.
5. The Oxford Handbook of Empirical Legal Research, Ed.: Peter Cane and Herbert M. Kritzer. Oxford University Press, 2010.
6. Pendleton, Michael, “Non-empirical Discovery in Legal Scholarship – Choosing, Researching and Writing a Traditional Scholarly Article” in Research Methods for Law. Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007.
7. Van Hoecke, Mark, Methodology of Comparative Legal Research. In Law and Method. Boom juridisch, 2015.
8. Wilson, Geoffrey, Comparative Legal Research. In Research Methods for Law. Ed: Mike McConville & Wing Hong Chui, Edinburgh University Press, 2007.

METHODOLOGY FOR IMPROVING THE STUDY OF LEGAL COHERENCE

Altanzul.A

*Associate professor, Head of the Department
of Law of the National Academy of
Governance (PhD)*

Narantuya.J

*Associate professor, Lecturer of the National
Academy of Governance (PhD)*

ABSTRACT:

The aim of the study described in this study was to suggest possibilities to study the relationship of legislation, in particular, its duplications, violations and gaps based on the main qualitative content analysis phases of the social science research.

We strongly recommend that it should be analyzed each term separately (definition of terms on the “Methods to eliminate duplication, gaps, and violations of legislation, and to improve the relationships between them” which is developed by the Ministry of Justice and Internal Affairs of Mongolia) using qualitative content analysis.

KEYWORDS:

Legislation, research methods for social science, methodology of research, analysis of the legal or not legal doctrinal research.

ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХИЙН ЭСРЭГ ДҮРЭМ, ЖУРМЫН ЗОХИЦУУЛАЛТ



О. Чулуунцэцэг

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах
багш*



С.Рэнцэндорж

*МУИС-ийн Бизнесийн сургуулийн ахлах
багш*

ТОВЧЛОЛ:

Улс орнууд дотоодын хууль тогтоомждоо олон улсын эрх зүйн хэм хэмжээний зохицуулалтыг илүүтэйгээр тусган хэрэгжүүлэх болжээ. Ингэснээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, улмаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, Засгийн газар хооронд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, маргаантай хэлэлцэхүйц асуудлыг харилцан мэдээлэл солилцох замаар шийдвэрлэх, үндэстэн дамнасан компаниудын үйл ажиллагааг хянах зэрэг олон чухал арга хэмжээг нэгдсэн хэм хэмжээгээр зохицуулах болов.

Эдгээр арга хэмжээний нэг нь татвараас зайлсхийх ажиллагааг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, холбогдох асуудлыг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулан, шаардлагатай тохиолдолд дотоодын хуулийн хэм хэмжээнд тусгаж өгөх явдал юм.

Манай улсад татвараас зайлсхийх арга хэмжээний ойлголтыг хэрхэн хэрэгжүүлж, хуулийн ямар зохицуулалтаар хийгдэж байгаа болон давхар татварын гэрээний хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байгааг товч байдлаар авч үзэхийг зорилоо.

ТҮЛХҮҮР ҮГС:

Татвар төлөвлөлт, хяналт шалгалт, татвараас зайлсхийх, дүрэм, давхар татварын гэрээ, татварын хууль тогтоомж, үнэ шилжилт.


1. ТАТВАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН ХЭМ ХЭМЖЭЭ

Монгол Улс 1992 оны Үндсэн хуульдаа олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлахаар тусгаж, түүнтэй нийцүүлэн гаргасан татварын хууль тогтоомжийн актыг татварын алба, татвар төлөгчид даган биелүүлэх үүргийг хуулиар тогтоож өгсөн билээ. Тухайлбал, хуулиар ногдуулсан албан татвар төлөх нь иргэний үндсэн үүрэг гэж хуульчилж өгсөн нь татварын хуулийн хэрэгжилттэй салшгүй холбоотой юм.

Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвараас зайлсхийх явдлыг багасгахад тусгайлан чиглэсэн агуулгатай хэлэлцээр байгуулах явдал олон улсын практикт түгээмэл дэлгэрсэн байдаг¹ гэсэн нь нийтлэг хэрэглэгддэг хэм хэмжээ юм. Энэ нь үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээний уялдаа холбооны талаарх асуудал бөгөөд татварын бодлогын хүрээнд үндэсний хууль тогтоомжоор шийдвэрлэсэн хэм хэмжээг олон улсын татварын эрх зүйн хэм хэмжээтэй хэрхэн уялдуулах, харилцан зөвшилцөж, тохирох тухай асуудалтай² хамтдаа хэрэгждэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан бөгөөд мөн Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол Улсын олон улсын гэрээнд татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн нь дотоодын хууль тогтоомжийн хүрээнд олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэглэж болохыг дурджээ. Эдгээр хуулийн хэм хэмжээний хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаа явуулж олсон орлого болон гадаад улсад олсон орлогод албан татвар ногдуулах зорилгоор 2006 оны Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т “Аж ахуйн нэгжийн болон хувь хүнээс гадаад улсад төлсөн албан татварт хөнгөлөлт үзүүлэхдээ орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай гэрээний дагуу шийдвэрлэх”³, түүнчлэн 2008 оны Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2-т зааснаар Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үед татварын нөхцөлийг хадгалах дэглэм тогтоохоор тус тус хуульчилж өгсөн. Гиймээс дараах улсуудтай давхар татварын гэрээг байгуулан хэрэгжүүлэхээр төлөвлөж байжээ. Үүнд:

*Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх,
татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай
хэлэлцээр байгуулсан улс*



Эх сурвалж: Татварын албаны статистик мэдээ

Монгол Улсаас бусад улсын Засгийн газартай давхар татварын гэрээ байгуулан хэрэгжүүлж байснаас үзвэл тус хэлэлцээрийг Кувейт улстай 1998 онд байгуулж 2012 онд хүчин төгөлдөр бус, Люксембургийн вант улстай 2001 онд байгуулж 2012 онд хүчин төгөлдөр бус, Нидерландын Вант улстай 2002 онд байгуулж 2012 онд хүчин төгөлдөр бус, Арабын Нэгдсэн Эмират Улстай 2003 онд байгуулж 2012 онд тус тус хүчин төгөлдөр бус болгож байсан байна.

¹ Т.Мэндсайхан, Олон улсын татварын эрх зүй /сургалтын гарын авлага/, Уб, 2009, 17 дахь тал.


² Монгол Улсын Татварын эрх зүй, ТЕГ, МУИС-ийн ХЗС, ШУАФСЭЗХ, Уб, 2009, 333 дахь тал.

³ Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Төрийн мэдээллийн эмхтгэл, 2006, №38.

Одоогийн байдлаар манай улс нийт 26 оронтой давхар татварын гэрээг байгуулж, улмаар гэрээ байгуулсан орнуудад татвараас зайлсхийх болон зугтах явдлыг гаргуулахгүй байх, татвар нуух боломжийг хаах зорилгоор уг гэрээг хэрэгжүүлэхийг эрмэлзсээр байна.

Дээрх хэлэлцээрт татвараас зугтах, зайлсхийх явдлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ бол хэлэлцээр хийсэн орнуудын хооронд гэрээнд тусгагдсан татваруудын аливаа асуудлаар мэдээлэл харилцан солилцох журам батлах явдал байсан бөгөөд мэдээллийг компьютерийн сүлжээгээр болон тусгайлан хүсэж мэдээлэл солилцох зэргээр хэрэгжүүлж байна⁴. Жишээ нь: Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Кувейт улсын хоорондын хэлэлцээрийн 26 дугаар зүйлд хоёр улсын татварын хууль тогтоомж нь уг хэлэлцээрт хамаарах татвартай зөрчилдөхгүй байгаа талаар зохих мэдээллийг харилцан солилцох ба мэдээлэл хадгалах хуулийн дагуу нууцалж, хэлэлцээрт хамаарагдах татварын хэмжээг тогтоох буюу хураахтай холбогдсон этгээдүүд, эрх барих байгууллагад мэдэгдэх эрхтэй гэсэн байдаг. Тиймээс хэлэлцээртэй холбоотой хэрэгжих журмыг тухайн улс баталж мөрддөг.

Монгол Улсын 2019 оны Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлд хуулийн хүрээнд татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм болон тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийн харилцан тохирох журмыг хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж байхаар тус тус заасан⁵. Улмаар Татварын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т зааснаар татварын харилцан тохирох журмыг Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, нэгдэн орсон олон улсын байгууллагаас тавигдах шаардлагад нийцүүлэн Сангийн сайдын 2019 оны 301 дүгээр тушаалаар “Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх журам”-ийг батлан хэрэгжүүлэх болсон. Хууль тогтоомжид нийцүүлэн баталсан журмаас гадна татварын алба Татвараас зайлсхийхийн эсрэг дүрмийн заалтын хүрээнд суутган тооцох татвар ногдуулалтын байдалд хяналт тавин хэрэгжүүлж байна. Тус дүрмийг хэрэгжүүлэхдээ татварын схемийн хүрээнд тухайн татвар төлөгч татвараас зайлсхийх замаар татварын ашиг хүртсэн үед хэрэглэх ёстой. Өөрөөр хэлбэл, татварын схем нь татварын ашиг хүртэх үндсэн зорилгоор хэрэгжүүлэх татвараас зайлсхийх үйл ажиллагаа бөгөөд татварын схем зохион байгуулахад татвараас зайлсхийх үндсэн зорилго бүхий үйлдэл, гэрээ, хэлцэл, зохион байгуулалт, төлөвлөгөө, төсөл, гүйцэтгэл зэргийг шууд болон шууд бус хэлбэрээр, дангаар эсхүл бусад этгээдтэй хамтран, бүхэлд нь ба хэсэгчлэн хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хамруулан авч үзнэ. Жишээ нь: татварын схемийг ашиглан тодорхой үр дүнд татварын ашиг хүртэх ажиллагааг авч үзье. Үүнд:




⁴ Монгол Улсаас гадаад улстай байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”-ийн харилцан тохирох ажиллагааг хэрэгжүүлэх журам. УБ, 2013, Сангийн сайдын 260 дугаар тушаал.

⁵ Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Төрийн мэдээллийн эмхтгэл, 2019, №22.

Олон улсад татвараас зайлсхийх гэсэн ойлголтод эдийн засгийн тодорхой зорилго, ашиг сонирхолд нийцүүлэхийн тулд татварын бүртгэл, тооцооллыг хуулийн дагуу зохих ёсоор тооцохдоо шууд буюу шууд бус аргаар дамжуулан татварын хэмжээг багасгах үйлдлийг авч үздэг. Тухайлбал, Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Нидерландын Вант улс хоорондын конвенцийн 23 дугаар зүйлийн 23.5-т тогтоосон татварыг Нидерланд улсын татвараас хасаж тооцох болон тус улсад давхар татвараас зайлсхийх тухай хуулийн заалтаар зөвшөөрөгдөх боловч тухайн улсын татвараас хасагддаг орлогын онцгой төрлүүд бол бууруулж болох дүнгээс хэтрэх ёсгүй гэж тусгажээ.

Манай улсын хуулиар татвараас зайлсхийх гэдгийг татварын ногдлыг бууруулах, татварын суурь багасгах, эсхүл алдагдлыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой хуульд заасан нөхцөлийг бүрдүүлж байгаа татвар төлөгчийн үйлдэл гэж томъёолж өгсөн. Ер нь бол 2006 оноос хойш татвараас зайлсхийх явдалтай эрчимтэй тэмцэн дотоодын хууль тогтоомждоо олон улсын хэм хэмжээний аргуудыг хэрэглэх болж, үүнээс зарим чухал арга зүйг эх сурвалж болгон хэрэгжүүлсээр иржээ. Үүнд:

Татвараас зайлсхийх арга зүйг хэрэгжүүлэх эх сурвалж



Дээрх арга зүйн эх сурвалжийг хэрэглэхдээ татвараас зайлсхийх аргуудын онцлог ойлголтыг ялгамжтай байдлаар товч авч үзье. Тухайлбал,


- Давхар татварын гэрээ нь орлогын эх үүсвэрийг чухалчилж улс хоорондын хамтын ажиллагааг сахин биелүүлэх, татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалах, татвараас зайлсхийх явдлыг багасгах зорилготой хэрэгждэг.
- Хяналтад байдаг гадаадын компанийн дүрэм нь орлогод бага хувь хэмжээгээр татвар ногдуулах замаар олон улсын татвараас зайлсхийх явдлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.
- Үнэ шилжилт нь харилцан хамаарал бүхий этгээдүүд хоорондын бараа, үйлчилгээ, биет бус хөрөнгө болон санхүүгийн үйлчилгээний ажил гүйлгээний нөхцөлийг тогтоох явдал юм⁶.
- Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм. Татвараас зайлсхийх зорилгоор хийгдсэн ажил гүйлгээ, бизнесийн хэлцлийг татвар төлөвлөлтийн хүрээнд хянан шалгах арга хэрэгсэл юм.

Давхар татварын гэрээг дангаар нь эрх зүйн шинэчлэлттэй холбоотойгоор 1992 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд улмаар 2006 онд дотоодын хууль тогтоомжийн хүрээнд тусгайлан заалт хэлбэрээр оруулж, тайлан гаргах хэмжээнд хийгдэж эхэлсэн. Гэвч улс орны хөгжлийн явцад давхар татварын гэрээ дангаараа үйлчлэх боломжгүй болж нэмэлт эрх зүйн эх сурвалжуудыг батлан мөрдүүлэх болсон. Энэ нь Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан

⁶ <https://www.moore-mongolia.mn/үйлчилгээ/зөвлөх-үйлчилгээ/үнэ-шилжилт>.

сэргийлэх тухай хэлэлцээрийн хүрээнд хяналтад байдаг гадаадын компаниудын дүрэм, үнэ шилжилт, татвараас зайлсхийх эсрэг дүрэм гэсэн тодорхой дүрэм, журмын хамт батлан хэрэгжүүлсэн. Олон улсын түвшинд хэрэглэгдэж байгаа эдгээр эх сурвалж нь дотоодын хууль тогтоомжид тусгагдан хэрэгжиж байгаа ч шинэлэг ойлголт хэвээр байна. Жишээлбэл, татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг татварын хуулийн заалт болгон хэрэгжүүлэх асуудал нь дараах нөхцөлөөр тусгагдсан байна. Үүнд:

Ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх нөхцөл



Ерөнхий дүрмийг хэрэгжүүлэхдээ татварын хяналт шалгалтын үеэр дээрх нөхцөл тогтоогдсон тохиолдолд хэрэглэнэ. Энэхүү нөхцөл нь 2019 оны татварын хуулийн шинэчлэлээр нэмэлт заалт болон хуульчлагдсан.

III. ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХ ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ

Давхар татварын хэлэлцээрт хэлэлцэн тохирогч хоёр улс буюу тэдгээрийн аль нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдийг хамруулдаг. Түүнчлэн хэлэлцээрээр хэлэлцэн тохирогч хоёр улс орлого ба хөрөнгийн татварын давхардлыг арилгах боломж бүрдэхээс гадна татвараас зайлсхийх, зугтах боломжийг хаах зорилготой үйлчилдэг. Тийм ч учраас олон улсын хэм хэмжээ хэрэгжих явцад зөрчил маргаан гарахаас урьдчилан сэргийлэх, зохицуулах талаар зөвлөмж гаргах эрхийн хүрээнд манай улс олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж⁷-ийн дагуу дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх хэлэлцээрийн зөвлөмж⁸ -ийг батлан хэрэгжүүлсэн билээ.

Улмаар 2012 оноос эхлэн Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу давхар татварын гэрээний хэрэгжилтийн явцад татвараас зайлсхийх асуудлууд үүсэж эхэлсэн юм. Тухайлбал,

№	Хууль, олон улсын гэрээний нэр	Хууль, хэлэлцээрийн заалт
	Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.2.9 дэх заалт	Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч Монгол Улсад олсон орлогод 20 хувиар албан татвар ногдуулна. Үүнд: • Монгол Улсад бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс авсан ногдол ашгийн орлого

⁷ “Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын Татварын конвенцийн үлгэрчилсэн загварын заалтуудыг хэрэгжүүлэх зөвлөмж”. Үндэсний Татварын Ерөнхий Газар. Уб, 2002.

⁸ “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, гадаад улс хоорондын хэлэлцээр”-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийг хянах, төлөлтийг баталгаажуулах, бүртгэх тухай зөвлөмж. Үндэсний татварын Ерөнхий Газар. Уб, 2009.

	<ul style="list-style-type: none"> • Эрхийн шимтгэлийн орлого, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого • Монгол Улсын нутаг дэвсгэр дээр борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого
<p>1. Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Кувейт Улс хоорондын хэлэлцээрийн 10.2, 11.2, 12.2 дах заалт</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Дивидендийн жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч бол ногдуулах татварын хэмжээ нь дивидендийн нийт хэмжээний 5 хувиас хэтэрч болохгүй. ▪ Дивидендийн жинхэнэ эзэмшигч нь хөрөнгийн 49 ба түүнээс дээш хувийг нь эзэмшдэг хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч компани байвал хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулахгүй. ▪ Хүүг жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч бол ногдуулах татварын хэмжээ нь хүүгийн нийт хэмжээний 5 хувиас хэтэрч болохгүй. ▪ Эрхийн шимтгэлийн жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугч бол ногдуулах татварын хэмжээ нь эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 10 хувиас хэтэрч болохгүй.
<p>2. Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 10.2, 11.2, 12.2 дах заалт</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Ногдол ашиг хүртэгч этгээд нь түүний жинхэнэ эзэмшигч мөн байх тохиолдолд ногдуулах татварын хэмжээ нь ногдол ашиг төлж буй компанийн хөрөнгийн 10 хувийг шууд эзэмшдэг компани бол ногдол ашгийн нийт дүнгийн 5 хувиас, бусад бүх тохиолдолд 15 хувиас тус тус хэтрэхгүй байх. ▪ Хүүгийн жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч бол ногдуулах татварын хэмжээ нь нийт хүүгийн 15 хувиас хэтрэх ёсгүй. ▪ Эрхийн шимтгэлийг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол ногдуулж буй татвар нь эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 5 хувиас хэтрэх ёсгүй.

3.	Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Нидерландын Вант Улс хоорондын конвенцийн 10.2-3, 11.2, 12.2 дах заалт	<ul style="list-style-type: none"> ■ Ногдол ашгийн жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч бол ногдуулах татварын хэмжээ нь ногдол ашгийн нийт дүнгийн 15 хувиас хэтрэхгүй. ■ Ногдол ашиг эзэмшигч нь байнгын оршин суугч бөгөөд компанийн хөрөнгө нь бүрэн буюу хэсэгчилсэн хувьцаанд хуваагддаг ба ногдол ашиг төлж буй компанийн хөрөнгийн 10-аас доошгүй хувийг шууд эзэмшиж байвал тухайн компанийн төлж буй ногдол ашигт уг компани байнга оршдог хэлэлцэн тохирогч улс нь татвар ногдуулахгүй. ■ Хүүгийн жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч нөгөө улсад байнга оршин суудаг бол ногдуулах татварын хэмжээ хүүгийн нийт дүнгийн 10 хувиас хэтэрч болохгүй. ■ Эрхийн шимтгэлийн жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч бол ногдуулж буй татвар нь эрхийн шимтгэлийн нийт дүнгийн 5 хувиас хэтэрч болохгүй.
4.	Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 12.2 дах заалт	<ul style="list-style-type: none"> ■ Эрхийн шимтгэлийн жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугч бол ногдуулах татварын хэмжээ нь эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 10 хувиас хэтэрч болохгүй.

Дээрх татварын хэлэлцээрийн заалтын хэсгээс үзэхэд Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд оршин суугч бус татвар төлөгчийн ногдол ашгийн орлого, хүүгийн орлого, бараа, ажил, үйлчилгээний орлогоос 20 хувийн татвар ногдуулахаар хуульчлагдсан байтал бусад улс оронтой байгуулсан татварын хэлэлцээрээр ногдол ашгийн орлогоос 5-15 хувиар татвар ногдуулах, зарим тохиолдолд татвар ногдуулахгүй байх, хүүгийн орлогоос 5-15 хувиар, эрхийн шимтгэлийн орлогоос 5-10 хувиар татвар тооцон суутгахаар зохицуулагдсан нь дотоодын хуулийн хэм хэмжээтэй олон эрх зүйн хэм хэмжээ зөрчилдөж байгааг илэрхийлнэ. Түүнчлэн хуулийн хэм хэмжээний заалт нь татварын хэлэлцээрийн хэрэгжилтийн заалттай илт зөрүүтэй хэрэгжиж байгаа эсэх талаар 2012 онд төрийн байгууллага (Ашигт малтмалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гадаадын хөрөнгө оруулалтын газар)-аас хяналт шалгалт хийх чиглэлийг засгийн газраас үүрэг болгож байжээ.

Татварын хуулиар заагдсан хэм хэмжээг зөрчин татварын гэрээг хэрэгжүүлсэн үйлдэлд дараах улсуудын хэлэлцээрийг хамааруулсан байдаг. Үүнд:



Олон улсын гэрээний хэрэгжилтийн хүрээнд үүсэж буй зөрчлүүд нь арал, улсуудын кодыг татварын албаны мэдээллийн баазад оруулаагүй, компанийн бүртгэл тодорхойгүй, хөрөнгө оруулагчид охин компаниа өөр улсад байгуулах, том компаниуд хөрөнгө оруулалтаа Монгол Улсад оруулж ирэх замаар төдийгүй давхар татварын гэрээний хэрэгжилттэй холбоотой татвараас зайлсхийх үйлдэл хийгдэж байжээ. Эдгээр үйл ажиллагаа нь хөрөнгөө тусгаарлах, татвараас зайлсхийх, бизнесийн чиглэлээ салгах зэргээр олон улсын гэрээний зохицуулалтын хүрээнд нь тухайн улсын дотоодын татварын хууль тогтоомжийг зөрчих байдлаар хэрэгжих болсон. Цаашилбал, энэ нь давхар татварын гэрээ, хувь нийлүүлэгчдийн гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ гэх мэтээр гэрээний хэм хэмжээний зохицуулалттай ч холбоотой байв. Жишээлбэл, ногдол ашгаас тэг хувь хэмжээгээр татвар ногдуулж байгаа нь татвараас зайлсхийх үйлдэлд хамаарах нөхцөл болох уу гэдэг асуудал хүртэл хөндөж эхэлсэн. Тиймээс Монгол Улсад татвар төлөхөөс зайлсхийх үйлдлийг үзүүлсэн гэж үзэх зарим улсын “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай улс хоорондын хэлэлцээр”-ийг дээрх 4 улсын хүрээнд хууль тогтоох эрх бүхий байгууллагаас хүчингүй болгон нийтэд мэдээлж байжээ. Тухайлбал,

Монгол Улсын Хэлэлцээр соёрхон батлах тухай
хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль

№	Хуулийн заалт
1.	1998 оны 7 дугаар сарын 30-ны өдөр баталсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс болон Кувейт Улс хоорондын Хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай. (Улсын Их Хурал, 2012-11-02)
2.	2001 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр баталсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж оногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Вант Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай. (Улсын Их Хурал, 2012-11-02)
3.	2002 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улс, Нидерландын Вант Улс хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Конвенцийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай. (Улсын Их Хурал, 2012-11-02)
4.	2003 оны 10 дугаар сарын 23-ны өдөр баталсан Монгол Улсын Засгийн газар, Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газар хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай. (Улсын Их Хурал, 2012-11-02)

Эх сурвалж: <https://old.legalinfo.mn/law/details/9381?lawid=9381>

Түүнчлэн татварын хууль тогтоомжийг зөрчсөн нь нотлогдсон, эсхүл татвар төлөхөөс зайлсхийсэн татвар төлөгчийн талаар татварын алба хуулийн дагуу нийтэд мэдээлэх эрх тусгайлсан журмаар зохицуулагддаг⁹.

Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу хяналтад байгаа ажил гүйлгээний ашгийг тухайн ажил гүйлгээнд оролцсон харилцан хамаарал бүхий талуудад эдийн засгийн үндэслэлтэй хуваарилах, мөн бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу харилцан хамаарал бүхий этгээд хооронд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нөхцөл, үнийг тодорхойлох зорилгоор үнэ шилжилтийн тохируулга хийх боломжийг хуульчилсан. Мөн Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.19.11-т заасны дагуу харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээтэй холбоотой үнэ шилжилтийн тайланг хуульд заасан хугацаанд гаргаж холбогдох татварын байгууллагад ирүүлээгүй бол улс бүрээр тайлангийн хувьд харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээ бол нийт дүнгийн 4 хувийн татварыг нөхөн төлөх үүрэгтэй гэсэн эрх зүйн хэм хэмжээний хариуцлагын заалтыг ч тусгасан. Үнэ шилжилтийн ойлголт нь харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд үүсэх харилцааны хүрээнд татварын суурьт нөлөөлөх, ажил гүйлгээний нөхцөлийг тогтоох, хяналтад байгаа ажил гүйлгээг хамруулах, татварын зардлаа бууруулах зэрэг олон асуудлыг дагуулсаар байдаг. Гиймээс харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдэж байгаа бодит бус үнэ хэрэглэж болзошгүй бараа, ажил үйлчилгээний үнийн мэдээллийн эх сурвалжийн жагсаалтыг татварын албанаас баталж гаргаж байжээ¹⁰. Жишээлбэл, хүнсний бараа, барилгын материал, ажил үйлчилгээнээс зээл ба түрээсийн хүү, хөдөө аж ахуйн анхдагч түүхий эд, уул уурхайн бүтээгдэхүүн гэх мэт.

Татвараас зайлсхийх ойлголт нь татвар төлөвлөлттэй салшгүй холбоотой юм. Учир нь татвар төлөгч бүрийн татварын өр төлбөрийг багасгах зорилгоор хууль тогтоомжийн хүрээнд тодорхой арга, техник, аргачлалыг хэрэглэх эрхийг хүлээн зөвшөөрөх асуудал байдаг. Үүнийг олон улсад татвар төлөвлөлтийг хуулийн үзэл баримтлал болон хуулийн хэм хэмжээний заалтын хүрээнд зөрчил үүсгэхгүйн улмаас тогтвортой хугацаанд татварын өр төлбөрийг багасгах замаар татвар төлөгчийн үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээ ч гэж тодорхойлдог¹¹. Татвар төлөвлөлтийн үндэс нь хууль тогтоомжид заагдсан хөнгөлөлт ба зөвшөөрсөн хэм хэмжээг олж, бүрэн дүүрэн зөв зохистой хэрэглэх явдал юм. Тухайлбал, бизнесийн тодорхой зорилгогүй татварын үйлдэлд төлөх татварын хэмжээг багасгах, татвар төлөхөөс зайлсхийх болон татвар төлөх хугацааг хойшлуулсан ажил гүйлгээ хийх, төлөвлөн гүйцэтгэх татвар төлөгчийн үйлдлийг хамруулахаар хуульчилсан байдаг.

Сүүлийн үед улс орнууд дотоодын татварын хууль тогтоомждоо Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм (General Anti-Avoidance Rule)-ийн заалтыг нэмж оруулах болсон. Энэхүү дүрмийн зорилгын талаар татвар төлөгч тухайн хуулийн заалтыг буруу хэрэглэсэн эсвэл урвуулан ашигласан гэх мэт татварын хуулийн үзэл баримтлалыг алдагдуулахуйц байдлаар хэрэгжсэн хууль ёсны үйл ажиллагааг таслан зогсооход чиглэх ёстой байдаг¹². Татвараас зайлсхийхтэй тэмцэх ерөнхий дүрэм (GAAR) нь арилжааны бус зориулалттай арилжаа, ажил гүйлгээний татварын үр өгөөжийг үгүйсгэх, татварын үр өгөөжийг цорын ганц давамгайл зорилготой этгээдэд хүртээх ёстой гэдгийг зохицуулахад оршино гэжээ¹³.

⁹ “Зөрчил бүхий татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх журам” Татварын Ерөнхий Газрын даргын 2009 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 225 тоот тушаалын 1 дүгээр хавсралт.

¹⁰ “Харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдэж байгаа борлуулалтад бодит бус үнэ хэрэглэж болзошгүй дотоодын бараа, ажил, үйлчилгээний төрөл, зах зээлийн үнийн мэдээллийн эх сурвалжийн жагсаалт” Татварын Ерөнхий Газрын даргын 2007 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн 165 тоот тушаалын хавсралт.

¹¹ См.: Raymond R.N., Clifford M. Hicks. *Income Tax influences on Legal Forms on Organizations for Small Business*. L., 1990. p.45

¹² Waerzeggers, Christophe and Cory Hillier, 2016, “Introducing a general anti-avoidance rule (GAAR)—Ensuring that a GAAR achieves its purpose,” Tax Law IMF Technical Note 2016/1, IMF Legal Department

¹³ Г.Алтанзаяа, Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм гэж юу вэ? (GAAR), УБ, 2020, 2 дахь тал

Олон улсад Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлж буй улс орнуудад Их Британи, Франц, Герман, Нидерланд, Бельги, Канад, Хятад, Сингапур, Итали, Өмнөд Африк, Кени, Австрали¹⁴ төдийгүй Монгол улс ч гэсэн дотоодын татварын хууль тогтоомждоо хэрэгжүүлэхээр хуулийн хэм хэмжээний тодорхой заалтыг тусгасан билээ. Тухайлбал, хууль эрх зүйн үүднээс татвараас зайлсхийх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар улс хоорондын уялдаа холбоог хангах, дотоодын татварын хууль тогтоомжийн нөлөөллийг үнэлэх, хууль эрх зүйн дүн шинжилгээ хийх, татвар төлөгчдийн татварын төлөвлөлт, давхар татварын гэрээний хэрэгжилт зэрэг нэлээд асуудлыг тус дүрмийн хэрэгжилттэй холбон авч үздэг¹⁵. Жишээлбэл, татварын орчны нөлөөллийн шинжилгээ, татвар төлөгчийн татварын ногдлыг тодорхойлоход харьцуулагдах байдлын шинжилгээ, эрх зүйн акт болон шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх гэх мэтээр ангилан хууль тогтоомжийн үр нөлөөг дээшлүүлэх боломжийг судалж болно.

Дээрх ойлголтыг олон улсын хэм хэмжээний хэрэгжилтийн хүрээнд дүгнэн үзэхэд татвараас зайлсхийх явдлыг багасгах арга нь давхар татварын гэрээгээр зохицуулагдах боловч түүнтэй нийцүүлэн хэрэгжүүлэх бусад дүрэм, журмыг нэмж зохицуулах шаардлага улс орнуудад үүсэж байдаг байна. Иймээс дотоодын хууль тогтоомжийн хэм хэмжээний дагуу олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ түүнд тохирсон дүрэм, журмын биелэлтэд төрөөс хяналт тавих, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайжруулах боломж нөхцөлийг судлах, сайн хэрэгжиж буй улс орны туршлагыг судлан нутагшуулах, олон улсын хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжид хэлбэржүүлэхдээ ойлгомжтой байдлаар томъёолох, татварын орчны үр нөлөөг сайжруулах, татвар төлөгчийн эрхийг дээдлэн хялбаршуулсан хэм хэмжээний журмыг түлхүү хэрэгжүүлэх нь зүйтэй санагдаж байна.

ДҮГНЭЛТ

1. Сүүлийн үед ихэнх орнууд татвараас зайлсхийх, түүнээс зугтах явдалтай тэмцэх зорилгоор татварын хэлэлцээрийг Засгийн газар хооронд хамтран хэрэгжүүлж эхэлсэн. Гэвч цаг хугацаа улиран өнгөрч, хөгжлийн шинэ үе шатанд очих тусам гэрээний үйлчлэл сулран нэмэлт арга зүйн эх сурвалжийг шаардах болжээ.
2. Давхар татварын гэрээтэй холбоотойгоор хяналтад байдаг гадаадын компаниудын дүрэм, үнэ шилжилт, татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм зэргээр олон улсын эрх зүйн нэмэлт актыг батлан тухайн улс дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн дагаж мөрдүүлэх болсон.
3. Монгол Улс бусад улсын Засгийн газартай татварын хэлэлцээрийг сүүлийн 20 гаруй жил хамтран хэрэгжүүлж байгаа хэдий ч дотоодын татварын хууль зөрчсөн хэм хэмжээнүүд үүссээр байна. Иймд цаашид бизнесийн орчны шинэчлэлтэй холбоотой тус хэлэлцээрийн заалтыг засаж сайжруулах боломж нээлттэй хэвээр л байна.
4. Давхар татварын гэрээний хэрэгжилтийн үйл ажиллагаанд төрийн байгууллага, судалгааны төвүүдээс хийх судалгаа шинжилгээг дэмжиж хөгжүүлэхгүй бол одоогийн байдлаар хэлэлцээрийн үйл явцын зохицуулалт тийм ч хангалттай бус байна. Цаашилбал, татварын хэлэлцээр болон дотоодын хуулийн хэм хэмжээний уялдаа холбооны хэрэгжилтэд хийх судалгаа, шинжилгээ, түүнд хяналт тавих шаардлага үгүйлэгдсээр байгааг анхаарах нь зүйтэй юм.

¹⁴<https://www.google.com/search?client=opera&q=General+Anti-Avoidance+Rule+countreis+list&sourceid=opera&ie=UTF-8&oe=UTF-8>.

¹⁵ Susi Baerentzen, The Effectiveness of General Anti-Avoidance Rules. 2022

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх****Хууль тогтоомж**

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Монгол Улсын Татварын ерөнхий хууль, 2019.
3. Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006.
4. Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, 2006.
5. Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, 2017.
6. Монгол Улсаас гадаад улстай байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр”-ийн харилцан тохирох ажиллагааг хэрэгжүүлэх журам, 2013.
7. Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, гадаад улс хоорондын хэлэлцээрийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийг хянах, төлөлтийг баталгаажуулах, бүртгэх тухай зөвлөмж, 2009.
8. Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Нидерландын Вант Улс хоорондын конвенц, 2002.
9. Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улс, Кувейт Улс хоорондын хэлэлцээр, 1998.
10. “Зөрчил бүхий татвар төлөгчийн талаар нийтэд мэдээлэх журам”, 2009.
11. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын Татварын конвенцийн үлгэрчилсэн загварын заалтуудыг хэрэгжүүлэх зөвлөмж, 2002.
12. “Харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдийн хооронд хийгдэж байгаа борлуулалтад бодит бус үнэ хэрэглэж болзошгүй дотоодын бараа, ажил, үйлчилгээний төрөл, зах зээлийн үнийн мэдээллийн эх сурвалжийн жагсаалт”, 2007.

Ном, сурах бичиг, судалгааны тайлан

13. Т.Мэндсайхан, Олон улсын татварын эрх зүй /сургалтын гарын авлага/, УБ, 2009.
14. Монгол Улсын Татварын эрх зүй, ТЕГ, МУИС-ийн ХЗС, ШУАФСЭЗХ, УБ, 2009.
15. Г.Алтанзаяа, Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм гэж юу вэ? (GAAR), УБ, 2020.

Гадаад хэл дээрх**Ном, сурах бичиг, судалгааны тайлан**

1. Raymond R.N., Clifford M. Hicks. Income Tax influences on Legal Forms on Organizations for Small Business. L.,1990.
2. Waerzeggers, Christophe and Cory Hillier, 2016, “Introducing a general anti-avoidance rule (GAAR)—Ensuring that a GAAR achieves its purpose,” Tax Law IMF Technical Note 2016/1.
3. Susi Baerentzen, The Effectiveness of General Anti-Avoidance Rules, 2022.

Цахим эх сурвалж

4. <https://www.moore-mongolia.mn/үйлчилгээ/зөвлөх-үйлчилгээ/үнэ-шилжилт>.
5. <https://www.google.com/search?client=opera&q=General+Anti-Avoidance+Rule+countreis+list&sourceid=opera&ie=UTF-8&oe=UTF-8>.

TAX ANTI-AVOIDANCE RULES AND PROCEDURES

Chuluuntsetseg.O

Senior Lecturer at School of Law, NUM

Rentsendorj.S

Senior Lecturer at Business School, NUM

ABSTRACT:

Countries have started to incorporate international legal norms into their domestic legislation. As a result, many important measures such as improving the implementation of laws, developing international cooperation, implementing international legal norms between governments, solving controversial issues through mutual information exchange, and monitoring the activities of multinational companies have been regulated by unified norms.

One of these measures is to stop and prevent tax evasion, regulate related issues according to international legal norms and, if necessary, incorporate them into domestic legal norms.

We intend to briefly consider how the concept of tax evasion measures is implemented in our country, what legal regulations are used and how it affects the implementation of double taxation agreements.

KEYWORDS:

Tax planning, audits, tax avoidance, rules, double tax treaties, tax legislation, transfer pricing.

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ ДАХЬ ТАЛУУДЫН ХҮСЭЛТ, ҮР ДАГАВАР



Б.Замбага

*ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, ахмад*

ТОВЧЛОЛ:

Шүүхээр баталгаажуулсан эрх, ашиг сонирхлыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг явуулдаг. Ийнхүү шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч нь эвлэрэх, төлбөр авагч нь төлбөр, шаардлагаасаа бүхэлд нь эсхүл зарим хэсгээс нь татгалзах, төлбөрийн шаардлагад эд хөрөнгө тооцуулах тохиолдол цөөнгүй гардаг. Талуудаас гаргасан хүсэлт, татгалзал, эвлэрлийг хүлээн авч шийдвэрлэх явцад шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын эсхүл шүүхийн шийдвэрээр эрх нь хамгаалагдаж байгаа тэтгүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх, талуудын хэн алинд нь төөрөгдөл үүсэх магадлал байдаг. Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудаас гаргасан хүсэлт, түүнд тавигдах шаардлагыг Иргэний хуульд тодорхойлсон хэлцэл, хэлцэлд тавигдах шаардлагад нийцүүлэн авч ашиглах шаардлагатай байгааг тодруулахыг зорилоо.

ТҮЛХҮҮР ҮГС:

Хүсэл зоригийн илэрхийлэл, шүүхийн шийдвэр, эрх зүйн хамгаалалт, баталгаат хүсэлт, хэлцлийн үндсэн шинж, дуусгавар болсныг сэргээх, хугацааг сэргээх.

ОРШИЛ

Хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаа нь дан ганц шүүхийн асуудал биш бөгөөд хууль зүйн олон эх сурвалжийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Эдгээрийн нэгэн илэрхийлэл нь Шүүх байгууллагаас хамгаалсан эрх, ашиг сонирхлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар дамжуулан хамгаалах тогтолцооны дагуу шийдвэр гүйцэтгэгч хуулиар олгогдсон эрх, үүрэг, дарааллыг үндэслэн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны журмаар шүүхээр баталгаажуулсан тэрхүү эрхийн хэрэгжилтийг хангаж ажилладаг. Үүнийг “Гайхалтай мэргэн шүүхийн шийдвэр гарлаа ч шийдвэр гүйцэтгэлээр дамжин түүний үр дүн нь баталгаажихгүй бол тэр нь ердөө хэрэгцээгүй цаас төдий” гэж Бүгд Найрамдах Солонгос Улсын дээд шүүхийн 16 дахь ерөнхий шүүгч Ким Мён Су /Kim Myeong-soo/ хэлсэн байдагтай санал нийлэхгүй байхын аргагүй юм.

Бид шүүхийн шийдвэр гүйцэтгэх олон талт ажиллагаанаас “Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа¹”-ны явц дахь талууд, оролцогчдын гаргасан санал, хүсэлт, тэдгээрт тавигдах хууль зүйн шаардлагын талаар судлан авч үзэхээр судалгааныхаа хүрээг хязгаарласан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явц дахь талуудын хүсэлт, түүний үр дагаврын талаар дагнан хийсэн судалгаа, нэг сэдэвт бүтээл байхгүй ч салбарын судлаач, эрдэмтэд өөрсдийн судалгааны ажлын агуулгад тусгасан байдгийг дурдах нь зүйтэй.

Ийнхүү шүүхээр баталгаажуулсан эрхийн хэрэгжилтийг хангах шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудын буюу төлбөр төлөгч, төлбөр авагч цаашлаад шийдвэр гүйцэтгэгч, гуравдагч этгээдийн зүгээс тухайн ажиллагаатай холбогдуулан санал, хүсэлт гаргах, зөвшөөрөл хүсэх эрх, үүргийг хэд хэдэн процесс ажиллагааны үед заавал хэрэгжүүлэхээр зааснаас гадна талууд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны аль ч үед эвлэрэх, төлбөр авагч шүүхийн шийдвэр, гүйцэтгэх баримт бичгээр хүлээн авахаар, гүйцэтгүүлэхээр заасан төлбөрийн шаардлагаасаа татгалзах эрх нь нээлттэй байхаар хуульчлан баталгаажуулсан байдаг. Иймд энэхүү хүсэлт, түүнд тавигдах шаардлагыг нягтлаагүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудын хэн алины эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, зарим төрлийн боломжийг тодруулах зорилгоор энэхүү сэдвийг сонгон судалсан.

*“Хүсэл зориг бол сэтгэхүйн хамгийн ойрын үнэн,
Хүсэл зориг бодит ахуйд өөрийгөө хувиргасан сэтгэхүй байдаг,
Сэтгэхүйгүй хүсэл зориг гэж үгүй”*

Г.В.Гегель²

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ ДАХЬ ТАЛУУДЫН ХҮСЭЛТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрлийг тусгахдаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн төрлөөр бус шийдвэрийн агуулга гүйцэтгэх ажиллагааны онцлог, төрлөөр нь хууль тогтоогч ангилан үзсэн. Энэ ч утгаараа иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах баримт бичгийг дараах байдлаар тодорхойлж, эх сурвалжийг нь бэхжүүлсэн.

Нэгдүгээрт: Иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр;

Хоёрдугаарт: Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж;

Гуравдугаарт: Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр;

Дөрөвдүгээрт: Шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр;

Тавдугаарт: Шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр;

Зургаадугаарт: Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж;

Долоодугаарт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг гаргуулах тухай

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017. 6.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах ажиллагаа хамаарна: 6.1.1.иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа /цаашид «иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа» гэх/.

² Х.Сэлэнгэ, Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ, 2009, 7 дахь тал.

ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр³ нь иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар гүйцэтгэх шийдвэр байхаар хуульчилсан.

Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нэг талаараа шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл болохын хувьд шүүхээс гүйцэтгэх баримт бичиг бичигдэж ирсэн нөхцөлд тухайн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх үндэслэл бүрддэг бөгөөд энэ нь нэхэмжлэгчийн хүсэл зоригийн үндсэн дээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах эсэх нь шийдвэрлэгддэгээрээ онцлогтой.

Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай⁴ хуулийн 183 дугаар зүйлийн 183.1 дэх заалтад “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл шүүхийн шийдвэр болон шүүхээр баталгаажуулсан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, эвлэрийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт, тэдгээрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна”, мөн хуулийн 186 дугаар зүйлийн 186.1 дэх заалтад “Дараах тохиолдолд шүүхийн шийдвэр болон гүйцэтгэх хуудсыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шууд олгож болно” гээд 186.1.1 төлбөрийг улсын төсвийн орлогод оруулах шийдвэр, 186.1.2 төлбөр төлөгч, төлбөр авагчийн аль нэг нь өөр улс, аймаг, сум, дүүрэгт оршин суудаг бол төлбөр авагчийн хүсэлтээр, 186.1.3 бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх, 186.1.4 төлбөр авагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлт гаргасан бол шүүхийн шийдвэр, гүйцэтгэх баримт бичгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шууд хүргүүлж, албадан гүйцэтгүүлэхээр заасан. Дээр дурдсанаас бусад эдийн болон эдийн бус шаардлагыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болсон бол хүсэлтийг үндэслэн төлбөр авагчид гардуулж, төлбөр авагч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар дамжуулан гүйцэтгүүлэх эсэхээ шийдвэрлэх боломжийг нээлттэй үлдээсэн байдаг.

Өөрөөр хэлбэл иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэрт хамаарах агуулга бүхий шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсыг шүүхээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шууд олгоогүй нөхцөлд гүйцэтгэх хуудаст төлбөр авагчаар заагдсан хүн, хуулийн этгээдэд баримт бичгийг гардуулан өгч, төлбөр авагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлтэй бол тухайн хүсэлтээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад уламжлан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах үндэслэл бүрддэг. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчөөр заагдсан этгээд сайн дураар биелүүлээгүй нөхцөлд төлбөр авагч албадан гүйцэтгүүлэх хүсэлтээ хуульд заасан тодорхой хугацааны дотор⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад гаргаж албадан гүйцэтгүүлэх боломжтой байхаар зохицуулсан.

Хүн, хуулийн этгээдийн шүүхээр баталгаажуулсан эрх, ашиг, сонирхлыг хамгаалах иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэхдээ шүүх байгууллагын шийдвэрийн үндсэн дээр болон төлбөр авагчийн хүсэлтийн үндсэн дээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх үндэслэлийг тусгаж өгсөн. Ийнхүү шийдвэр

³ Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал нөхөн төлүүлэх тухай шийдвэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтад хамаарна гэж нэрлэн тусгаагүй ч мөн хуулийн 19 дүгээр зүйлд “19.1. Гүйцэтгэх баримт бичигт энэ хуулийн 6.2.1, 6.2.2, 6.2.3, 6.2.4-т заасан шийдвэрийг үндэслэн олгосон гүйцэтгэх хуудас, энэ хуулийн 6.2.5, 6.2.6-д заасан шийдвэр болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг гаргуулах тухай шийдвэр хамаарна” гэж хуульчилсан байдаг тул энэхүү жагсаалтад тусгаж өгсөн болно.

⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.

⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт “Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь хугацаа өнгөрсөн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй: 18.1.1. энэ хуулийн 6.2.1, 6.2.2-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 4 жил, 18.1.2. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.2.3-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил, 18.1.3. энэ хуулийн 6.2.4, 6.2.5-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил, 18.1.4. энэ хуулийн 6.2.6-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 2 жил” байхаар хуульчилсан.

гүйцэтгэх ажиллагааг үүсгэх үндэслэлийг нэг талаасаа төлбөр авагчид эрх олгож, нөгөө талаасаа шүүхээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад заавал хүргүүлэхээр үүрэгжүүлэн заасан нь онолын үүднээс “Эрх нь хүмүүсээс сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх зан үйлийн боломж хэлбэрээр илэрдэг бол үүрэг нь хүмүүсээс зайлшгүй хийж гүйцэтгүүлэхээр хуульчлан тодорхойлсон зан үйл байна” гэж тайлбарласан судлаачдын тодорхойлолттой дүйж байна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүн, хуулийн этгээдийн хүсэлтийн үндсэн дээр эхлүүлж байгаа нь иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардалтай уялдаг учир төлбөр авагч (нэхэмжлэгч⁶)-ийн хүсэлтийн үндсэн дээр ажиллагааг эхлүүлэх шаардлага тавигддаг. Өөрөөр хэлбэл төлбөр авагч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлөх үүрэг хүлээж тухайн зардлаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддагтай холбоотой.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд буюу төлбөр төлөгч, төлбөр авагч нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад үүссэн нөхцөл байдал болон баримт бичгийн шийдвэрлэлтийн талаарх хүсэл зоригийг дараах агуулгын хүрээнд хуульчилсан байдаг.

1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад үүссэн асуудлаар санал, хүсэлт гаргах;
2. Шийдвэр гүйцэтгэгчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох;
4. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгахаас өмнө эвлэрэх;
5. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах хөрөнгийн талаар санал гаргах;
6. Төлбөрт гаргуулсан, хураан авсан хөрөнгийн үнэлгээний талаар санал гаргах;
7. Тодорхой үйлдэл хийлгэх эсхүл тодорхой үйлдэл хийлгэхгүй байхаас татгалзах;
8. Эд хөрөнгө, мөнгийг шилжүүлэх, өөрөө болон төлөөлөгчөөрөө дамжуулан хүлээн авах, хүлээлгэн өгөх;
9. Төлбөрийн шаардлагаас бүхэлд эсхүл хэсэгчлэн татгалзах;
10. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хойшлуулах талаар санал гаргах;
11. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явц, үр дүнгийн талаар өргөдөл, гомдол, санал гаргах гэх зэрэг агуулгын хүрээнд нийтлэг байдлаар хүсэл зоригоо илэрхийлдэг.

Тиймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний амьдралын янз бүрийн ашиг сонирхол, харилцан адилгүй хүсэл, хэрэгцээ элбэг тохиолдох учир эдгээр нь хоорондоо зөвшилцөх, тохиролцох, зөрчилдөх явдал цөөнгүй гардаг. Эдгээр хүсэл зоригийг шийдвэрлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч нарын хооронд үүссэн аливаа асуудлыг зохицуулахад талуудын хүсэл зориг буюу хүсэлтэд тавигдах хэлбэр, агуулгын шаардлагыг журамлах нь талуудын хэн алины цаг хугацаа, хөрөнгө санхүү, жам ёсны болон зүй ёсны эрхийг хангах, хамгаалах нэгэн боломж гэж харж байна. Учир нь хүсэлтэд тавигдах хэлбэрийн шаардлагыг хангаагүйгээс явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг, дуусгавар болгосон шийдвэрийг хүчингүй болгох тохиолдол цөөнгүй үүсдэг. Өөрөөр хэлбэл хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн аливаа ээдрээ, төвөгтэй асуудлыг эрх зүйн хамгаалалтыг тогтоох замаар тэдгээрийн эрх, үүргийг тэнцвэржүүлж, тухайн харилцаанд оролцогчдын хэн алины эрхийг хангах шаардлагатай. Учир нь эрх зүй нь хүмүүс хоорондын эрх, үүргийн тэнцвэрт байдлыг хангах, зохицуулах чиг үүрэгтэй ухагдахуун байдаг.

Иймд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, гүйцэтгэх баримт бичгийг албадан гүйцэтгэх болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явц, үр дүнд шууд нөлөөлөх үндэслэл

⁶ Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамжийг биелүүлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч нь төлбөр авагчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцдог.

болсон хүсэлтийн хэл зүйн болоод хууль зүйн утга, агуулгын талаарх ойлголтыг авч үзье.

Хэл зүйн үүднээс нь “хүсэлт” гэдгийг хүсэх, гуйх үйлийн үр дүнг заасан нэр, хүссэн гуйсан юм, хувийн хүсэлт, санал хүсэлт нь хувь хүний санаа бодол, хүсэж мөрөөдөх зүйл⁷ хэмээн тайлбарласан байна.

Тэгвэл “хүсэлт”-ийг хууль зүйн үүднээс нь:

Нэгдүгээрт: Өргөн утга санаагаараа холбогдох асуудлыг хянан шийдвэрлэх эрх мэдэл бүхий субъектэд төрийн байгууллага, иргэн, аж ахуй нэгж, хуулийн этгээдээс ирүүлсэн гуйлт;

Хоёрдугаарт: Хэрэг бүртгэх байгууллага, мөрдөгч, прокурор, шүүгч буюу шүүхэд хандан байцаан шийтгэх ажиллагааны үйлдэл хийлгэх талаар гаргасан гуйлт⁸ гэж тайлбарласан байна.

Ингэхдээ хүн, хуулийн этгээдийн хүсэлт нь гомдол, мэдэгдэл, өргөх бичиг, өргөдөл, санал хэлбэртэй байж болохоор тайлбарласан. Иймд эдгээрийг тайлбарласан хууль зүйн онолын тайлбарыг мөн адил дэлгэрүүлэн авч үзлээ.

“Гомдол” гэдгийг нэгдүгээрт: “Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт”, хоёрдугаарт: “Олон улсын эрх зүйд хүний эрхийг хамгаалахаар конвенцод тусгагдсан болон олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүлээсэн үүргээ төр зөрчсөн гэж үзэн хүний эрхийн комисс, шүүх зэрэг олон улсын байгууллагад хандан хувь хүн, бүлэг этгээд буюу эсхүл аливаа нэг улс бичгээр гаргасан албан ёсны хүсэлт”⁹;

“Мэдэгдэл” гэдгийг “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон иргэдээс гаргасан хүсэлт”¹⁰-ийг ойлгоно;

“Өргөх бичиг” гэдгийг “засаг төрийн дээд байгууллагад албан бичгийн хэлбэрээр гаргасан хамт олны хүсэлт. Гол төлөв ямар нэгэн хүсэлт, санаа санаачилга, тулган шаардлагыг агуулсан байна”¹¹;

“Өргөдөл” гэдгийг “Улс нийгмийн ач холбогдолтой асуудлаар төрийн байгууллага албан тушаалтанд хандан гаргасан хүсэлт. Өргөдөл нь хүсэлт, санал, мэдэгдэл, мэдээлэл, шаардлагын зэрэг шинжтэй байж болно”¹²;

“Санал” гэдгийг нэгдүгээрт: Үндсэн хуулийн эрх зүйд сонгогч саналаа өөрийн сонгох гэж байгаа парламентын гишүүн буюу төрийн сонгууль эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллагын албан тушаалд нэр дэвшигчид өгөх үйлдэл, төрийн хамтын байгууллага буюу нутгийн өөрийн удирдлагын байгууллагын хуралдааны үед өөрийн шийдвэрээ гаргах зорилго бүхий үйлдэл, аливаа байгууллагын буюу төрийн бус удирдах байгууллагын гишүүний шийдвэр гаргах үйлдэл, хоёрдугаарт: үндсэн хуулийн эрх зүйд төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлт, гуравдугаарт: шүүхэд тусгай журмын дагуу буюу зөвшөөрөл авч гаргасан хүсэлт, дөрөвдүгээрт: Парламентын чуулганд гишүүнээс гаргаж тавьсан хүсэлт”¹³ гэсэн утга, агуулгаар хэрэглэнэ гэж тус тус тайлбарласан байна.

Хэл зүйн болон хууль зүйн тайлбарыг нэгтгэн авч үзвэл иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явц дахь хүсэлт гэдгийг шүүхийн шийдвэрээр тогтоогдсон шаардлагыг албадан биелүүлэхийн тулд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага (ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, ерөнхий шийдвэр

⁷ Монгол хэлний их тайлбар толь (mongoltoli.mn)

⁸ С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, Уб, 2015, 578-579 дэх тал.

⁹ С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, Уб, 2015, 113 дахь тал.

¹⁰ С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, Уб, 2015, 269-270 дахь тал.

¹¹ С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, Уб, 2015, 340 дэх тал.

¹² С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, Уб, 2015, 340 дэх тал.

¹³ С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, Уб, 2015, 362 дахь тал.

гүйцэтгэгч)-д хүн, хуулийн этгээдийн зүгээс хандан гаргасан өргөдөл, гомдол, саналыг, нөгөө талаасаа шийдвэр гүйцэтгэгчийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, ерөнхий шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч, оролцогч бус хүн, хуулийн этгээдэд хандан гаргасан цаасан суурьтай мэдэгдэл, мэдэгдэх хуудсыг ойлгож болохоор байна. Цаасан суурьтай гэсний учир нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг дэх бусад баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэн авч үзэхийн тулд бичгийн хэлбэрт оруулсан байхыг шаарддаг бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явц, үр дүнг цаасан суурьтай баримтад тулгуурлан бэхжүүлж шийдвэр гүйцэтгэлийн хувийн хэрэгт хавсаргадаг. Шийдвэр гүйцэтгэлийн хувийн хэрэг нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, шүүхийн гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бэхжүүлсэн шийдвэр гүйцэтгэгчийн тэмдэглэл, гаргасан шийдвэр, акт, мэдэгдэл, мэдэгдэх хуудас, талуудын хувийн мэдээлэл, тухайн ажиллагаатай холбогдуулан талуудын болон гуравдагч этгээдийн зүгээс гаргасан хүсэлт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явц, үр дүнд шууд нөлөөлөхгүй боловч ач холбогдол бүхий мэдээллийг агуулсан бусад баримтаас бүрдэх бөгөөд баримтыг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан цаг, хугацааны дарааллыг үндэслэн хавсаргадаг¹⁴ онцлогтой.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн эх сурвалж болсон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль¹⁵ (2002)-г хэрэглэх, хууль хэрэглээний зөрүүг арилгахын тулд Монгол Улсын дээд шүүх бүрэн эрхийнхээ хүрээнд 2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор мөн хуулийн зарим зүйл заалтыг тайлбарласан байдаг¹⁶. Ингэхдээ бидний судалгааны ажлын объект болсон “хүсэлт”-ийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудаас гаргасан хүсэлт, шийдвэр гүйцэтгэгч, эрх бүхий албан тушаалтны зүгээс гаргасан хүсэлт гэсэн агуулгаар ангилан тавигдах шаардлагыг тодорхойлон дараах байдлаар тайлбарласан байна.

Нэгдүгээрт. Тогтоолын 3 дугаар зүйлд “Хуулийн 15 дугаар зүйлд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэлийн талаарх зохицуулалтыг дараах байдлаар тайлбарласугай гээд 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтад “Энэ зүйлийн 15.1.3¹⁷-т заасан “хүсэлт гарсан бол түүнийг дахин шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарах хүртэл” гэснийг хүсэлт гарсан тохиолдолд түүнийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн¹⁸ 181, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн¹⁹ 362 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх хүртэл гэж ойлгоно” гэж тайлбарласан. Энэ нь шинэчлэн найруулагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь хэсэгт заасан “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас гүйцэтгэх баримт бичгийн үндэслэл болох шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргасан бол түүнийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болтол” гэж заасантай адилтан үзэхээр байна;

Хоёрдугаарт. Тогтоолын 3 дугаар зүйлийн 3.5 дахь заалтад “Мөн зүйлийн 15.4²⁰-т заасан “мэдэгдэх” гэдэгт шийдвэр гүйцэтгэгч нь энэ хуулийн 15.1, 15.2-т заасан үндэслэл илэрсэн талаар бичгийн хэлбэртэй албан ёсны мэдэгдлийг шүүхэд, эсхүл ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргасан байхыг ойлгоно” гэж тайлбарласан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн (шинэчилсэн найруулга) 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтад заасан

¹⁴ Б.Замбага, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг талуудын эрхийг хангах нотлох баримт болох нь. //Human right and forensic science, Online international scientific conference, 2022 №1, 304 дэх тал.

¹⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002.

¹⁶ Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, УБ, 2007. №43.

¹⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002, 15.1.3 дахь заалт “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гарсан бол түүнийг дахин шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарах хүртэл”.

¹⁸ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.

¹⁹ Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 2002.

²⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002, 15.4 дэх заалт “Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 15.1,15.2-т заасан үндэслэл илэрсэн өдрөөс хойш 3 хоногийн дотор шүүхэд, эсхүл ахлах шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх ба эрх бүхий этгээд түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулна”.

“Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 27.1.1-д заасан үндэслэл илэрсэн бол шүүхэд, 27.2-т заасан үндэслэл илэрсэн бол ахлах шийдвэр гүйцэтгэгчид ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх бөгөөд эрх бүхий албан тушаалтан түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулна” гэсэн зохицуулалтын агуулгыг илэрхийлж байна;

Гуравдугаарт. Тогтоолын 4-т “Хуулийн 16 дугаар зүйлд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох зохицуулалтыг дараах байдлаар тайлбарласугай: Тогтоолын 4.1 дэх заалтад “Энэ зүйлийн 16.1.1²¹-д заасан “төлбөр авагч нь төлбөр авахаас татгалзвал”, мөн хуулийн 17.1.1-д заасан “төлбөр авагч хүсэлт гаргасан” гэдэгт гүйцэтгэх баримт бичигт заасан биелэгдээгүй төлбөрөөс, эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулахыг, түүнчлэн тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгасныг гүйцэтгүүлэхээс бүрэн хэмжээгээр татгалзана гэж ойлговол зохино” гэсэн нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн (шинэчилсэн найруулга) 29 дүгээр зүйлийн 29.1.2.төлбөр авагч төлбөр авахаас татгалзаж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасан гэсэн зохицуулалттай, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх хэсгийн тайлбар нь хуулийн (шинэчилсэн найруулга) 31 дүгээр зүйлийн 31.1.1.төлбөр авагч хүсэлт гаргасан гэж тайлбарласан хуулийн зохицуулалттай тохирч болохоор байна;

Дөрөвдүгээрт. Мөн заалтын «хүсэлт», энэ зүйлийн 16.1.3²²-т заасан “тодорхойлолт” гэдэгт төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгч иргэний хүсэл зоригоо бичгийн хэлбэрээр илэрхийлж, гарын үсгээр баталгаажуулсан баримт, төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгч хуулийн этгээдийг төлөөлөх бүрэн эрхтэй этгээдийн гарын үсэг, тамга, тэмдэг бүхий албан ёсны баримтыг тус тус ойлгоно гэж тайлбарласан. Энэ нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2, 29.1.4, 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх хэсгийн зохицуулалт дахь хүсэлтээр шүүхийн шийдвэр, гүйцэтгэх баримт бичигт явуулах баталгаажуулах арга хэмжээг дуусгавар болгох, ажиллагааг зогсоох үндэслэлийг зохицуулсан зохицуулалттай адилтан үзэж болохоор харагдаж байна.

Монгол Улсын дээд шүүх хүсэлт, тодорхойлолт гэдгийг тайлбарлахдаа төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгч иргэний хүсэл зоригоо бичгийн хэлбэрээр илэрхийлж, гарын үсгээр баталгаажуулсан баримт, төлбөр авагч, эсхүл төлбөр төлөгч хуулийн этгээдийг төлөөлөх бүрэн эрхтэй этгээдийн гарын үсэг, тамга, тэмдэг бүхий албан ёсны баримт гэж тайлбарласан нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын зүгээс хүсэл зоригоо бичгийн хэлбэрээр илэрхийлж, гарын үсгийг баталгаажуулсан байхыг шаардсан байна. Хуулийн этгээдийн тухайд эрх бүхий этгээдийн хүсэл зоригийг баталгаажуулах баримт нь гарын үсэг, түүнийг баталгаажуулсан тухайн хуулийн этгээдийн тамга, тэмдэг байна. Харин төлбөр авагч, төлбөр төлөгч иргэний (Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн) гаргасан хүсэлт нь бичгийн хэлбэртэй, түүндээ гарын үсэг зурж, гарын үсгээ баталгаажуулсан байхыг ойлгоно гэж тайлбарласан нь Нотариатын тухай хуульд²³ заасан нотариатчийн бүрэн эрхэд тодорхойлсон 4 дүгээр зүйлийн 4.4.3 дахь хэсэгт гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх, үүргийг тодорхойлсон бол 44 дүгээр зүйлийн 44.4 дэх заалтад заасан “үйлчлүүлэгч биеллэн ирж тухайн баримт бичиг болон нотариатын үйлдлийн бүртгэлд гарын үсгээ зуруулна” гэх байдлаар тухайн хүсэл зоригийн илэрхийллийг баталгаажуулсан байх шаардлагыг Монгол Улсын дээд шүүхээс тайлбарласан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргасан дээрх хууль зүйн болон агуулгын шаардлагыг хангаагүй хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэснээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хүчингүйд тооцогдох, нөгөө талаасаа шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд санаатай

²¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002, 16.1.1 дэх заалт “төлбөр авагч нь төлбөр авахаас татгалзвал түүний хүсэлтээр”.

²² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002, 16.1.3 дахь хэсэг “төлбөр төлөгч, төлбөр авагч хоорондоо эвлэрвэл тэдгээрийн гаргасан тодорхойлолтоор”.

²³ Нотариатын тухай хууль, 2011.

саад учруулах (удаашруулах) зорилгоор шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эцсийн үр дүнд шууд нөлөөлсөн хүсэлтийг гаргах нь элбэг байна. Үүнийг абстракт буюу хийсвэр жишээн дээр тайлбарлавал: Шийдвэр гүйцэтгэгч Ю нь төлбөр төлөгч А болон Б-нарын дуудан ирүүлж уулзах явцад талууд дараах хүсэлтийг гаргажээ. Төлбөр авагч А нь шүүхийн шийдвэр, гүйцэтгэх баримт бичгээр төлбөр төлөгч Б-ээс гаргуулан авахаар заасан 50,000,000.0 төгрөгөөс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар дамжуулан 40,000,000.0 төгрөгийг бэлэн мөнгөөр гаргуулан авч, үлдэгдэл 10,000,000.0 төгрөгт тооцон төлбөр төлөгчийн одоо унаж яваа түүний өмчлөлийн 00-00 УНУ улсын дугаартай, Aqua маркийн автомашиныг хүлээн авч Б-д холбогдох гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгохоор талууд тохиролцож, төлбөр авагч бичгээр хүсэлт гаргажээ. Дээрх хүсэлтийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч ахлах шийдвэр гүйцэтгэгчдээ хандан төлбөрийн шаардлага бүрэн хангагдсан тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон тухай тогтоол гарган өгөхийг хүссэн байна. Ахлах шийдвэр гүйцэтгэгч хүсэлтийн дагуу төлбөр төлөгчийн эд хөрөнгийн болон бусад эрхийг битүүмжилсэн эрхийг сэргээж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь хэсгийг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгож, тогтоолыг тухайн өдөр нь гардуулан өгсөн байна. Гэтэл төлбөр авагч А шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болгосны дараа 5 хоногийн дараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандан 10,000,000.0 төгрөгт тооцон авсан хөрөнгө нь бусдад барьцаалсан хөрөнгө байх тул тээврийн хэрэгслийг буцаан өгч, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон тогтоолыг хүчингүйд тооцуулж, үлдэгдэл төлбөрөө гаргуулан авах тухай хүсэлт гаргасан гэж төсөөлье.

Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч талуудын гаргасан хүсэлтийн үндсэн дээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон үйлдэл нь хууль зүйн дагуу хийгдсэн ажиллагаа гэж харж болох боловч дараах үндэслэлийн дагуу тогтоолыг хүчингүйд тооцогдоно.

Нэгдүгээрт: Гүйцэтгэх баримт бичгээр тодорхойлсон төлбөрийн шаардлагаас 10,000,000.0 төгрөгт тооцон хүлээн авсан гэх хөрөнгийн эрх шилжсэн эсэхийг баталгаажуулахгүйгээр дуусгавар болгосон нь төлбөр авагчийн эрхийг зөрчсөн;

Хоёрдугаарт: Төлбөр авагч хүсэлт гаргасантай холбогдуулан гүйцэтгэх баримт бичгийн шаардлагад тооцуулан өгөх эд хөрөнгийг үл маргах журмаар шилжүүлэх эсхүл шилжүүлсэн эсэх талаарх баримтыг төлбөр төлөгчөөс гаргуулан аваагүй, хөрөнгө шилжүүлээгүйгээс үүсэх эрх зүйн үр дагаврыг тайлбарлаагүй нь дүр эсгэн хийсэн хэлцлийг баталгаажуулсан ажиллагаа болсон;

Гуравдугаарт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар дамжин гүйцэтгэгдээгүй буюу дамжин шилжээгүй хөрөнгийг төлбөрт тооцон шилжүүлэх хугацаа олгоогүй, хүсэлтийн дагуу хөрөнгө шилжүүлэх ажиллагааг хийгээгүй нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэгт заасан “дур мэдэн, эсхүл хууль бусаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх” гэж заасны дагуу хууль бусаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоосон гэж үзнэ;

Дөрөвдүгээрт: Төлбөр авагч хүсэлт гаргасантай холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосноос үүссэн үр дагаврыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцахгүй байх талаар тайлбарлаагүй нь тогтоолыг ерөнхий шийдвэр гүйцэтгэгч хүчингүйд тооцох үндэслэл бүрдүүлнэ. Хэдийгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, төлбөр авагч оролцож, хүсэлтийг хамт гаргасан ч эрх бүхий этгээдээр буюу нотариатчаар баталгаажуулан хувийн хэрэгт хавсаргаж байх нь талуудын хүсэл зоригийн илэрхийлэл хууль ёсны болохыг баталгаажуулах арга байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэр, гүйцэтгэх баримт бичгээр тодорхойлоогүй, шийдвэр гүйцэтгэгч албадан гаруулаагүй хөрөнгийг төлбөрт тооцон өгөх, төлбөрт тооцох авах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түр хугацаагаар

хойшлуулах хүсэлтийг гаргах тохиолдол цөөгүй. Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удирдан зохион байгуулж байгаа шийдвэр гүйцэтгэгч талуудаас гаргасан хүсэлтийг хүлээн авч нэн даруй шийдвэрлэх үүрэгтэй ч эрхийн доголдолгүй хөрөнгийг бүрэн шилжүүлэн өгсний үндсэн дээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох нь зүйтэй. Дээрх жишээгээр л авч үзэхэд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх процесс ажиллагааны явцад талуудын хүсэл зоригийн илэрхийлэл нь хууль зүйн шаардлагыг хангаагүйгээс төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх, шийдвэр гүйцэтгэх албадан ажиллагааны дагуу битүүмжилсэн, барьцаалсан, хамгаалалт тогтоосон хөрөнгийн эрх сэргээгдэж бусдад шилжих, үрэгдэх нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд хүсэлтийг тайлбарласан хэл зүйн болон хууль зүйн тайлбар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хэрхэн ойлгож хэрэглэх хэрэглээний тайлбар, хийсвэр жишээ зэргийг нэгтгэн авч үзвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд, оролцогчдын зүгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үйл явц, үр дүнд нөлөөлөхөд чиглэсэн үйлдэл болон эс үйлдэхүйгээр илэрч буй хүсэл зоригийн илэрхийлэл гэж тайлбарлаж болох юм. Хэрэв ийнхүү тайлбарлах нь талуудын эрхийг хангах, хамгаалах хэрэгсэл болно гэж үзвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргаж буй хүсэлтийг Иргэний хуульд тодорхойлсон хэлцэл, түүнд тавигдах шаардлагын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хэлбэр, агуулгыг тодорхойлон хуульчлах нь талуудын эрхийг хангах, шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр, үйл ажиллагаа хууль ёсны байх шинжийг бүрэн хангана гэж үзлээ.

Бид өөрчлөгдөхгүйгээр юмс өөрчлөгддөггүй.

Гёте.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх процессыг хуульд тодорхойлон зааснаас бусад тохиолдолд төлбөр авагчийн хүсэл, зоригийн илэрхийллээр буюу хүсэлтийн үндсэн дээр эхлүүлж байна. Төлбөр авагчийн шүүхээр баталгаажуулсан эрхийг сайн дураар хэрэгжүүлэхгүй байгаагаас улбаалан хөндөгдсөн эрхээ хамгаалуулахаар, хүсэл зоригоо гүйцэтгүүлэхээр ханддаг. Үүнийг академич Ж.Амарсанаа “Бид ихэнх төлөв аргагүй тулгамдаж мухардсан үедээ л хуульд хандаж тусламж эрдэг. Гэтэл бидний өдөр тутмын амьдрал, үйл ажиллагааг анхааралтай ажиглавал тэр бүхэнд эрх зүй үйлчилж байгааг харах болно²⁴” гэж хэлсэн байдаг. Хуульд хандаж хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хянан шийдвэрлэх эрхийг Шүүх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлж, түүний биелэлтийг хангах, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үндсэн чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны журмаар гүйцэтгэдэг. Шийдвэр ажиллагааны зорилго нь хүний эрхийг сэргээн эдлүүлэх, хөндөгдөх явдлаас урьдчилан сэргийлэх байдаг. Энэ ч утгаараа хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаа талуудын хүсэлтийн үндсэн явагдахдаа шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч этгээдүүдийн хэн алины эрхийг зөрчих учиргүй.

Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч болон бусад этгээдийг төөрөгдөлд оруулахгүй, хууль хэрэглээний зөрүү гаргахгүйн тулд талуудаас гаргаж буй хүсэлтүүдийг хэлбэрийн хувьд бичгээр хийгдсэн, гарын үсэг зурж баталгаажуулсан, агуулгын хувьд шүүхийн шийдвэрийн болон гүйцэтгэх баримт бичгийн огноо, дугаар, төлбөрийн шаардлага, тухайн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ямар эрхийг эдэлж, үүргийг хүлээн оролцож байгаа, ямар төрлийн баталгаажуулах арга хэмжээг гүйцэтгүүлэх болон

²⁴ Ж.Амарсанаа, Эрх зүй-Нийгмийн харилцааг тохируулагч, УБ, 1988, 3 дахь тал.

гүйцэтгэсэн арга хэмжээтэй санал нийлэхгүй байгаа тухайгаа болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдуулан гаргаж байгаа санал, хүсэлтдээ тусгасан байх шаардлагыг хуульчлах нь зүйтэй гэж үзлээ. Хууль тогтоогч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талууд болон оролцогчоос гаргах хүсэлтэд хэлбэрийн болон агуулгын шаардлагыг тусгах шаардлагагүй гэж үзвэл эрх зүйт төрийн зарчмын дагуу хүн, хуулийн этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах, хуулийг зөв ойлгож, зөв хэрэгжүүлэх, шударга ёсонд нийцсэн практикийг тогтоох зорилгын үүднээс өнөөгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа эрх бүхий албан тушаалтны зүгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудаас гаргаж буй хүсэлтэд тавигдах нийтлэг шаардлагыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тохиолдолд үндэслэлийг тухайн хүн, хуулийн этгээдэд мэдэгдэх, уг ажиллагаатай холбогдон үүсэх эрх, үүргийг тайлбарлах, хүндэтгэлтэй харьцах, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй” гэж заасны дагуу практик үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын соёл, хүний эрхийн мэдрэмжийг нэмэгдүүлэх ажил болно гэж харж байна.

Нийгмийн болон технологийн хурдацтай хөгжилтэй уялдан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор энэ хуульд заасан ажиллагааг гүйцэтгэхэд цахим мэдээллийн сүлжээ ашиглаж болно” гэж заасны дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад талуудын гаргасан хүсэлтийг цахим хэлбэрээр баталгаажуулан авч болох боломжийг тусгаж өгсөн. Энэ нь Нотариатын тухай хуульд²⁵ тодорхойлсон цахим үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зохицуулалт, Цахим гарын үсгийн тухай²⁶ болон Улсын бүртгэлийн тухай хуульд тодорхойлсон цахим мэдээллийн сан дахь мэдээлэл цаасан эх хувьтай адил тооцогдох эрх зохицуулалттай уялдаж байна. Иймд эдгээр хууль зүйн боломжийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад түгээмэл ашиглах, алба хаагчдын хууль хэрэглээний ур чадварыг нэмэгдүүлэх үүднээс талуудаас гаргах хүсэлт, тэдгээрийн баталгаанд тавигдах шаардлагыг нэгтгэн зохицуулах үүднээс дараах саналыг дэвшүүллээ.

1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэх болон шийдвэр гүйцэтгэх тодорхой ажиллагааны явцад талуудаас гаргах хүсэлт нь “Шийдвэр гаргасан шүүхийн нэр, огноо, дугаар, шийдвэрийн агуулга, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ямар эрхийг эдэлж, үүргийг хүлээн оролцож байгаа, албадан биелүүлэх ажиллагааг хүлээн зөвшөөрч байгаа болон зөвшөөрөхгүй байгаа талаарх үндэслэл, албадан биелүүлэх ямар төрлийн ажиллагааг албадан гүйцэтгүүлэх хүсэлтэй байгаа” зэргийг тусгасан байх хууль зүйн шаардлагыг бүрдүүлэх;

2. Талуудын гаргасан хүсэлт нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эцсийн үр дүнд болон албадан биелүүлэх ажиллагааны үр дүнд шууд нөлөөлөхүйц хүсэлт бол гарын үсгийн баталгааг хийлгэсэн байх;

3. Хүсэлтийг цахим хэлбэрээр болон цаасан хэлбэрээр гаргасан байх зэрэг шаардлагыг хуульчлан бэхжүүлэх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа шуурхай байх, талуудад б олон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч нарт хүндрэл учруулахгүй байх, төрийн үйлчилгээг найдвартай, шуурхай хүргэх боломж бүрдэнэ гэж үзлээ. Эрх зүйт төрийн зарчмын дагуу хүн, хуулийн этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах, хуулийг зөв ойлгож, зөв хэрэгжүүлэх, шударга ёсонд нийцсэн практикийг тогтоох зорилгын үүднээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа эрх бүхий албан тушаалтны зүгээс дээрх саналыг үйл ажиллагаандаа баримтлах нь хүний эрхийг дээдэлсэн байгууллагын соёлыг түгээх чухал үзүүлэлт гэж үзэж санал дэвшүүлсэн болно.

²⁵ Нотариатын тухай хууль, 2011.

²⁶ Цахим гарын үсгийн тухай, 2022.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль тогтоомж:***

1. Монгол Улсын Үндсэн хууль.
2. Иргэний хууль, 2002.
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002.
4. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, 2002.
5. Нотариатын тухай хууль, 2011.
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017.
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002.
8. Цахим гарын үсгийн тухай, 2022.
9. Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, №43, 2007.

Ном, сурах бичиг, судалгааны тайлан

10. С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, УБ, 2015.
11. Ж.Амарсанаа, Эрх зүй-Нийгмийн харилцааг тохируулагч, УБ, 1988.
12. Х.Сэлэнгэ, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ, 2009.
13. Human right and forensic science, Online international scientific conference, 2022 №1.

Цахим эх сурвалж:

14. [Монгол хэлний их тайлбар толь /mongoltoli.mn/](http://mongoltoli.mn/).
15. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn).
16. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. /[ЦШГЕГ \(cd.gov.mn\)](http://цшгег.сд.гов.мн).

REQUESTS OF THE PARTIES IN THE DECISION EXECUTION PROCESS AND ITS CONSEQUENCES

Zambaga.B

*Lecturer at the Department of Civil Decision Execution
of the University of Internal Affairs, Captain*

ABSTRACT:

In order to fully implement the rights and interests confirmed by the courts, enforcement of the court decision is conducted. In the process of enforcement of the court decision, there are many cases where the payer and the payee conciliate, the payee refuses all or part of the payment and demands, and the property is counted against the payment requirements. In the process of receiving and resolving requests, refusals, and conciliations submitted by the parties, there is a possibility that the rights and legal interests of the parties to the enforcement proceedings or the grantee whose rights are protected by the court's decision may be violated, or confusion may arise for any of the parties. Therefore, this article was intended to clarify that requests made by the parties of the enforcement proceedings and requirements for their requests shall be used in accordance with the requirements for transactions defined in the Civil Code.

KEYWORDS:

Expression of will, court decision, legal protection, guarantee request, basic feature of transaction, recovery of termination, recovery time.

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ КАРТЕЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ: ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ШҮҮМЖ



Л.Отгонбаяр

*СЭЗИС-ийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш,
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант
(Эдинбургийн Их Сургуулийн магистр)*

ТОВЧЛОЛ:

Өрсөлдөөний эрх зүйн чухал сэдвүүдийн нэг болох картель хэмээх үзэгдлийг 2010 онд Монгол Улсын Өрсөлдөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д зохицуулах үед онол, үзэл баримтлалын мэтгэлцээн, хэлэлцүүлэг төдийлөн өрнөөгүй. Тэгвэл энэхүү өгүүлэл нь картелийн эрх зүйн зохицуулалтын тухай онолын сэтгэлгээний түүх, түүний талаарх үзэл баримтлал, хандлага, өрнөж буй мэтгэлцээнүүдийг тоймлон хөндсөн. Мөн Өрсөлдөөний тухай Монгол Улсын хууль дахь картелийн тодорхойлолтыг түүний үзэл баримтлал, онолын үндэслэл, дэлхий нийтэд өргөн хэрэглэгддэг өрсөлдөөний эрх зүйн онолын ойлголттой харьцуулж, санал, шүүмжээ уншигчдад танилцуулах зорилготой.

ТҮЛХҮҮР ҮГС:

Өрсөлдөөн, өрсөлдөөний эрх зүй, картелийн эрх зүй, картелийн сонгодог онол, картелийн орчин үеийн онол, картелийг гэмт хэрэгт тооцох, пүүсүүдийн хамтын ажиллагааны спектр, экспортын картель, дахин борлуулах үнийг тогтоох.

I. ОРШИЛ

Өрсөлдөөний эрх зүйн тулгуур ойлголтуудын нэг болох картелийг гагцхүү сөрөг үзэгдэл юм¹ гэсэн тогтсон ойлголт нэлээд түгээмэл. Манай Улсын Өрсөлдөөний тухай хууль, Зөрчлийн тухай хуулиуд картелийг энэ л ойлголтоор хуульчилж, хамгийн хүнд санкц бүхий зөрчилд тооцжээ.

Картель нь хувийн хэвшил зонхилсон зах зээлийн эдийн засаг бүхий аль ч улс оронд түгээмэл тохиолддог нийгмийн үзэгдэл болно. Тиймээс онолын хэсэгт картель хэмээх үзэгдэлд хандах дэлхий нийтийн онол, үзэл сэтгэлгээ, өрнөж буй мэтгэлцээнийг өгүүллийн эхний хэсэгт авч үзнэ. Картелийн тухай онолын сэтгэлгээ орчин үед аль нэг үзэл суртлаас ангид хөгжиж, картелийг эдийн засаг, нийгмийн үзэгдэл талаас нь судлах болж, түүний хүрэн дэх зүй тогтлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлах чиглэлээр хөгжиж байна. Тэрчлэн олон улсын байгууллагуудын зүгээс картелийг хэрхэн тодорхойлж байгаа, картелийн талаар Дэлхийн худалдааны байгууллагын хүрээнд улс орнууд ямар

¹ A.Ezrachi, Competition and Antitrust law. A Very Short Introduction, Oxford University Press, 2021, pp. 63-4.

хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлж байгааг тоймлон үзлээ.

Өгүүллийн хоёр дахь хэсэгт Монгол Улс дахь өрсөлдөөний эрх зүй, картелийн эрх зүйн зохицуулалтын үзэл баримтлалыг тодруулж, өрсөлдөөний тухай хуульд картелийг хуульчлан тодорхойлсон байдалд дүн шинжилгээ хийж, хууль зүйн алдаа, логик зөрчил байгаа тухайд судлаач өөрийн дүгнэлт, саналыг дэвшүүлсэн. Ингэхдээ нэгэнт манай улсын Өрсөлдөөний тухай хуульд картелийг тодорхойлохдоо алдаа гарсан гэж дүгнэж байгаа тул аль нэг улсын эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжтой нарийвчлан харьцуулахаас илүүтэй картель үзэгдлийг тодорхойлж буй олон улсын эрдэмтдийн ном, сурах бичигт авч үздэг онолын нийтлэг ойлголт, тодорхойлолттой харьцуулан авч үзэхийг зорьсон.

Энэхүү өгүүллээр картелийн эрх зүйн тухайд төдийгүй ерөөс өрсөлдөөний эрх зүйн нарийн төвөгтэй асуудал болох хувийн эрх зүйн хамгаалалт, хөшүүрэг, тэрчлэн эрүүгийн эрх зүйн үр дагавартай холбоотой асуудлыг авч үзээгүй бөгөөд судлаач энэ чиглэлээр тусгайлан судалгааны ажил гүйцэтгэж уншигчдад толилуулахаар төлөвлөж байна.

II. КАРТЕЛИЙН ТУХАЙ ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, МЭТГЭЛЦЭЭН

2.1. Картелийн ойлголт, нэрт томъёо, олон улсын олон талт баримт бичигт тусгагдсан нь

Оксфордын хууль зүйн толь бичигт: “(1) Үндэсний болон олон улсын хэмжээнд бие даасан аж ахуй эрхлэгчдийн тодорхой салбарт монополь бий болгохын тулд нэгдсэн холбоо. Картельд ихэвчлэн бизнесүүд харилцан өрсөлдөхгүй байхыг нууцаар, аман хэлбэрээр, ихэнхдээ албан бусаар хэлэлцэн тохирох явдал ордог. Картелийн гишүүд гол төлөв өөрсдийн үнэ, гарцын хэмжээ, хямдрал, зээлийн хугацаа, хэрэглэгчид, нийлүүлэлт хийх орон зай, тендерийн ялагчийг тохиролцсон байж болно. (2) Дайтаж байгаа талуудын хооронд үл дайсагнах хэлцэл хийх эсхүл хоригдол солилцох тухай хэлэлцээр” гэж тодорхойлжээ.²

Анх олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөхүйц картелийн тодорхойлолтыг НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас 1980 онд “Бизнесийг хязгаарлах сөрөг практикуудыг хянан зохицуулах олон талын хүлээн зөвшөөрсөн тэгш байдлын багц зарчмууд”³ хэмээх баримт бичигт нийтэлж дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- a) Үнэ (үүнд экспорт болон импортыг мөн хамааруулна)-ийг үгсэн тохиролцох
- b) Тендерийн хуйвалдаан
- c) Зах зээлээр эсвэл хэрэглэгчээр нь хувааж авах тохиролцоо хийх
- d) Үйлдвэрлэл, худалдаанд квот тогтоон хувааж авах.

Тус байгууллага 2010 онд өрсөлдөөний загвар хууль болон түүний тайлбарыг боловсруулж нийтэлсэн. Өрсөлдөөний загвар хуулийн тайлбарын “зарчмын хориглолтууд” гэсэн хэсэгт дээр иш татсан 4 заалт бүхий тодорхойлолтыг хэрэглэсэн байдаг бөгөөд энэ нь ямар нэгэн зорилго, гарах нөлөөг харгалзах шаардлагагүй гэсэн утгыг илэрхийлсэн гэлтэй.

Харин Эдийн Засгийн Хөгжил, Хамтын Ажиллагааны Байгууллага (OECD) 1998 онд Картельтэй үр дүнтэй тэмцэх тухай зөвлөмжийг боловсруулж нийтэлсэн байдаг. Энэ зөвлөмжийн тэргүүн бүлэгт багтсан тодорхойлолтыг өрсөлдөөний эрх зүйн дагнасан судлаачид ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмээн үнэлээд байна.⁴ Энэхүү тодорхойлолт нь:

“a) Хүнд хэлбэрийн картель (hardcore cartel) гэж өрсөлдөгчдийн хооронд үнийг үгсэн тогтоох, тендерийн нууцаар тохиролцох, зах зээлийг хэрэглэгч, нийлүүлэгч, нутаг дэвсгэр, борлуулалтын сувгаар тус тус хуваахад чиглэсэн өрсөлдөөнд харш тохиролцоо, зохион байгуулалттай арга хэмжээ, өрсөлдөөнд харш зохион байгуулалтыг ойлгоно.”

² A Dictionary of Law. Ed. Law, Jonathan.: Oxford University Press, 2009. pp.79-80

³ ‘The set of multilaterally agreed equitable principles for the control of -restrictive business practices’, UNCTAD 1980.

⁴ Eleanor M. Fox, Daniel A. Crane ‘Global Issues in Antitrust and Competition Law’, Second Edition, 2017. p.8.

б) Картельд дараах зүйлсийг хамааруулахгүй: (i) өртгийг бууруулахтай эсхүл гарцын үр өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой хууль ёсны зорилго агуулсан, (ii) гишүүн улс өөрийн дотоодын хууль тогтоомжоор шууд болон шууд бусаар үл хамааруулахаар онцгойлон заасан, эсхүл (iii) тэдгээр хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн тохиролцоо, зохион байгуулалттай арга хэмжээ, зохион байгуулалт.”

Картелийн үүсэл хөгжлийн зүй тогтол, эдийн засаг, нийгэмд гүйцэтгэх үүрэг, үр дагаврыг хэрхэн тодорхойлж байгаагаас шалтгаалан энэхүү үзэгдлийн эрх зүйн зохицуулалтын чиглэл нь зөвшөөрөх эсхүл хориглох зэргээр харилцан адилгүй байж ирсэн байна.

2.2. Онолын сэтгэлгээний тойм

Фрайбургийн их сургуулийн эрх зүй ба эдийн засгийн профессор Р.Лифманны картелийн сонгодог онол⁵, Чикагогийн их сургуульд эрх зүй ба эдийн засаг гэсэн чиглэлийн суурийг тавьсан профессор Ж.Стокинг болон Ж.Стиглер зэрэг картелийн орчин үеийн онолын төлөөлөгчид энэхүү үзэгдлийг судалж, шинжлэх ухааны мэдлэгийн системийг түүчээлэн хөгжүүлжээ.

2.2.1. Картелийн сонгодог онол

Картелийн сонгодог онол буюу картелийн талаарх шинжлэх ухааны үндэстэй анхны мэдлэгийн систем нь 1930-аад оныг хүртэлх АНУ, Европын эдийн засагт өрнөсөн үзэгдлүүдэд хийсэн эмпирик ажиглалтанд тулгуурлан хөгжиж эхэлсэн. Эдийн засгийн хүндрэлтэй мөчлөгт салбарын өрсөлдөгч нар хямралаас зайлсхийх, тогтвортой байдлаа хадгалах, эрсдэлийг сайтар зохион байгуулалттайгаар удирдлага, хяналттай даван туулахын тулд төрийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй зүй ёсны арга хэмжээ хэмээн картелийн сонгодог онолын төлөөлөгч Р.Лифманн үзсэн.

Картелийн мандан бадралын үе гэж хэлж болох энэ цаг хугацаанд картелиуд олон нийтэд ил тод байж, томоохон аж үйлдвэрийн салбарын картелиуд удирдлагын төв хэмээх сүрлэг сайхан ордон хүртэл сүндэрлүүлж, түүнд нь картелийн захиргаа, бүртгэл мэдээлэл, хяналт-мониторингийн аппарат ажиллаж, тогтмол хуралддаг гишүүдийн чуулгантай байв. Картелиуд төртэй онцгой харилцаатай байсан бөгөөд картель гэрээ нь хууль ёсны бөгөөд хүчин төгөлдөр хэрэгжинэ. Гэвч картель нь төрийн санаачилгатай гэхээс илүүтэйгээр зах зээлд аяндаа бий болдог зохицуулалтын хэрэгсэл гэж ойлгогдож байсан гэж үзэж болно. Сүүлийн үеийн судлаачид картелийн сонгодог онол 1930-аад оны эдийн засгийн хямралыг давахад тухайн үеийн Германд үүргээ гүйцэтгэсэн түүхэн ач холбогдолтой онол гэдгийг хүлээн зөвшөөрөх болжээ⁶.

2.2.2. Картелийн орчин үеийн онол

Картелийн орчин үеийн онолын гол онцлог нь улс төрийн либераль үзэл баримтлал, неокласстик эдийн засгийн онолд суурилж, Чикагогийн их сургуулийн манлайллаар шинжлэх ухаанд жинтэй хувь нэмэр оруулан дэлхий дахинаа нөлөөтэй болсон. Тус онолын төлөөлөгч Ж.Стокинг⁷, Ж.Стиглер⁸ нар картелийн сонгодог онол гэж байхгүй гэсэн үгүйсгэлээс картель хэмээх үзэгдэл нь тогтвортой үр нөлөөтэй байх боломжгүй, түүний хор уршиг ямар их болохыг орчин үеийн математикжсан эдийн засгийн судалгаа шинжилгээ, арга зүйн тусламжтайгаар олон талаас нь эрс буруушааж ирэв.

⁵ Robert Liefmann, *Cartels, Concerns and Trusts* (1932, first edition) Batoche Books Kitchener, 2001.

⁶ H.A.Leonhardt: *The Development of Cartel 28 + Theory between 1883 and the 1930s*, pp.78-9.

⁷ Stocking G.W. and M.W. Watkins, *Cartels or Competition? The Economics of International Controls by Business and Government*, New York: The Twentieth Century Fund, 1948.

⁸ G.J.Stigler, 'A Theory of Oligopoly', *Journal of Political Economy*, Vol. 72, 1964, pp.44-61; reprinted in his *The Organization of Industry*, University of Chicago Press, 1968.

Энэхүү онол ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, эрх зүйт ёс, хүмүүнлэг нийгмийн суурь үзэл санаа бэхжээгүй улс оронд хэт зохион байгуулагдсан картель систем нь дарангуйллын тогтолцоог дэмжиж дэлгэрүүлэх эдийн засгийн хөрс суурь болно гэсэн үзэл сурталд тулгуурлана. Картелийн орчин үеийн онол 1945 оноос хойш АНУ, Европын болон тэдэнтэй нэгдмэл үнэт зүйл бүхий “барууны” улс орнуудад эрх зүйн зохицуулалтын тулгуур үзэл баримтлал болж ирсэн. Картель байгуулах нь нэгэнт эрх зүйн зөрчил болсон тул практикт энэ төрлийн хууль бус үйл ажиллагаа нууц далд хэлбэрт шилжсэн ба байгууллага хэлбэртэй гэхээс илүү үгсэл тохиролцоо, тэр бүү хэл “эрчүүдийн тохиролцоо”, “сарны явдлаар баримжаалан үнийн өсөлт ба тендерийн ялагчийг тодорхойлох” хүртэл байж болох бүхий л далд хэлбэрээр орших болсон билээ.

2.2.3. Картелийг гэмт хэрэгт тооцох олон улсын зохицуулалтын хөдөлгөөн

Энэхүү хөдөлгөөн үзэл суртлын хувьд картелийн орчин үеийн онолд суурилдаг. Картелийг гэмт хэрэгт тооцох олон улсын хөдөлгөөн 1998 оноос эхлэн Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага (OECD), Өрсөлдөөний олон улсын сүлжээ (ICN)-ний бодлогын дагнасан хэлэлцүүлгийн механизм, олон удаагийн судалгааны тайлан, нийтлэлээр өргөжин тэлж ирсэн гэж судлаачид үздэг.⁹

Картелийг эрүүгийн хариуцлагатай болгон хуульчилсан улс орнуудыг АНУ түүчээлсэн. Тус улсын Дээд шүүхийн шийдвэрлэсэн алдарт *US vs Socony Vacuum* хэрэгт шүүхээс дүгнэхдээ “картель нүүрээ харуулсан л бол хууль бус” буюу *per se illegal* зарчмыг тогтоожээ.¹⁰

Оксфордын их сургуулийн хэвлэлийн газраас холбогдох чиглэлээр тэргүүлэх эрдэмтдийн нэгтгэн дүгнэснээр хүргэдэг хүн төрөлхтний мэдлэгийн дээж бүхий “Маш товч танилцуулга” нэртэй цувралыг эрхлэн гаргадаг. Эл цувралын өрсөлдөөний эрх зүйн тухай бүтээлийн зохиогч, тус сургуулийн судлаач А.Эзраки, бодлого боловсруулагч нар картелийг бүхэлдээ сөрөг үр дагавартай тул орчин цагийн эдийн засгийн хорт хавдар хэмээн зүйрлэн үздэг тул эрх зүйд картелийг хоёрдмол утгагүйгээр хориглож хамгийн хүнд хариуцлагыг хуульчилж, хууль сахиулагчид илрүүлэх ажлыг тэргүүн зэргийн зорилгоо болгодог хэмээн бичжээ.¹¹

Судлаачийн зүгээс картелийг гэмт хэрэгт тооцох олон улсын зохицуулалтын хөдөлгөөний эерэг ба сөрөг тал, хөдөлгөөнд нэгдсэн нэгдсэн ИБУИНХУ, ХБНГУ, Австрали, Канад, Ирланд болон Европын холбооны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, картелийг эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцон хуульчилснаар эдийн засагт картель, үгсэн хуйвалдах явдлыг үнэхээр бууруулж, саармагжуулж чадаж байгаа эсэхийг шүүмжлэлтэйгээр авч үзжээ.¹²

Энэхүү хөдөлгөөний хүрээнд эргэлзээ үүсгэх мэтгэлцээн дагуулж байгаа сэдвүүдэд картелийг гэмт хэрэгт тооцоо гэхэд эрүүгийн хариуцлагыг уг үйлдлийг зохион байгуулж үйлдсэн хувь хүнд хүлээлгэх үү, эсхүл хуулийн этгээдэд үү зэрэг асуудал орно. Ялангуяа жижиг эдийн засагтай, цөөн өрсөлдөгчтэй зах зээлд эрүүгийн хариуцлагын хэмжээний өндөр торгох санц нь өрсөлдөгчдийг дампуурахад хүргэх, ингэснээр өрсөлдөөнөөс шууд аль нэг өрсөлдөгчийг гаргах, улмаар монополь бий болгох, зах зээлийн төвлөрлийг шууд ихэсгэх үр дагавартай тул хууль зүйн бодлогын зөв шийдэл биш гэж үзэж байна.

⁹ Beaton-Wells, C., & Ezrachi, A. *Criminalizing cartels: Critical Studies of an International Regulatory Movement*, Hart Publishing, 2011, pp.3-23.

¹⁰ Fox, E., & Crane, D. *Global issues in antitrust and competition law*. West Academic, 2017, p.6.

¹¹ A.Ezrachi, *Competition and Antitrust law. A Very Short Introduction*, Oxford University Press, 2021, pp.63-4.

¹² Beaton-Wells, C., & Ezrachi, A. *Criminalizing cartels: Critical Studies of an International Regulatory Movement*, Hart Publishing, 2011, pp.3-23.

2.2.4. Шинэлэг хандлага

Картелийн талаарх өнөөдрийг хүртэлх ойлголтуудад үнэлэлт, дүгнэлт өгч картелийн талаарх хандлагаа шинээр эргэцүүлэх шаардлагатай гэж Харвардын их сургуулийн судлаач Ж.Фийр үзсэн. Тэрбээр энэ санаагаа нотлохын тулд картелийн орчин үеийн онолыг үгүйсгэсэн эмпирик судалгаануудыг эш татан өмнөх бүхий л тогтсон ойлголтууд нь няцаагдаж байгаа¹³ учир картелийн тухай илүү баялаг харьцуулсан судалгаа, хандлага хэрэгтэй байгааг тэрбээр онцлоод, чингэхдээ улс төр, улс төрийн соёл, улс үндэснийхээ зорилтуудад аялдан үйлчлэгч эрх зүйтэй уялдаа холбоотой авч үзэх нь зүйтэй гэж мэтгэсэн. Түүнийхээр ширүүн өрсөлдөөн бүхий энэ ертөнцөд картелиуд байж болох тохиромжтой хоёр дахь шилдэг стратегийг ямагт санал болгодог мөн чанартай. Картель бидэнд капитализмын нөхцөл дэх зогсолт ба хурд, өсөлт ба уналтын эдийн засгийн өртөг хийгээд тэнцвэр, тэрчлэн бодит тогтвортой байдал ба эрсдэлийн менежментийн ашиг тус, үнэ ба чанар, хэрэглэгч ба үйлдвэрлэгч талуудын тэнцвэртэй харилцааг зааж өгдөг. Картель нь хамтын ажиллагаа хэрхэн инновацлаг бөгөөд үр ашигтай байж болох талаар төсөөлөх боломжийг ч олгодог гэж үзсэн.¹⁴

Картелиг эдийн засгийн амьдралд оршин байдаг үзэгдлийнх нь хувьд ойлгоход Ж.Фийрийн боловсруулсан пүүсүүдийн хамтын ажиллагааны спектр хэмээх дүрслэл ач холбогдолтой. Тэрбээр пүүсүүдийн үгсэх, эсхүл хоршиж нягтрах шинжтэй үзэгдлүүдийг зорилго, чиг үүрэг, эрх зүйн зохицуулалтаар нь төрөлжүүлж бүдүүвчээр харьцуулсан. Үүнээс харахад пүүсүүдийн хамтын ажиллагаа бүхэн картель биш боловч энэ хүрээнд бий болдог картельтэй зэрэгцээ үзэгдлүүд байгааг мөн ажиглаж болно. Аж ахуй эрхлэгчдийн хамтын ажиллагаа нь энгийн анхдагч зах зээл дэх аж ахуй эрхлэгчдийн эвсэл, холбооны яриа хэлэлцээнээс эхлээд, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, стандартыг жигдлэх гэсэн санаачилга, тэрчлэн зах зээл дэх үйлдвэрлэл, худалдаа, борлуулалтын гол урсгалд байрлаж үгсэл хуйвалдаан, үнэ, нийлүүлэлт, хуваарилалтанд “тоглолт” хийдэг картель, цаашилбал олон улсын хэмжээнд бүрэн нягтарсан, түүхий эд, олон улсын худалдааг “зохицуулах” шатлан захирах тогтоц (hierarchies) хүртэлх өргөн цар хүрээтэй ойлголт болохыг харуулжээ.

Ж.Фийрийн дүрслэн харуулсан пүүсүүдийн хамтын ажиллагааны түвшин бүхэнд өөр өөр картелиуд агуулагдана. Пүүсүүдийн хамтын ажиллагааг зорилгоор нь “процедурын”, “гол төвд тоглох”, “үйлдвэржилт ба нийгмийн бодлогын” гэсэн гурван төрөлд ангилсан байна.

Процедурын зорилготой хамтын ажиллагаа гэдэгт цар хүрээний хувьд хязгаарлагдмал буюу үндэсний хэмжээний бөгөөд үйлдвэрлэл, худалдаанд байгаль орчны болон чанарын стандартын шаардлага тавих, эсхүл патентад нэгдэх гэсэн пүүсүүдийн хамтын ажиллагаа орно. Энэ хүрээний картель нь цар хүрээгээр үндэсний зах зээлийг хамрах бөгөөд үйлдвэрлэл, борлуулалтыг үр ашигтай байлгах процессын нийтлэг зорилго агуулж, өөрийгөө зохицуулах буюу салбарын эвлэл, холбоодоор удирдуулна.

Гол төвд тоглох буюу Hardcore¹⁵ хэмээх тодотголтой картель гэдэгт чухамдаа өрсөлдөөний хуулиар хориглохыг зорьдог, үнийг үгсэн тогтоох, нийлүүлэлтийг хязгаарлах, зах зээл, хэрэглэгчдийг өөр хоорондоо хувааж авах зорилготой пүүсүүдийн хамтын ажиллагааг илэрхийлжээ.

¹³ Fear, J. R. Cartels and competition: Neither markets nor hierarchies. Division of Research, Harvard Business School, 2016. pp. 18-33.

¹⁴ Ibid., pp. 26-7.

¹⁵ Картелиг 1998 оны Эдийн засгийн хөгжил хамтын ажиллагааны байгууллагын зөвлөмжийн баримт бичгээс эхлэн “hard core cartel” гэх тодотголтойгоор олон улсын хэд хэдэн бичиг баримтад хэрэглэсэн байдаг. Картелийн төрлүүдээс хамгийн хүнд хэлбэрийн гэсэн тодотголоос гадна, пүүсүүдийн хамтын ажиллагааны бүдүүвчийн төв хэсэгт оршиж байгаа, эсхүл үйлдвэрлэл, худалдаа, борлуулалтын голд явагддаг гэх мэт олон утгаар авч үзэж болохоор байна. Мөн энэхүү хэллэг нь картелийг илтэд гутаан доромжилсон өнгө аястай, хатуу санцрийг хүлээн зөвшөөрүүлэх гэсэн мэт хэмээн А.Эзраки, К.Бийтон-Уэльс нар тэмдэглэсэн байдаг. Beaton-Wells, C., & Ezrachi, A. Criminalizing cartels: Critical Studies of an International Regulatory Movement, Hart Publishing, 2011, p.1.

Үйлдвэржилт ба нийгмийн бодлогын картел нь тухайн салбарын бодлогыг шийдвэрлэх зорилготой гэх пүүсүүдийн хамтын ажиллагаанаас нь өргөн цар хүрээтэй шатлан захирах тогтоц /hierarchies/ шинжтэй. Үүнд экспорт, импортын картель, зах зээлийн рациональчлалын картель, хямралын болон онцгой үед зохион байгуулалтанд ордог картель, урт хугацааны хэд хэдэн улсын буюу улс дамнасан бизнесийн хамтын ажиллагааны гэрээнд үндэслэсэн картель буюу олон улсын харилцаа, зохицуулалтын бодлогын түвшинд тохиролцсон хамтын ажиллагаа хамаарахаар дүрслэгдсэн байна.

Бүдүүвч 1: Пүүсүүдийн хамтын ажиллагааны спектр

Пүүсүүдийн хамтын ажиллагааны спектр			
Зах зээлүүд		<ul style="list-style-type: none"> Аялдагч зах зээл Олигополь зах зээл (далд хуйвалдаантай) Үйлдвэрлэл/худалдааны холбоод 	<p>Нэг улсын хүрээнд</p> <p>Олон улсын хэмээнд хүрсэн, зохицуулагдах</p>
Хувийн, өөрийгөө зохицуулагч (Associations)	Процедуран (procedural)	<ul style="list-style-type: none"> Гэрээт эсвэл нөхцөлт картель Нэр төрлийн эсхүл стандартын картель: <ul style="list-style-type: none"> Байгаль орчин/ аюулгүй байдал чанарын Бүтээгдэхүүний баталгаажуулалтын Патент эсвэл патентын лицензийн картель Тооцооллын картель Хөнгөлөлтийн картель Тендерийн картель 	
Картелүүд (Cartels)	Хууль бус хүнд хэлбэрийн картель (Illegal hardcore)	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчийг хуваах картель Төрөлжсөн картелүүд Нутаг дэвсгэрийг хуваах картель Квот хуваарилалтын картель Жентлеменүүдийн тохиролцоо Үнэ тогтоох картель Синдикатууд 	
Шатлан захирах тогтоц (Hierarchies)	Үйлдвэржилт, Нийгмийн бодлогын зорилготой (Industrial/Social policy)	<ul style="list-style-type: none"> Экспорт/импортын картель Рациональчлалын картель Хямралын үеийн картель: <ul style="list-style-type: none"> Онцгой үе эсхүл бүтцийн хямралын картель Хамтын маркетинг/борлуулалтын гэрээ Урт хугацааны гэрээ Сүлжээ: <ul style="list-style-type: none"> Аж ахуйн нэгжүүдийн нэгдэл Туслан гүйцэтгэгчид (Хувьцааны хамааралгүй) Стратегийн холбоод (Хувьцаа эзэмшлээр холбоотой) Хамтарсан компани/пүүсүүд 	

Пүүсүүдийн хамтын ажиллагааны спектрээс гадна, картельд хандах хандлагын талаар сонирхолтой дилем хөндөгдөнө. Түүний нотолж байгаагаар Европ, Японы эдийн засгийн өсөлтийн ид хурдацтай үед эдийн засгийн хамгийн динамик салбаруудад картелиуд бий болж, чухал үүрэг гүйцэтгэсэн. Тэрчлэн Япончууд картелиуд капиталист өсөлтийг завхруулсан гэхээсээ хувь нэмэр илүүтэй оруулсан гэж үзэх хандлагатай байдаг гээд картельгүйгээр өсөлт илүү хурдан байх байсан болов уу, Тэд яагаад зогсонги байдалд хүргэсэнгүй вэ, Бизнесийн түүхчид эдийн засаг, бизнесийн нэг зуун жилийн хөгжлийг тэдэнгүйгээр биш картельтай уялдуулан ярих ёстой хэмээн нэлээд хурц асуултуудыг судлаачдын өмнө тавьсан.¹⁶

2.2.5. Экспортын картель хэмээх онцгой хэлбэрийн хүрээнд өрнөж буй мэтгэлцээн

Нийгмийн сонголтын онол (Public choice theory)-ыг баримтлагчид пүүсүүд хамтран бүтээгдэхүүнээ гадаадын улс орны тарифын болон тарифын бус саадыг хамт даван туулж шинэ зах зээлд нэвтрэх, эсхүл олон улсын худалдаанд байр суурь олж авахын тулд экспортын картель байгуулж болно гэж үздэг. Чингэснээр импортлогч орны зах зээл илүү

¹⁶ Ibid., p.11.

өрсөлдөөнтэй болно гэж үзнэ.¹⁷

Дотоодын болон олон улсын экспортын картель нь хоорондоо ялгаатай. Олон улсын экспортын картель нь хэд хэдэн орны пүүсүүдээс бүрддэг. Экспортын картелийн үйл ажиллагаа нь оролцогч талуудын экспортын бизнесийг төвлөрүүлж, ингэснээр экспортын зах зээл дээрх тэдгээрийн хоорондох аливаа өрсөлдөөнийг хязгаарлах, эсхүл экспортын үнийг үгсэн тохиролцох, экспортын квот тогтоох, экспортын зах зээлийг өөр хоорондоо хуваарилах, тендер сонгон шалгаруулалтад санал ирүүлэхдээ хуйвалдах, ийм замаар худалдан авалтын төлөөх өрсөлдөөнийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хязгаарлана.¹⁸

Экспортын картелийг ихэнх өндөр хөгжилтэй улс орнуудад өрсөлдөөний хууль тогтоомжоор хориглоогүй байдаг. ХБНГУ, Япон, АНУ нь экспортын картелийг зөвшөөрдөг. Харин Австрали, Британи, АНУ, Японд экспортын картель заавал бүртгэгдэх эрх зүйн зохицуулалттай.¹⁹

Ф.Бекер²⁰, Д.Сокол нарын тус тусдаа хийсэн судалгаанаас үзэхэд²¹ экспортын картель нь импортлогч орны дотоодын зах зээлд нэвтрээд цаашид өрсөлдөөнийг хязгаарлах үр дагавар үүсгэх боломжтой. Заримдаа олон улсад эзлэх зах зээлийн хувь багатай боловч тодорхой зах зээлд тун өндөртэй байр суурьтай байх нь бий. Ялангуяа хөгжиж буй орнуудад энэ байдал ихээхэн хүндээр тусдаг ажээ.

Харамсалтай нь экспортын картелийн талаар эмпирик тоо баримт дутмаг учир ул суурьтай судлагдахгүй өнөөг хүрсэн.²² Экспортын картель тодорхой хэмжээгээр ашигтай байж болох ч өрсөлдөөнийг зохицуулах байгууллага эрх зүй ба эдийн засгийн ухааны хандлагын үүднээс институцийн түвшний сайтар дүн шинжилгээг хийж энэ тухай ямар байр суурь илэрхийлэхээ шийдэх ёстой гэж үздэг байна.²³

Ш. ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ДАХЬ КАРТЕЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ШҮҮМЖЛЭЛТ ДҮН ШИНЖИЛГЭЭ

Өмнөх хэсэгт картелийн талаарх онол, үзэл баримтлалууд, гадаад орнууд болон олон улсын байгууллагуудын хүрээнд өрнөсөн картелийн талаарх байр сууриудыг харьцуулан авч үзсэн. Тэгвэл энэ хэсэгт нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хууль болон өрсөлдөөний тухай хуулиудад картелийг хуульчлах эш үндэс болсон онол, үзэл баримтлалыг эрэлхийлж, дүн шинжилгээ хийхийг зорив. Хоёрдугаарт, манай улсын Өрсөлдөөний тухай хуульд картелийг хуульчлан тодорхойлсон байдалд шинжилгээ хийж, хууль зүйн алдаа, логик зөрчил байгаа эсэхийг авч үзнэ. Өрсөлдөөний тухай хуульд картелийг тодорхойлохдоо алдаа гарсан бол аль нэг улсын эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжтой нарийвчлан харьцуулалгүйгээр картель үзэгдлийг тодорхойлж буй олон улсын эрдэмтдийн ном, сурах бичигт авч үздэг онолын нийтлэг ойлголт, тодорхойлолттой харьцуулж, гарч болзошгүй үр дагаврыг төсөөлөхийг зорив.

¹⁷ Sokol, D. D. (2008). What do we really know about export cartels and what is the appropriate solution? *Journal of Competition Law and Economics*, 4(4), p.968; Becker, F. The Case of Export Cartel Exemptions: Between Competition and Protectionism' (2007). *Journal of Competition Law & Economics*, 3, p.97.

¹⁸ 'Encyclopedia of World Problems & Human Potential': <http://encyclopedia.uia.org/en/problem/134189> [last accessed 04/17/2023]

¹⁹ Ibid.

²⁰ Becker, F. The Case of Export Cartel Exemptions: Between Competition and Protectionism' (2007). *Journal of Competition Law & Economics*, 3, p. 97.

²¹ Sokol. *Supra* note.

²² Ibid, p.972.

²³ Martyniszyn, M. (2012). Export cartels: is it legal to target your neighbour? Analysis in light of recent case law. *Journal of International Economic Law*, 15(1), p.188; Sokol, D. D. (2008). What do we really know about export cartels and what is the appropriate solution? *Journal of Competition Law and Economics*, 4(4), pp.967-982.

Картель нь олон улсын, экспортын, импортын, үндэсний зах зээлд гэхчлэн харилцан адилгүй орон зайд оршиж байдаг өвөрмөц, нарийн төвөгтэй үзэгдэл боловч аль ч нийгэмд оршиж байдаг нийтлэг үзэгдэл. Өрсөлдөөний эрх зүйн тэргүүлэх эрдэмтэд болох Э.Фокс, Д.Крэйн нарынхаар орчин цагт улс орнуудын үндэсний өрсөлдөөний эрх зүйд тулгамдаж байгаа сэдвүүдийг ярихад чухамдаа картелиас эхлэх нь зүйд нийцэх бөгөөд улс орнуудын үндэсний эрх зүйд картелийн зохицуулалттай холбоотой дараах нийтлэг асуултууд хариулт нэхэж байгааг онцолжээ.²⁴ Үүнд:

- Хэлцлийг нотлох асуудал: Талууд үнэхээр бие биетэйгээ хэлцэн тохирсон уу?
- Картелийн шинж: Гэрээ нь үнэхээр картель мөн үү, эсхүл хамтарсан компани, үр ашигтай гэж үзэж болох өөр ямар нэг төрлийн гэрээ юу?
- Үр нөлөө: Гомдлын шаардлага гаргагч тал үнэхээр гэрээг өрсөлдөөнд хохирол учруулна гэдгийг нотлох шаардлагатай юу?
- Нийтийн ашиг сонирхол: Хямралын үеийн картель зөвшөөрөгдөхүйц зүйл үү? “Нийтийн ашиг сонирхол” бүхий өөр ямар нэг зөвтгөл байж болох уу?
- Төрийг эс буруутгах: Төрөөс картелийг хөхиүлэн дэмжсэн үед, тэрчлэн төрийн үйл ажиллагаа, гадаадын төр засгийн шахалт, улс төр нь онцгой тохиолдолд тооцогдож зөвшөөрөгдөх ёстой юу? Улс хоорондын хамтын ажиллагаа нь дотоодын эрх зүйгээр зөвшөөрөгдөх эсхүл онцгой тохиолдолд хамаарах ёстой юу?²⁵

Монгол Улс дахь картелийн эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэхэд юуны урьд өөрийн орны түүхэн онцлог, нийгэм, эдийн засгийн хүрсэн түвшин, хөгжлийн хэрэгцээг харгалзан үзэхийн зэрэгцээ дор хаяж дээрх эрдэмтдийн дэвшүүлэн тавьсан асуултуудын хүрээнд судалгаатайгаар хариу өгөх нь онол, арга зүйн хувьд илүү үндэслэлтэй болно.

3.1. Үндсэн хууль ба өрсөлдөөний хууль тогтоомжийн үзэл баримтлал, картелийн эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжлийн тойм

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь эдийн засгийн нэг тогтолцооноос нөгөөд шилжих улс төр, эдийн засаг, эрх зүйн үндэс суурь болсон. Үндсэн хуулийн Тавдугаар зүйлд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.”, “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж тус тус заасан.

Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн үзэл баримтлал. Монгол Улсын Засгийн газраас УИХ-д 1993 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр өргөн барьсан “Шударга өрсөлдөөнийг дэмжих тухай” хуулийн төслийн үзэл баримтлал гэж үзэхүйц цорын ганц танилцуулга баримт бичигт анхны хуулийн төслийг боловсруулахдаа “манай оронд өрнөж байгаа өөрчлөн байгуулалтын үр дүнд аж ахуйн үйл ажиллагааны төвлөрсөн тогтолцоо задарч аж ахуйн нэгжүүдийн зах зээлд өрсөлдөх үйл ажиллагааны хууль зүйн зөв орчин бүрдүүлэх, нөгөө талаас шинээр үүсч байгаа зах зээлийн харилцааг анхнаас нь эрүүл, шударга зах зээл болгох үүднээс” хуулийн төслийг өргөн барьж байгаа хэмээгээд, АНУ-ын болон бусад орнуудын эрдэмтдээс хийсэн судалгаа, ОУВС, АХБ, НҮБ-ын мэргэжлийн байгууллагуудаас өгч байгаа зөвлөмжүүдийг авч үзсэн гэж тэмдэглэсэн байна.²⁶

Анхны 1993 оны хуулийн төслийн тухай Засгийн газрын танилцуулга²⁷, 1993, 2000 оны хуулиудыг боловсруулах ажилд оролцсон ахмад мэргэжилтний лекцэнд дурдсанаар шилжилтийн цаг хугацаанд төрөөс өрсөлдөөн зохицуулалтын чиглэлээр баримталж

²⁴ Eleanor M. Fox, Daniel A. Crane ‘Global Issues in Antitrust and Competition Law’, Second Edition (2017). p.8.

²⁵ Ibid., pp.5, 8.

²⁶ Тус хуулийн хувийн хэргээс үзэхэд хуулийн үзэл баримтлал гэсэн тусдаа баримт бичиг хуулийн төсөлтэй хамт өргөн бариагүй. Тиймээс хуулийн танилцуулгыг үзэл баримтлал туссан цор ганц эх сурвалж гэж үзэхээс аргагүй.

²⁷ Мөн тэнд, 23 дахь тал.

байсан хууль зүйн бодлогын хамгийн гол зорилтуудад хуучин тогтолцооноос өвлөгдөн үлдсэн төрийн монополийг хязгаарлах, боломжтой бүх салбаруудад өрсөлдөөн нэвтрүүлэх асуудал орж байжээ.²⁸

Хууль санаачлагч хуулийн төслийг “Нийтлэг үндэслэл”, “Зах зээлд ноёрхох үйл ажиллагаа”, “Шударга бус өрсөлдөөн”, “Давамгайлах байдалтай аж ахуйн нэгж бий болохыг хянах”, “Өрсөлдөөний асуудал эрхлэх хорооноос шийдвэр гаргаж, түүнийг биелүүлж, давж заалдах журам”, “Хууль зөрчсөнд хүлээлгэх хариуцлага” гэсэн 7 бүлэг, 18 зүйлтэй боловсруулсан.²⁹ Улсын Их Хурлаас 1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр эцсийн хэлэлцүүлгээр батлахдаа 5 бүлэг, 14 зүйлтэй байхаар баталжээ.³⁰

Анхны болон хоёр дахь хуулийг хэлэлцсэн баримт бичгүүд, батлагдсан хуулийн эх сурвалжийг шинжлэн үзэхэд картелийн талаарх зохицуулалт төслүүдэд эхнээсээ “картель” гэсэн нэр томъёогүйгээр агуулгаараа тусгагджээ.³¹

Өрсөлдөөний тухай 2010 оны хууль /Шинэчилсэн найруулга/-д картелийн талаар “Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл (картель) байгуулахыг хориглох”³² зохицуулалт тусгагдсан. Засгийн газрын 2009 онд өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалд тэмдэглэсэнээр гамшиг, гэнэтийн бусад аюул болон эдийн засгийн хүндрэл, улс орныг хамарсан онцгой нөхцөл байдал бий болсон үед хүн амын амьжиргаа, зах зээлийн шударга өрсөлдөөнийг хамгаалах үүднээс зах зээлийн зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлага тулгараад байна. Зөвхөн зүй ёсны монополь байдалтай аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүний үнийг хянан зөвшөөрөл олгохоор заасныг өргөжүүлж, бараа бүтээгдэхүүний хэт өндөр үнийг хянах, үнийн хөөрөгдлийг таслан зогсоох эрх зүйн зохицуулалтыг бий болгох, зарим бараа бүтээгдэхүүнийг Засгийн газраас тогтоох, хяналт тавих замаар зах зээлийн зохицуулалтыг бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх, үнийг зохиомлоор өсгөх, зориудаар үнийн хөөрөгдөл бий болж буй гол буруутай этгээд нь жижиг худалдаа эрхлэгч /ченж/ байгаа нь тодорхой хэдий ч тэдгээрийг зах зээлийн харилцаанд оролцоход нь хяналт тавих, зохицуулалт хийх, шударга бус үйл ажиллагааг нь таслан зогсоох эрх зүйн орчныг бий болгохыг зорьсон болохыг тодорхойлжээ.³³

Өрсөлдөөний тухай хуулийн үзэл баримтлалд картелийн талаар тодорхой агуулга тусгаагүй байх бөгөөд хуулийн хувийн хэрэг материалаас үзэхэд улс орнуудын картелийг зохицуулж буй туршлага, бодлогын альтернатив, хуулиар ихэнх өндөр хөгжилтэй орнууд зөвшөөрдөг экспортын картелийн талаар авч үзээгүй, хэлэлцүүлэгт энэ талаар хөндөөгүй байна.³⁴

Өмнөх хэсэг (2.2.3)-т авч үзсэн зарим нэр бүхий болон улсын байгууллагаас манлайлан явуулдаг картелийг хатуу хориглох ба улмаар гэмт хэрэгт тооцох чиглэлтэй олон улсын зохицуулалтын хөдөлгөөн бодлогын хэлэлцүүлгийн түвшинд идэвхтэй өрнөдөг тухай авч үзсэн. Өрсөлдөөний тухай Монгол Улсын хуульд картель нь эхэндээ захиргааны хариуцлагын нэлээд хүнд санкцитай зөрчилд тооцогдох болсон бол улмаар “жижиг эрүүгийн хууль” (misdemeanor) гэгдэх Зөрчлийн тухай хуульд тусган хамгийн хүнд

²⁸ Гавьяат эдийн засагч, профессор Д.Байлхүү “Шилжилтийн эдийн засгийн үеийн төрийн бодлого, эрх зүйн шинэчлэлийн туулсан зам, өнөөгийн сорилтууд” сэдвээр СЭЗИС-д 2022 оны 4 сарын 13-нд уншсан хүндэтгэлийн лекцээс тэмдэглэж авав.

²⁹ Монгол Улсын Засгийн газраас УИХ-д 1993 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр өргөн барьсан “Шударга өрсөлдөөнийг дэмжих тухай” хуулийн төслийн танилцуулга, “Монгол Улсын Өрсөлдөөний эрх зүйн эх сурвалжид холбогдох баримт бичиг (1993-2022)” МУИС, ЭЗБЭЗСТ, УБ., 2023, 21-22 дахь тал.

³⁰ Мөн тэнд, 79-88 дахь тал.

³¹ Мөн тэнд.

³² Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг.

³³ Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2009 оны 11 сарын 17-ны өдөр. “Монгол Улсын Өрсөлдөөний эрх зүйн эх сурвалжид холбогдох баримт бичиг (1993-2022)” МУИС, ЭЗБЭЗСТ, УБ., 2023, 268-69 дахь тал.

³⁴ Мөн тэнд. 260-268 дахь тал.

хариуцлага хүлээлгэх³⁵ болсноос үзвэл дээрх олон улсын байгууллагуудын (“картелийг гэмт хэрэгт тооцох хөдөлгөөн” гэж нэрлэгдэх) олон талтай судалгаа, хэлэлцүүлэг, нийтлэлүүдийн нөлөө туссан гэж таамаглаж болохоор байна.

Бүдүүвч 2: *Өрсөлдөөний тухай 2010 оны хууль дахь картелийн зохицуулалтын агуулгыг 1993, 2000 оны хуулиудтай харьцуулсан нь.*

Хориглосон зохицуулалтын төрөл	1993 оны хууль	2000 оны хууль	2010 оны хууль
Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулах/картель/, холбогдох үйл ажиллагаа явуулахтай холбоотой зохицуулалт:			
Аж ахуй эрхлэгчид өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн дараахь гэрээ, хэлцэл (картель) байгуулахыг хориглоно:			
Бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох	+	+	+
Зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл, худалдан авагчаар хуваарилах	+	+	+
Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалт, ачилт болон тээвэрлэлт, зах зээлд нэвтрэн орох боломж, хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэлийг хязгаарлах	-	-	+
Уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцохдоо бараа бүтээгдэхүүний үнэ болон бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох	-	+ ¹	+
Бараа худалдах болон худалдан авахад үнээр өрсөлдөхөөс татгалзах	+	-	-
Аж ахуй эрхлэгчдийн хооронд байгуулсан дараахь гэрээ, хэлцэл (картель) нь нийтийн ашиг сонирхолд харшлах, эсхүл өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэхээр бол хориглоно:			
Эдийн засгийн болон технологийн үндэслэлгүйгээр аж ахуйн харилцаа тогтоохоос татгалзах;	+	+	+
Барааг гуравдагч этгээдэд худалдах, худалдан авахыг хязгаарлах;	+	+	+
Өрсөлдөөнд чухал ач холбогдол бүхий хэлцэл, тохиролцооноос хамсан татгалзах;	+ ²	+ ³	+
Аж ахуйг ашигтай эрхлэх зорилгоор аль нэг байгууллагад гишүүнээр элсэхэд нь өрсөлдөгчид саад учруулах.	+	+	+
Аж ахуй эрхлэгч нь дээрх хэсэгт дурдсан гэрээ, хэлцлийг дэмжиж оролцохыг хориглоно.	-	-	+

Эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурь, онцлог. Хууль зүйн тодорхой ойлголт эрх зүйн системчлэлийн хувьд нийтийн эсхүл хувийн эрх зүйд аль алинд хамаарч, хууль зүйн үр дагавар үүсгэж, тогтолцооны хувьд тэдгээрт тодорхой чиг үүрэг гүйцэтгэдэг нэг жишээ нь картель юм.

Судлаач Т.Мөнх-Эрдэнэ ХБНГУ-ын болон Монгол Улсын өрсөлдөөний эрх зүйн системчлэлийг харьцуулан судлаж, өрсөлдөөний эрх зүй нь салбар дундын шинжтэй, хувийн болон нийтийн эрх зүйн ялгаатай арга хэрэгсэл хэм хэмжээг ашиглан зорилгодоо хүрдэг онцлогтой бөгөөд нийтийн эсхүл хувийн эрх зүйн алинд нь ч дангаар харьяалагддаггүй буюу холимог шинжтэй гэж үзсэн.³⁶ Түүний дотроос харин картелийн эрх зүй нь төрийн хяналт шалгалтын арга, хэрэгслээр захиргааны байгууллагын хяналт, түүний шийдвэр гаргах ажиллагааны хүрээнд хэрэгждэг бөгөөд нийтийн эрх зүйд хамаарна гэсэн байр

³⁵ Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7.1 дэх хэсэг: Хууль бусаар олсон хөрөнгө, орлого, эд зүйлийг хурааж аж ахуй эрхлэгчийг тухайн бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын 6 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

³⁶ Т. Мөнх-Эрдэнэ “Өрсөлдөөний тухай хууль ба бусад хуулийн уялдаа холбоо” эрдэм шинжилгээний өгүүлэл <https://legaldata.mn/buteel/pdf?id=834> 5 дахь тал.

суурь баримталжээ гэж үзэж болохоор байна.³⁷

МУИС-аас эрхлэн хэвлүүлсэн судлаач Б.Амарсанаа, Г.Давааням нарын хамтын зохиогчтой “Арилжааны эрх зүй” анхны бүтээлд зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлахгүй байх, картелийн эрх зүйн зохицуулалт нь арилжааны эрх зүй дэх итгэлийг хамгаалах тогтолцооны иж бүрдлийн нэг гэж үзэн уг бүтээлд системчлэн тусгажээ.³⁸

Картелийг хуульчлан хориглосон тохиолдолд (ихэвчлэн нууц далд аргаар оршдог тул) өрсөлдөөний асуудлаар тухайлан дагнасан төрийн байгууллага хяналт шалгалт явуулж илрүүлэх, эдийн засагт үзүүлэх нөлөөг мэргэжлийн үүднээс үнэлж дүгнэх, шаардлага байдаг. Түүнчлэн тухайн улсын хууль тогтоомжоор аж ахуй эрхлэгчид картельд хамаарах гэрээ, хэлцэл байгуулах тохиолдолд хуулиар тусгайлан харьяалуулсан төрийн байгууллагад хүсэлтээ бүртгүүлж зөвшөөрөл авах шаардлагыг хуульчилдаг жишиг³⁹ байдаг нь нийтийн эрх зүйд хамаарна. Харин зөвхөн картель төдийгүй шударга бус өрсөлдөөний хэлбэрүүдийг хуульчилж, оюуны өмчийн эрх, хууль бусаар өрсөлдөөнийг хязгаарласан хэлцлийг хүчин төгөлдөр бус болохыг тогтоох, үр дагаврыг таслан зогсоох, хохирлыг арилгуулах, орлогыг хураахыг шаардах, нөхөн төлүүлэх зэрэг эрх⁴⁰ сэргээх (remedy) иж бүрэн зохицуулалтыг хувийн ба нийтийн эрх зүйн системчлэлийн уялдаа холбоонд хуульчилснаар итгэл хангагдах тогтолцоо бүрдэнэ.

Түүхэн тодорхой цаг үед картель нь зөвхөн бие даасан аж ахуй эрхлэгчдийн хүнд нөхцөлийг хамтдаа давж туулах, магадгүй сөргөөр авч үзвэл ашгаа ихэсгэх гэсэн санаачилга байсан бол, өөр нэгэн цаг үед төрийн зүгээс эдийн засгийг үр ашигтай, гүйцэтгэлийн өндөр түвшинд удирдах арга хэрэгсэл (өмнөх 2.2.1 хэсэгт авч үзсэн), өөр нэг цаг үеэс хуулиар эрс хатуу хориглож эрх зүйн зөрчилд тооцогдохыг уриалдаг (2.2.2 ба 2.2.3 дахь хэсэгт дурдсан) болж байна. Тэрчлэн хориглох хийгээд зөвшөөрөх аль аль нь тодорхой болзол шаардах хэлбэрээр зэрэгцэн орших тохиолдол орчин үед ч байх агаад өндөр хөгжилтэй улс орнуудад дотоодын аж ахуй эрхлэгч нарт картелийг хатуу хориглох хэдий ч тэдний экспорт, импортын чиглэлийн буюу гадаад худалдаанд картель гэрээ, хэлцэл байгуулахыг хуулиар зөвшөөрөх тохиолдол бодитоор оршиж буйг өмнөх хэсэг (2.2.5)-г авч үзсэн. Тиймээс онолын олон урсгал, төрөл бүрийн шалтгаантай байгааг нэгэнт ийнхүү онолын хэсэгт тайлбарласан тул цаашид картель хэмээх үзэгдлийг дан ганц сөрөг талаас нь авч үзэх нь буруу бөгөөд танин мэдэхүйн түвшинд ч алдаатай чиглэл болохыг анхаарууштай юм.

Гэвч нэгэнт Өрсөлдөөний тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн зохицуулалтын бодит байдлыг харгалзан эхний ээлжинд одоо байгаа хууль тогтоомжид онолын ойлголтыг нь алдаагүй зөв томъёолоход анхаарахад чиглэгдсэн санал, шүүмжлэлийг өгүүллийн дараагийн хэсгүүдэд тусгая.

3.2.1. Гэрээ, хэлцэл дэх картелийн ил, далд хэлбэрүүд

Энэ хэсэгт гэрээ, хэлцэл дэх картелийн хэлбэрийг авч үзнэ. Картель ба хувийн эрх зүй дэх гэрээ, хэлцлийн харилцаа, ялгаа зааг, хамаарал нь манай улсын хувьд онолын түвшинд бага судлагдсан.

Судлаач Н.Баярмаа өрсөлдөөний тухай хууль тогтоомжоор хориглосон зүйлс болох ноёлох үйл ажиллагаа, картелийн хэлцлүүдийг гэрээний эрх зүйн үүднээс судлахад эн тэргүүнд хариулах шаардлагатай асуулт нь гэрээний чөлөөт байдлын зарчимтай уялддаг болохыг онцлоод, гэрээний чөлөөт байдлын зарчмыг хязгаарласан эсэхийг Монгол Улсын шүүх тодорхойлохдоо (ноёлох үйл ажиллагаанд холбогдуулан) нэгдүгээрт, өрсөлдөх нөхцөлийг хязгаарласан эсэх, хоёрдугаарт, хэрэглэгчийг хясан боогдуулсан эсэхийг

³⁷ Мөн тэнд 13 дахь тал.

³⁸ Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл “Арилжааны эрх зүй” УБ, 2022, 195 дахь тал.

³⁹ *Regulating Competition : Cartel Registers in the Twentieth-Century World*. Ed., Susanna Fellman. ROUTLEDGE; 2019

⁴⁰ Б.Буянхшиг “Хувийн эрх зүй: Онол – арга зүй, эдийн засгийн анализ, харьцуулсан судлал” (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) УБ., 2017, 152 дахь тал.

шалгуур болгон авч үзэж байна гэсэн ажиглалт хийжээ. Тэрбээр, өрсөлдөөний хууль тогтоомж нь аж ахуй эрхлэгчдийн зан байдлыг зохицуулах замаар тэдгээрийн үйл ажиллагаа явуулах баталгаат түвшинг тогтоож зах зээлд оролцогчид гэрээний болон эд хөрөнгийн эрхээ эдлэн чөлөөт эдийн засгийн зарчимд нийцсэн үйлдэл хийхийг бүрэн дэмжих боловч нөгөөтээгүүр гэрээний харилцаанд оролцогч бус гуравдагч этгээдийн эрх ашгийг ямагт анхаарч, зах зээлийн бүх оролцогчдын ашиг сонирхлын төлөө зах зээлийг хамгаалан гэрээний эрх зүйн хамгаалалт чөлөөт өрсөлдөөний зорилгод нийцэж буй эсэхэд үнэлэлт өгдөг хэмээн тэмдэглэсэн.⁴¹ Түүний судалгааны ажил өрсөлдөөний эрх зүй дэх ноёлох үйл ажиллагааны тохиолдлуудыг эш татан үнэлэлт дүгнэлт өгсөн бөгөөд басхүү картелийн хувьд ч хамааруулан хийсэн дээрх ерөнхий дүгнэлт нийцтэй эсэхийг 3.2.2 дахь хэсэгт авч үзлээ. Гэхдээ юуны өмнө өрсөлдөөнд хамааралтай ямар хэлцэл зайлшгүй өрсөлдөгчдийн дунд байж болох хийгээд, илтэд хохиролтой, өрсөлдөөнд харш болохыг товч авч үзсэн нь зүйтэй болов уу.

Өрсөлдөгчдийн хооронд байгуулагдаж болох хэлцэл, тохиролцоо. Нэг зах зээл дэх өрсөлдөгч нар үгсэн тохиролцоо боломжтой боловч хэвтээ чиглэлтэй арилжааны гэрээ өрсөлдөгч нарын хооронд байгуулагдах нь зайлшгүй шалтгаантай байх тохиолдол бий. Зохих практик ажиглалт, судалгаа хийж үзэхэд дараах тохиолдлуудад өрсөлдөгч нар зайлшгүй хоорондоо хэвтээ чиглэлтэй гэрээ, хэлцэлд байгуулдаг байна. Гэхдээ тэрхүү хэлцлийн шинж чанар нь түүний гол зорилгоос хальсан “сөрөг нөлөөтэй”⁴² эсэхийг харгалзах ёстой.

1/ Шинэ технологи нэвтрүүлэхийн тулд салбарын өрсөлдөгч нар өртөг зардлаа бууруулах, чанар баталгаажуулах, инновац нэвтрүүлэх зорилгоор нэгдсэн стандарт нэвтрүүлэх, эсхүл стандарт, патентын эвсэл (patent pool)-д нэгдэх. Өрсөлдөгч нар хоорондоо хэрэглэгчийн мэдээлэл солилцох зайлшгүй хэрэгтэй байх тохиолдлын нэг жишээ нь өрсөлдөгч эмнэлгүүд эмчлүүлэгчийн мэдээллийг шуурхай солилцох бодит шаардлага гарна. Түүнийг солилцох стандарт, технологийн шийдэл бүхий платформ нэвтрүүлэх нь хэвтээ чиглэлд талууд хамтран ажиллах шаардлагыг бодитоор бий болгоно.

2/ Сүлжээ салбар (network industry) буюу эдийн засагт бий болж буй аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөгт нөлөө үзүүлдэг ба өөр хоорондоо зайлшгүй холбогддог салбаруудад хэвтээ чиглэлтэй гэрээгээр хамтран ажиллах зайлшгүй үүрэгтэй байх нь бий. Жишээлбэл, үүрэн холбооны үйлчилгээ үзүүлэгчдийн сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээ, мөн банк хоорондын төлбөрийн харилцан тооцооны хүү, шимтгэлийг зохицуулсан гэрээг нэрлэж болно. Эдгээр гэрээнүүд нь зайлшгүй хоорондоо холбогдож ажиллах (essential interoperability) үүрэгт хамаарах өрсөлдөөний эрх зүй дэх зарчмын хүрээнд яригддаг.⁴³

Илт сөрөг нөлөөтэй картель. Өрсөлдөгчдийн хоорондын гэрээ нь B2B (business-to-business) буюу аж ахуй эрхлэгчдийн хоорондын гэрээнд тооцогдох боловч зах зээлд Өрсөлдөөний тухай хуулиар хориглосон үйлдлийг хийхээр өөр хоорондоо тохиролцоо тохиолдолд үр дагавар нь B2B төдийгүй B2C (business-to-consumer) буюу хэрэглэгчийн гэрээний хэлцлийн зардлыг өсгөх, үнэ тариф нэмэх, сонголтыг хязгаарлах, технологийн хөгжлийг хясан хязгаарлах, хомсдол үүсгэх зэрэг сөрөг нөлөөтэй.

Өрсөлдөөний эрх зүйн онолын хувьд өрсөлдөгч нарын хооронд хийгдэх үгсэл хуйвалдаан нь (a) арилжааны тодорхой гэрээ, хэлцэл эсхүл мэдээлэл солилцоо зэрэг шууд бус далд (tacit collusion) хэлбэрийн, (b) ямарваа гэрээгээр халхавчлагдаагүй бөгөөд

⁴¹ Н.Баярмаа “Өрсөлдөөний эрх зүй ба гэрээ” эрдэм шинжилгээний өгүүлэл. Уб, 2017. <https://legaldata.mn/b/310>, 2 болон 7 дахь тал.

⁴² Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан (a) нийтийн ашиг сонирхол, (б) өрсөлдөөн хязгаарлагдах гэсэн шалгуураар.

⁴³ Brinsmead, S. (2021). *Essential Interoperability Standards: Interfacing Intellectual Property and Competition in International Economic Law*. Cambridge University Press. p 20, Hovenkamp, H. (2023). Antitrust Interoperability Remedies. *Columbia Law Review*, 123(1), 1-36.

өрсөлдөөний гол элементүүдийн талаар өрсөлдөгч нарын илэрхий (explicit collusion) хэлбэрийн хуйвалдаан хэмээн ангилагддаг.⁴⁴

Бүдүүвч 3: Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан картелийн хэлбэрүүд ба түүнээс хохирч болох субъектүүд

Картель гэрээ, хэлцэл	Хохирч болох талууд
11.1.1. бараа, бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох	Хэрэглэгч, өрсөлдөгч
11.1.2. зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл, худалдан авагчаар хуваарилах;	Хэрэглэгч
11.1.3. бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалт, ачилт болон тээвэрлэлт, зах зээлд нэвтрэн орох боломж, хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэлийг хязгаарлах;	Өрсөлдөгч, аж ахуй эрхлэгч, шууд бус утгаараа хэрэглэгч
11.1.4. уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцохдоо бараа бүтээгдэхүүний үнэ болон бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох.	Уралдаант шалгаруулалт, худалдан авалт, тендер зарлагч, тэдгээрт оролцогч
11.2.1. эдийн засгийн болон технологийн үндэслэлгүйгээр аж ахуйн харилцаа тогтоохоос татгалзах;	Өрсөлдөгч, аж ахуй эрхлэгч, шууд бус утгаараа хэрэглэгч
11.2.2. барааг гуравдагч этгээдэд худалдах, худалдан авахыг хязгаарлах;	Өрсөлдөгч, аж ахуй эрхлэгч, шууд бус утгаараа хэрэглэгч
11.2.3. өрсөлдөөнд чухал ач холбогдол бүхий хэлцэл, тохиролцооноос хамсан татгалзах;	Өрсөлдөгч, аж ахуй эрхлэгч, шууд бус утгаараа хэрэглэгч
11.2.4. аж ахуйг ашигтай эрхлэх зорилгоор аль нэг байгууллагад гишүүнээр элсэхэд нь өрсөлдөгчид саад учруулах.	Өрсөлдөгч, аж ахуй эрхлэгч, шууд бус утгаараа хэрэглэгч

Картель байгуулагч талууд хоорондоо албан ёсны гэрээ, хэлцэл хэрэглэгдэхгүйгээр далд хэлбэрээр тохиролцох тохиолдол түгээмэл байдаг. Энэ нь магадгүй картелийн нийгэм, эдийн засаг, хэрэглэгчид хамгийн их хохирол учруулах нөлөөтэй хэлбэр нь мөн. Хоорондын тохиролцоогоо бичгээр үйлдэлгүйгээр “жентлемэнүүдийн тохиролцоо” хэмээн нэрлэх нь бий. “Жентлемэнүүдийн тохиролцоо” гэсэн ойлголтыг бий болгосон, олон улсад зартай хинин үйлдвэрлэл, борлуулалтын картелийн жишээг доор авч үзэхэд энэ нь хууль болон зан суртахууны хэм хэмжээнд үл нийцэх аман тохиролцоо агуулсан байдаг. Эдийн засгийн ихээхэн өргөн цар хүрээ, үр дагавар бүхий, дээр нь өрсөлдөөнийг хязгаарлаад зогсохгүй цаашлаад шинжлэх ухаан, технологийн ололтыг хэрэглээнд нэвтрүүлэхийг хязгаарласнаараа зүй бус, сөрөг нөлөө ихтэй юм.

⁴⁴ <https://www.concurrences.com/en/dictionary/Collusion-12162> [Сүүлд үзсэн огноо: 18/05/2023]

Шигтгээ 1: ACF CHEMEFARMA V. ЕВРОПЫН КОМИСС (ХИНИН) хэргийн дугаар: 41/69, EU:C:1970:71 (Европын шүүх 1970)

Факт:

Хумхаа болон сонсголын замын өвчнийг эмчлэх зориулалттай бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглагддаг Хинин болон Хинидин хэмээх бодис байдаг. Тус бодисыг Нидерланд Улсын Недкем, тус улсын бусад 5 компани, Герман Улсын Боэхрингер, Буклер компаниуд үйлдвэрлэдэг байна. 1958 онд тус компаниудын хооронд дотоодын зах зээлийг хуваах, бусад улс руу экспортлох үнэ, квотыг тогтооходтой холбогдсон хэлцэл хийсэн. Уг хэлцлийг Германы Холбооны Картелийн Алба илрүүлсэний дараа тус картель нь хэлцлийн хамрах хүрээнээс Европын холбооны улсуудыг хасаж, Европын холбооны хилийн гаднах зах зээлд хамаарах буюу эрх зүйн зохицуулалтгүй картелийн хувилбар болох экспортын картель байгуулжээ. Талууд бичгэн хэлбэрээс татгалзан шинэ гэрээ болох “Жентлемэнүүдийн тохиролцоо” гэгчийг хийсэн байдаг. Энэ тохиролцоо нь Европын холбооны гишүүн бус орнууд руу экспортлох квотыг өөр хоорондоо тогтоож, зарим гишүүдэд зориулж тус холбооны зах зээлээс гадуур тодорхой зах зээлийг хувааж өгөх зэрэг зохицуулалт руу шилжсэн. Ногдох квотыг хэтрүүлсэн эсхүл биелүүлээгүй тохиолдолд бусад гишүүдийн худалдах тоо хэмжээг тэнцүүлэх, хэлэлцээрт оролцогч гишүүн орнууд гуравдагч этгээд болох хэлэлцээрт оролцоогүй компаниудтай зах зээлээс гадуур хинин, хинидин үйлдвэрлэх, борлуулах чиглэлээр хамтран ажиллахыг хориглосон байна. Хэлэлцээрт оролцогч талууд хаана, хэнд, ямар үнээр худалдсан тухай мэдээллээ бусад гишүүдэд мэдээлэх, Недкем компани ирүүлсэн мэдээлэлд үндэслэн цаашид худалдаалах тоо хэмжээг тэнцүүлэн тогтоох эрхийг хэрэгжүүлж байв.

Францын талууд синтетик хинидин туршиж эхэлсэнтэй холбогдуулан энэхүү шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхгүй байхаар тохиролцсон бөгөөд хэлцэлд оролцсон талууд Жентлемэнүүдийн хэлэлцээрийг дагаж мөрдөөгүй тохиолдолд бичгээр байгуулсан экспортын гэрээг хүчингүй болгох үндэслэл болохыг дурдсан байв.

Картелийн бас нэг чиглэл нь талууд хинин үйлдвэрлэх түүхий эдийн нөөцийг хамтран ашиглах гэрээ байгуулсан. Уг нөөц нь модны холтос бөгөөд үүнийг Недкем компаниас нэгдсэн байдлаар худалдан авч байв. Нөгөө талд Недкем компани нь их хэмжээний модны холтсыг АНУ- аас худалдан авч, картелийн гишүүн байгууллагуудад хуваах, хуваарилах үүргийг гүйцэтгэн борлуулалтаас 2 хувийн шимтгэл авдаг байв.

Илрүүлсэн нь:

1963-1964 онуудын хооронд Вьетнамд өвдсөн Америк цэргүүдийн амийг аврахын тул их хэмжээний хининийн эрэлт бий болоход, үүнтэй зэрэгцэн Недкем компани их хэмжээний холтсыг АНУ-аас худалдан авч байсан нь АНУ-ийн засаг захиргааны зүгээс олон улсын хининийн картель байгаа эсэх талаар сэжиглэл дэвшүүлэхэд хүргэсэн. АНУ-ын Хууль зүйн яамнаас тус асуудалтай холбоотойгоор өргөн цар хүрээтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бөгөөд 1967 онд тухайн хяналт, шалгалттай холбоотой мэдээллийг Европын холбооны Комиссд хүргүүлэн, мэдээлэл солилцож, хамтран ажилласан байна. 1962 оноос хойш Европын Комисс болон гишүүн орнуудын Үндэсний эх баригчид шалгалтын ажил явуулж, 1965 оны 2 дугаар сард тус төрлийн хууль зөрчсөн картель байгуулсан үйлдэлд их хэмжээний торгууль ногдуулсан. Тус картельд оролцогчдод дотоодын зах зээл дэх байр сууриа хадгалах ба хувааж авах, үнийг үгсэн тогтоох, борлуулалтын квотыг тогтоох, синтетик хинидин үйлдвэрлэлийг хориглох хууль бус үйлдлүүдийг хийсэн болохыг тогтоожээ.

Дээр авч үзсэн хинин бодисын картелийг шалгасан хэрэгт дурдагдсан зах зээлийг хувааж авах, үнийг үгсэн тохиролцоо, борлуулалтын квот тогтоох, өрсөлдөөнийг болон технологийн дэвшлийг хязгаарлах гэрээ, хэлцлүүд нь манай улсын Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлд бүгд хуульчлагдсан байгаа нь харагдаж байна.

3.2.2. Өрсөлдөөний тухай хууль дахь картелийн ангилал

Энэ хэсэгт картелийн тухай манай улсын Өрсөлдөөний тухай хууль дахь тодорхойлолтыг өрсөлдөөний эрх зүйн онолын ном сурах бичигт тодорхойлсон дэлхий нийтийн чиг хандлагатай харьцуулан авч үзэж, тухайн ойлголтын системчлэлийг онолын үүднээс тайлбарлах оролдлого хийхийг зорив.

Өрсөлдөөний тухай хуульд картелийг гурван өөр зарчим, аргачлалаар тодорхойлсон гэж хэлж болно. Үүнээс *Perse illegality*, *Rule of reason* гэсэн хоёр зарчим нь дэлхий нийтэд хэрэглэгддэг онолын түгээмэл зарчмууд мөн.

/1/ Perse illegality зарчим. Энэ зарчмын дагуу шууд хууль бус байх хэлцэл, тохиролцоонуудыг нэрлэн заасан /Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсгийн 11.1.1-11.1.4 дэх заалт/.

Хууль тогтоогч энэ хэлбэрийн картель гэрээ, хэлцэл байгуулсан тохиолдолд өрсөлдөөн хязгаарласан эсэх, хэрэглэгчийг хяссан гэх аливаа нэг үр дагаврын шалгуур нөхцөл тавилгүй. Эдгээр гэрээ, хэлцэлд:

- *Бараа, бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох;*
- *Зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл, худалдан авагчаар хуваарилах;*
- *Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалт, ачилт болон тээвэрлэлт, зах зээлд нэвтрэн орох боломж, хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэлийг хязгаарлах;*
- *Уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцоходоо бараа бүтээгдэхүүний үнэ болон бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцоо.*

Дээрх агуулга бүхий гэрээ, хэлцлийг хориглож буй учир нь үнэ, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэл зэрэг хүчин зүйлсээр өрсөлдөж байх ёстой аж ахуй эрхлэгчид харилцан хоорондоо өрсөлдөлгүй, эсрэгээрээ өрсөлдөөнөөс зайлсхийж, зах зээлийн зарчмаар тогтоох ёстой үнэ болон бусад хүчин зүйлсийг зохиомлоор тогтоож, барьж буй болохоор юм.⁴⁵ Картелийн орчин үеийн онолд *hardcore cartel* буюу хүнд хэлбэрийн бөгөөд нийлүүлэлт, борлуулалтын цөмд орших хэмээн онолын хувьд тодорхойлогддог картелийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, дээрх зохицуулалт нь картелийн зохицуулалтыг хуульчилсан гадаадын олон улсуудын хууль тогтоомжийн зохицуулалттай үндсэндээ ижил байна.

/2/ Rule of reason зарчим. Хуульд заасан тодорхой гэрээ, хэлцэл нь нийтийн ашиг сонирхолд харшлах, эсхүл өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэхээр бол картель гэж үзэхийг өрсөлдөөний хуульд⁴⁶ заасан. Өмнө авч үзсэн зарчмаас ялгаатай нь хэвтээ чиглэлтэй үгсэл, тохиролцоог хийх бодит учир шалтгаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, хуульд заасан шалгуур үзүүлэлтийг харьцуулан авч үзэх зарчим юм.

Энэ нь Өрсөлдөөний хууль тогтоомж дахь нэгэн сонирхолтой, онцлог зохицуулалт юм. Хуульд заасан шалгуур үзүүлэлтэд (а) нийтийн ашиг сонирхол, (б) өрсөлдөөн хязгаарлагдах эсэх оржээ. Хууль тогтоогч Өрсөлдөөний хууль тогтоомжийг сахиулах хүрээнд гүйцэтгэх засаглалын төлөөлөгч (ШӨХТГ)-д гэрээ байгуулагч талуудын хэлцлийн нөхцөлийг картель гэж дүгнэх эсэх, улмаар эрх зүйн хариуцлага хүлээлгэх бүрэн эрхийг олгосон байна.

⁴⁵ Б.Амарсанаа, М.Уянга, Г.Давааням нар “Өрсөлдөөний эрх зүйн онол, практик Уб, 2022, 231 дэх тал.

⁴⁶ Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг.

Чингэхдээ зөвхөн дараах хүрээг хамруулахаар хуульчилсан нь бүгд холбогдох зах зээлд өрсөлдөгчийг хясан боогдуулах, зах зээлээс шахан зайлуулах (exclusionary abuse) шинжтэй үйлдлүүд байна. Үүнд:

- Эдийн засгийн болон технологийн үндэслэлгүйгээр аж ахуйн харилцаа тогтоохоос татгалзах;
- Барааг гуравдагч этгээдэд худалдах, худалдан авахыг хязгаарлах;
- Өрсөлдөөнд чухал ач холбогдол бүхий хэлцэл, тохиролцооноос хамсан татгалзах;
- Аж ахуйг ашигтай эрхлэх зорилгоор аль нэг байгууллагад гишүүнээр элсэхэд нь өрсөлдөгчид саад учруулах.

Өрсөлдөөний тухай хуульд зааснаар⁴⁷ аж ахуй эрхлэгчдийн хооронд байгуулсан гэрээ, хэлцлийн хувь заяаг шийдвэрлэхүйцээр нийтийн ашиг сонирхолд харшлах, эсхүл өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэхээр бол гэж онцлон ямар учраас оруусныг хууль санаачлагч тодорхой тайлбарласан зүйлгүй ба энэ талаар эрдэм шинжилгээний хүрээнд мэтгэлцээн манайд өрнөөгүй байна.

Эдийн засгийн болон технологийн үндэслэлгүйгээр аж ахуйн харилцаа тогтоохоос татгалзах, барааг гуравдагч этгээдэд худалдах, худалдан авахыг хязгаарлах, өрсөлдөөнд ач холбогдолтой хэлцэл, тохиролцооноос хамсан татгалах, аж ахуйг ашигтай эрхлэх зорилгоор аль нэг байгууллагад гишүүнээр элсэхэд нь саад учруулсан үйлдлээс болж өрсөлдөөн хязгаарлагдсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харш байдлыг тогтооход юуны өмнө гэрээний эрх чөлөөтэй харьцуулан үзэх шаардлага бий болно. Энэ асуудлыг шалгахад судлаач Н.Баярмаагийн дэвшүүлсэн дээр дурдсан хоёр шалгуураас эхний шалгууртай нийцж байх бөгөөд хоёр дахь шалгуур болох “хэрэглэгчийг хясан боогдуулсан (эсэх)” нь “нийтийн эрх ашигт харш” гэсэн ойлголттой адил эсхүл ялгаатай эсэх, тэрчлэн эдгээр хоёр ойлголт нь ямар харьцаатайг тодруулах шаардлагатай.

Судлаач Т.Мөнх-Эрдэнэ нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох урьдчилсан нөхцөлийг тодорхой нэг тохиолдолд хууль тогтоогчийн тогтоосон хуулийн агуулга, зорилгыг нь цогцоор нь тайлбарлах замаар шүүхээс тогтоох зүйл гэжээ.⁴⁸

Нэгэнт Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хясан боогдуулах шинжтэй картель үйлдлийг хуулиар хориглох шалгуур нь нийтийн ашиг сонирхол хэмээх өргөн хүрээтэй тодорхойлогдсон байх тул түүнд өртсөн хувь нэг өрсөлдөгчийн гомдол үүнд хамаарахгүй гэж мэтгэх боломжтой харагдаж байна. Харин нийтийн шинжтэй олонлог хэрэглэгч, өрсөлдөгч нарын ашиг сонирхол үүнд хамаарч болох юм.

Ер нь шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаанаас хэрэглэгчид учирдаг хохиролтой үр дагаварт юуны түрүүнд сонголт хийх боломжгүй болсон нөхцөл байдал хамаарна. Улмаар нийтийн эрх ашигт харшлах шинжийг агуулахын тулд дээрх үйлдлээс зөвхөн хэрэглэгч хохироод зогсохгүй олон тооны өрсөлдөгч хохирч, нийгмийн зардал нэмэгдэх, эсхүл жишээлэн авч үзсэнчлэн хинин бодисын картель шиг шинжлэх ухаан, инновацыг боомилох үр дагавар үүсгэхүйц нөхцөл байж болно. Өрсөлдөөний эрх зүйд хэрэглэгч гэдэг нь юуны өмнө, тодорхой нэг бүтээгдэхүүн, үйлчилгээний холбогдох (relevant) зах зээлийн эрэлт талыг хангалттай төлөөлж чадах буюу худалдан авахад бэлэн байгаа эсхүл худалдан авдаг талыг илэрхийлэх, олонлог ойлголт юм.

Сонирхолтой жишээ авахад, нэг хувь хэрэглэгч тодорхой нэг технологи, загварыг хэрэглэж дассан боловч үйлдвэрлэгч нар (хоёр ба түүнээс дээш тооны өрсөлдөгч) нь түүхий эдийн хомсдол, эсхүл эдийн засгийн үр ашгийн үүднээс тухайн нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхгүй болж, харин түүнийг орлох дараагийн шатны загвар, технологи бүхий бүтээгдэхүүн санал болгохоос өөр гарцгүй болсныг тухайн хэрэглэгчийг хясаж байгаа үгсэн хуйвалдаан гэж тооцох тухай асуудал байж таарахгүй.

⁴⁷ Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг.

⁴⁸ Т.Мөнх-Эрдэнэ, “Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь” эрдэм шинжилгээний өгүүлэл, 14 дэх тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=143> [Сүүлд үзсэн огноо: 6/20/2023]

Картелийн хүрээнд сүүлийн үед яригдах болсон нэг чиг хандлага бол “нийтийн ашиг сонирхлын картель” (public interest cartel) гэсэн үзэл баримтлал юм. Энэ үзэл баримтлал Европын хэд хэдэн улсуудын өрсөлдөөний эрх зүйд нэвтрээд байна. Өрсөлдөөний хууль тогтоомжийг сахиулахад нийтийн ашиг сонирхлын картель нь шүүхээс хууль тайлбарлах практикт тохиолдож байгаа ба чингэхдээ гол төлөв хүрээлэн буй орчныг хамгаалах, биологийн төрөл зүйлийг устахаас хамгаалах, нийгмийн эрүүл мэнд, тогтвортой хөгжлийн асуудлуудыг үүнд хамааруулж эдгээр чиглэлээр картель гэрээ, хэлцлийг зөвтгөж байгааг шүүх харгалзан үздэг болжээ.⁴⁹

Өгүүллийн өмнөх хэсэг(2.1.1)-г дурдсанчлан НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал (UNCTAD) 1998 онд картельтэй үр дүнтэй тэмцэх тухай зөвлөмжийг боловсруулахдаа улс орнууд хууль тогтоомжоор зөвшөөрсөн хэлцэл, зохион байгуулалттай арга хэмжээг картельд тооцохгүйгээр зохицуулж болохыг тэмдэглэсэн байдаг.⁵⁰

3/ Картелийг дэмжиж оролцох. Картелийн өвөрмөц гурав дахь хэлбэрийг манай Өрсөлдөөний тухай хуульд картельд тооцохоор⁵¹ хуульчилсан. Чингэхдээ өмнөх хоёр хэлбэрийн гэрээ, хэлцэлийг дэмжиж оролцсон байх шинжийг картельд тооцон хориглохоор заажээ. Текстын шууд агуулгаар уншвал гэрээ хэлцлийг дэмжиж оролцсон гэдэгт юуны өмнө хуульд заасан хоёр төрлийн картелийн аль нэг байгуулагдсан байх, мөн энэ үгсэл тохиролцоонд шууд оролцоогүй, албан ёсны гэрээ, хэлцэл байгуулалгүйгээр араас нь дэмжиж, үйл ажиллагаа, үнэ тарифын шийдвэрээр дагасан байхаар ойлгогдож байна.

Энд нэгэн сонирхолтой асуудал гарч ирнэ. Өрсөлдөгч нартай шууд хэлцэл байгуулж оролцоогүй боловч тэдгээрийн авч хэрэгжүүлж байгаа шийдвэр, үйл ажиллагааны зорилго чиглэлийг санаатайгаар “аялдан дагалдагсад”-ыг буруутгах үндэслэл байж болно. Гэтэл зах зээл дээр гэнэт зонхилоод ирсэн өөрчлөлт, эсхүл зах зээлд манлайлагчийн үнийн хандлагыг баримжаалаад сурчихсан “гэмгүй” өрсөлдөгч дассан сурснаа хийхэд л картель хийсэнд тооцогдох боломжтой юм. Ялангуяа сүүлийн тохиолдолд хамаарч торгуулийн шийтгэл хүлээсэн тохиолдолд хэрэглэгч нар хохирол нэхэмжлэх хүртэл үр дагавар үүсэх боломжтой.

Картель нь үнийг үгсэж хуйвалдах (price fixing) үйлдэлд илүү холбогдохоос бус үнийн хандлагыг дагаж өөрийн үнээ тогтоож байгаа (price taking) аж ахуй эрхлэгчид хамаатай асуудал мөн билүү? Тиймд ялгаатай ойлголтуудыг ялгамжтай хуульчлахгүй бол үзэмжээр аж ахуй эрхлэгчийн эрхийг зөрчихөд хүргэж болзошгүй байна.

Хэрэв хууль тогтоогч өрсөлдөгч нар албан ёсны гэрээ, хэлцэл байгуулахгүйгээр шууд бусаар үгсэн тохирч, үйл ажиллагаагаар “дөрөө харшуулан явах” (alignment)-ыг хориглох зорилготой байсан гэвэл тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-г хуульчилсан энэ ойлголтын анхны санаа нь гадаадын зарим орнууд (тухайлбал, Британи, Сингапур, Малайз, Австрали)-ын өрсөлдөөний эрх зүйд болон Европын өрсөлдөөний эрх зүйд тогтсон “concerted practice” буюу “зөвшилцөх практик” гэж орчуулж болох ойлголт байж, хууль боловсруулах, батлагдах явцад утга санаа нь бүдгэрсэн байж магадгүй юм. Картелийн хүрээнд зайлшгүй авч үздэг энэхүү үзэгдлийг манай өрсөлдөөний эрх зүйд өмнө нь хөндөж байгаагүй бөгөөд хууль тогтоомжид тусгагдаагүй юм.

Өрсөлдөөний эрх зүй судлаачдын хөгжүүлж буй нээлттэй цахим толь бичигт “зөвшилцөх практик”-ийг талууд заавал нэгдсэн тохиролцоонд хүрэхгүйгээр өрсөлдөөний эсрэг хамтран ажиллах нэг хэлбэр гэжээ. Чингэхдээ, шууд болон шууд бус харилцаа холбоогоор дамжуулах ба талуудын энэхүү уялдаа холбоо ба зах зээлийн хэвийн нөхцөлийг өөрчлөх гэсэн учир шалтгааны хоёр хүчин зүйлийн нэгдэл гэж тодорхойлсон. Зөвшилцөх практик нь аж ахуйн эрхлэгчийн ирээдүйд төлөвлөж буй үнэ, гарц, хүчин чадал зэрэг

⁴⁹ Schinkel, M. P., & Toth, L. Balancing the public interest-defense in cartel offenses. Amsterdam Center for Law & Economics Working Paper, (2016-01), p.2.

⁵⁰ ‘The set of multilaterally agreed equitable principles for the control of -restrictive business practices’ (UNCTAD 1980).

⁵¹ Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг.

арилжааны нууц мэдээллийг бодит болон/ эсхүл боломжит өрсөлдөгчдийн хооронд солилцох үед өрсөлдөөнд хор хөнөөл учруулна⁵² гэдэг.

Чөлөөт зах зээл өндөр хөгжсөн орнуудад аж ахуй эрхлэгчид бие даан ажиллаж, зах зээлийн нөхцөл байдалд зохицсон бодитой шийдвэр гаргах бүх талын боломжийг бүрдүүлэх, түүнийг гажуудуулахыг хуулиар хориглодог.⁵³ Учир нь бие даан шийдвэр гаргах нь чухамдаа эрэлт, нийлүүлэлтийг жинхэнэ утгаар нь тэнцвэрт оруулж, түүнд аж ахуйн нэгж бүр дасан зохицох ёстой ердийн зан үйл байдаг. Энэ нь зах зээл дэх ирээдүйн зан төлөв, жишээлбэл, ирээдүйн үнэ, стратегийн талаар шийдвэр гаргахдаа өрсөлдөгч нь бусад өрсөлдөгчдийн нөлөөнд автахгүй байх ёстой гэсэн үг юм. Өрсөлдөгчдийн хооронд шууд үүсдэггүй холбоо, харилцаа холбоог гуравдагч этгээд бий болгож арилжааны нууц мэдээлэл солилцуулдаг жишээнд салбарын холбоод, дистрибьютер эсхүл нэг жижиглэн худалдаалагчаас нөгөөд нийлүүлэгчээр дамжуулах гэх мэт орно.⁵⁴

3.2.3. Шүүмжлэлт дүн шинжилгээ: Картелийн тодорхойлолтын логик зөрчил ба үр дагавар

Картелийн тодорхойлолтын маргаан дагуулахуйц асуудал нь Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3 дахь хэсэгт картелийг тодорхойлохдоо босоо болон хэвтээ чиглэлтэй харилцааг аль алиныг нь багтаахуйц “аж ахуй эрхлэгчдийн”⁵⁵ хооронд” гэсэн ерөнхий илэрхийлэл ашигласантай холбогдож байна. Дараах логик зөрчил, үр дагавар гарахаар байна.

Энэ өгүүллийн эхэн(II хэсэг)-д картелийн шинжийг ойлголтын болон онолын түвшинд авч үзэхэд картель нь нэг бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл дэх хэвтээ/horizontal/ чиглэлд орших өрсөлдөгчдийн хооронд явагддаг үгсэл, тохиролцоо болохыг дурдсан. Тэрчлэн Өрсөлдөөний тухай 2010 оны хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдахаас өмнөхөн судлаач М.Уянга, хөндлөн шугамын түвшин байгаа аж ахуйн нэгжүүдэд тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний талаар хуйвалдахыг картель гэж нэрлэдэг⁵⁶ хэмээн картелийг босоо чиглэлтэй гэрээний харилцаанаас зөв зүйтэй ялгаж байсан ч, харамсалтай нь өрсөлдөөний тухай хуульд үүнээс эсрэг байдлаар тусгагдсан. Үнэхээр ч судлаач М.Уянгын тодорхойлж байсантай утга нэг байдлаар өрсөлдөөний эрх зүйн онолын ном сурах бичгүүдэд картелийг хэвтээ чиглэлд өрсөлдөгч нарын байгуулдаг өрсөлдөөнд харш үгсэл, тохиролцоо хэмээн тодорхойлсон нь нийтлэг байна.⁵⁷

Ж.Фийр “босоо картель” гэх ойлголт байх ёсгүйн учир нь картель ижил төстэй бүтээгдэхүүний зах зээлийг өөр хоорондоо хянах зорилготой өрсөлдөгчдийн харилцаа тул ханган нийлүүлэгчид, туслан гүйцэтгэгчид, бөөний худалдаачид, жижиглэнгийн худалдаачид эсхүл аж ахуйн нэгжүүдтэй хийсэн урт хугацааны гэрээ нь өрсөлдөөнд харш байх ч картель биш юм. Үүнийг «босоо картель” гэж төсөөлж болох ч тэдгээрийг

⁵² <https://www.concurrences.com/en/dictionary/Concerted-Practice> [Сүүлд үзсэн огноо: 07/29/2023]

⁵³ Английн давж заалдах шатны шүүхийн Өрсөлдөөний эрх зүйн танхим Британийн Шударга худалдааны газраас Argos Ltd & Littlewoods and Umbro Holdings Ltd-д холбогдуулан зөвшилцөх практик ашиглан мэдээлэл солилцсонтой холбогдуулан торгууль ногдуулсныг эс зөвшөөрч гаргасан гомдлыг давж заалдах шатны журмаар хянаад зуучлагчаар дамжуулан мэдээлэл солилцсоныг өрсөлдөгчдийн бие даасан байдалд нөлөөлж өрсөлдөөнийг хязгаарлах гэсэн зорилготой зөрчил гэж тооцож, давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн байдаг. <https://www.catribunal.org.uk/cases/10141103-10151103-argos-limited-lit-littlewoods-limited> [Сүүлд үзсэн огноо: 07/29/2023]

⁵⁴ Ibid.

⁵⁵ Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “аж ахуй эрхлэгч” гэж Монгол Улсад бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүнийг ойлгоно гэж тодорхойлсон.

⁵⁶ М.Уянга “Хууль зүйн судалгааны зарим асуудал” (түүвэр эмхэтгэл) Уб, 2014, 50 дахь тал, энэ өгүүлэл нь МУИС-ийн “Эрх зүй” сэтгүүлийн 2010 оны №18-19 дугаарт нийтлэгдсэн.

⁵⁷ Fox E. M. & Crane D. A. (2017). Global issues in antitrust and competition law (Second). West Academic Publishing. pp.5-9; Whish R. & Bailey D. (2012). Competition law (7th). Oxford University Press. pp 512-552; Jones A. & Sufrin B. (2008). EC Competition Law: Text cases and Materials. Oxford University Press. pp 866-7; Fox E. M. Gerard D. & Edward Elgar Publishing. (2023). Eu competition law cases texts and context (Second). Edward Elgar Publishing. pp 33-4.

пүүсүүдийн сүлжээ, стратегийн түншлэл, аж ахуйн нэгжүүдийн бүлэг эсхүл хамтарсан компани гэвэл илүү оновчтой гэж үзсэн.⁵⁸

Босоо чиглэлтэй /vertical/ харилцаа гэдэг нь бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын гинжин хэлхээг үйлдвэрлэгчээс эцсийн хэрэглэгчийн гар дээр хүргэх аж ахуйн амьдралын мөчлөгийг илэрхийлсэн ойлголт. Энэ л мөчлөгт үнэ хэлцэн тогтоогдож байдаг. Гэтэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хууль дахь картелийн тодорхойлолтонд дараах эргэлзээ зүй ёсоор үүсэж байгааг тодруулбал:

/а/ Босоо түвшинд үнийн бүх хэлцлийг хориглосон мэт ойлгогдох логик зөрчил. Үйлдвэрлэгч, агуулахын, бөөний худалдаалагч, зуучлагч, худалдааны төлөөлөгч, дистрибьютерууд, эцсийн буюу жижиглэнгийн худалдаалагч нарын хооронд шат шатандаа, тус тусдаа худалдах-худалдан авах гэрээ байгуулагддаг. Нэгэнт худалдах, худалдан авах гэрээ байгуулагдах үед түүний гол бөгөөд зайлшгүй нөхцөл болох “бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох” шаардлага үүснэ. “Хэлцэн тогтоох” гэдэг үгийн үндэс “хэлцэх”, “хэлцээ” нь ямарваа сөрөг утга агуулдаггүй.⁵⁹ Мэдээж хэвтээ чиглэлд өрсөлдөж байгаа талуудын хооронд борлуулах бүтээгдэхүүний үнийг хэлцэн тохирох нь зүй бус бөгөөд хориглох ёстой үйлдэл мөн. Харин босоо чиглэлд буй жам ёсны гэж хэлж болох ийм харилцааг эрх зүйн хувьд хориглосон нь ердөө эрх зүйн хэм хэмжээн дэх алдаа зөрчил биз хэмээн хүлгэлзэж, цаашид залруулна хэмээн найдна.

/б/ Дахин борлуулах үнийг тогтоох бодлогын бүх оролдлогыг хориглож, оролцсон бүх талуудад эрх зүйн хариуцлага хүлээлгэх нөхцөл байдал бий болсон нь. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийн дээд түвшин (upstream market) буюу үйлдвэрлэгчээс эцсийн, тэрчлэн жижиглэнгийн худалдааны зах зээл (downstream market)-д борлуулах үнийг тогтоохыг “resale price maintenance” (RPM)⁶⁰ гэдэг. Энэ нь бизнест түгээмэл хэрэглэгддэг нэг үнийн стратегитай холбогддог. Гэтэл энэ нь манай улсын өрсөлдөөний тухай хуулиар уг стратегийг хэрэгжүүлэгч давамгай байдалтай төдийгүй тийм биш жижиг аж ахуйн нэгжүүдэд, RPM бодлого хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулсан талд, эс үйлдлээр энэ бодлогод нэгдэгчдэд хууль зүйн хувьд эрсдэлтэй эрх зүйн зохицуулалт юм.

Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “тухайн бараа бүтээгдэхүүнийг дахин борлуулах үнэ, нутаг дэвсгэрийг тогтоож өгөх” (RPM) үйлдлийг зүй ёсны монополь, давамгай байдалтай аж ахуй эрхлэгчид хориглосон. Шууд бус утгаараа давамгайлагч биш “аж ахуй эрхлэгч” нь RPM-ыг тус хуулийн 11 дүгээр зүйл /картель/-ийн 11.1 дэх заалтаар хориглосон гэж ойлгогдоно. Манай улсын шүүхийн практикт (зах зээлд давамгайлагч байр суурьтай аж ахуй эрхлэгч бус) RPM-ыг “босоо картель” гэж үзээд хориглож шийдвэрлэсэн тохиолдол байна. Хэдий тийм ч шүүхээс хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг хэрэглэн шийдвэрлэсэн тул түүнийг буруутгах боломжгүй юм.

⁵⁸ Ibid., p.7.

⁵⁹ “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” <http://toli.gov.mn> -д 1. хэлцэл 1.17.4 [ж.н] гэрээ, тохирол; 1. хэлцээ 1.12.4 [ж.н] яриа, хэлэлцээ хийх.

⁶⁰ Timo Klein, Resale Price Maintenance (RPM), Global Dictionary of Competition Law, Concurrences, Art. N° 12338.

Шигтгээ 2: Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2020 оны 90 дүгээр тогтоол.

Факт:

“М-Си-Эс Кокакола” ХХК нь өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний жижиглэнгийн борлуулалтыг нэг үнийн бодлогоор борлуулах нөхцөлийг “Оргил”, “Номин”, “Скай” сүлжээ дэлгүүрүүдэд тавьж, тэдгээртэй нийлүүлэлтийн гэрээ байгуулжээ.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн газрын улсын байцаагч нар “М-Си-Эс Кокакола” ХХК нь Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэж, өмнөх жилийн борлуулалтын орлогоос тодорхой хувиар тооцож торгох шийтгэл ногдуулсан байна.

“М-Си-Эс Кокакола” ХХК нь дээрх шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулахаар захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан. Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүх гомдлыг хангаж шийдвэрлэсэн бол Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасныг Давж заалдах шатны шүүх хангаж шийдвэрлэсэн, “М-Си-Эс Кокакола” ХХК нь Давж заалдах шатны шүүхийн магадлалыг үндэслэлгүй гэж үзэн Улсын Дээд шүүхэд хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан боловч хяналтын шатны шүүх гомдлыг хянаад Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж, хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн.

Улсын Дээд Шүүхийн шийдвэрийн үндэслэлээс:

“23. Хэдийгээр хууль тогтоогч картелийн хэлбэрийг нарийвчлан заагаагүй ч хууль зүйн онол болон олон улсын практикт ийм төрлийн картелийг “босоо” ба “хэвтээ” гэж ангилан авч үздэг...”

24. Мөн гомдол гаргагч нь тухайн гэрээ байгуулсан зорилгоо тайлбарлахдаа “хэрэглэгчид хямд үнийн баталгаа гаргах” гэж байгаа боловч хууль тогтоогч хэлцэн тохирч үнэ тогтоох бүхий л хэлбэрийг “шударга бус” хэмээн хориглосон буюу хэрэглэгчид хүрэх хямд үнэ нь хэлцэл (картель)-ийн журмаар бус, харин өрсөлдөөний үр дүнд хэрэглэгчид бараа бүтээгдэхүүний хямд үнэ тогтоох чөлөөт зах зээлийн үзэл баримтлалыг хуульчилсан учир энэ талаарх гомдлыг хүлээн авах боломжгүй байна” гэжээ.

RPM-ыг хэрэгжүүлэхийн тулд бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс жижиглэнгийн борлуулагч нэг бүртэй эцсийн хэрэглэгчид тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах үнийг нэг түвшинд байлгах талаар хэлцэл хийх зайлшгүй шаардлагатай болдог.

Нөгөө талаар жижиглэнгийн борлуулагч нар RPM бодлого бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулах үнийн талаар өөр хоорондоо хэвтээ түвшинд гэрээ, хэлцлийн харилцаанд оролцдоггүй боловч бодит үйлдлээр, эсхүл эс үйлдлээр RPM бодлогыг хэрэгжүүлэхэд хамжиж, эсхүл дан дангаараа уг хөтөлбөр, бодлогод нэгдэж, дэмжиж оролцох нөхцөл байдалд орно. Чингэснээр тэд Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг зөрчих байдалд хүрэх юм.

Хууль зүйн бодлогын хувьд улс орнуудын өрсөлдөөний хууль тогтоомж RPM-ыг янз бүрээр зохицуулсан боловч өрсөлдөөний эрх зүйн олон жилийн түүхтэй улс орнуудад, тухайлбал, АНУ-ын Дээд шүүхийн жишигт 1997 оноос хойш энэ үйлдлийг хууль бус гэж тооцохын өмнө “учир шалтгаанд захирагдах ёс” (rule of reason)-ны үүднээс авч үзэж,

эдийн засгийн үр дагаврыг нь шинжилж үзэх болсон байна.⁶¹ Учир нь зах зээлд давамгай байдалтай үйлдвэрлэгч/нийлүүлэгч RPM хэрэгжүүлэхдээ жижиглэнгийн худалдаалагчдад шахалт үзүүлж, нөхцөл тулгаж дагахгүй бол бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхээ зогсоох ба чингэснээр хэрэглэгч хохирох, хэрэглэгчээ бодож бараа бүтээгдэхүүнийг тус нөхцөлөөр нь хүлээн авахад өөрөө алдагдал хүлээж болдог байх нь бий. Гэтэл үүний нөгөө талд зах зээлийн хүч нөлөө багатай аж ахуй эрхлэгч өөрийн бүтээгдэхүүнд RPM бодлого хэрэгжүүлбэл бүх ашиг ба эрсдэлийг зөвхөн өөрөө хариуцах ба бусад өрсөлдөгчид хохиролгүй, зах зээлд нөлөө үзүүлэхгүй, шинээр зах зээлд ороход нь ялгарах зүйл болж, өрсөлдөөн ба сонголтыг нэмэгдүүлж, энэ нь магадгүй хэрэглэгчид ашигтай байж болно.

Тиймээс “аж ахуй эрхлэгчдийн хооронд” гэдэг үгийг мөн хуулийн 11.1 дэх хэсгээс хассан “өрсөлдөгч нарын хооронд” гэсэн үгээр сольсноор RPM-ыг манай улс зөвхөн зүй ёсны монополь, давамгай байдалтай аж ахуй эрхлэгчид хориглосон гэж нэг мөр ойлгогдоно. Ингэснээр, бизнесийн салбарын давамгайлагч бус оролцогчдод бусдад хохиролгүй, “өөрсдөө эрсдэлээ хариуцсан” үнийн янз бүрийн хувилбаруудаар өрсөлдөх эрх чөлөө олгох юм. Зах зээл өндөр хөгжсөн олон оронд нэг үнийн бодлогоор ялгарах, бүх бүтээгдэхүүн нэг үнэтэй дэлгүүр худалдааны төв ажиллаж, хэрэглэгчид өргөн сонголтыг өгч байдаг.

/в/ Үйлдвэрлэгчээс борлуулалтын зохион байгуулалт хийх боломжийг хязгаарласан агуулгатай логик зөрчил. Босоо чиглэлтэй харилцааны үед аж ахуй эрхлэгч нь өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтын төлөөлөгч, онцгой эрхт дистрибьютеруудтай газарзүйн байршил, тээврийн зардал, ложистик, агуулахын хүрэлцээ зэрэг зайлшгүй хүчин зүйлсийг харгалзан эдийн засгийн үр ашигтай ажиллах объектив нөхцөл бололцоог тооцож, тэдгээрийн хариуцах хамгийн боломжит “зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэр, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл худалдан авагчаар хуваарилах” харилцаа гарцаагүй явагддаг. Гэвч Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т хэвтээ, босоо аль чиглэлтэй харилцааг хориглож байгаа нь ойлгомжгүй хуульчлагдсан. Энд зөвхөн босоо чиглэлтэй харилцаан дахь хуваарилалт, зохион байгуулалтыг онцолж байгааг дахин тэмдэглэе. Харин өрсөлдөгчдийн буюу хэвтээ түвшний харилцааны тухайд хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасан хуваарилах үйлдлийг хориглох нь зүй ёсны юм.

IV. ДҮГНЭЛТ

1. Картелийн тухай онол, үзэл баримтлал, өрнөж буй мэтгэлцээнүүдийг харьцуулан үзсэнээр тус үзэгдлийн мөн чанар, төрөл, хэлбэр, хөгжлийн мөчлөг зэрэг олон чухал ойлголтыг танин мэдэж, хууль зүйн бодлого, эдийн засгийн эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэхэд онол, арга зүйн ач холбогдолтой юм.

2. Картелийн сонгодог онол, шинэлэг хандлагаар картель нь эдийн засгийн хүнд нөхцөлд аяндаа бий болдог үзэгдэл, олон тохиолдолд өрсөлдөгчдийн зүгээс үндэсний эдийн засагт ач холбогдолтой шийдлүүдийг төлөөлдөг хэмээн нотолж байна. Тэгвэл картелийн орчин үеийн онол үүнийг илүү өргөн хүрээгээр авч үзэж, картель зөвхөн сайн сайхан санаачилга агуулсан зүйл бус харин өрсөлдөөнийг хянаж, хязгаарлах гэсэн хүсэлд хөтлөгдсөн, тодорхой нөхцөл бүрдсэн үед бий болдог эдийн засаг дахь үзэгдэл хэмээн үздэг билээ. Орчин үеийн онолын үндсэн дээр хүнд хэлбэрийн картель нь нийгэмд хор аюултай үйлдэл тул үндэсний эрх зүйд эрүүгийн гэмт хэрэгт тооцох ёстой гэсэн олон улсын зохицуулалтын хөдөлгөөн өрнөж байна гэж хэлж болно. Манай улсад картелийг Зөрчлийн тухай хуулийн хамгийн хүнд санкцтай зөрчил болгон хуульчилсан байдлаас үзвэл хууль тогтоогч олон улсын зарим байгууллага, тухайлбал, Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллагаас нийтэлсэн зөвлөмж, нийтлэлүүдээс чиг баримжаа авсан, эсхүл түүний нөлөө туссан болов уу гэсэн таамаглалд хүрэв.

⁶¹ https://www.law.cornell.edu/wex/resale_price_maintenance_agreements [Сүүлд үзсэн огноо: 07/29/2023]

3. Экспортын картель нь аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудын дотоодын аж ахуйн нэгжүүд гадаадын шинэ зах зээлд нэвтрэхэд хамтран ажиллах, энэ явцдаа тулгарч буй тарифын болон тарифын бус саадыг даван туулах, өөр хоорондоо өрсөлдөхөөс илүү шинэ зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ байршуулахад төвлөрөх зэрэг ач холбогдолтой бөгөөд экспортын картелийг бүртгэх, зөвшөөрөл олгох эрх зүйн зохицуулалтыг нухацтай судалж, үндэсний эрх ашгийн үүднээс Монгол Улс дахь картелийн эрх зүйн зохицуулалтын үзэл баримтлалын хүрээнд авч үзэж, шинээр нэвтрүүлэх нь чухал гэж дүгнэж болохоор байна.

4. Өрсөлдөөний тухай Монгол Улсын хууль дахь картелийн эрх зүйн зохицуулалтыг энэ өгүүллийн эхэнд шинжлэн үзсэн онол, арга зүй, үзэл баримтлалуудын хүрээнд хангалттай тайлбарлах боломжгүй байна. Анх батлагдах үед онол, практикийн хангалттай хэлэлцүүлэг өрнүүлээгүй байгаагаас хууль тогтоогчийн үзэл баримтлалыг тодруулахад хүндрэл үүссэн.

5. Картелийн тодорхойлолтыг Өрсөлдөөний тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуульчлахдаа босоо ба хэвтээ харилцааг ялган зааглаагүйгээс энэ үзэгдлийг өрсөлдөгчдийн хооронд бий болж буй үгсэл, тохиролцоо гэдэг онолын ойлголтоос хазайлгаж, дахин борлуулах үнийг тогтоох, борлуулалтын сүлжээг босоо түвшингээс удирдах үйл ажиллагааг зөрчил болгох үр дагаварт хүрсэн байх тул цаашид өрсөлдөөний хууль тогтоомжийг аж ахуйн үйл ажиллагааны түгээмэл үйл ажиллагаа, хэв шинжтэй хэлбэр, агуулгын хувьд зөрчилдөхгүй байлгахад анхаарах шаардлагатай.

6. Зөвшилцөх практик (concerted practice), энэ хүрээнд арилжааны нууц мэдээлэл зуучлах, хуваалцах зэргээр зах зээлийг урвуулан ашиглах үйл ажиллагааг хуулиар хориглож байгаа гадаад орнуудын туршлагаас нэвтрүүлж өөрийн улсын өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгоход анхаарч үзэл баримтлалын хэмжээнд авч үзэж хуульчлах шаардлагатай гэж үзэж байна.

7. Нийтийн эрх ашгийн үүднээс зөвшөөрч болох картелийн бүртгэл, хяналт дүн шинжилгээ хийх, зөвшөөрөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, энэ чиглэлээр дагнасан судалгаа хийх шаардлагатай байна. Нэн ялангуяа, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийг устгахаас сэргийлэх болон нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг анхаарах чиглэлээр гадаад орнуудын туршлагыг судлан үзэл баримтлалын хүрээнд анхаарч өрсөлдөөний хууль тогтоомжид тусгах шаардлага бий болжээ.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээр*****Ном, өгүүлэл, судалгааны тайлан***

1. Б.Амарсанаа, М.Уянга, Г.Давааням нар “Өрсөлдөөний эрх зүйн онол, практик УБ., 2022
2. Б.Амарсанаа, Г.Давааням, С.Батбаяр, Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар, Д.Ганхүрэл “Арилжааны эрх зүй” УБ., 2022
3. Б.Буянхишиг “Хувийн эрх зүй: Онол – арга зүй, эдийн засгийн анализ, харьцуулсан судлал” (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) УБ., 2017
4. “Монгол Улсын Өрсөлдөөний эрх зүйн эх сурвалжид холбогдох баримт бичиг (1993-2022)” МУИС, ЭЗБЭЗСТ, УБ., 2023.
5. Н.Баярмаа, “Өрсөлдөөний эрх зүй ба гэрээ” эрдэм шинжилгээний өгүүлэл, УБ, 2017, <https://legaldata.mn/b/310>.
6. Т.Мөнх-Эрдэнэ, “Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь” эрдэм шинжилгээний өгүүлэл, <https://legaldata.mn/buteel/pdf?id=143>.
7. М.Уянга, “Хууль зүйн судалгааны зарим асуудал” (түүвэр эмхэтгэл), УБ., 2014, “Эрх зүй” сэтгүүл, 2010, №18-19.

Гадаад хэл дээр***Ном, өгүүлэл, судалгааны тайлан***

1. A.Ezrachi, Competition and Antitrust law. A Very Short Introduction, Oxford University Press, 2021.
2. Dictionary of Law. Ed. Law, Jonathan: Oxford University Press, 2009.
3. ‘The Set of Multilaterally Agreed Equitable Principles for The Control Of -Restrictive Business Practices’, UNCTAD 1980.
4. Eleanor M. Fox, Daniel A. Crane, ‘Global Issues in Antitrust and Competition Law’, Second Edition, 2017.
5. Robert Liefmann, Cartels, Concerns and Trusts (1932, First edition) Batoche Books Kitchener 2001.
6. H.A.Leonhardt: The Development of Cartel 28 + Theory between 1883 and the 1930s.
7. Stocking G.W. and M.W. Watkins, Cartels or Competition? The Economics of International Controls by Business and Government, New York: The Twentieth Century Fund, 1948.
8. G.J.Stigler, ‘A Theory of Oligopoly’, Journal of Political Economy, Vol. 72, 1964, pp 44-61; reprinted in his The Organization of Industry, University of Chicago Press, 1968.
9. Beaton-Wells, C., & Ezrachi, A. Criminalizing cartels: Critical Studies of an International Regulatory Movement, Hart Publishing, 2011.
10. A.Ezrachi, Competition and Antitrust law. A Very Short Introduction, Oxford University Press, 2021.
11. Fear, J. R. Cartels and competition: Neither markets nor hierarchies. Division of Research, Harvard Business School, 2006.
12. Sokol, D. D. What do we really know about export cartels and what is the appropriate solution? Journal of Competition Law and Economics, 4(4), 2008, p.968;
13. Becker, F. The Case of Export Cartel Exemptions: Between Competition and Protectionism’, 2007, Journal of Competition Law & Economics, p.3.
14. ‘Encyclopedia of World Problems & Human Potential’: <http://encyclopedia.uia.org/en/problem/134189>.

15. Becker, F. The Case of Export Cartel Exemptions: Between Competition and Protectionism', *Journal of Competition Law & Economics*, 2007, 3.
16. Martyniszyn, M. Export cartels: is it legal to target your neighbor? Analysis in light of recent case law. *Journal of International Economic Law*, 2012, 15(1).
17. Sokol, D. D. What do we really know about export cartels and what is the appropriate solution? *Journal of Competition Law and Economics*, 2008, 4(4).
18. *Regulating Competition : Cartel Registers in the Twentieth-Century World*. ROUTLEDGE; 2019
19. Brinsmead, S. (2021). *Essential Interoperability Standards: Interfacing Intellectual Property and Competition in International Economic Law*. Cambridge University Press.
20. Hovenkamp, H. (2023). *Antitrust Interoperability Remedies*. *Columbia Law Review*, 123(1)
21. <https://www.oecd.org/daf/competition/cartels/48948847.pdf>.
22. <https://www.concurrences.com/en/dictionary/Collusion-12162>.
23. Schinkel, M.P, Toth, L, Balancing the public interest-defense in cartel offenses. *Amsterdam Center for Law & Economics Working Paper Paper*, 2016-01.
24. <https://www.concurrences.com/en/dictionary/Concerted-Practice>.
25. <https://www.catribunal.org.uk/cases/10141103-10151103-argos-limited-littlewoods-limited>.
26. Whish R. & Bailey D, *Competition law (7th)*. Oxford University Press, 2012.
27. Jones A. & Sufrin B., *EC Competition Law: Text cases and Materials*. Oxford University Press, 2008.
28. Timo Klein, *Resale Price Maintenance (RPM)*, *Global Dictionary of Competition Law*, *Concurrences*, Art. N° 12338.
29. https://www.law.cornell.edu/wex/resale_price_maintenance_agreements.

CARTEL DEFINITION IN COMPETITION LAW OF MONGOLIA: THEORIES, CONCEPTS AND CRITICAL ANALYSIS

Otgonbayar.Lkh

*Senior Lecturer, Department of Legal Studies,
The University of Finance and Economics, Mongolia,
Ph.D student, School of Law, NUM
(LL.M University of Edinburgh, UK)*

ABSTRACT:

When the Mongolian Law on Competition was adopted in 2010, there was a lack of substantial theoretical and conceptual debate and discussion. Cartel formation, being a cornerstone of competition law, is a phenomenon addressed in this article. In the first part of this article, the author critically examines the historical development of theories, debates surrounding the legal regulation of cartels, and various conceptual frameworks, opinions, and ongoing discussions.

In the second part, the concept of cartels in the Mongolian Law on Competition is analyzed in comparison with the legal regulations of foreign countries. Finally, the author shares his opinion and criticism regarding the current state of the legal definition of cartels in Mongolia.

KEYWORDS:

Competition, competition law, cartel law, classic theory of cartel, modern theory of cartel, criminalizing cartels, firms' cooperation spectrum, export cartel, resale price maintenance.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТ НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС



Г. Дагвасүрэн
*СЭЗИС-ийн багш, Статистикийн
шинжлэх ухааны магистр, Бизнесийн
удирдлагын магистр*



Ц. Анужин
СЭЗИС-ийн оюутан

I. ТОВЧЛОЛ

Энэхүү судалгааны ажлаар мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэж буй байдлыг Базелийн Засаглалын Хүрээлэнгээс эрхлэн гаргадаг Базелийн индексээр төлөөлүүлэн түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг цогцоор нь судлахыг зорилоо. Эмпирик судалгаанд нийт 90 орны 2012 оноос 2020 он хүртэлх хугацааны давтамжтай авлигын төсөөллийн индекс, хүний хөгжлийн индекс, санхүүгийн институтийн индекс, санхүүгийн зах зээлийн индекс, ажилгүйдлийн түвшин, бизнесийн таатай орчин гэх хувьсагчдад мөнгө угаах эрсдэлийн түвшинд нөлөөлөхийг эконометрикийн загвар үнэлэн шинжилгээ хийлээ. Судалгааны үр дүнд авлигын төсөөллийн индекс болон санхүүгийн зах зээлийн индекс өсөх нь мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн түвшинг нэмэгдүүлж байна. Мөн түүнчлэн, санхүүгийн салбарын индекс, ажилгүйдлийн түвшин, хувь хүний хөгжлийн индекс, бизнесийн таатай орчны оноо нь өндөр байх тусам мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн түвшин бууруулна гэсэн үр дүн гарлаа. Иймд, боловсрол, эрүүл мэндийн өсөлт болон авлигатай тэмцэх арга хэрэгсэл, санхүүгийн хөгжлийн өсөлтөд хөрөнгө оруулах нь мөнгө угаах гэмт хэргийн эрсдэл, тархалтыг бууруулахад ихээхэн хэмжээний өгөөж авчрах болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Базелийн индекс, Гэмт хэргийн статистик, Хугацаан цуваан шинжилгээ, Регрессийн шинжилгээ

II. ҮНДСЭН ХЭСЭГ

Удиртгал

Мөнгө угаах гэмт хэрэг нь дэлхий даяар санхүүгийн систем, эдийн засаг, хууль сахиулах байгууллагуудад ихээхэн бэрхшээл учруулдаг өргөн хүрээтэй, нарийн төвөгтэй гэмт хэргийн үйл ажиллагаа юм. Хууль бусаар олсон хөрөнгийг хууль ёсны мэт хөрөнгө болгон хувиргах далд үйл явц нь хар тамхины наймаа, авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг янз бүрийн гэмт хэргийн байгууллагуудын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Дэлхийн эдийн засаг улам бүр харилцан уялдаатай болж байгаа энэ үед мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь засгийн газар, санхүүгийн байгууллага, олон улсын байгууллагуудын тэргүүлэх чиглэл болоод байна. Мөнгө угаахад нөлөөлж буй хүчин зүйлсийг ойлгох нь энэхүү хууль бус үйлдэлтэй тэмцэх үр дүнтэй бодлого, стратеги боловсруулах чухал алхам юм.

Өмнөх судалгааны ажлуудад мөнгө угаах гэмт хэргийн янз бүрийн талыг судалж байсан бол мөнгө угаах гэмт хэргийн түвшин болон түүнд нөлөөлөх гол хүчин зүйлс хоорондын хамаарлыг нарийн судлахын тулд эконометрик загварчлалын арга ашигласан нь энэхүү судалгааны гол онцлог болно. Энэхүү судалгааны зорилго нь хоёр талтай: нэгдүгээрт, мөнгө угаах үйл ажиллагаанд нөлөөлж буй нийгэм, эдийн засаг, санхүү, зохицуулалтын гол хүчин зүйлсийг тодорхойлох, хоёрдугаарт, эконометрик загвар ашиглан эдгээр хамаарлын хүч, чиглэлийг эмпирик байдлаар үнэлэх явдал болно. Мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдох олон төрлийн судалгааны ажлуудаас мөнгө угаах гэмт хэргийг эконометрик загвараар тайлбарласан судалгааны ажил хангалттай олон биш байлаа. Иймээс, энэхүү судалгааны ажил нь тус орон зайг тодорхой хэмжээнд нөхнө хэмээн найдаж байна.

Эконометрик арга, техникийг ашигласнаар бид мөнгө угаахтай холбоотой нарийн төвөгтэй динамикийн талаар найдвартай, өгөгдөлд тулгуурласан ойлголт өгөхийг зорьж байна. Аливаа улсын эдийн засаг нь гэмт хэргийн түвшин тодорхойлогч маш чухал үзүүлэлтийн нэг юм. Тухайн бүс нутгийн ажилгүйдэл, ядуурал өндөр байх нь орлогын түвшин буурч, иргэд санхүүгийн байдлыг сайжруулахын тулд хууль бус үйл ажиллагаанд оролцох буюу авлига, хээл хахуульд холбогдох зэрэг тус гэмт хэргийг нуун дарагдуулах магадлалтай. Ингэснээр, гэмт хэрэгтнүүд хууль, эрх зүйн зохицуулалт сул улмаас санхүүгийн институтийн тусламжтайгаар зах зээлд хууль бус орлогын хэлбэрийг хувиргах боломжтой юм. Тиймээс ажилгүйдэл, санхүүгийн салбар ба санхүүгийн зах зээлийн хөгжил, авлигын үзүүлэлтүүд өндөр байх нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх магадлал өндөр. Өрхийн орлогын түвшин, хууль эрх зүйн орчин өндөр байх нь мөнгө угаах гэмт хэргийн тохиолдол цөөн байх боломжтой гэх таамаглалыг дэвшүүлж байна.

Судлагдсан байдлын тойм

Майкл Леви, Питер Ройтер (2006) нар гэмт хэргийн олон хэлбэрээс мөнгө угаах гэмт хэргийг чухалчлан авч 1980 оноос эхлэн Британ улсад банкны салбарын санхүүгийн ажилтан Роберт Максвелл гэх хэвлэлийн үйлдвэр, тэтгэврийн сангаас мөнгө завшсан байна. Ингэснээр, тус хэрэгт холбогдох иргэдийн нэхэмжлэлийн дагуу банк ямар ч торгууль оногдуулаагүй бөгөөд тухай үед санхүүгийн салбараас гадна жижиг, дунд бизнес эрхлэгчид их хэмжээний хар тамхи тээвэрлэгдэг байжээ. Судлаачид мөнгө угаалт нь терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй харьцуулахад үйлдэгдэх үе шат ижил боловч мөнгө угаах гэмт хэрэг нь дансандаа бэлэн мөнгөөр орлого хийж эх үүсвэрийг нь нуун далдлах хэлбэрээр биет хөрөнгөд хөрөнгө оруулдаг¹. Харин, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь санхүүгийн системд хөрөнгөөр хөрөнгө оруулалт оруулж эх үүсвэрийг нь нуун далдлах

¹ Peter Reater and Edwin M. Truman., "Chasing Dirty Money: The Fight Against Anti-Money Laundering", Peterson Institute for International Economics, 2004.

хэлбэрээр терроризмын үйл ажиллагаанд оролцдог. Иймд, Дэлхийн банкны статистик тооцоололд үндэслэн 1980-аад оны дунд үеэс эхлэн Засгийн газар болон Хууль сахиулах байгууллагууд санхүүгийн системээр дамжих мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, түүнийг бууруулахын тулд арга хэмжээг боловсруулсан байна. Гэвч Америкийн Нэгдсэн Улсын мөнгө угаах үйлчилгээний зах, бусад улс орон луу мөнгө угаалтын тархалтын хэлбэр, мөнгө угаах гэмт хэрэгт бүртгэгдсэн статистик мэдээлэлд үндэслэн мөнгөний экспорт, өмч хөрөнгийн тоо, зээл, төлбөр тооцоо, банкны шилжүүлэг зэрэг мөнгө угаах гэмт хэргийн арга замыг дэлгэрүүлэн судалсан байна. Үүнээс харахад, хуулийн зохицуулалт нь мөнгө угаах гэмт хэрэгт хүчтэй нөлөөлсөн хэмээн статистик мэдээлэл хангалттай харагдахгүй байгаа нь мөнгө угаах гэмт хэргийн зардал ихтэй хуулийн зохицуулалт хийсний дараа өнгөлөн далдлах замаар өмнөх үеэс орчин үед харьцангуй бага мөнгийг эргэлдүүлж байна.

Надмид Кириаκος-Саад ба Жанлука Эспозито (2012) нар авлига ба мөнгө угаах гэмт хэргийн хоорондын хамаарлыг судалсан байна. Хээл хахууль, нийтийн эд хөрөнгө хулгайлахдаа хууль бус аргаар санхүүгийн системд нэвтрэх нь авлигын гэмт хэргийн нэг жишээ. Авлига нь мөнгө угаах гэмт хэрэгтэй хэрхэн холбогдох вэ? гэвэл мөнгө угаах үйл явцыг хөнгөвчлөх замаар авлига авсан албан тушаалтан мөнгө угааж байгаа гэмт хэрэгтнүүдэд хяналт, ял шийтгэлээс мултрах боломжийг олгодог байна. Судалгааны ажил нь мөнгө угаах гэмт хэрэг ба авлигын хоорондох санхүүгийн гэмт хэргийн талаар ФАТФ, Санхүүгийн секторын үнэлгээний төв, Олон Улсын Валютын Сан зэрэг байгууллагуудын статистик, жишээ баримтад тулгуурлан мөнгө угаах гэмт хэргийг хянахад олон талт арга барил, түүний ач холбогдол, авлига өндөр байгаа хэсэгт олон улсын байгууллагууд өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан түлхүү төвлөрч ажиллах, гэмт хэрэг их үйлдэгдэж буй улс оронд олон улсын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх нь тухайн улс орны мөнгө угаах болон авлигатай тэмцэх бодлогод чухал нөлөө үзүүлэх юм.

Санта Вайтилигам ба Махендхиран Наир (2007) зэрэг эрдэмтэд мөнгө угаах гэмт хэргийн үзэгдэлд дүн шинжилгээ хийж эхэлсэн бөгөөд судалгааны ажлууд нь эдийн засгийн загварт суурилжээ.

Санта Вайтилигам ба Махендхиран Наир (2007) нар мөнгө угаах гэмт хэргийн тархалтад нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлэх зорилготойгоор тус эмпирик судалгаанд технологи, хүмүүн капитал, хуулийн хэрэгжилт, хуулийн ёс зүй, инновацын чадамж зэрэг хүчин зүйлүүд хөгжингүй болон хөгжиж буй орнуудын мөнгө угаах гэмт хэргийн тархалтын нөлөөллийг судалсан байна. Судалгааны таамаглалаар хуулийн зохицуулалт буюу корпорацийн засаглал нь мөнгө угаах гэмт хэргийн үйл ажиллагаанд багаар нөлөөлнө. Харин, өндөр инновацын чадамжтай бол мөнгө угаах гэмт хэргийн тархалтад сөрөг хамааралтай байх боломжтой. Эмпирик арга зүй нь 88 хөгжиж буй болон хөгжингүй улс орнууд мөнгө угаах гэмт хэргийн гурван үе шаттай тархалтын хоёр суваг болох банк ба банк бус санхүүгийн байгууллагуудыг авч үзэж олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээг үнэлсэн. Тэрбээр, мөнгө угаах гэмт хэргийн эдийн засгийн эхний загварт технологи, хүмүүн капитал, хуулийн хэрэгжилт, хуулийн ёс зүй, инновацын чадамж зэрэг хувьсагчид мөнгөний тархалтын нөлөөлөл шалгасан. Хоёр дох загварт хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хувьд хуурмаг хувьсагчдын оруулж ирсэн. Гурав дах загварт огтлолцох болон налуу хуурмаг хувьсагчдыг оруулж ирснээр хөгжиж буй болон хөгжингүй орнуудын мөнгө угаах гэмт хэргийн ахиу нөлөөг харуулсан. Эмпирик үр дүнгээр, хөгжингүй орнуудын дэд бүтэц буюу технологийн дэвшил хөгжиж буй орнуудтай харьцуулахад мөнгө угаах гэмт хэргийн тархалтыг бууруулж байна. Хүмүүн капитал нь мөнгө угаах гэмт хэргийг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байгаа ч 10 хувийн түвшинд статистик ач холбогдолтой үнэлгээ илрээгүй. Гэхдээ, дээрх загварт хуурмаг хувьсагчийн ахиу нөлөө илэрснээр сөрөг хамаарлыг бий болгосон байна. Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын хуулийн зохицуулалтын үр ашгийн түвшин нь мөнгө угаах гэмт хэргийн тархалтад нөлөөлөх буюу

хууль зохицуулалт өндөр байх нь мөнгө угаах гэмт хэргийн тархалт багасаж байгаа гэх илрэл нь судлаачдын таамаглал биелсэнгүй. Инновацын чадамж нь мөнгө угаах гэмт хэргийн тархалтад сөрөг 5 хувийн түвшинд статистик ач холбогдолтой. Инновацын чадамж нэмэгдэх тусам мөнгө угаах гэмт хэргийг илрүүлж бууруулна бөгөөд судлаачдын таамаглал биелсэн гэх үндэслэлтэй байна. Дүгнэлтэд, судалгааны ажлын эмпирик шинжилгээгээр хөгжиж буй орнуудын таван хүчин зүйлс нь хөгжингүй орнуудын үзүүлэлтээс бага байна. Үнэлсэн загваруудад зохих засварын хийж үнэлсэн ч улс орнуудын мөнгө угаахтай тэмцэх бодлогыг сайжруулахад нөлөө үзүүлэх илүү урт хугацааны мэдээлэлд үндэслэн мөнгө угаах гэмт хэргийн сайн эконометрикийн загвар үнэлэх хэрэгтэй.

Онол, арга зүй

Эртний соёл иргэншлээс мөнгө угаах гэх ойлголт улбаатай бөгөөд түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлоход ихээхэн нарийн төвөгтэй ч тодорхой хэд хэдэн хүчин зүйлсийн талаар авч үзэх нь зүйтэй. Одоогоос 2000 гаруй жилийн өмнө эртний Хятад, Ромын эзэнт гүрний хөрөнгөжсөн албатууд хүн наймаалах, томоохон дээрэм тонуул хийх, авлига, хээл хахууль авах болон түүнтэй нэр холбогдох, алба гувчуураас зайлсхийх зэрэг хууль бус үйл ажиллагаа эрхэлснээр авлига бол эртний үзэгдэл бол сүүлийн үед мөнгө угаах гэмт хэрэг танигдсан. Хамгийн нөлөө бүхий авлига нь Преториан харуулын авлига бөгөөд Ромын эзэнт гүрний уналтын нэг шалтгаан байсан гэж эрдэмтэн судлаачид үздэг².

1810 Наполеоны код нь авлигын эсрэг ял оноох тухай хатуу тусгасан байна³. Мөнгө угаах гэмт хэрэг нь анх их хэмжээний үйлдвэрлэл, аж ахуй нэгжүүдийн өсөлтөөс хууль бус орлого олох, мөн түүнчлэн, хар тамхины гэмт хэрэгтэй холбогдсон. Аль Капоне буюу сорвит (нэрээр алдаршсан) нь анх “мөнгө угаах” нэршлийг өгснөөрөө алдартай. Тэрхүү 1899 онд Нью-Йорк хотын Бруклин дүүрэгт мэндэлсэн байна. Тэрбээр, хамгийн томоохон гэмт хэргийн бүлэглэлийн гишүүн байсан бөгөөд 1925 оноос 1931 онд хамгийн алдартай зохион байгуулалттай гэмт хэргийн толгойлогч байжээ. 1931 оны 6-р сарын 5-ны өдөр Аль Капоне улсын 22 орлогын татвараас зайлсхийх хэргээр буруутгагдаж байсан. Тус оны 10 сард 23 гэмт хэргийн гуравт нь шүүх хурлаар буруутайд тооцогдож \$50.000-ийн торгууль төлөх, 11 жилийн хорих ялаар яллах болсон бөгөөд шоронд 8 жил өнгөрүүлсний дараа 1939 онд өршөөлийн хуулиар суллагджээ. 1947 онд, Флорида луу явах замд амиа алдсан байна. Аль Капоне нь мөнгө угаах гэмт хэргийг олон илүү таниулсан гэмт хэрэгтэн бөгөөд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хар тамхины тэмцэх албанаас гаргасан мэдэгдлээр жил бүр Аль Капоне угаалгын газар худалдаж авах нэрийдлээр хар тамхины наймаа, биеэ үнэлэлт, татвараас зайлсхийх фронт болгон 2 их наяд гаруй доллар угаадаг байсан нь тогтоогджээ. Ингэснээр, Сорвит хөрөнгөжих болон гэмт хэргийн эх үүсвэрийн холбон өнгөлөн далдлах байдлаар татвараас зайлс хийжээ. Иймд, хууль ёсны дүр өгөхийн тулд нуун дарагдуулсан шинж чанартай гэмт хэргийн үйл ажиллагаанд холбогдох хянан шалгалт, ял шийтгэл зэргээс ангижрах хэлбэрийн үйл явцыг мөнгө угаах гэмт хэрэг гэж ойлгож болохоор байна.

Монгол Улсын хувьд, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг “мөнгө угаах” гэмт хэрэг гэж заажээ.

Харин бидний судалгааны хувьд, мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн түвшинг Базелийн мөнгө угаахтай тэмцэх индексээр төлөөлүүлэн авч үзэж байгаа болно. Швейцарт

² Kyriakos-Saad, N., Esposito, G. & Schwarz, N., “The Incestuous Relationship Between Corruption and Money Laundering”, Cairn Info, 2012

³ Council of Europe’s Program of Action against Corruption, 1995

төвтэй Базелийн Засаглалын Институт нь улс орнуудын эдийн засгийн гэмт хэрэг дундаа мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, үр дүнд нь засаглалыг сайжруулах зорилготой бие даасан байгууллага юм. Тус байгууллага нь 2012 оноос эхлэн жил бүр дэлхийн улс орнуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдэлийг хэмжээний дүнд Базелийн мөнгө угаахтай тэмцэх индексийг зарлаж байгаа билээ. Базелийн мөнгө угаахтай тэмцэх индексийн зорилго нь тодорхой эрх зүйн үйл ажиллагааг хэмжих бус эрсдэлийн олон талт байдлыг илтгэх юм. Тус индексийн утга нэмэгдэх тусам мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх нь өсөж байгаа буюу эрсдэл өндөртэй болох юм.

Энэхүү индекс нь “Транспэрэнси Интернэшнл” байгууллага, Дэлхийн банк, Дэлхийн Эдийн Засгийн Форум, ФАТФ зэрэг олон нийтэд нээлттэй томоохон эх сурвалжуудын өгөгдөлд үндэслэн 18 үзүүлэлт бүхий эрсдэлд нөлөөлөх 5 бүлгийн ((i) Мөнгө угаахтай тэмцэх хэрэгжилтийн чанар-65%, (ii) Авлига ба хээл хахуулийн эрсдэл-10%, (iii) Санхүүгийн ил тод байдал ба стандарт-10%, (iv) Нягтлан бодох бүртгэлийн ил тод байдал-5%, (v) Нягтлан бодох бүртгэлийн ил тод байдал-10%) хүчин зүйлсийн дагуу улс орнуудыг 1-10 хүртэлх утга авах бөгөөд өндөр байх тусам эрсдэл ихтэй хэмээн эрэмбэлдэг цорын ганц бие даасан, судалгаанд суурилагдсан индекс байсаар байна⁴.

Мөнгө угаах гэмт хэргийн гаралтад бизнесийн салбарын таатай орчин, хувь хүний хөгжил, эдийн засгийн гэмт хэргийн төрөлд багтах авлига ба хээл хахууль, санхүүгийн салбарын ба зах зээлийн хөгжил, эдийн засгийн нөлөө бүхий үзүүлэлт болох ажилгүйдэл гэх олон талт хүчин зүйлсийг нөлөөлөх боломжтой гэж үзлээ.

Бизнесийн таатай орчин: Бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд зохих хамгаалалт байхгүй бол санамсаргүй болон санаатай байдлаар мөнгө угаах тодорхой нөхцөлийг бүрдүүлж болно. Иймд хууль, эрх зүйн зохицуулалтын орчин сул, түүнтэй холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлэх чадвар сул, тогтвортой хяналтгүй, ил тод байдал хязгаарлагдмал улс орнуудад мөнгө угаах үйл ажиллагаа явуулахын тулд эдгээр сул талыг ашиглах боломжтой. Ялангуяа, бизнесийн үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг байгууллагууд санхүүгийн тайлагнах үүрэг дутмаг байх нь сэжигтэй үйл ажиллагааг эхлүүлэх улмаар гэмт хэрэг хэрэгжих орчныг бүрдүүлэх юм. Иймд санхүүгийн тайлагнах үүргийг чандлан сахиж сэжигтэй үйлдлийг олж тогтоох, мэдээлэх нь нэн чухал.

Хүний хөгжил: Эдийн засгийн үзүүлэлт болох ДНБ, боловсрол, урт удаан ба эрүүл амьдрал гэх 3 үзүүлэлт нь хүний хөгжлийг илтгэнэ. Иргэдийн орлогын түвшин өндөр, ядуурлын түвшин доогуур, эдийн засгийн өсөлттэй байх нь хувь хүмүүсийн хууль бус үйл ажиллагааг бууруулах боломжтой. Хүмүүс албан ажилтай болж, хангалттай орлоготой болсон тохиолдолд хууль бус үйл ажиллагаанд оролцох сэдэл буурдаг. Мөн, хүний хөгжил нь мэдлэг боловсролтой нягт уялдаа холбоотой бөгөөд мөнгө угаах гэмт хэргийн хор уршгийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх нь дүрэм, журам, ёс зүйтэй зан үйлийг дагаж мөрдөх магадлал өндөр болно.

Авлига: Өндөр албан тушаалтнууд мөнгө угаах гэмт хэргийн үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд эрх мэдлийг урвуулан ашиглах боломжтой бөгөөд гэмт хэрэгтнүүд эрх мэдэл бүхий албан тушаалтад их хэмжээний мөнгө амлан сэжигтэй үйлдэл хийж, түүнийг тас нуух эрсдэл үүсэж болно. Мөн түүнчлэн, хууль бус санг нуун дарагдуулах буюу хууль бус аргаар олсон мөнгөөр компани байгуулах, үл хөдлөх хөрөнгө худалдан авах зэргээр гарал үүслийг халхалдаг.

Санхүүгийн салбарын хөгжил: Санхүүгийн салбарын хөгжилд санхүүгийн институт болон зах зээлийн хөгжлийг авч үздэг ч салбарын институтийн хөгжил өндөр байх нь санхүүгийн зах зээлийн хөгжлөөс тогтмол хамаарахгүй учир тус бүрийн нөлөөг авч үзэх хэрэгтэй юм. Санхүүгийн институт өөрийн үйлчлүүлэгчийг таньж мэдэх (KYC) журмыг баталж KYC болон eKYC эсхүл хэсэгчилсэн байдлаар ашигласнаар мөнгө угаах боломжит

⁴ Basel AML Index 2022:11th Public Edition

үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж, бууруулах боломжтой. Харин санхүүгийн институтаас бусад сувгаар угаасан мөнгийг ихэвчлэн санхүүгийн бусад хэрэгсэл болон санхүүгийн хэрэгслээр дамжуулан мөнгөний зах зээл, хөрөнгийн зах зээл, уламжлалт зах зээл, криптовалют эсхүл үл хөдлөх хөрөнгө, үнэт эдлэл, эртний эдлэл, тансаг зэрэглэлийн автомашин зэрэг хөрөнгө оруулалт хийж санхүүгийн зах зээлийн хөгжлийг саармагжуулах болон сайжруулах магадлалтай.

Ажилгүйдэл: Тогтмол орлого олж чадахгүй байгаа хувь хүмүүс санхүүгийн байдлаа сайжруулах зорилгоор хууль бус үйл ажиллагаанд оролцох магадлал өндөр бөгөөд мөнгө угаагчид ажил эрхлэлт, санхүүгийн тогтвортой байдлын төлөө цөхрөнгөө барж байгаа хүмүүсийг онилж, залилан мэхэлж болно. Мөн түүнчлэн, ажилгүйдлийн түвшин өссөнөөр орлогын тэгш бус байдал нэмэгдэж улмаар нийгмийн тогтворгүй байдлыг үүсгэх эрсдэлтэй.

Мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох эконометрик загвар

Мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох эконометрикийн эмпирик байдлаар тодорхойлон бичвэл:

$$basel = \beta_0 + \beta_1cpi + \beta_2hdi + \beta_3fi + \beta_4fm + \beta_5unem + \beta_6bus + low_income + low_mid_income + upper_mid_income + u_t$$

Энд, нь Базелийн Мөнгө угаахтай тэмцэх индекс, нь авлигын төсөөллийн индекс бөгөөд энэхүү үзүүлэлт өндөр байх нь авлигын түвшин бага байгааг илэрхийлнэ. нь хүний хөгжлийн индекс буюу индекс өндөр байх нь улс орны иргэдийн мэдлэг боловсролын түвшин өндөр, дотоодын нийт бүтээгдэхүүн их, урт удаан, эрүүл амьдрал их байхыг илэрхийлнэ. нь санхүүгийн институтийн индекс бөгөөд тус үзүүлэлт өндөр байх нь санхүүгийн үйл ажиллагаа эдийн засагт үзүүлэх нөлөө өндөр, 100,000 насанд хүрэгч тутамд салбарын хүртээмжтэй байдал өндөр, институтийн үр өгөөж их зэргийг илэрхийлнэ нь санхүүгийн зах зээлийн индекс бөгөөд тус зэх зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөө, олон нийтэд хүртээмжтэй байдал, зах зээлийн үр өгөөж зэргийг тодорхойлно. нь ажилгүйдлийн түвшин, нь бизнесийн таатай орчны оноо бөгөөд тус үзүүлэлт нь их байх нь тухайн улс оронд бизнесийн үйл ажиллагаа явуулахад хууль эрх зүйн орчин таатай байгааг илтгэнэ, нь орлогын түвшинээрх ангилал бөгөөд эдгээр чанарын хувьсагчдыг үнэлж буй загварт хуурмаг хувьсагчаар сонгон авсан.

Дээрх загварыг ердийн хамгийн бага квадратуудын аргаар үнэлсний дараа коэффициентын статистик ач холбогдлыг t тестээр, регрессийн ерөнхий ач холбогдлыг F тестээр шалгаж статистик дүгнэлт хийнэ. Загварын хэлбэр буруу тавигдсан алдаа илэрсэн эсэхийг Рамсэйн RESET-ээр шалгана. Үлдэгдлийн шинжилгээний хүрээнд, алдааны вариаци тогтмол буюу хомоскедаст эсэхийг Брүш-Паганын тестээр шалгана. Хэрэв хомоскедаст байх нөхцөл зөрчигдвөл, тэсвэртэй стандарт алдааг хэрэглэж статистик дүгнэлт хийнэ.

Тоон мэдээлэл

Судалгаанд хамааран хувьсагчаар мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийг хэмжих 2012-2020 он хүртэлх хугацааны давтамжтай Базелийн Мөнгөн угаахтай тэмцэх индексийг сонгон авч түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах юм. Тайлбарлагдагч хувьсагчийг тайлбарлахаар бэлтгэсэн 16 тайлбарлагч хувьсагчдыг 2012-2020 он хүртэлх хугацаанд сонгон авсан 90 орны тоон мэдээлэл бүрэн, мөн мултиколлинеар байдлаас сэргийлж нэг нь нөгөө хувьсагчийг тайлбарлахааргүй байх, бусад хүчин зүйлийг хянаагүй үед 0.5-аас өндөр хамааралгүй байх зэрэг шалгуур үзүүлэлтээр 6 тайлбарлагч хувьсагчдыг сонгон авсан байна. Мөн үнэлж буй эдийн засгийн загварт 2012-2020 хүртэлх жилийн давтамжтай бага, дундаж бага, дундаж өндөр орлогын түвшинээр хуурмаг хувьсагчдыг оруулсан.

Хүснэгт 1. Шинжилгээнд ашиглагдах хувьсагчид

Хувьсагчид	Хугацаа	Эх сурвалж	Тайлбар
Базелийн индекс	2012-2020	БЗХ	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдэлийн хэмжүүр.
Бизнесийн таатай орчны оноо	2012-2020	Дэлхийн банк	Бизнесийн үйл ажиллагаа явуулахад хууль эрх зүйн орчин
Авлигын төсөөллийн индекс	2012-2020	ТИ	Эдийн засгийн гэмт хэрэг болох авлигын түвшин
Хүний хөгжлийн индекс	2012-2020	НҮХП	Мэдлэг боловсрол, ДНБ, урт удаан, эрүүл амьдрал
Санхүүгийн салбарын индекс	2012-2020	ОУВС	Санхүүгийн институтийн хүртээмжтэй байдал, үр өгөөж, эдийн засагт үзүүлэх нөлөө
Санхүүгийн зах зээлийн индекс	2012-2020	ОУВС	Санхүүгийн зах зээлийн хүртээмжтэй байдал, үр өгөөж, эдийн засагт үзүүлэх нөлөө
Ажилгүйдлийн түвшин	2012-2020	Дэлхийн банк	Ажилгүй бөгөөд ажил идэвхтэй хайж байгаа хүмүүс
Дундаж бага орлогын түвшин	2012-2020	Дэлхийн банк	Нэг хүнд ногдох орлого \$1036-\$4045
Дундаж өндөр орлогын түвшин	2012-2020	Дэлхийн банк	Нэг хүнд ногдох орлого \$4046-\$12535
Бага орлогын түвшин	2012-2020	Дэлхийн банк	Нэг хүнд ногдох орлого \$1035-аас бага

Эмпирик үр дүн

Хүснэгт 2-ийн үр дүнгээс хараад, Базелийн индексээр хэмжигдэх мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн түвшингийн дундаж түүвэрт хамрагдсан 128 улсын ерөнхий дүнгээр сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. Тодруулбал, мөнгө угаах гэмт хэргийн түвшин буурах төлөвтэй байна гэсэн үг юм. Харин, Монгол улсын хувьд жил бүр олон улсын дунджаас нэлээд дээгүүр байсан бөгөөд 2020 оны байдлаар 128 орноос эрсдэл өндөр 20 орны нэг болсон байна. Монгол улс нь анх 2011 онд ФАТФ-ын саарал жагсаалтад орсон бөгөөд үүний дараа, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуультай болсноор 2014 онд гарч чадсан. 2019 оны 10 дугаар сард дэлхийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага болох ФАТФ нь Монгол улсыг саарал жагсаалтад оруулсан. Энэ жагсаалтад орсон шалтгаан нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, зэвсэг дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод тогтолцоо нь стратегийн дутагдалтай бөгөөд энэхүү асуудлаа нэн даруй шийдвэрлэх шаардлагатай гэж үзжээ⁵. Иймд 2013-2020 оны хооронд Монгол улсын мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн түвшин өндөр байжээ.

⁵ ФАТФ-ын “Саарал жагсаалт”-д орсноор Монгол улсын банк, санхүүгийн салбарт үүсэх сорилтууд болон хэрэгжүүлэх арга хэмжээ, Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл, 2019

Хүснэгт 2. Мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн тодорхойлогч статистик, 2012-2020 он

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Монгол	6.35	6.14	6.14	6.13	6.11	6.14	6.65	6.57	6.24
Дундаж	5.70	5.70	5.63	5.58	5.62	5.37	5.37	5.30	5.13
Станд. хазайлт	1.06	1.04	1.06	1.06	1.03	1.26	1.11	1.06	1.10

Мөнгө угаах гэмт хэргийн загварыг жил бүрийн тоон мэдээлэлд үндэслэн 2012-2020 оны хооронд үнэлсэн үр дүнг харуулав (Хүснэгт 3). Мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийг тайлбарлах эконометрик загварын үнэлгээний үр дүнгээс харахад, Базелийн индексээр хэмжигдэх мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн түвшингийн нийт хэлбэлзлийн 47.7-69.3 хувь нь авлигын төсөөллийн индекс, хүний хөгжлийн индекс, санхүүгийн хөгжлийн индекс, санхүүгийн зах зээлийн индекс, ажилгүйдлийн түвшин болон тухайн улсын орлогын түвшингээр тайлбарлагдаж байна. Бусад нөхцөл ижил үед, авлигын төсөөллийн индекс нь өндөр (авлигагүй) бол мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн индекс доогуур байх төлөвтэй буюу статистик ач холбогдол бүхий сөрөг хамааралтай бөгөөд энэхүү үр дүн нь судалгааны таамаглалыг дэмжсэн байна. Хүний хөгжлийн индекс нь өндөр бол мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн индекс доогуур байх төлөвтэй буюу статистик ач холбогдол бүхий сөрөг хамааралтай. Энэхүү үр дүн нь эдийн засгийн хүчин зүйлс өндөр байх нь мөнгө угаах гэмт хэрэгтэй сөрөг хамааралтай болох судалгааны таамаглалыг дэмжсэн. Санхүүгийн институтын хөгжлийн индекс нь өндөр бол мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлийн индекс доогуур байх хандлагатай буюу статистик ач холбогдолтой бүхий сөрөг хамааралтай. Энэхүү үр дүн нь судалгааны таамаглалыг няцаасан байна. Санхүүгийн зах зээлийн хөгжлийн индекс нь өндөр бол мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэлийн индекс дээгүүр байх төлөвтэй буюу статистик ач холбогдолтой бүхий эерэг хамааралтай бөгөөд тус үр дүн нь судалгааны таамаглалыг дэмжсэн. Мөн, ажилгүйдлийн түвшин нь өндөр бол мөнгө угаах гэмт хэрэг гаралтын эрсдэлийн индекс доогуур байх хандлагатай буюу статистик ач холбогдол бүхий сөрөг хамааралтай. Энэхүү үр дүн нь судалгааны таамаглалыг няцаасан байна. Бизнесийн таатай орчны оноо нь өндөр (хууль эрх зүйн орчин өндөр) бол мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн индекс доогуур байх төлөвтэй буюу статистик ач холбогдол бүхий сөрөг хамааралтай. Энэхүү үр дүн нь судалгааны таамаглалыг дэмжсэн байна. Харин, 2017 онд бага орлогын түвшин, 2019 онд дундаж бага орлогын түвшин нь өндөр бол мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн индекс дээгүүр байх хандлагатай буюу статистик ач холбогдолтой бүхий эерэг хамааралтай.

Жил бүрийн хувьд үнэлсэн мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн түвшинг тайлбарлах загварууд нь хомоскедаст байх, алдааны илэрхийллийн тархалт нь нормаль байх, загварын хэлбэр зөв тодорхойлогдсон байх тухай сонгодог шугаман регрессийн суурь нөхцөлүүдийг биелүүлж байгаа болох нь холбогдох тестүүдийн үр дүнгээр баталгаажсан байна.

Хүснэгт 3 (а). Мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн загварын үнэлгээ, 2012-2016 он

	Загварууд				
	2012	2013	2014	2015	2016
<i>cpi</i>	-0.018** (0.007)	-0.009* (0.005)	-0.012** (0.005)	-0.006 (0.005)	-0.006 (0.005)
<i>hdi</i>	-1.893* (1.119)	-2.940*** (1.049)	-2.721*** (1.034)	-1.132 (1.083)	-2.562** (1.261)
<i>fi</i>	-1.351* (0.743)	-1.929** (0.748)	-2.292*** (0.720)	-1.514** (0.730)	-0.483 (0.750)
<i>fm</i>	0.682 (0.503)	1.081** (0.521)	1.493*** (0.475)	1.313*** (0.452)	0.865* (0.475)
<i>unem</i>	-0.028** (0.014)	-0.016 (0.013)	-0.013 (0.013)	-0.020 (0.013)	-0.024* (0.014)
<i>bus</i>				-0.039*** (0.012)	-0.032*** (0.011)
<i>low_income</i>	0.101 (0.294)	0.389 (0.302)	0.071 (0.351)	0.327 (0.311)	0.306 (0.321)
<i>low_mid_income</i>	-0.059 (0.242)	-0.024 (0.231)	0.288 (0.227)	0.369* (0.222)	0.396* (0.224)
<i>upper_mid_income</i>	0.138 (0.215)	0.141 (0.209)	0.231 (0.205)	0.265 (0.193)	0.258 (0.199)
Огтлогч	8.591*** (0.623)	9.052*** (0.608)	8.870*** (0.611)	9.579*** (0.630)	9.968*** (0.662)
Түүврийн хэмжээ	90	90	90	90	90
R-квадрат	0.477	0.478	0.503	0.566	0.530
Бруш-Паганы тест	F=0.872	F=0.909	F=0.819	F=0.544	F=0.819
RESET тест	F=3.465	F=0.502	F=1.741	F=0.051	F=0.309

***-1% түвшинд, **-5% түвшинд, *-10% түвшинд ач тэг таамаглал няцаагдсан

Өөр өөр хэмжих нэгж бүхий тайлбарлагч хувьсагчдын хамааран хувьсагчид үзүүлэх нөлөөг үнэлэгдсэн коэффициентуудаар шууд тайлбарлах нь зохимжгүй байдаг билээ. Иймд хувьсагчдын стандартчилсан үнэлгээгээр тооцогдох стандартчилсан бета коэффициентийг жилийн бүрийн хувьд тооцож нөлөөллийн хэмжээг харьцуулсан болно (Зураг 1).


Үнэлгээгээр, нийт улс орнуудын мөнгө угаахтай тэмцэх индексэд хамгийн өндөр нөлөө үзүүлж буй санхүүгийн зах зээлийн индекс байгаа нь мөнгө угаагчид хууль бус үйл ажиллагаагаар олсон орлогыг санхүүгийн зах зээлд богино ба урт хугацааны хэлцлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх замаар хууль ёсны хөрөнгө болгохыг эрмэлзэж байна. Иймд санхүүгийн зах зээлийн хөгжил нь мөнгө угаах гэмт хэргийг нэмэгдүүлэхэд түлхэц өгөх буюу санхүүгийн зах зээлийн хяналт сул байгааг илтгэж байна. Харин, мөнгө угаахтай тэмцэх индексэд хүчтэй сөрөг хамааралтай нь санхүүгийн институтийн индекс болон хүний хөгжлийн индекс байгааг харч болохоор байна. Санхүүгийн институтууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтад хамрагддаг. Ингэснээр сэжигтэй гүйлгээний үйл ажиллагаа, хяналтыг тавих, харилцагчдыг таних журмыг (KYC) даган мөрдөх ба үүнийг хэрэгжүүлэх, ажилтнуудад зориулсан сургалт хөтөлбөрүүд зохион байгуулах зэрэг арга хэмжээг тогтвортой авч чадаж буй орнуудын мөнгө угаах гэмт хэрэг бага тохиолдолтой байна. Хүний хөгжил буюу иргэдийн мэдлэг боловсролын түвшин өндөр, эдийн засгийн өсөлттэй, урт удаан ба эрүүл амьдралын хэв маягтай улс оронд мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх нь цөөн байдаг. Мөн түүнчлэн, мөнгө

угаах индексэд харьцангуй бага нөлөөг үзүүлж байгаа нь авлигын төсөөллийн индекс, бизнесийн таатай орчны оноо, ажилгүйдлийн түвшин зэрэг байна.


Хүснэгт 3 (б). Мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлийн загварын үнэлгээ, 2017-2020 он

	Загварууд (үргэлжлэл)			
	2017	2018	2019	2020
<i>cpi</i>	-0.014*** (0.005)	-0.015*** (0.005)	-0.012*** (0.005)	-0.012** (0.005)
<i>hdi</i>	-3.792*** (1.187)	-4.367*** (1.073)	-2.794*** (0.918)	-3.267*** (1.003)
<i>fi</i>	-0.950 (0.801)	-1.293*** (0.725)	-2.924*** (0.645)	-2.161*** (0.677)
<i>fm</i>	0.725 (0.475)	1.209*** (0.439)	1.774*** (0.431)	1.772*** (0.439)
<i>unem</i>	-0.041*** (0.015)	-0.025 (0.016)	-0.005 (0.017)	-0.017 (0.016)
<i>bus</i>	-0.029** (0.011)	-0.009 (0.010)	-0.005** (0.009)	-0.019* (0.010)
<i>low_income</i>	0.710** (0.287)	0.307 (0.294)	-0.066 (0.334)	0.113 (0.395)
<i>low_mid_income</i>	0.149 (0.229)	-0.246 (0.207)	0.491** (0.198)	0.162 (0.213)
<i>upper_mid_income</i>	0.153 (0.197)	0.087 (0.182)	0.208 (0.178)	0.064 (0.196)
Огтлогч	11.305*** (0.667)	10.456*** (0.624)	9.138*** (0.631)	10.118*** (0.665)
Түүврийн хэмжээ	90	90	90	90
R-квадрат	0.693	0.646	0.630	0.601
Бруш-Паганы тест				
RESET Тест				

***-1% түвшинд, **-5% түвшинд, *-10% түвшинд тэг таамаглал няцаагдсан



Зураг 1. Стандартчилсан бета коэффициент



Зураг 2-7. Хамааран ба үл хамааран хувьсагчдын хамаарал, 2020 он

2020 оны байдлаар мөнгө угаахтай тэмцэх индекс болон бусад хувьсагчдын хооронд цэгэн диаграмм байгуулсан бөгөөд бөмбөлөг том байх тусам мөнгө угаах эрсдэл өндөр байгааг илтгэнэ. Судалгааны нийт улс орнуудын дунд Монгол улсыг улаан өнгөөр тэмдэглэн харуулсан байна. Үүнээс харахад, авлигын төсөөллийн индексийн хувьд дунджаас бага буюу авлига нь дунджаас өндөр, ажилгүйдлийн түвшин ба санхүүгийн зах зээлийн индекс нь дунджаас бага, бизнесийн үйл ажиллагаа явуулахад хууль, эрх зүйн орчин дунджаас өндөр, мөн, хүний хөгжлийн индекс болон санхүүгийн институтын индекс дундад ойр байна.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Судалгаагаар улс орнуудын хувьд мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлд нөлөөлөх гол хүчин зүйлсийг тодорхойлохыг зорилоо. Эдгээр нь авлигын төсөөллийн индекс, хүний хөгжлийн индекс, санхүүгийн институтын индекс, санхүүгийн зах зээлийн индекс, ажилгүйдлийн түвшин, бизнесийн таатай орчны оноо болно.

Базелийн AML индексээр хэмжигддэг мөнгө угаах гэмт хэргийн эрсдэл болох ХХИ хооронд мэдэгдэхүйц урвуу хамаарал байгаа нь харагдлаа. Боловсролын түвшин өндөр, дундаж наслалт урт, нэг хүнд ногдох орлого өндөр байгаа нь ХХИ-ийн өндөр оноотой байх шалтгаан болох бөгөөд ийм улс орнууд мөнгө угаах эрсдэл багатай байна. Энэ нь хууль бус санхүүгийн үйл ажиллагаанд өртөмтгий байдлыг бууруулахад нийгэм, эдийн засгийн хөгжил ямар үүрэгтэйг харуулж байна. Өөрөөр хэлбэл, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд хүний хөгжил, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс чухал болохыг харуулж байна. Бодлого боловсруулагчид мөнгө угаах эрсдэлийг бууруулах цогц стратеги боловсруулахдаа үүнийг анхаарч үзэх хэрэгтэй. Боловсрол, эрүүл мэнд, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлснээр мөнгө угаах гэмт хэргийг бууруулахад ихээхэн нөлөө үзүүлнэ.

Авлигын түвшин өндөр (авлигын төсөөллийн индексэд бага утгатай) улс орнуудын хувьд мөнгө угаах гэмт хэргийн эрсдэл өндөртэй байх хандлагатай буюу мэдэгдэхүйц хамаарал байгаа нь ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, авлигын түвшин өндөр байх нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээний үр нөлөөг сулруулж, мөнгө угаах гэмт хэргийн үйл ажиллагааг идэвхтэй байх нөхцөл болж байгааг онцолж байна. Авлига газар авсан орчинд зохицуулах байгууллага болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа алдагдаж, улмаар хууль бус санхүүгийн үйл ажиллагаа нь ял шийтгэлгүй үлдэх боломжийг олгодог. Цаашилбал, авлига нь засаглалыг сулруулж, ил тод байдлыг алдагдуулж, мөнгө угаах гэмт хэрэг цэцэглэх нөхцөлийг бүрдүүлдэг. Хууль бус хөрөнгийг хууль ёсны гүйлгээний урсгалын хүрээнд нуун дарагдуулж болох бөгөөд энэ нь авлига өндөртэй улс орнуудад илрүүлэхэд илүү төвөгтэй болгодог. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд авлигатай тэмцэх хатуу арга хэмжээг багтаасан цогц, нэгдсэн арга барил шаардлагатайг бид онцолж байна. Авлигатай тэмцэх нь санхүүгийн системийн нэгдмэл байдлыг бэхжүүлж, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээний үр нөлөөг сайжруулж, улмаар мөнгө угаах эрсдэлийг бууруулж чадна.

Санхүүгийн салбар илүү хөгжсөн (Санхүүгийн институтын индекс нь өндөр утгатай) байх нь мөнгө угаах эрсдэлийг бага байхтай холбоотой болох нь манай судалгаанаас харагдлаа. Энэ нь хөгжингүй санхүүгийн салбар нь ихэвчлэн мөнгө угаах үйл ажиллагааг үр дүнтэй илрүүлж, таслан зогсоох илүү бат бөх зохицуулалтын тогтолцоо, хяналтын механизмыг агуулдаг болохыг харуулж байна. Өөрөөр хэлбэл, санхүүгийн салбарыг үр дүнтэй зохицуулалт, хяналтын хамтаар хөгжүүлж чадвал мөнгө угаах эрсдэлийг бууруулах шийдлийн салшгүй хэсэг болж чадахаар байна. Бодлого боловсруулагчид болон санхүүгийн байгууллагууд хамтран ажиллах ёстой бөгөөд санхүүгийн салбарын хөгжил нь санхүүгийн системийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх хүчин чармайлттай зэрэгцэн урагшлах ёстой.

Харин санхүүгийн зах зээл илүү хөгжсөн (Санхүүгийн зах зээлийн индекс нь өндөр утгатай), идэвхтэй улс орнууд мөнгө угаах эрсдэл өндөртэй байх хандлагатай байна. Үүнийг эдгээр зах зээл дэх гүйлгээний нарийн төвөгтэй байдал, хэмжээ нь хууль бус хөрөнгийг нуун далдлах, хуулийн санхүүгийн системд нэгтгэх илүү их боломжийг олгож байгаатай холбон тайлбарлаж болно. Эдгээр зах зээлд санал болгож буй санхүүгийн дэвшилтэт хэрэгсэл, үйлчилгээг мөнгө угаагчид үйл ажиллагаандаа ашиглаж болно. Түүгээр ч зогсохгүй эдгээр зах зээлийн дэлхийн шинж чанар нь хөрөнгийн хил дамнасан шилжилтийг хөнгөвчилж, нөгөө талаараа илрүүлэх ажлыг улам хүндрүүлж болох юм. Эндээс өндөр хөгжилтэй санхүүгийн зах зээлд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэж, түүний

эсрэг хяналт, хатуу арга хэмжээ авах нь чухал болохыг харуулж байна. Мөнгө угаахтай тэмцэхэд санхүүгийн зах зээлийн динамикийн талаар нарийн ойлголттой байх шаардлагатай гэж харж байна. Иймд цаашдын судалгаа нь мөнгө угаах эрсдэлийг улам даамжруулж буй санхүүгийн зах зээлийн онцлог шинж чанарууд, мөн криптовалюта зэрэг хөгжиж буй технологиуд энэ байдалд хэрхэн нөлөөлж байгааг гүнзгий судлах ёстой.

Эмпирик шинжилгээний үр дүнгээс ажилгүйдлийн түвшин өндөр орнууд мөнгө угаах эрсдэл багатай байх төлөвтэй байна. Зөрчилтэй мэт санагдах энэхүү хамаарлыг хэд хэдэн боломжит хүчин зүйлтэй холбон үзэж болно. Нэг боломжит тайлбар нь ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь хууль ёсны санхүүгийн гүйлгээний хэмжээг бууруулж, улмаар хууль бус мөнгө угаах арга замыг хязгаарлаж байж болзошгүй юм. Нэмж дурдахад, ажилгүйдэл өндөртэй орнуудын санхүүгийн системд хөрвөх чадвар багасаж, хууль бус үйл ажиллагаа нь анзаарагдахгүй байж болно. Мөн ажилгүйдлийн түвшин өндөр орнуудад санхүүгийн систем сул хөгжсөн байх магадлалтай бөгөөд энэ нь мөнгө угаах нарийн схемийн боломжийг хязгаарлаж болзошгүй юм. Түүнчлэн ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь хяналт шалгалт, зохицуулалтын хяналтыг чангатгасны улмаас хууль бус санхүүгийн үйл ажиллагааг зогсоож буй эдийн засгийн өргөн хүрээний хүндрэлийг илэрхийлж болно. Эдгээр нь ажилгүйдэл болон мөнгө угаах гэмт хэргийн хоорондын хамаарлын талаар шинэ үзэл баримтлалыг бий болгохын зэрэгцээ мөнгө угаах нь нийгэм, эдийн засгийн асуудал бөгөөд маш нарийн төвөгтэй болохыг онцлон тэмдэглэж байна.

Бидний судалгааны таамаглалын дагуу авлигын түвшин болон санхүүгийн зах зээлийн хөгжил өндөр байх нь мөнгө угаах гэмт хэргийн индексэд эерэг хүчтэй хамааралтай, өрхийн орлогын түвшин ба хууль эрх зүйн орчин өндөр байх тусам мөнгө угаах гэмт хэргийг бууруулна гэх таамаглал үндэслэлтэй биелсэн. Харин, ажилгүйдэл болон санхүүгийн салбарын хөгжил өндөр байх нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэхэд сөрөг нөлөөг үнэлсэн учир судалгааны таамаглалыг дэмжих үндэслэл олдсонгүй. Цаашдын судалгааны ажлуудад нь ялангуяа ажилгүйдлийн янз бүрийн хэлбэр эсвэл ажилгүйдэл өндөртэй орнуудын санхүүгийн болон зохицуулалтын тогтолцооны онцлогт анхаарлаа хандуулж, энэхүү гайхмаар хамаарлыг үргэлжлүүлэн судлах ёстой. Энэхүү хамаарлын талаар илүү гүнзгий ойлголттой болох нь мөнгө угаахтай тэмцэх стратегийн улам сайжруулж, илүү үр дүнтэй бодлого боловсруулахад хувь нэмэр оруулах болно.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Ном, өгүүлэл, судалгааны тайлан***

1. Г.Дагвасүрэн, “Гэмт хэргийн эдийн засгийн шинжилгээ”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2022.
2. Ц.Танан, “Мөнгө угаах тэмцэх индексийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ”, Санхүүгийн зах зээлийн сургалт, судалгааны хүрээлэн, 2023.
3. Э.Сугарбаяр, “Гэмт хэргийн гаралтад нөлөөлөгч нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийн шинжилгээ”, бакалаврын зэрэг горилсон бүтээл, СЭЗИС-ЭЗТ, 2019.

Гадаад хэл дээрх***Ном, өгүүлэл, судалгааны тайлан***

1. Basel AML Index 2022:11th Public Edition, 2022
2. Council of Europe’s Program of Action against Corruption, 1995
3. Kyriakos-Saad, N., Esposito, G. & Schwarz, N., “The Incestuous Relationship Between Corruption and Money Laundering”, Cairn Info, 2012
4. Micheal Levi & Peter Reuter. “Money Laundering”, Chicago Journals, 2006
5. Peter Reater and Edwin M.Truman., “Chasing Dirty Money: The Fight Against Anti-Money Laundering”, Peterson Institute for International Economics, 2004
6. Santha Vaithilingam. “Factors affecting money laundering: lesson for developing countries?”, Journal of Money Laundering Control, 2007.

FACTORS AFFECTING MONEY LAUNDERING

Dagvasuren.G

*Lecturer at the University of Finance and
Economics, Mongolia (MSc & MBA)*

Anujin.Ts

*Student, The University of Finance and
Economics, Mongolia*

ABSTRACT:

The study aims to analyze the factors affecting money laundering, specifically through the Basel AML Index created by the Basel Institute on Governance in Switzerland. Empirical study has shown a total of 90 countries from 2012 to 2020, the Corruption Perception Index, the Human Development Index, the Financial Institute Index, the Financial Market Index, unemployment rates, and Ease of Doing Business Scores impact the money laundering risk level in the econometric model. As a result of the study, the increase in the Corruption Perception Index and Financial Market Index increases the risk of money laundering. In addition, the Financial Institute Index, the unemployment rate, the Human Development Index, and the Ease of Doing Business Scores reduce the risk of money laundering. Therefore, investing in education, health growth, anti-corruption tools, and financial development growth will bring significant returns to reduce the risk and pervasiveness of money laundering

KEYWORDS:


Basel AML Index, Crime statistics, Time series analysis, Regression analysis.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН АНТРОПОЛОГИ ГЭЖ ЮУ ВЭ?



С.Номынбаясгалан

Монголын Криминологичдын холбооны ахлах судлаач (ВВА), МУИС-ийн ШУС-ийн Нийгмийн ухааны салбарын антропологийн хөтөлбөрийн докторант, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант



Э.Тамир

“Word Media” ХХК-ийн “Өрөг.мн” сайтын Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Монголын Криминологичдын холбооны гэрээт судлаач (LL.B)

ТОВЧЛОЛ:

Антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан юм. Судлагдахуун нь гол төлөв урт хугацааны туршид зорилтот оролцогчдыг ажиглаж, бодит амьдрал дээрх зүйлсийг судлахад оршино. Хэвлэл мэдээллийн антропологи бол шинэ зүйл биш. Хэвлэл мэдээлэл ба антропологи нь антропологи үүсч эхэлснээс хойш салшгүй холбоотой байв. Хэвлэл мэдээллийн антропологи нь хэвлэл мэдээлэл болон антропологи хоорондох хэвлэл мэдээллийн хэрэгслээр судлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүрэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл цуглуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр заах болон хэрэглээний хэвлэл мэдээллийн антропологи гэсэн 5 зүйлд төвлөрдөг. “Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи гэж юу вэ” өгүүлэл нь хууль зүйн антропологи судлалын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

Хүн судлал (антропологи), антропологийн хандлага, антропологийн төрөл, нийгэм соёлын антропологи, эрх зүйн антропологи (хууль зүйн антропологи), хууль зүйн нэр томьёо, хэвлэл мэдээллийн эрх зүй, антропологийн судалгаа, хэвлэл мэдээллийн антропологи, аман эх сурвалж, медиа судлалын үндсэн үе шатууд, медиа судлалын үндсэн чиглэлүүд, өмгөөллийн сэтгүүл зүй, хууль зүйн хэвлэл мэдээлэл.

I.Хэвлэл мэдээллийн эрх зүйг “антропологийн ухаан”¹-ы үүднээс авч үзэх нь

Монгол Улсын хууль зүйн салбарт “Чезаре Ломброзо (Cesare Lombroso)-гийн үндэслэсэн антропологийн онолын (Үүнийг бас “эрүүгийн эрх зүйн антропологийн сургаал”² эсвэл “гэмт явдлын биологийн онол”³ буюу “био криминологи”⁴ гэх зэргээр нэрлэх нь бий) талаар авч үзэж байсан болохоос эрх зүйн антропологийн чиглэлээр төдийлөн судалж байгаагүй”⁵ шинэ чиглэл болно. Учир нь “социализмын гэх тодотголтой өмнөх үеийн эрх зүйн тогтолцоонд антропологийн ухааны талаар судлах боломж бололцоо ихээхэн хомс байв. Энэ нь “хөрөнгөтний гадны юм” гэж үзэж байсантай холбоотой болов уу. Харин өдгөө энэ байдал өөрчлөгдөн хөгжлийн шинэ чиг хандлагаа олох нөхцөл боломж нь бүрдсэн”⁶ гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт “. . . хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгох . . .”⁷ тухай зааснаар антропологийн ухааны судалгаа хийх хууль зүйн үндэслэл нь болж байна. Иймээс антропологийн ухааны онол, арга зүйн үүднээс өөрийн орны үндэсний хууль тогтоомжийг судлах нь нийгэм, соёлын антропологийн дэд салбар болох эрх зүйн антропологийг хөгжүүлэх үндэс суурь гэж үзэж байна. Энэ нь монголын эрх зүйн тогтолцоонд антропологийн ухааны сэтгэлгээ, онолын урсгалыг бий болгохоос гадна энэ чиглэлийн судалгааг “дан ганц эрх зүйн онол, сэтгэлгээний хүрээнд бус харин хууль зүйн хэрэглээ болгох үүднээс салбар эрх зүйн жишээлбэл “хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи” гэх зэргээр төрөлжүүлэн хийж болох” талаар энэ өгүүлэлд ийнхүү хөндөж байна. Мөн түүнчлэн Олон түмний харилцааны онол хэмээх (2009) бүтээлд хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны үндсэн ялгааны талаар авч үзэхдээ өмгөөллийн сэтгүүл зүйн (Advocacy journalism)⁸ чиглэлийг дурдсан нь ихээхэн онцлог байна.⁹ Товчхондоо бол хэвлэл мэдээллийн салбарт хэвлэл мэдээллийн эрх зүй гэдгийг: нэгд, “хэвлэл, мэдээллийн харилцааг зохицуулахын тулд төрд нь эрх зүйн тусгай хэм хэмжээ тогтоодог ба үүнийг “хэвлэл, мэдээллийн эрх зүй”¹⁰ гэж; хоёрт, ““олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрх зүй” гэдгийг иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын бие даасан байдлыг хангаж өгсөн эрх зүйн зохицуулалт”¹¹ гэж ялгамжтай байдлаар явцуу болон өргөн хүрээнд тодорхойлж байна.

Дээрх хууль зүйн нэр томьёо, ухагдахууныг антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны үүднээс хэрхэн оноож нэрших, хэвшүүлэн хэрэглэх вэ?, нэн ялангуяа үзэл санаа, утга агуулгад юу хамаарах, хэрхэн тодорхойлох вэ? гэдгийг салбар дундын ухааны үүднээс авч үзэх хэрэгцээ шаардлага, шинжлэх ухааны ач холбогдол нь юу болох, мөн түүнчлэн эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар болох уу, түүний судлагдахуун нь

¹ Энэхүү өгүүлэлд “антропологи” гэсэн гадаад нэр томьёог “хүн судлал” хэмээн монгол нэр томьёонд буулгалгүйгээр хэрэглэсэн болохыг анхаарна уу. Энэ тухайгаа өгүүллийн үндсэн хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлаж, тийнхүү авч үзсэн үндэслэлээ товч танилцуулна.

² С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, Гурав дахь хэвлэл, Уб., 2011, 409 дэх тал.

³ Осман Долу, Криминологийн онолууд, орч. Э.Дашгаадан, Уб., 2022, 70 дахь тал.

⁴ С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол, I боть, Уб., 2009, 926 дахь тал.

⁵ С.Номынбаясгалан, “Арилжааны эрх зүйн антропологи гэж юу вэ?”, Хууль дээдлэх ёс, №1 (2023), 29–39 дэх тал, С.Номынбаясгалан, “Худалдааны эрх зүйн антропологийн тухай”, Хууль дээдлэх ёс, №2 (2023), 196–220 дахь тал.

⁶ С.Номынбаясгалан, “Эрх зүйн хүн судлал”, Хууль дээдлэх ёс, №3 (2022), 35–36 дахь тал.

⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367> [Сүүлд үзсэн: 2023.07.30]

⁸ Үүнд: 1/ Сэтгүүл зүйн гол зарчмуудыг баримталдаг эсэх; Сэтгүүл зүйн зарим нэг зарчмыг баримталдаг; 2/ Дүн шинжилгээ хийх чиглэл ба зах зээлийн хязгаарлалт; Улс төрийн мэдээлэлтэй, үзэл сурталд үнэнч иргэд, дээд болон дунд зэрэглэлийн хэрэглэгчид; 3/ Илгээлтний агуулгын үндсэн хэлбэр: Нуугдмал үр дүн гаргаж ирэх эрэн сурвалжлага, үзэл бодол, дүн шинжилгээтэй эссэ буюу полемик, нэг талыг баримталсан түрэмгий ярилцлага; 4/ Мэдээлэх үүргийн гүйцэтгэл: Мэдээлэх үүргийг гүйцэтгэх боловч хэр зэрэг гүйцэтгэх нь тухайн хүний үзэл бодлын чиглэлээс хамаарна.

⁹ А.Оюунгэрэл, Олон түмний харилцааны онол, Уб., Нөблмэн, 2009, 135 дахь тал.

¹⁰ Ш.Үнэнтөгс, Монголын хэвлэл мэдээлэл, Уб., Интерпресс хэвлэлийн компани, 2000, 71 дэх тал.

¹¹ Б.Болд-Эрдэнэ, М.Зулькафил ба бусад, Сэтгүүл зүйн үндэс, Уб., МУИС-ийн хэвлэлийн үйлдвэр, 2021, 408 дахь тал.

юу болох вэ? гэсэн асуултууд зүй ёсоор тавигдаж, хариултаа хүлээсээр өнөөг хүрсэн байна. Хэвлэл мэдээлэл, түүнд холбогдох асуудлыг улс төр, эрх зүй, социологи, сэтгэл судлал зэрэг олон талаас нь нилээдгүй судалсан хэдий ч антропологийн онол, арга зүйд суурилсан, тэр дундаа хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн утгаар авч үзсэн, хэвлэгдсэн судалгаа хомс байна. Антропологийн ухаанд хэрэглэдэг оролцон ажиглах аргын талаар М.Зулькафиль Сэтгүүл зүйн тайлбар толь хэмээх (2011) бүтээлд “. . . Ялангуяа социологи, антропологи, нийгмийн сэтгэл зүй, сэтгүүл зүй зэрэг нийгмийн шинжлэх ухаанд чухал ач холбогдолтой юм. . . . Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйд ажиглалтыг бие даасан, өргөн хүрээтэй, түгээмэл арга гэж үздэг. . . . Антропологи тийм аргыг ажиглагч оролцож буй тэр орчноос өөр соёлыг судлахад ашиглах болсон. . . . Орчин үед энэ аргыг сэтгүүл зүйн практик үйл ажиллагааг судлахад түгээмэл ашиглаж байгаа бөгөөд мониторингийн судалгаатай хослон хэрэглэх замаар томоохон амжилтанд хүрч байна . . .”¹² гэж, Д.Батжаргал Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар хэмээх (2008) бүтээлд “Ажиглалт (observation) бол сэтгүүл зүйн нэгэн чухал эх сурвалж юм. Сайн сэтгүүлч үргэлж ажиглаж явдаг. . . . Ажиглалтаас сурвалжилга төрдөг”¹³ гэж тус тус бичиж тэмдэглэжээ. Энэ салбарын талаар зарим бүтээлүүдэд “. . . голдуу нүүдэлчин хүн амтай, өргөн уудам газар нутагт ажиллаж буй сэтгүүлчдийн асуудал нь Улаанбаатар хотод ажилладаг сэтгүүлчдээс эрс ялгаатай . . .”¹⁴ гэж; мөн түүнчлэн “. . . өргөн уудам нутагт тархмал аймаг, сумдад орон нутгийн чөлөөт хэвлэл ихээхэн чухал боловч өдий болтол дорвитой хөгжиж бэхжиж чадаагүй . . .”¹⁵ гэж тулгамдсан асуудлуудыг хөндөж бичжээ. Энэ бол дэлхий дахины чөлөөт сэтгүүл зүйн онцлог, чиг хандлага, туршлагыг таньж мэдэх, боломжтой зүйлийг өөрийн орны сэтгүүл зүйн онцлог, уламжлалыг харгалзан нэвтрүүлэхийг шаардах болсны илрэл юм.¹⁶ Нөгөөтэйгүүр “хэвлэл мэдээлэл” хэмээх онцгой хэрэгслийг хэн нэгэн үл бүтэх этгээд баяжих, ашиг завшаан, нэр алдар олох хэрэглүүр төдий үзэж явцуу зорилго, сонирхолдоо ашиглах нь хүний эрх, эрх чөлөө, нийгмийн тогтвортой хөгжил, улс үндэстний язгуур эрх ашигт ч ихээхэн хор уршигтай үр дагаварт хүргэж болохыг эрхбиш бодолцох ёстой болов.¹⁷

Энэ байдлыг харгалзан энэхүү өгүүлээр хэвлэл мэдээллийн эрх зүйг (Media law) нийгэм, соёлын антропологийн (Social and cultural anthropology) дэд салбар болох эрх зүйн антропологийн (Anthropology of law) үүднээс хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи гэж юу вэ? гэсэн асуултад хариулахыг гол зорилгоо болгов. Тиймээс өгүүлэлд “Метаонол”¹⁸–ыг удирдлага болгов. Энэ өгүүллийн хүрээнд “хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи бол эрх зүйн антропологийн төрөлжсөн чиглэл” гэж үзэж байгаа учраас энэхүү өгүүллийн агуулга эрх зүйн антропологийн үндсэн асуудлаас хөндийрэх учиргүй юм. Ардчилсан эрх зүйт нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааны үндэс суурь нь мэдээллийн эрх чөлөө байдаг.¹⁹ Олон улсын эрх зүйн хэм хэмжээний үүднээс хэвлэл

¹² М.Зулькафиль, Сэтгүүл зүйн тайлбар толь, Уб., Соёмбо, 2011, 9 – 10 дахь тал.

¹³ Д.Батжаргал, Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар, Уб., Чөлөөт монгол, 2008, 5–6 дахь тал.

¹⁴ Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал ба түүнийг олон улсын сайн жишигт нийцүүлэх нь, судалгааны тайлан, Уб., 2022, 20 дахь тал.

¹⁵ Ж.Батбаатар, Суурь сэтгүүл зүй, Уб., Мөнхийн үсэг, 2023, 28 дахь тал.

¹⁶ М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб, Соёмбо принтинг, 2010, 11 дэх тал.

¹⁷ Ж.Батбаатар, Суурь сэтгүүл зүй, Уб., Мөнхийн үсэг, 2023, 41 дэх тал.

¹⁸ Грекийн мета – “дараа нь”, theoria – “ажиглалт, судалгаа, авч үзэх” гэсэн үгнээс гаралтай. Бусад онолын шинж чанар, арга, бүтцийг авч үздэг логикийн онол мөн. Метаонолын зорилго нь судалж буй онолыг хэрэгжүүлэх мужийн хил хязгаарыг тогтоох, шинжлэх ухааны тухайн хөгжлийн нөхцөлд зөрчилгүй, бүрэн боловсорсон эсэхэд хариулт өгөх, түүний шинэ ойлголтуудыг нэвтрүүлэх болон тэднийг нотлох арга замыг судлахад оршино. Метаонолыг боловсруулах шаардлага юуны өмнө математикт тулгарсан. Энэ нь нотолгоо, аксиом, онол зэрэг ойлголтын утгыг тайлбарлах, метаматикийн онолын бүтцийг судлах, тэдний үнэн бодитой эсэхэд хариулт өгөх шаардлагаас урган гарсан байдаг. Дараа нь нийгмийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэх болжээ. М.Зулькафиль, Сэтгүүл зүйн тайлбар толь, Гурав дахь хэвлэл, Уб., Удам соёл, 2018, 90 дэх тал.

¹⁹ М.Зулькафиль, Ч.Чойсамба, Сэтгүүлчийн ёс зүй, Уб., МУИС–ийн хэвлэх үйлдвэр, 2004, 82 дахь тал.

мэдээллийн эрх зүйн орчин таатай байхын тулд цөөнгүй хэдэн “шаардлага”²⁰ тавигддаг байна.²¹ Энэ утгаар хэвлэл мэдээллийн эрх зүйн амин сүнс нь иргэний улс төрийн суурь эрх, эрх чөлөө болох үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх болох учир энэ өгүүллийн гол утга учир үүнд л оршиж байна. Энэ бүлэг эрх хүний үзэл санааны эрх чөлөөг хамгаалсан байна. Үзэл санаа бол бие махбодийн эрх чөлөөг тодорхойлох шинжтэй, хүний уугуул мөн чанараас эх сурвалжтай, зөвхөн хүнд байдаг төрөлх шинж юм.²² Иймд хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн тухай лавшруулан судлахаас өмнө нэн тэргүүнд тодруулбал зохих хэдэн зүйл байгааг энэ өгүүллийн “нэр томьёоны асуудал” болон “ерөнхий ойлголт, судлах зүйл” гэсэн үндсэн хоёр хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлах нь зүйтэй гэж үзлээ. Эхний хэсэгт нэр томьёоны нэршил, оноолтын талаар товчхон авч үзэв. Удаах хэсэгт нэгд, нийгэм, соёлын антропологийн дэд салбар болох “эрх зүйн” болон “хэвлэл мэдээллийн” антропологийн тухай, хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар болох эсэх асуудал; хоёрт, хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн судлагдахуун болох хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд холбогдох гол суурь “хууль тогтоомж болон тэдгээрийг хэлэлцэн баталсан тэмдэглэл”²³; гуравт, эрх зүйн антропологиор дэмжигдэн буй хүний эрхийн хандлага, хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн “хэрэгцээ шаардлагын” талаар; дөрөвт, хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи тодорхойлох, хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи болон эрх зүйн антропологийн бусад төрөлжсөн чиглэл болох “арилжааны эрх зүйн антропологи” гэх мэтийн уялдаа холбоо, харилцан хамаарал зэргийг илүүтэй онцлон авч үзэх оролдлого хийв.

II. Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи: Нэр томьёоны асуудал

1. Нэр томьёоны нэршил, оноолтын тухай цөөн үгээр

A. “Media” хэмээх нэр томьёоны үүсэл, хөгжил

Т.Дорждагва нарын English хэмээх (2005) соёл судлал, хүн судлал, сэтгүүл зүйн мэргэжлийн оюутанд зориулсан гарын авлагад ““Media” – “хэвлэл мэдээлэл””²⁴ гэж англи хэлнээс монгол хэлэнд буулгасан байна. Сүүлийн жилүүдэд өргөн хэрэглэгдэх болсон “Медиаци” хэмээх нэр томьёо ч сэтгүүлчийн мэргэжлийг ойлгоход чухал ач холбогдолтой юм. Латин хэлний mediation – зуучлах, зуучлах явдал; mediator – зуучлагч; medium – тэг дунд, төв, бөөгнөрөл, нийгмийн амьдрал, ил болгох, нийтийн үзүүлбэр, нийтийн сонорт хүргэх гэх мэт; mediū – тэг дунд нь байх, төвийн, газар ба тэнгэрийн дунд байх, дундын гэх мэт утгыг илэрхийлдэг байна. Тэгвэл медиацитай холбоотой бүх үг үндсэндээ хоорондын, дундын байдал, хил хязгаарын гэсэн утгыг илэрхийлдэг гэж ойлгож болно. Мөн энэ үгнээс гаралтай медиа зах зээл, медиа улс төр, медиа эдийн засаг зэрэг нэр томьёо ч бидний үгийн санд ороод удаж байна.²⁵

Энэ “Media” (латины medium – “дамжуулагч, дундыг баримтлагч” гэсэн утгатай үг) гэдэг нэр томьёо XV зууны үед анх англи хэлэнд тодорхой ойлголтын төвшинд бий болж, XVII зуунд философийн хэлэнд, XVIII зуунаас олон нийтийн мэдээлэл харилцааны анхны хэрэгсэл болох сонинд хэрэглэж эхэлжээ. XIX зууны дунд үеэс “Media” гэдэг үгийг

²⁰ Үүнд: (1) цагдан хяналтыг хориглосон хуультай байх; (2) төрийн байгууллагын мэдээлэл, баримт бичгийг олж үзэх боломжтой байх; (3) сэтгүүлчид хуулиар нууц эрх сурвалжаа хамгаалах эрхтэй байх; (4) хариуцлага хүлээх чадвар бүхий редакцтай байх; (5) Үр дүнтэй өөрийн зохицуулалтын механизмтай байх гэх мэт.

²¹ Х.Наранжаргал, Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй, Уб., Чөлөөт хэвлэл сан, 2021, 67 – 68 дахь тал.

²² Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль: Шинжлэх ухааны тайлбар, Уб., Адмон принтинг, 2022, 294 дэх тал.

²³ Энэхүү өгүүллийн “хавсралт” хэсгээс Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн холбогдох заалтуудыг хэлэлцэн баталсан БНМАУ-ын Бага Хурлын гишүүдийн болон Ардын Их Хурлын депутатуудын үг хэлсэн байдлыг үзнэ үү.

²⁴ Т.Дорждагва, А.Амарсанаа, Ц.Цэцэгжаргал, Ч.Чойсамба, English, (соёл судлал, хүн судлал, сэтгүүл зүйн мэргэжлийн оюутанд зориулсан гарын авлага), Уб., МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2005, 78 дахь тал.

²⁵ М.Зулькафиль, Сэтгүүлчийн мэргэжил: Өчигдөр, өнөөдөр, маргааш, Уб., Удам соёл, 2014, 75 дахь тал.

орчин үеийн буюу мэдээллийг харилцаа холбооны тусгай техник хэрэгслүүдийн (шуудан, цахилгаан мэдээ) тусламжтайгаар түгээх гэсэн утгаар хэрэглэх болжээ. Сониныг зар сурталчилгаа түгээгч гэсэн утгаар XX зууны эхэнд “Media”-д хамруулж байсан бол радио (XX зууны 20–иод он), телевиз (XX зууны 40–өөд он) үүсч хөгжсөнөөр энэ ойлголтын цар хүрээ тэлж, “Mass Media” гэсэн арай өргөн утгаар хэрэглэж эхэлсэн түүхтэй.²⁶ Орчин үед Масс медиа (Mass media)²⁷ гэдгийг олон нийтийн мэдээлэл харилцаа гээд олон нийтийн мэдээллийн харилцаа гэдгийг мэдээллийг тусгай техник хэрэгслийн тусламжтайгаар нэгэн зэрэг хэсэг бүлэг хүмүүст дамжуулах үйл явц²⁸ гэж ойлгож байна. XX зууны эхний үеэс эрчимтэй хөгжиж эхэлсэн мэдээлэл харилцааны техник, технологийн хөгжил мэдээлэлд өөрөөр хандахыг шаардах болсон. Үүнд хариулт өгсөн зүйл бол К.Э.Шэнноны 1940–өөд оны үед боловсруулж, 1948 онд В.Уивертэй хамтран бичсэн “Мэдээлэл харилцааны математикийн онол” бүтээлд тусгасан мэдээллийн онол юм.²⁹ Энэ талаар М.Зулькафиль Сэтгүүл зүйн тайлбар толь хэмээх (2018) бүтээлд “Масс медиа олон нийгэд чиглэгдсэн харилцааны бүх хэлбэрийг илэрхийлж буй ерөнхий нэр томьёо бөгөөд үүнд уламжлал ёсоор сонин, сэтгүүл, кино, радио, телевиз, хялбаршуулсан утга зохиол болон хөгжим, сүүлд орж ирсэн цахим мэдээллийн хэрэгсэл, түүний дотор интернет багтдаг”³⁰ гэж тэмдэглэсэн байна. Үүний зэрэгцээ Х.Наранжаргал Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй хэмээх (2021) бүтээлд ““Digital media” буюу цахим хэвлэл мэдээлэл нь дуу, дүрс бичлэг, бичвэрийг тоон системийн хэв хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэж буй мэдээлэл харилцааны төрөл бөгөөд бидний нэрлэж заншсанаар цахим хуудас буюу website, нийгмийн хэвлэл мэдээлэл (social media) ашигладаг”³¹ тухай бичсэн байна.

Мөн түүнчлэн мэдээллийг хэрэглэгч телевиз, радио хүлээн авагч, утсан холбоо, электрон шуудангийн бүх шинжийг агуулсан харилцааны нэгдмэл тогтолцоо цахим тооцоолуурын мэдээллийг ашигладаг “multimedia”-гийн үе нэгэнт эхэлсэн. Эзнийхээ хэрэгцээ сонирхлыг мэддэг, түүний захиалгыг цаг тухайд нь биелүүлдэг компьютерийн санамжид хадгалагдсан сонинны мэдээллээс хэрэглэгч дурын мэдээллийг принтерээр хэвлэж авах боломжтой болов. Ийнхүү орчин үеийн сэтгүүл зүйн ертөнцөд “бродкастинг”, “бродкэтч” болон хувирч, хувь хүний онцлогт тохирсон олон нийтийн мэдээлэл хэмээх гайхамшигтай үзэгдэл бодит зүйл болж байна. Энэ үзэгдэл XXI зууны сэтгүүл зүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох болов.³² Орчин үед мэдлэг гэдэг нь аливаа улс орны үндэсний гол баялаг мөн гэдгийг нэгэнт хүлээн зөвшөөрч байна. Тухайн улс орны материаллаг үйлдвэрлэлийн хүчин чадал, оюун сэтгэлгээний нөөц нь тэнд оршин эргэж буй мэдээллийн хэмжээ чанараас шууд бөгөөд үндсэн хамааралтай юм. Тиймээс ч бидний амьдарч буй XXI зууныг мэдээллийн эрин мөн гэдгийг хүн төрөлхтөн аль хэдийнээ хүлээн зөвшөөрч байна.³³

²⁶ М.Зулькафиль, Сэтгүүл зүйн тайлбар толь, Гурав дахь хэвлэл, Уб., Удам соёл, 2018, 81 дэх тал.

²⁷ Үүнд “Хүлээн авагчдад мэдээлэл хүргэх зорилгоор ашиглаж буй янз бүрийн хэрэгслүүдийн нийлбэр мөн. Энэхүү хэрэгслүүдэд уламжлалт олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээс гадна ном, товхимол, кино, диск, дүрс бичлэгийн хуурцаг зэрэг зүйл багтдаг” байна.

М.Зулькафиль, Сэтгүүл зүйн тайлбар толь, Гурав дахь хэвлэл, Уб., Удам соёл, 2018, 81 дэх тал.

²⁸ М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 68 дахь тал.

²⁹ М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 68 дахь тал.

³⁰ М.Зулькафиль, Сэтгүүл зүйн тайлбар толь, Гурав дахь хэвлэл, Уб., Удам соёл, 2018, 84 – 85 дахь тал.

³¹ Х.Наранжаргал, Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй, Уб., Чөлөөт хэвлэл сан, 2021, 80 дахь тал.

³² Е.П.Прохоров, Сэтгүүл зүйн онолын удиртгал, орч. Л.Норовсүрэн, Уб., МУИС–ийн хэвлэх үйлдвэр, 2022, 38 дахь тал.

³³ М.Зулькафиль, Орчин үеийн сэтгүүлчийн ёс зүй, Уб., Адмон принтинг, 2007, 17 дахь тал.

Б. Хэвлэл мэдээллийн антропологи тухай

Олон нийтийн цахим сүлжээнд “anthropology of media” буюу “media anthropology”, эсвэл “anthropology of mass media” гэсэн нэр томъёонуудыг түгээмэл хэрэглэжээ.³⁴ Эдгээр нэр томъёо бүгд л хэвлэл мэдээллийн антропологи гэсэн утгыг илэрхийлж байна. Хүн төрөлхтөн үүссэн цагаас мэдээллийн харилцааны эхлэл тавигджээ. Хүн сүргээс хүмүүсийн нэгдэл үүсэн бүрэлдэх шилжилтийн үед мэдээллийн харилцаа зайлшгүй хэрэгцээтэй болсон байна.³⁵ Ийнхүү мэдээлэл солилцох хүн төрөлхтний хэрэгцээ эрт балар үед үүсчээ.³⁶ Энэ хэрэгцээ алс орон зайд нэвтрэх хүчирхэг хэрэглүүр – бичиг үсэг бий болсноор бүр ч нэмэгдэв. Ингэснээр овог аймгийн нэгдлийн эдийн засаг, улс төрийн харилцаанд нөлөөлж, орлого зарлага, татвар, бараа эргэлт зэргийг бүртгэж, данладаг төр үүсэх үеэс нэн хүчирхэгжив.³⁷ Энэ ч утгаараа хэвлэл мэдээллийн антропологи бол шинэ зүйл биш. Тиймээс хэвлэл мэдээлэл ба антропологи нь антропологи үүсч эхэлснээс хойш хоорондоо салшгүй уялдаа холбоотой байна. Нийгмийн амьдралыг сэтгүүл зүйгүйгээр, түүнийг мэдээлэлгүйгээр төсөөлөх арга зүй юм. Учир нь орчин үед мэдээллийн ач холбогдол эрс өсөн нэмэгдэж, энерги, матери хэмээх тулгуур ойлголтуудтай адилтган үздэг болжээ. Үүнээс үзэхэд хүн төрөлхтний амьдралд үнэн бодитой мэдээллийн үнэ цэнэ, ач холбогдол, үүрэг роль үнэлж баршгүй чухал гэдэг нь ойлгомжтой.³⁸

Сэтгүүл зүйн салбар хэрхэн үүссэн талаар Дэлхийн сэтгүүл зүйн түүх хэмээх бүтээлүүдэд “Сэтгүүл зүйг бий болгосон угтвар нөхцөл нь улсыг засах хэрэглүүр, үзэл суртлын идэвхтэй зэвсэг, үнэ ханшийг хэдэх ундарга гэж үзэн, эд бүгдийг цаасан дээрх элдэв бичвэрээр гүйцэтгэх болсон улс төр, оюун санаа, эдийн засгийн сонирхол материаллаг үндэс болжээ”³⁹; “Сэтгүүл зүй үүсэх үндсэн шалтгаан нь материал, техникийн урьдчилсан нөхцөлийн зэрэгцээ нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын цогц хүчин зүйл байв”⁴⁰ гэж тус тус бичсэн байна. Тэгээд ч сэтгүүл зүйн эрчимтэй хөгжлөөс шалтгаалан “сэтгүүлч” хэмээх мэргэжлийн агуулга ихээхэн өөрчлөгдөж янз бүрийн мэргэжлийн шинжийг нэгэн зэрэг агуулж, зөвхөн мэдээллийг олж, боловсруулагч бус эх бэлтгэгч, хянан найруулагч, дизайнер, эвлүүлэгч, дуу оруулагч, зураглаач, гэрэл зурагчин, орчуулагч болон хувирч байна.⁴¹ Нөгөө талаар сэтгүүлчид мэдээлэл олж авах асар өргөн боломж нээгдэж, тэд цахим сүлжээний баримт мэдээллийг түлхүү ашиглаж, тусгах объекттой биеслэн танилцах, газар дээр нь шууд ажиглалт хийх, оролцогсодтой шууд харилцах боломжийг хязгаарлах болсон нь нийтлэл, нэвтрүүлгийн чанарт нөлөөлөх бас нэгэн чухал хүчин зүйл юм.⁴²

В. Хэвлэл мэдээллийн эрх зүйг тодорхойлох нь

Нэр томъёоны хувьд авч үзвэл, Б.Болд – Эрдэнэ, М.Зулькафиль нарын Сэтгүүл зүйн үндэс хэмээх (2021) сурах бичигт “олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрх зүй”⁴³ гэсэн нэр томъёог хэрэглэжээ. Харин (1) Х.Наранжаргал Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй хэмээх (2021) бүтээлд “хэвлэл мэдээллийн эрх зүй”⁴⁴ гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. Тэрээр “хэвлэл мэдээллийн эрх зүй нь хөгжлийн тухайн үе шатанд төрөөс зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, харилцааны тогтолцоог бий

³⁴ https://en.wikipedia.org/wiki/Anthropology_of_media [Сүүлд үзсэн: 2023.07.30].

³⁵ Е.П.Прохоров, Сэтгүүл зүйн онолын удиртгал, орч. Л.Норовсүрэн, Уб., МУИС–ийн хэвлэл үйлдвэр, 2022, 31 дэх тал.

³⁶ Ч.Чойсамба, Дэлхийн сэтгүүл зүйн түүх, (Тогтмол хэвлэлийн үе 1609 – 1900), I боть, Уб., Мөнхийн үсэг, 2009, 5 дахь тал.

³⁷ В.В.Ворошилов, Дэлхийн сэтгүүлзүйн түүхээс, орч. Ш.Одонтог, С.Амартовшин, Уб., Соёмбо принтинг, 2001, 6 дахь тал.

³⁸ М.Зулькафиль, Орчин үеийн сэтгүүлчийн ёс зүй, Уб., Адмон принтинг, 2007, 17 дахь тал

³⁹ В.В.Ворошилов, Дэлхийн сэтгүүлзүйн түүхээс, орч. Ш.Одонтог, С.Амартовшин, Уб., Соёмбо принтинг, 2001, 5 дахь тал.

⁴⁰ Ч.Чойсамба, Дэлхийн сэтгүүл зүйн түүх, (Тогтмол хэвлэлийн үе 1609 – 1900), I боть, Уб., Мөнхийн үсэг, 2009, 12 дахь тал.

⁴¹ М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 271 – 272 дахь тал.

⁴² М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 272 дахь тал.

⁴³ Б.Болд – Эрдэнэ, М.Зулькафиль ба бусад, Сэтгүүл зүйн үндэс, Уб., МУИС–ийн хэвлэлийн үйлдвэр, 2021, 407 дахь тал.

⁴⁴ Х.Наранжаргал, Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй, Уб., Чөлөөт хэвлэл сан, 2021, 67 дахь тал.

болгох, бүрдүүлэх, мэдээлэл олж авах, хайх, хүлээн авах, хуваалцах, түгээх, зохистой хязгаарлалтын зохицуулалт хийх явцад үүссэн нийгмийн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээний цогц”⁴⁵ гэж тодорхойлжээ; мөн түүнчлэн (2) Ж.Батбаатар Суурь сэтгүүл зүй хэмээх (2023) бүтээлд “хэвлэл мэдээллийн эрх зүй”⁴⁶ гэсэн нэр томъёог хэрэглэжээ. Тэрбээр “Ардчилсан нийгэмд хамгийн үнэт капитал болох хүнд л бүх зүйл зориулагдаж төрөөс эхлээд нийгмийн бүх тогтолцоо, чухамдаа эд эс бүхэн нь хүний төлөө байж, хүнд л үйлчилж байх ёстой”⁴⁷ гэж үзсэн байна.

Товчхондоо бол аливаа эрх зүйг зохицуулах зүйл, зохицуулалтын арга нийгэмд гүйцэтгэх үүргээр нь салбар эрх зүй мөн эсэхийг тодорхойлдог онолыг иш үндэс болговол хэвлэл мэдээллийн эрх зүй нь бие даасан нэг салбар эрх зүй мөн бөгөөд бусад эрх зүйтэй нэлээд холимог өвөрмөц зохицуулалтын салбар болон хөгжиж байна. Иймд салбарын дагнасан хууль гэх ойлголт хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинд үгүй.⁴⁸ Энэ талаар М.Зулькафиль Монголын олон нийтийн мэдээлэл хэмээх (2010) бүтээлд “. . . сэтгүүл зүйн үйл ажиллагааг эрх зүйн үүднээс зохицуулж, хөгжүүлж ирсэн хэд хэдэн чиглэл байдаг. Үүнд: Нэгдүгээрт, энэ бол төр засгийн ашиг сонирхлыг хамгаалах; хоёрдугаарт, энэ бол хүний хуулийн ашиг сонирхол болон эрхийг хамгаалах явдал юм . . .”⁴⁹ гэж бичсэн байна. Тиймээс ардчилсан тогтолцооны амин үндэс болох чөлөөт хэвлэл, түүний эрх зүйн орчин, хамгаалалт, зохицуулалтыг боловсронгуй болгох тухай асуудал нь тоон технологийн ололтод суурилсан мэдээллийн хэмжээлшгүй боломжийн нэг томоохон хэсэг болох “нийгмийн сүлжээ”-г аливаа шударга бус үйл, үйлдлээ халхавчлах хэрэгсэл болгон буруу, бусармаг байдлаар ашиглах, нийгмийн сэтгэл зүйг хэрэгтэй зүгтээ хөтлөн залуурдах, эзэн биегүй суртал ухуулга хийж, явцуу зорилго, ашиг сонирхолдоо нийцүүлэн тархи угаах явдал илт хавтгайрсан цахим дарангуйллын энэ цаг үед урьд урьдынхаас илүү чухлаар тавигдаж байна. Ийм нөхцөлд шударга үнэн, ил тодын төлөө тэмцэж, нийгэм, иргэдийн дуу хоолой болох үүргээ хэлбэрэлтгүй биелүүлэх ёстой, мэдээллийнхээ бодит байдал, хариуцлагыг нийгэм, олон түмний өмнө хүлээдэг соёл нь төлөвшин тогтсон хариуцлагатай систем, чөлөөт хэвлэлийн эрх хэмжээ, хараат бус байдлыг нэмэгдүүлэх, хамгаалалтыг нь баталгаажуулсан хууль, эрх зүйн сайн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа нь нэгэнт тодорхой юм.⁵⁰

Ц.Ган-Оч, Б.Доньжчимбуу нар Мэдээллийн эрх зүй хэмээх (2019) бүтээлд “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтад “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан. Энэ нь олон нийтийн мэдээлэл төдийгүй бусад бүхий л төрлийн мэдээллийг хайх, хүлээн авах нь нээлттэй гэсэн үг юм. Олж авахыг хязгаарласан буюу нууцад хамаарах мэдээллийг түгээх хязгаарлалтыг зөвхөн хуулиар тогтооно. Олон нийтийн мэдээллийг боловсруулах, дамжуулах ба түгээх эрх чөлөөний баталгааг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 8 дахь заалтад тусгасан. Энэ хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтад “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” гэж тунхагласан. Хэм хэмжээ нь тодорхой мэдээллийн төрлийг тогтоодог

⁴⁵ Мөн тэнд.

⁴⁶ Ж.Батбаатар, Суурь сэтгүүл зүй, Уб., Мөнхийн үсэг, 2023, 171 дэх тал.

⁴⁷ Ж.Батбаатар, Суурь сэтгүүл зүй, Уб., Мөнхийн үсэг, 2023, 28 дахь тал.

⁴⁸ Х.Наранжаргал, Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй, Уб., Чөлөөт хэвлэл сан, 2021, 67 дахь тал.

⁴⁹ М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 201 – 202 дахь тал.

⁵⁰ Ж.Батбаатар, Суурь сэтгүүл зүй, Уб., Мөнхийн үсэг, 2023, 171 дэх тал.

бөгөөд тухайн мэдээллийг тараах нь хувь хүн, нийгэм болон төрийн ашиг сонирхлыг зөрчих ийм мэдээлэл тараахыг хориглодог. Хэнийг ч үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, эсвэл түүнээс татгалзахад албадаж болохгүй. Энэхүү хэм хэмжээ нь тухайлбал, сэтгүүлчид мэдээллийг эх сурвалжаас нь хүч хэрэглэн олж авах явдлыг үл зөвшөөрөх (хориглох) хэм хэмжээг тогтоож байгаа бөгөөд ийм мэдээллийг тараахыг хориглож байна”⁵¹ гэж бичсэн байна.

Г. “Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи” гэсэн нэр томъёоны тухайд товчхон

Эрх зүйн антропологи судалгааны “арилжааны эрх зүйн антропологи”, “худалдааны эрх зүйн антропологи” гэх зэрэг төрөлжсөн чиглэлүүд байж болох талаар хөндсөн цөөнгүй судалгаанууд бий. Иймд нэгэнт тогтсон хууль зүйн нэр томъёог өөрчлөх гэхээсээ илүүтэй утга агуулга, үзэл санааг нь нэг мөр ойлгох нь чухал⁵² гэж үзэж байна. Нийтээр хэвшсэн нэр томъёог аль болох хэвээр нь хэрэглэхийн зэрэгцээ антропологи ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс хүлээн зөвшөөрөгдөхийц байх ёстой. Энэ утгаар антропологи хэмээх нэр томъёог хууль зүйн болон хэвлэл мэдээллийн салбаруудад, нэн ялангуяа хэвлэл мэдээллийн хуулийн антропологи гэсэн томъёог хэрэглэснээр “хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи агуулгыг хэт явцууруулан тодорхойлуулах” төдийгүй “эрх зүйн илрэн гарах хэлбэрийн тухай ойлголтыг эрх зүйн мөн чанарын тухай ойлголттой адилтган ойлгох” нөхцөлийг бүрдүүлэх юм. Тухайлбал, хэвлэл мэдээллийн хуулийн антропологи гэх зэргээр нэрлэх нь хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологиос агуулга, мөн чанарын хувьд эрс ялгаатай гэж үзэж байна. Түүнчлэн эрх зүйн онолын хувьд эрх зүй хуулиас ялгаатай төдийгүй илүү өргөн агуулгаар тодорхойлогддог⁵³ болохыг мартаж учиргүй юм. Өөрөөр хэлбэл, эрх зүй судлал (эрх зүйг тогтолцооноос нь хальж, илүү өргөн хүрээтэй судалдаг) нь хууль зүй судлал (эрх зүйн тогтолцооны хүрээнд)–аас судалгааны онол, арга зүйн хувьд ялгаатай болно. Эрх зүй, түүний илрэн гарах хэлбэр болох хууль, тэдгээрийн ялгаа, харилцан хамаарлын тухай үзэл санаа нь эрх зүйн тухай үзэл санаатай зэрэгцэн нэн эртнээс үүссэн бөгөөд одоо ч гэсэн эрх зүйн танин мэдэхүйн анхаарлын төвд байсаар байна.⁵⁴ Энэ дээр үндэслэн эрх зүй, хуулийг агуулгын ялгаагүй гэж үзэж болохгүй, ялангуяа хууль нь агуулгаасаа гажсан тохиолдол бүр ч болохгүй юм. Харин хууль нь агуулгаасаа гажаагүй, эрх зүйд нийцсэн буюу эрх зүйт хуулийг эрх зүй гэж үзэж болох боловч өнөөг хүртэл хууль тогтоох явцад хууль нь агуулгаасаа гажиж байдаг тул эрх зүй, хууль хоёрыг ялгах хэрэгцээ шаардлага байгаа юм.⁵⁵ Өөр үгээр хэлбэл, нэр томъёог хэрхэн оноож өгснөөс шалтгаалан хоёрдмол утгаар ойлгогдох үр дагавартай байна. Өөрөөр хэлбэл эрх зүйн онол, философийн үүднээс эрх зүйн хэлбэрийг агуулгатай адилтган авч үзэх эрсдэлтэй болж байна. Тийм учраас хууль эрх зүйт шинжийг бүрэн олоогүй байгаа тохиолдолд “эрх зүй”, “хуулийн” ялгааг сайтар ухаарах, судлах, хууль тогтоомж бүрийг эрх зүйн шалгуураар шалгах шаардлага зайлшгүй бий. Энэ бол эрх зүйт төр, хуультай болох нэн чухал угтвар нөхцөл⁵⁶ болохыг онолын хувьд бас санах учиртай. Иймд нэр томъёоны

⁵¹ Ц.Ган – Оч, Б.Доньжчимбуу, Мэдээллийн эрх зүй, Уб., Соёмбо принтинг, 2019, 223 – 224 дэх тал.

⁵² “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” (Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл) Уб., 2016, 73 болон 77 дахь тал.

⁵³ 1.Хууль нь эрх зүйн илрэх гадаад хэлбэр. Д.Баярсайхан, Эрх зүйн онол, Тав дахь хэвлэл, Уб., 2018, 34 дэх тал.

2.Эрх зүйн ба хууль тогтоомжийн тогтолцооны харьцаа: эрх зүйн тогтолцоо ба хууль тогтоомжийн тогтолцоо бие даасан бөгөөд харилцан уялдаатай юм. Эдгээр нь өөр хоорондоо хэлбэр ба агуулгын харьцаатай байна. Эрх зүйн тогтолцоо бол агуулгыг илэрхийлэх бөгөөд нийгмийн харилцааг зохицуулах шинжид нийцсэн эрх зүйн дотоод бүтэц юм. Хууль тогтоомжийн тогтолцоо нь эрх зүйн эх сурвалжийн байгууламжийг илэрхийлдэг эрх зүйн гадаад хэлбэр өөрөөр хэлбэл хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын тогтолцоо. Эрх зүй нь хууль тогтоомжгүйгээр оршихгүй болохын хамт харин хууль тогтоомж нь өргөн хүрээтэй ойлгоцоор эрх зүй болно. С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), Уб., 2001, 87 дахь тал.

⁵⁴ Х.Сэлэнгэ, “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл”, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 150 дахь тал.

⁵⁵ Х.Сэлэнгэ, “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл”, Эрх зүй сэтгүүл, Уб., 2014, №1, 151 дэх тал.

⁵⁶ Н.Лүндэндорж, Эрх зүй судлал: Философи, онол, Уб., 2011, 26 дахь тал.

нэршил, оноолтын хувьд хууль зүйн болон хэвлэл мэдээллийн салбаруудад нэгэнт нийтээр хүлээн зөвшөөрч нэрлэж, цаашлаад хэрэглэж дадсан “дадна” гэж үзвэл салбар бүрт адил утгаар ойлгон хэрэглэгддэг нийтлэг нэр томьёо болгон хэвшүүлэх боломжтой юм. Энэ нь бас антропологийн ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны онолын үүднээс хэвлэл мэдээллийн хуулийн антропологи гэж нэрлэхийн оронд *хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи гэсэн нэр томьёонд хэвшүүлэн нэрлэх (хэрэглэх) нь зүйтэй гэж үзэж байна.

II. Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи: Ерөнхий ойлголт, судлах зүйл

1. Антропологийн ухааны салбаруудын учир холбогдлын талаар

А. Эрх зүйн болон “хэвлэл мэдээллийн” эрх зүйн антропологи “нийгэм, соёлын антропологи”-ийн дэд салбар болох нь

Антропологийн ухааныг 1/ нийгэм, соёлын; 2/ биологийн салбар, 3/ хэл шинжлэлийн; 4/ археологи гэсэн дэд салбарт хуваан үзэж байна. Эдгээр салбаруудын дундаас хамгийн өргөн хүрээтэй нь нийгэм, соёлын салбар болж байна. Эдгээр нь аль алиныгаа өөртөө багтааж байх бололцоогүй болтлоо өргөжин тэлж хөгжсөн. Жишээ нь нийгэм, соёлын антропологи л гэхэд 50 гаруй дэд салбартай бөгөөд цаашид энэ тоо нэмэгдэх төлөвтэй байна.⁵⁷ Нийгэм, соёлын антропологийн ухааны мөн чанараас үүдэн аливаа асуудлыг цогц байдлаар нь судлах оролдлого нь энэ олон дэд салбарын эхлэл болов.⁵⁸ Нийгэм, соёлын антропологийн бусад дэд салбаруудын нэгэн адил эрх зүйн антропологи нь харьцуулсан судалгааны талбар⁵⁹ бөгөөд түүнийг яг хэзээ үүссэн гэдгийг баттай хэлэхэд хэцүү; эрдэмтэд эрх зүйн антропологийн судалгаа гэдгийг авч үзэхээсээ (ойлгохоосоо) өмнө энэ чиглэлийн судалгааг хийж байв. Зарим судлаачид улс төр болон эрх зүйн талаархи антропологийн үүслийг НТӨ V зуунд Грект (Herodotus), эсвэл XVIII зуунд Францид (Baron Charles – Louis de Montesquieu) гэж авч үзсэн байна.⁶⁰ Энэ талаар Жан Копаны Угсаатан судлал, хүн судлалын удиртгал хэмээх бүтээлд “. . . хууль цаазын болон аман уламжлалын өргөн талбар бол хуулийн хүн судлалын салбарыг үүсгэдэг. Хүн судлалын олон сэтгэгчид хуульчид (Henry Sumner Maine, Lewis Henry Morgan зэрэг) байсан учраас хуулийн үүднээс бодож сэтгэж байв. Энэ ухааны хамгийн эртний мэргэжил мэргэшлийн нэг болсон . . .”⁶¹ тухай бичжээ. Хэвлэл мэдээлэл ба антропологи нь антропологи үүсч эхэлснээс хойш хоорондоо салшгүй уялдаа холбоотой тухай өмнө дурдсан. Энэ ч үүднээс хэвлэл мэдээллийн антропологийн товч түүхийн (A brief history of Media anthropology) талаар олон нийтийн цахим сүлжээнд ““хэвлэл мэдээллийн антропологи нь нийгэм, соёлын антропологийн хүрээнд судлах”⁶² бөгөөд “хэвлэл мэдээлэл, соёл, нийгэм хоорондын хамаарлыг цогцоор нь судалдаг өсөн нэмэгдэж буй салбар”⁶³ гэж тодорхойлжээ.

⁵⁷ Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат, Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, Уб., МУИС Пресс, 2017, 4 – 5 дахь тал.

⁵⁸ Г.Мөнх – Эрдэнэ, П.Чулуунбат, Нийгэм – соёлын хүн судлалын удиртгал, Уб., МУИС Пресс, 2017, 209 дэх тал.

⁵⁹ Elizabeth Mertz, Mark Goodale, “Comparative anthropology”, *Comparative Law and Society (Research handbooks in Comparative law)*, USA, Edward Elgar Publishing, 2012, p.77.

https://books.google.mn/books?hl=ru&lr=&id=q3vK0g2jOAO&oi=fnd&pg=PR1&dq=Cover+Comparative+Law+and+Society+Comparative+Law+and+Society+David+S.+Clark&ots=50BTU1Rq9U&sig=20qMgAtsrx6fsFp33Y9YIHKE7PU&redir_esc=y#v=onepage&q&f=false [Сүүлд үзсэн: 2023.07.30].

⁶⁰ Elizabeth Mertz, Mark Goodale, “Comparative anthropology”, *Comparative Law and Society (Research handbooks in Comparative law)*, USA, Edward Elgar Publishing, 2012, p.79.

⁶¹ Жан Копан, Угсаатан судлал, хүн судлалын удиртгал, орч. С.Дулам, Уб., 2007, 71 дэх тал.

⁶² https://en.wikipedia.org/wiki/Anthropology_of_media [Сүүлд үзсэн: 2023.07.30].

⁶³ <https://anthrolic.com/media-anthropology> [Сүүлд үзсэн: 2023.07.30].

Б. Эрх зүйн болон “хэвлэл мэдээллийн” эрх зүйн антропологи эрх зүй судлалын шинжлэх ухааны салбар болох нь

Ч.Нямсүрэн Эрх зүйн ерөнхий онол хэмээх (2017) бүтээлд “. . . өнөө үед (XX зууны сүүл, XXI зууны эхэн) эрх зүйн ерөнхий онол нь дэлхийн улс орнуудад, ялангуяа эх газрын эрх зүйн тогтолцоотой улс оронд хууль зүйн цоо шинэ шинжлэх ухааны (эрх зүйн антропологи болон бусад) шинэ мэдлэг, арга зүйн болон үзэл суртлын олон ургальч хандлагад тулгуурлан хөгжиж байна . . .”⁶⁴ гэж бичсэн байна. Үүнийг улам тодруулан доктор Б.Тамир Олон улсын хувийн эрх зүй хэмээх (2019) бүтээлд “. . . олон улсын хувийн эрх зүйн хөгжил нь салбар дундын байдлаар буюу эдийн засаг, улс төр ба антропологийн шинжлэх ухааны чиг хандлагыг хослуулан хөгжсөөр байна . . .”⁶⁵ гэж баримталж байгаа хандлагуудыг онцлон гаргаж ирэв. Энэ нь эрх зүй судлалын шинжлэх ухааны салбарууд болох нь ““эрх зүйн философи”, “эрх зүйн онолын”⁶⁶ нэгэн адил “эрх зүйн антропологи” нь эрх зүйн судлалын шинжлэх ухааны нэг салбар”⁶⁷ гэдгийг ерөнхийд нь илэрхийлж байна. Энэ утгаар антропологийн ухааны, нэн ялангуяа нийгэм, соёлын антропологийн дэд салбар болох эрх зүйн антропологийг, тэр дотроо хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийг Монгол Улсад хөгжүүлэх нь онолын төдийгүй практикийн ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

В. Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн судлагдахууныг тодорхойлох нь

Антропологи бол бодит туршлагад суурилсан ухаан бөгөөд түүний онцлог нь нийгэм, соёлын бүтээгдэхүүн болох эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, ёс, уламжлал, зан заншил, үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийг тусгасан хэв хууль, ахуй, аж байдал зэрэгт ач холбогдол өгч, гол судлагдахуун болгон судалдаг. Эрх зүйн уламжлал нь эрх зүйн тогтолцоог тухайн соёлтой холбож илэрхийлдэг. Тэгэхлээр эрх зүйн антропологи нь эрх зүйн мөн чанарыг нийгмийн үзэгдэл талаас нь судална.⁶⁸ Тодруулбал эрх зүйн антропологи нь байгаа болон байх ёстой зүйлийн хүрээнд бус харин байгаа зүйлийн хүрээнд илүүтэй авч үздэгээрээ эрх зүйн философиос ялгаатай гэж үзэж болох юм. Энэ утгаар хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи нь хэвлэл мэдээллийн эрх зүйн болон эрх зүйн тогтолцооны талаарх антропологи анализ болж байна. Тиймээс хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн судлагдахуун нь үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр, шүүхийн шийдвэр зэргээр хязгаарлагдахгүй ихээхэн өргөн хүрээтэй болно. Тэгээд ч нийгмийн бүхий л харилцааг хуулиар зохицуулах боломжгүй. Тиймээс эрх зүйн харилцаанд нийтээр хүлээн зөвшөөрсөн зан заншил, ёс суртахууны хэм хэмжээг өргөнөөр хэрэглэдэг.⁶⁹ Энэ нь тухайн улс орон эрх зүйн ямар системийг баримтлан чиг баримжаагаа болгодог, түүнчлэн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ямар байр сууринаас тодорхойлж, хэвлэл, мэдээллийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэл нь ямар түвшинд байгаа, бүр цаашилбал тухайн улс үндэстний хөгжил, зан заншлын хэм хэмжээгээр хэвлэл, мэдээллийн нийгэмд эзлэх байр суурь, хэрэгцээг тодорхойлдог.⁷⁰ Мөн Д.Батжаргал Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар хэмээх (2008) бүтээлд “Эх сурвалжийг дотор нь аман, бичгийн, ажиглалт гэж ангилах бөгөөд аман эх сурвалжид (oral source) уулзсан, утсаар ярьсан, хэвлэлийн бага хурал дээр үг хэлсэн зэргийг оруулж болно”⁷¹ гэж бичсэн байна. Энэ талаар Ж.Баатар нарын Практик сэтгүүлзүй хэмээх (2010) бүтээлд “Эх сурвалжтай уулзаж ярилцах, үйл явдлыг газар дээрээс нь ажиглаж сурвалжлах, тухайн

⁶⁴ Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, Уб., 2017, 44 дэх тал.

⁶⁵ Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй, Уб., 2019, 48 дахь тал.

⁶⁶ Х.Сэлэнгэ, “Эрх зүй, хууль зүй гэсэн нэр томъёоны талаарх шүүмж, эргэцүүлэл”, Эрх зүй сэтгүүл №1 (2014), 151 дэх тал.

⁶⁷ С.Номынбаясгалан, “Эрх зүйн антропологи”, Эрх зүй сэтгүүл №3 (2022), 51 дэх тал.

⁶⁸ С.Номынбаясгалан, “Эрх зүйн антропологи”, Эрх зүй сэтгүүл №3 (2022).

⁶⁹ Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй, Уб., 2019, 74 дэх тал.

⁷⁰ Ш.Үнэнтөгс, Монголын хэвлэл мэдээлэл, Уб., Интерпресс хэвлэлийн компани, 2000, 87 – 88 дахь тал.

⁷¹ Д.Батжаргал, Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар, Уб., Чөлөөт монгол, 2008, 7 – 8 дахь тал.

сэдэв, үйл явдалтай холбоотой нэмэлт мэдээлэл цуглуулах зэрэг идэвхтэй сурвалжлагын үр дүнд баримт бүрддэг”⁷² гэжээ.

Г. Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн хэрэгцээ шаардлагын талаар

Өмнө нь дурдсанчлан хэвлэл мэдээллийн эрх зүйн амин сүнс нь болсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар баталгаажуулжээ.⁷³ Тиймээс хэвлэл мэдээллийн асуудлыг антропологийн ухааны, нэн ялангуяа хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн үүднээс авч үзэх хэрэгцээ шаардлага монголын эрх зүйн тогтолцоонд үгүйлэгдэж ирсэн байна. Энэ талаар Ц.Ган – Оч, Б.Доньжчимбуу нарын Мэдээллийн эрх зүй хэмээх (2019) бүтээлд “1990 оноос өмнө манай улсад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн зохион байгуулалт болон үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн акт ч байгаагүй. Эрх зүйн зохицуулалтыг нь намаас баталсан дүрэм журмаар орлуулж байсан. Энэ үед олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хууль тогтоомж нь “цензурын эрх зүй” болж байсан гэж үзэж болно”⁷⁴ гэж бичсэн байна. Үүнээс гадна Л.Норовсүрэн нарын Монголын сэтгүүл зүй – 100 жил хэмээх (2013) бүтээлд монголын сэтгүүл зүйд цензур тогтоосон хамгийн анхны баримт бичгийн талаар “Хорь, гучаад онд нам, засгаас хэвлэл мэдээллийн талаар авч явуулсан бодлого, шийдвэрүүд нь тухайн салбарын хөгжлийг түргэтгэх, олон түмний гэгээрэл боловсролд ахиц дэвшил гаргахад шийдвэрлэх үүрэгтэй байсан нь маргаангүй боловч сонин хэвлэлийн нийтлэлд хөндлөнгөөс хэт хутгалдан оролцож, бичиж туурвих ажлыг үзэл суртлын явцуу хүрээнд хашиж, улмаар өөр үзэл бодол, чөлөөт үгийг хаан боогдуулахад хүргэж байсан гашуун сургамжийн эхийг тавьсан байна. Хориод оны эхэн үеэс эрч хүчээ авсан хэвлэл мэдээллийн хэрэгслийг цагдан хянах явдлын эх суурь хувьсгалын бүр эхэн үеэс улбаатай ажээ. Энэ нь 1921 онд гарсан Монгол Ардын Намын Түр зуурын дүрэмд: <<Сонин бичиг, сэтгүүлийн зүйлүүдийг оролдох хүнийг тохоон томилж, бичих зүйлийг байцаан харгалзана>> гэсэн заалт орж байснаас үзэхэд тодорхой юм”⁷⁵ гэж бичжээ.

Тиймээс орчин үед хуучин коммунист сэтгүүл зүй өөрийн онолын үзэл баримтлалыг үндсээр нь өөрчилж, олон асуудлыг эргэж харах, дахин боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж буй өнөөгийн нөхцөл дээр дурдсан асуудалд тал бүрээс нь нухацтай хандаж, сэтгүүл зүйн судлалын тулгамдсан асуудал болгож тавих нь монголын сэтгүүл зүйн судлалыг, түүний дотор онолын сэтгэлгээг хөгжүүлэх чухал алхам болно.⁷⁶ Мөн түүнчлэн Б.Болд – Эрдэнэ, М.Зулькафиль нарын Сэтгүүл зүйн үндэс хэмээх (2021) бүтээлд “Манай оронд 1990 оноос эхлэн чөлөөт хэвлэл, мэдээллийн хэрэгсэл оршин тогтнохыг төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн боловч гурван гол асуудал одоо хүртэл бүрэн шийдэгдээгүй юм. Энэ бол: 1.Чөлөөт хэвлэлийг бий болгож аваад явах санхүүгийн нөхцөл байдал; 2.Хууль эрхийн хувьд чөлөөтэй байх, өөрөөр хэлбэл хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдал гэдэг нь хуулийн хүрээнд бүх талаар бүрэн баталгаажуулаагүй; 3.Төр засгийн болон улс төрчид, эрх мэдэлтнүүдийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн монопол эрхээр дамжуулан чөлөөт хэвлэлд дарамт үзүүлэх явдал мөн”⁷⁷ гэж бичсэн байна. Иймд хэвлэл мэдээллийн эрх зүйн хөгжлийн асуудлыг хэвлэл мэдээллийн эрх чөлөө, түүнд хамаарах эрх зүйн зохицуулалтын жишээн дээр авч үзвэл хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болсныг хууль зүйн практик харуулах болно.

⁷² Ж.Багбаатар, С.Амаргүвшин, М.Одмандах, Практик сэтгүүл зүй, Уб., Бемби сан хэвлэлийн газар, 2010, 9 дэх тал.

⁷³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=546> [Сүүлд үзсэн: 2023.07.30].

⁷⁴ Ц.Ган – Оч, Б.Доньжчимбуу, Мэдээллийн эрх зүй, Уб., Соёмбо принтинг, 2019, 224 дэх тал.

⁷⁵ Л.Норовсүрэн, М.Зулькафиль, Ч.Чойсамба, Монголын сэтгүүл зүй – 100 жил: Хамгийн, хамгийн, хамгийн, Уб., ВСИ хэвлэлийн компани, 2013, 113 дахь тал.

⁷⁶ М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 14 дэх тал.

⁷⁷ Б.Болд – Эрдэнэ, М.Зулькафиль ба бусад, Сэтгүүл зүйн үндэс, Уб., МУИС–ийн хэвлэлийн үйлдвэр, 2021, 391 дэх тал.

2. Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи, түүнд холбогдох бусад асуудал

А. Хуулийн хувийн хэрэг хэвлэл мэдээллийн эрх зүйн судлагдахуун болох нь

Энэ дэд хэсэгт хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи судлагдахуун болох хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд холбогдох гол суурь “хууль тогтоомж болох Монгол Улсын Үндсэн хуулийг, нэн ялангуяа Арван зургадугаар зүйлийн 16 болон 17 дахь заалтуудыг хэлэлцэн баталсан тэмдэглэл” зэргийг илүүтэй онцлон авч үзэв. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийг Улсын Бага Хурлын хуралдаан, Ардын Их Хурлын чуулганаар хэлэлцсэн тэмдэглэл (протокол)–ээс зөвхөн уг хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийг хэлэлцсэн тэмдэглэлийг холбогдох албан ёсны эх сурвалжаас нь түүвэрлэн нэгтгэх нь нэгдүгээрт, эрх зүйн соёл сэтгэлгээний хүрсэн түвшинг; хоёрдугаарт, уг зүйлийн заалт бүрийн үндэслэлийг хэрхэн ойлгож, томъёолсон байдлыг; гуравдугаарт, хэлэлцүүлгийн явцад Улсын Бага Хурлын гишүүд, Ардын Их Хурлын депутатуудын илэрхийлж байсан байр суурийг; дөрөвдүгээрт, Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдалд НҮБ болон бусад олон улсын байгууллагаас өгсөн үнэлгээнд дүн шинжилгээ хийхэд; тавдугаарт, уг зүйлийн заалт бүрийн хэрэгжилтийг хангах, илэрхийлсэн утга санааны мөн чанарыг тус тус судлахад чухал ач холбогдолтой юм.⁷⁸

Тиймээс энэхүү хэсэгт тэмдэглэлүүдийн түүвэрлэлтээс авч үзвэл,⁷⁹ “1.БНМАУ–ын Бага Хурлын (БХ) гишүүдийн хувьд (1991.05.17., 1991.10.12., 1991.10.14–ний өдрүүдэд) 16 дахь заалтад 44 удаа, 17 дахь заалтад 33 удаа харин БНМАУ–ын Ардын Их Хурлын (АИХ) депутатуудын хувьд (1991.11.27., 1991.11.28., 1992.01.04–ний өдрүүдэд) 16 дахь заалтад 63 удаа, 17 дахь заалтад 134 удаа тус тус давхардсан тоогоор үг хэлсэн байна; 2.БХ–ын гишүүдийн хувьд “16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;” гэснийг 44 удаа, АИХ–ын депутатуудын хувьд “17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар хамгаална;” гэснийг 134 удаа асуулт асууж, хариулт авч байр сууриа илэрхийлж байсан нь хэлэлцүүлгийн хамгийн өндөр үзүүлэлт юм; 3.Хэлэлцүүлгийн эцэст “16 дахь заалтыг 307 депутат буюу 93 хувь нь зөвшөөрч, 16 хүн тагталзаж, 6 хүн түдгэлзсэн⁸⁰ бол 17 дахь заалтыг 270 депутат буюу 284 хувь нь зөвшөөрч, 34 хүн тагталзаж, 16 хүн түдгэлзэж⁸¹ баталсан” байна; 4.” гэсэн ерөнхий дүгнэлтийг хийв.

Б. Эрх зүйн антропологиор дэмжигдэн буй хүний эрхийн хандлагын талаар товчхон

Э.Булаг Монгол дахь ястны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал хэмээх (2020) бүтээлд “хүн судлалаар дэмжигдэн буй хүний эрхийн хандлага (the

⁷⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 11 дэх тал

⁷⁹ Энэхүү өгүүллийн “хавсралт” хэсгээс Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 болон 17 дахь заалтуудад холбогдох төсөл, тэдгээрийг хэлэлцэн баталсан БНМАУ–ын Бага Хурлын гишүүдийн болон Ардын Их Хурлын депутатуудын үг хэлсэн байдлыг №1, №2, №3 хүснэгтүүдээс дэлгэрүүлж үзнэ үү.

⁸⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 466 дахь тал

⁸¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 506 дахь тал

human rights approach supported by anthropology/ethnology)⁸²–ын талаар авч үзсэн нь ихээхэн онцлог байв. Энэ талаар Б.Болд – Эрдэнэ, М.Зулькафиль нарын Сэтгүүл зүйн үндэс хэмээх (2021) бүтээлд “Сэтгүүл зүйн тусгах асуудлын цөм нь хүн байдаг. Түүнд яаж хандаж, түүний үйл ажиллагааны гол ололт, амжилт, алдаа дутагдлыг ямар аргаар сурталчлахаас их юм шалтгаална . . . Сэтгүүлч ямар асуудлыг тусгаж байлаа ч тэр нь эцсийн үр дүнд хүний төлөө, хүнтэй холбоотой гэдгийг мэдэж байх ёстой”⁸³ гэж сэтгүүл зүйн үндсэн зарчим болох хүнлэг байх зарчмыг бичсэн байна. Энэ зарчмын талаар Д.Ганболд Сэтгүүл зүйн онол, практикийн нэр томъёоны хураангуй тайлбар толь хэмээх (2002) бүтээлд “. . . олон нийтийн мэдээллийн хэрэгслийн өмнө биш, дэлхий дахины сэтгүүл зүйн өмнө тавигдаж буй гол зорилт юм. Энэ зарчим нь сэтгүүл зүй хувь хүн хоёрын хоорондох харилцааг илэрхийлдгээрээ онцлогтой байдаг. Сэтгүүл зүйд тусгаж буй гол цогц цөм нь хүн байдаг. Түүнд яаж хандах, түүнийг үйл ажиллагааны гол ололт амжилт, алдаа дутагдлыг ямар байдлаар бичигдэхээс шалтгаалдаг. . . . Хүнлэг байх зарчим нь сэтгүүл зүйн үйл ажиллагаанд тавигдах шаардлагуудыг бүхэлдээ нэгтгэсэн байдаг учир сэтгүүл зүйн зарчмуудын системд онцгой байр эзэлдэг. Сэтгүүл зүйн хүнлэг байр суурь нь хүмүүсийн сайн сайхны төлөө эдийн засаг, нийгэм, соёл боловсролын, аж төрөх ёсны тухай түүнийг нийгэмд хүргэх нөхцөлийг хангахад чиглэгдсэн байдаг”⁸⁴ тухай тэмдэглэжээ.

В. Хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи болон эрх зүйн антроплогийн бусад төрөлжсөн чиглэл хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарал

Хэвлэл мэдээллийн эрх зүйд холбогдох асуудлыг антроплогийн ухааны үүднээс авч үзэх гол хүчин зүйл нь хэвлэл мэдээлэл яагаад янз бүрийн зорилгын төлөө үйлчилдэг, улс орон болгонд яагаад өөр өөр хэлбэрээр илэрдэг вэ, нэг улс орны хэвлэл мэдээлэл нөгөө улс орны хэвлэл мэдээллээс яагаад эрс өөр, ялгаатай вэ гэх асуултуудад хариулт эрэлхийлэх учиртай юм. Янз бүрийн улс орны хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх ялгаа нь янз бүрийн газар нутагт хүмүүс юу хийдэг вэ, өөрийнхөө хувийн туршлагаас шалтгаалан тэд юу уншихыг хүсэн хүлээдэг вэ гэдгийн тусгал болохыг ямар нэгэн хэмжээгээр илэрхийлдэг. Гэхдээ энэхүү ялгаанд түүнээс илүү чухал, суурь шинжтэй шалтгаан бий.⁸⁵

Энэ утгаар нь монгол хөрсөн дээр буулган авч үзвэл, Монгол Улсын (1992 оны) Үндсэн хууль батлагдсанаар өнөөгийн улс төр, нийгэм – эдийн засаг, нийгмийн тогтолцооны хөрс суурь нь болсон юм. Энэ ардчилсан өөрчлөлт, шинэчлэлийн үр дүнд улсын өмчийн аж үйлдвэрийн газар, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний салбар хувьчлагдав. Энэхүү үйл явц монголын хэвлэл мэдээллийн салбарыг ч тойрсонгүй. Энэ он жилүүдэд монголын хэвлэл мэдээллийн салбарт хувийн хэвшлийн мэдээллийн хэрэгсэл байгуулагдаж эхлэв.⁸⁶ Ингэж л монголд чөлөөт сэтгүүл зүй жам ёсоороо хөгжих эх суурь тавигдав.⁸⁷ Энэ нь цаашлаад өнөөгийн үзэгч, сонсогчдын хэв шинж, сонирхол хэрэгцээ өчигдрийн үзэгч, сонсогчдоос зарчмын эрс ялгаатай байгааг тооцохгүй байхын аргагүй. Чухам л аль болох олон үзэгч, сонсогчийг өөртөө татахын төлөө тэмцэх нь өрсөлдөөний жам. Үүний цаана ашиг орлого гэсэн арилжааны хууль үйлчлэх нь гарцаагүй.⁸⁸ Энэ салбарт үйл ажиллагаа явуулах байгууллагууд олшрох тусам өрсөлдөөн нэмэгдэх болжээ. Үүнээс болж зарим

⁸² Э.Булаг, Монгол дахь ясны үзэл ба үндэстний эв нэгдэл, тэдгээрт холбогдох эрх зүйн асуудал, орч. Э.Туулайхүү, Ш.Туяа, Уб, 2020, 101 – 102 дахь тал.

⁸³ Б.Болд – Эрдэнэ, М.Зулькафиль ба бусад, Сэтгүүл зүйн үндэс, Уб., МУИС–ийн хэвлэлийн үйлдвэр, 2021, 37 дахь тал.

⁸⁴ Д.Ганболд, Сэтгүүл зүйн онол, практикийн нэр томъёоны хураангуй тайлбар толь, Уб., 2002, 98 дахь тал.

⁸⁵ Фред С Сиберт, Уилбур Шрамм, Теодор Питерсон, Хэвлэл мэдээллийн дөрвөн онол, орч. М.Зулькафиль, Г.Өнөрбаяр, Уб., Удам соёл, 2016, 5 дахь тал.

⁸⁶ МУИС–ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим, Телевизийн сэтгүүл зүй: Түүх, онол, практик, Сэтгүүлчийн номын сан, цуврал №2, Уб., Удам соёл, 2018, 15 дахь тал.

⁸⁷ М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 10 дахь тал.

⁸⁸ МУИС–ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим, Телевизийн сэтгүүл зүй: Түүх, онол, практик, Сэтгүүлчийн номын сан, цуврал №2, Уб., Удам соёл, 2018, 12 дахь тал.

байгууллага зах зээлээс “арчигдаж” байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэх ашгийн асуудлыг өндөр хариуцлага дагадаг.⁸⁹ Арилжааны шинж бүхий сэтгүүл зүйд сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл тодорхой зах зээлд үйлчилдэг байх ёстой гэсэн үзэл баримтлал өргөн дэлгэрсэн.⁹⁰ Тодруулбал, мэдээллийн зах зээлийн эрчимтэй хөгжил уншигчдын сонирхлыг богино хугацаанд татаж чадсан мэдээлэл – арилжааны хэвлэлийн шинэ хэв маяг үүсэхэд хүргэв.⁹¹ Социализмын үед зугаацуулах шинжтэй хөнгөн чанарын хэвлэл мэдээлэл байгаагүй, бас хүмүүст тийм хэвлэлийн хэрэгцээ шаардлага байсан зэрэг нь мэдээлэл – арилжааны хэвлэлийн энэ төрөлд “эрэлт – нийлүүлэлт” хэмээх зах зээлийн үндсэн механизм нөлөөлж, тэдний тоо хэмжээ урьд өмнө байгаагүй төвшинд хөгжих боломж олгосон юм.⁹² Хэвлэл мэдээллийн хэрэгсэл мэдээллийн бус арилжааны байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагаа улам эрчимжиж байна. Өөрөөр хэлбэл, томоохон компаниуд хэвлэл мэдээллийн хэрэгслийг худалдан авах, хувьцааг эзэмших, хөрөнгө оруулах замаар медиа – концерн болох явдал ихээхэн идэвхжиж байна.⁹³ Харин орчин үед дэлхийн томоохон сонинууд орлогыг бараг бүхэлдээ зар сурталчилгаанаас олдог юм. Тухайлбал, Америкийн нөлөө бүхий том сонин <<Los Angeles Times>> сонин орлогын 95 хувийг реклам ашгаас олдог байна. Ингээд арилжааны реклам ашиг орлогын үндсэн эх үүсвэр болж хувирсан юм. Энэхүү арилжаанаас олох орлого эрс нэмэгдсэн нь томоохон сонин хэвлэлийг (ялангуяа томоохон хотуудын өдөр тутмын сонинууд) өндөр ашиг орлоготой хэвлэлийн үйлдвэрүүд болгон хувиргахад хүргэжээ.⁹⁴ ХХ зууны эцэст дэлхийн олон улс оронд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл арилжааны хэрэгсэл болох хандлага улам хүчтэй өрнөх болов.⁹⁵ Арилжааны хүчин зүйл орчин үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлж байгааг Америкийн сэтгүүл зүйн жишээгээр тайлбарлаж болно.⁹⁶ Энэ нь арилжааны эрх зүйн антропологийн судлагдахуун⁹⁷ болохыг харуулж байна. Эндээс авч үзвэл хэвлэл мэдээллийн болон арилжааны эрх зүйн антропологи хоорондоо ихээхэн уялдаа холбоотой болох нь харагдаж байна.

IV. Дүгнэлт, санал

Хэвлэл мэдээллийн антропологи нь нийгэм, соёлын антропологийн хүрээнд судлах бөгөөд нийгэм, соёлын үр дагаврыг нийгэм, соёлынх нь хүчин зүйлсийн нөлөөлөлд авч үздэг антропологийн ухааны дэд салбарыг “хэвлэл мэдээллийн антропологи” гэж нэрлэж болох юм. Энгийнээр бол хэвлэл мэдээллийн антропологи бол хэвлэл мэдээллийн тухай мэдлэгийн цогц юм. Тийм ч учраас хэвлэл мэдээллийн эрх зүйд хамаарах үндэсний хууль тогтоомж, тэдгээрийг хэлэлцэн баталсан тэмдэглэл, практикт тогтсон нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад хэм хэмжээ (заншил зэрэг) болон олон улсын гэрээ, хэлэлцээр зэрэг

⁸⁹ МУИС–ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим, Телевизийн сэтгүүл зүй: Түүх, онол, практик, Сэтгүүлчийн номын сан, цуврал №2, Уб., Удам соёл, 2018, 69 дэх тал.

⁹⁰ МУИС–ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим, Телевизийн сэтгүүл зүй: Түүх, онол, практик, Сэтгүүлчийн номын сан, цуврал №2, Уб., Удам соёл, 2018, 96 дахь тал.

⁹¹ М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 107 дахь тал.

⁹² М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 108 дахь тал.

⁹³ М.Зулькафиль, Ч.Чойсамба, Америкийн сэтгүүл зүйн түүх, Уб., Одсар Инк ХХК, 2007, 146 дахь тал.

⁹⁴ М.Зулькафиль, Ч.Чойсамба, Америкийн сэтгүүл зүйн түүх, Уб., Одсар Инк ХХК, 2007, 100 дахь тал.

⁹⁵ М.Зулькафиль, Ч.Чойсамба, Америкийн сэтгүүл зүйн түүх, Уб., Одсар Инк ХХК, 2007, 170 дахь тал.

⁹⁶ М.Зулькафиль, Ч.Чойсамба, Америкийн сэтгүүл зүйн түүх, Уб., Одсар Инк ХХК, 2007, 171 дэх тал.

⁹⁷ Мэдээлэл – арилжааны хэвлэл монголын тогтмол хэвлэлийн шинэ хэв маяг болох нь: Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, олон намын тогтолцоо, олон ургальч үзэл, ил тод байдал хэвийн үзэгдэл болсон нь сэтгүүлчид, хэвлэн нийтлэгчдээс санхүүгийн эх үүсвэрийг бие дааж олж, эдийн засгийн хямралаас гарах, менежмент, маркетингийн цоо шинэ арга барилыг нэвтрүүлэх, хүлээн авагчдын хэрэгцээ сонирхлыг нухацтай судлах, зар сурталчилгаа нийтлэхийг шаардаж эхэлсэн. М.Зулькафиль, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл, Уб., Соёмбо принтинг, 2010, 105 – 106 дахь тал.

нь эрх зүйн антропологийн, тодруулбал хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн нэн чухал судлагдахуун болох юм. Энэ утгаараа хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи бол эрх зүйн антропологийн судалгааны төрөлжсөн чиглэл төдийгүй хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи нь эрх зүй судлалын шинжлэх ухааны нэгэн салбар болж байна. Ийнхүү антропологийн үзэл баримтлалыг ухагдахууны түвшинд тодорхойлох, эрх зүйн антропологийн онцлогийг эрх зүйн ерөнхий үзэл баримтлал болгон хөгжүүлэх нь хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох үндэс болно гэж үзэж байна. Энэ үүднээс нь авч үзвэл хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологийн асуудал нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө хэрэгжих орчин буюу хэвлэл мэдээллийн эрх зүй бүрдэх орчны талаар авч үзэх юм.

Эцэст нь тэмдэглэхэд “хэвлэл мэдээллийн эрх зүйн болон үндэсний эрх зүйн тогтолцооны талаархи антропологи анализыг хэвлэл мэдээллийн эрх зүйн антропологи” гэж тодорхойлж болох юм.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 1998.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Б.Бат–Эрдэнэ ба бусад, Сэтгүүл зүйн үндэс, Уб., МУИС–ийн хэвлэх үйлдвэр, 2021.
2. Ж.Батбаатар, Суурь сэтгүүл зүй, Уб., Мөнхийн үсэг, 2023.
3. Д.Батжаргал, Сэтгүүл зүйн бичлэгийн нэр томъёоны товч тайлбар, Уб., Чөлөөт монгол, 2008.
4. Ц.Ган – Оч, Б.Доньжчимбуу, Мэдээллийн эрх зүй, Уб., Соёмбо принтинг, 2019.
5. Д.Ганболд, Сэтгүүл зүйн онол, практикийн нэр томъёоны хураангуй тайлбар толь, Уб., 2002.
6. Т.Дорждагва, А.Амарсанаа, Ц.Цэцэгжаргал, Ч.Чойсамба, English, (соёл судлал, хүн судлал, сэтгүүл зүйн мэргэжлийн оюутанд зориулсан гарын авлага), Уб., МУИС–ийн хэвлэх үйлдвэр, 2005.
7. М.Зулькафил, Монголын олон нийтийн мэдээлэл: Нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүргэл, Уб., Соёмбо принтинг, 2010.
8. М.Зулькафил, Сэтгүүлчийн мэргэжил: Өчигдөр, өнөөдөр, маргааш, Уб., Удам соёл, 2014.
9. М.Зулькафил, Сэтгүүл зүйн тайлбар толь, Уб., Удам соёл, 2018.
10. М.Зулькафил, Ч.Чойсамба, Америкийн сэтгүүл зүйн түүх, Уб., Одсар Инк ХХК, 2007.
11. М.Зулькафил, Ч.Чойсамба, Сэтгүүлчийн ёс зүй, Уб., МУИС–ийн хэвлэх үйлдвэр, 2004.
12. М.Зулькафил, Орчин үеийн сэтгүүлчийн ёс зүй, Уб., Адмон принтинг, 2007.
13. Е.П.Прохоров, Сэтгүүл зүйн онолын удиртгал, орч. Л.Норовсүрэн, Уб., МУИС–ийн хэвлэх үйлдвэр, 2022.
14. А.Оюунгэрэл, Олон түмний харилцааны онол, Уб., Нөблмэн, 2009.
15. Ш.Үнэнтөгс, Монголын хэвлэл мэдээлэл, Уб., Интерпресс хэвлэлийн газар, 2000.

16. Фред с Сиберт, Уилбур Шрамм, Теодор Питерсон, Хэвлэл мэдээллийн дөрвөн онол, орч. М.Зулькафиль, Г.Өнөрбаяр, Уб., Удам соёл, 2016.
17. Х.Наранжаргал, Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй, Уб., Чөлөөт хэвлэл сан, 2021.
18. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (Түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023.
19. В.В.Ворошилов, Дэлхийн сэтгүүлзүйн түүхээс, орч. Ш.Одонтөр, С.Амартөвшин, Уб., Соёмбо принтинг, 2001.
20. Ч.Чойсамба, Дэлхийн сэтгүүл зүйн түүх, (Тогтмол хэвлэлийн үе 1609 – 1900), I боть, Уб., Мөнхийн үсэг, 2009.

Англи хэл дээрх

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

1. Фернанда Пирие, Эрх зүйн антропологи, анхны хэвлэл, Оксфорд Университи пресс, 2013.

ХАВСРАЛТ

Хүснэгт – I

/БНМАУ–ын Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их цааз (Үндсэн хууль) төсөл /1991.05.25// ¹	/БНМАУ–ын Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын хуралдаанаар хэлэлцээнд БНМАУ–ын Бага Хуралд өргөн барьсан хувь /1991.10.05// ²
<p>Монгол Улсын Үндсэн хууль /Их цааз/</p> <p>Хоёрдугаар бүлэг Хүний эрх, эрх чөлөөг илтгэн тунхаглах нь</p> <p>19 дүгээр зүйл Монгол Улсын иргэд дараахь үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ: 8/ иргэд соёл, шинжлэх ухааны амьдралд чөлөөтэй оролцох, соёл, урлагийн бүтээл, шинжилгээ судалгааны үр дүнг ашиглах, өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн үр шимийг хүртэх, зохиогчийн эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах эрхтэй; 10/ иргэд төрийн нууцад хамаарахаас бусад асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Төрийн нууцыг хуулиар тогтоож хамгаална; 16/ иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайвнаар жагсаал үйлдэх, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал үйлдэх, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал үйлдэх, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;</p>	<p>Монгол Улсын Үндсэн хууль /Их цааз/</p> <p>Хоёрдугаар бүлэг Хүний эрх, эрх чөлөөг</p> <p>Арван долдугаар зүйл Монгол Улсын иргэд дараахь үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ: 8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, түүний үр шимийг хүртэх эрхтэй. Зохиогчийн болон шинэ бүтээлийн эрх, нээлтийн онц эрхийг хуулиар хамгаална; 16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайвнаар жагсаал үйлдэх, цуглаан хийх эрх чөлөөтэй. Хэвлэн нийтлэх, жагсаал үйлдэх, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно; 17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор төр, түүний байгууллагаас задруулж үл болох төрийн болон хувь хүн, байгууллагын нууцыг хууль тогтоомжоор тодорхойлно;</p>
/Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэн баталсан нь /1992.01.13// ³	

Монгол Улсын Үндсэн хууль

Хоёрдугаар бүлэг
Хүний эрх, эрх чөлөө

Арван зургадугаар зүйл

Монгол Улсын иргэд дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, түүний үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар хамгаална;

/Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 8, 16, 17 дахь заалтуудыг хэлэлцсэн

БНМАУ–ын Бага Хурлын гишүүдийн үг хэлсэн байдлыг үзүүлбэл/⁹⁸

Д/д	Гишүүдийн нэрс	Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн заалт			Үг хэлсэн давтамж
		8	16	17	
1	Авирмэд Б.,	-	-	-	-
2	Авхиа Ж.,	-	-	-	-
3	Амарсанаа Ж.,	5	1	1	7
4	Баасанжав Д.,	-	-	-	-
5	Балдан-Очир Д.,	-	-	-	-
6	Барамсай Ж.,	-	-	-	-
7	Батмөнх С.,	-	-	-	-
8	Батсүх Д.,	5	-	-	5
9	Баттулга Д.,	-	-	2	2
10	Баяр С.,	-	-	-	-
11	Баярцогт С.,	-	1	1	2
12	Болат А.,	-	-	-	-
13	Бямбажав Ж.,	-	-	1	1
14	Бямбацэрэн Н.,	-	-	-	-
15	Галсан Т.,	-	-	-	-
16	Галсандорж Б.,	-	2	1	3
17	Ганбаатар .,	-	-	-	-
18	Ганбаяр Н.,	-	-	-	-
19	Ганболд Д.,	-	1	-	1
20	Гантөмөр Т.,	-	-	-	-
21	Ганхуяг Ө.,	-	-	-	-
22	Гончигдорж Р.,	7	11	9	27
23	Дагвадорж Б.,	-	-	-	-
24	Дэндэв Г.,	-	-	-	-
25	Зориг С.,	-	-	-	-
26	Зуунай Г.,	3	-	1	4
27	Жанцан Н.,	-	-	-	-
28	Ламжав Д.,	1	2	-	3
29	Лүндээжанцан Д.,	-	-	-	-
30	Лхагважав Гү.,	1	2	3	6
31	Лханаасүрэн Б.,	-	-	-	-
32	Одончимэд Л.,	-	-	-	-
33	Очиржав О.,	-	1	-	1
34	Очирхүү Т.,	-	2	3	5

⁹⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 543 – 544 дэх тал

35	Өөлд Ц.,	-	-	-	-
36	Пүрэв Д.,	-	-	-	-
37	Пүрэвдагва Х.,	-	-	1	1
38	Пүрэвдорж Ч.,	-	-	-	-
39	Пүрэвжав.,	-	-	-	-
40	Самат Н.,	-	2	-	2
41	Сандуйжав Б.,	-	-	-	-
42	Сумьяа Б.,	-	-	-	-
43	Товуусүрэн Ц.,	1	-	-	1
44	Төмөр С.,	-	-	-	-
45	Төмөрбаатар Г.,	-	-	-	-
46	Улаанхүү П.,	6	12	-	18
47	Уртнасан Ж.,	-	-	-	-
48	Хатанбаатар Р.,	-	-	-	-
49	Цог Л.,	1	1	1	3
50	Цогт-Очир Л.,	-	-	-	-
51	Цэндбаяр Ш.,	-	-	-	-
52	Цэрэндагва Ч.,	-	-	-	-
53	Чилхаажав Д.,	-	1	-	1
54	Чимид Б.,	3	4	1	8
55	Чулуун Д.,	-	-	-	-
56	Чулуунбаатар С.,	-	-	-	-
57	Шагдарсүрэн Ш.,	-	1	-	1
58	Элбэгдорж Ц.,	-	-	5	5
59	Энхбаатар Д.,	-	-	3	3
60	Энхсайхан М.,	1	-	-	1
		34	44	33	

/Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 8, 16, 17 дахь заалтуудыг хэлэлцсэн

БНМАУ–ын Ардын Их Хурлын депутатуудын үг хэлсэн байдлыг үзүүлбэл⁹⁹

Д/д	Гишүүдийн нэрс	Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн заалт			Үг хэлсэн давтамж
		8	16	17	
1	Аварзэд Ү.,	1	1	-	2
2	Авхиа Ж.,	-	-	-	-
3	Адъяа М.,	-	-	-	-
4	Алгаа.,	-	-	-	-
5	Алтангэрэл Э.,	-	-	-	-
6	Амарбаян.,	-	-	-	-
7	Анигар.,	-	-	-	-
8	Баарин.,	1	-	-	1
9	Баасанжав Д.,	-	-	-	-
10	Бадам Ш.,	-	-	-	-
11	Бадарч.,	-	-	-	-
12	Балдан – Очир Д.,	-	-	-	-
13	Банди Б.,	-	-	-	-
14	Барамсай Ж.,	-	1	1	2
15	Барсболд Р.,	-	1	1	2
16	Батбаяр.,	-	-	-	-
17	Батжаргал.,	-	-	-	-
18	Батмөнх С.,	-	2	-	2
19	Батсайхан Б.,	-	1	-	1
20	Батсүх С.,	-	-	-	-
21	Баттулга Д.,	-	1	4	5
22	Бат – Үүл С.,	-	11	8	19
23	Баяндалай Л.,	-	-	-	-
24	Баянмөнх Б.,	-	-	-	-
25	Баяншагай.,	-	-	-	-
26	Баяр С.,	-	-	-	-
27	Баярцогт С.,	-	3	-	3
28	Баярцэнгэл Д.,	-	2	1	3
29	Билэгсайхан С.,	-	-	-	-
30	Болат А.,	-	-	-	-
31	Болд Л.,	-	-	1	1
32	Буяндэлгэр Б.,	-	-	1	1
33	Бямбаа Ж.,	-	-	-	-
34	Бямбажав Х.,	-	-	-	-

⁹⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийг хэлэлцсэн БНМАУ–ын Бага Хурлын чуулганы болон Ардын Их Хурлын хуралдааны тэмдэглэлүүд, (түүвэр), эмх. С.Номынбаясгалан, Б.Баатарцогт, Э.Тамир, Уб., Адмон принтинг, 2023, 545 – 548 дахь тал

35	Вандандагва Г.,	-	-	-	-
36	Галсан Т.,	-	-	-	-
37	Галсандорж Б.,	1	-	1	2
38	Ганболд Г.,	-	-	1	1
39	Ганболд Д.,	-	-	-	-
40	Ганзориг П.,	-	-	-	-
41	Гантөмөр Д.,	-	-	1	1
42	Ганхуяг Ө.,	-	-	1	1
43	Гаравсүрэн Н.,	-	-	-	-
44	Гарамжав Д.,	-	-	-	-
45	Гомбо.,	-	-	-	-
46	Гомбожав.,	-	-	1	1
47	Гомбосүрэн.,	-	-	-	-
48	Гончиг С.,	-	-	-	-
49	Гончигдорж Р.,	-	-	4	4
50	Гүнджалам.,	-	-	1	1
51	Гүрбазар Ш.,	-	-	-	-
52	Даваажид Ц.,	-	-	-	-
53	Дагвадорж Б.,	-	-	-	-
54	Дамдин.,	-	-	-	-
55	Дамдинсүрэн Л.,	-	-	-	-
56	Данаа Х.,	-	-	-	-
57	Даргахүү Ж.,	-	-	-	-
58	Даш.,	-	-	2	2
59	Дашбалбар О.,	-	1	-	1
60	Дашням Л.,	-	3	1	4
61	Дүйсинсанги Л.,	-	-	-	-
62	Дэмбэрэлням Ч.,	-	-	1	1
63	Дэмид Д.,	-	-	-	-
64	Дэндэв Г.,	-	-	-	-
65	Зардыхан К.,	-	-	-	-
66	Зарыккан Д.,	-	-	-	-
67	Зориг С.,	-	-	-	-
68	Зуунай Г.,	-	-	1	1
69	Жамсран М.,	-	-	-	-
70	Жанцан Н.,	-	-	-	-
71	Жанжаадорж З.,	-	-	-	-
72	Ламжав Д.,	-	-	-	-
73	Лантуу Л.,	-	-	-	-
74	Лоохууз Ц.,	-	-	-	-
75	Лүндээжанцан Д.,	-	1	-	1
76	Лхагвадорж Д.,	-	-	-	-
77	Лхагвасүрэн Д.,	-	-	-	-
78	Лхагвасүрэн С.,	-	-	-	-
79	Лханаасүрэн Б.,	-	-	1	1
80	Мандах Д.,	-	-	-	-

81	Марав Д.,	-	-	-	-
82	Мизамхан К.,	-	-	-	-
83	Моголцог Е.,	-	-	2	2
84	Мөнгөн Б.,	-	-	-	-
85	Мөнхөө Д.,	-	1	-	1
86	Найдан.,	-	-	-	-
87	Намсрай Ч.,	-	-	-	-
88	Норовсамбуу Ж.,	-	-	-	-
89	Нямбуу Б.,	-	-	-	-
90	Нямдаваа.,	-	-	-	-
91	Одончимэд Л.,	-	-	-	-
92	Оросоо Ж.,	-	-	-	-
93	Осор Б.,	-	-	-	-
94	Очирбат Г.,	-	-	-	-
95	Очирбат Р.,	-	-	-	-
96	Очирхүү Т.,	-	-	-	-
97	Өөлд Ц.,	-	-	-	-
98	Пүрэв Д.,	-	-	-	-
99	Пүрэвдагва Х.,	-	-	-	-
100	Пүрэвдорж Д.,	-	-	-	-
101	Пүрэвжав.,	-	1	-	1
102	Рэнцэннацаг Д.,	-	-	-	-
103	Сайраан.,	-	-	-	-
104	Самат Н.,	-	-	-	-
105	Сандуйжав Б.,	-	-	-	-
106	Содном.,	-	-	1	1
107	Сумъяа Б.,	-	-	-	-
108	Сүрэнхорлоо Д.,	-	-	-	-
109	Төмөрбаатар Г.,	-	-	-	-
110	Улаанхүү П.,	-	3	-	3
111	Уртнасан Ж.,	4	17	56	77
112	Хаадгар П.,	-	-	-	-
113	Харжаубай С.,	-	-	-	-
114	Хатанбаатар Р.,	-	-	-	-
115	Хашбаатар Г.,	-	-	-	-
116	Хишигдалай Ч.,	-	-	-	-
117	Цог Л.,	-	6	5	11
118	Цогтбаяр Д.,	-	-	-	-
119	Цогт – Очир Н.,	-	-	-	-
120	Цэндбаяр Ш.,	-	-	1	1
121	Цэрэндагва Ч.,	-	-	4	4
122	Чагнаа Н.,	-	-	-	-
123	Чимид Б.,	1	5	29	35
124	Чинбат Ч.,	-	-	-	-
125	Чойжамц.,	-	-	-	-
126	Чойжилсүрэн.,	-	-	-	-

127	Чулуун Д.,	-	-	-	-
128	Чулуунбаатар С.,	-	-	-	-
129	Чунагсүрэн Ж.,	-	-	-	-
130	Шагдарсүрэн Ш.,	-	1	-	1
131	Шоовдор Ж.,	-	-	1	1
132	Элдэв – Очир Б.,	-	-	-	-
133	Элбэгдорж Ц.,	-	-	2	2
134	Энхсайхан М.,	-	2	-	2
135	Ядамсүрэн Т.,	-	-	-	-
-	-	8	63	134	

WHAT IS THE ANTHROPOLOGY OF MEDIA LAW?

Nomynbayasgalan.S

*Senior researcher of Mongolian
Criminological Society (BBA),
Ph.D. Candidate, School of Arts and
Sciences, NUM,
Ph.D. student, School of Law, NUM*

Tamir.E

*Researcher of Mongolian Criminological
Society (LL.B),
Chief Operating Officer (COO) of “www.
urug.mn” of “Word Media” LLC*

ABSTRACT:

Anthropology is an empirically – grounded discipline. Its material is observed in the real world, typically through long – term, focused participant observation. Media anthropology is nothing new. Media and anthropology have been inalienably linked since the beginning of anthropology. Media anthropology centers on an awareness of five points of articulation between the various media and anthropology: the study of media, reaching the public with media, gathering data with media, teaching with media, and applied media anthropology. Research paper “what is the anthropology of media law” will certainly contribute to the development of the legal anthropological studies.

KEYWORDS:

Anthropology, anthropological approach, kinds of anthropology, social and cultural anthropology, anthropology of law (legal anthropology), legal terminology, media law, anthropological research, anthropology of media (media anthropology), oral source, basic stages of media research, main directions of media research, advocacy journalism, legal media.

ГЭМ БУРУУГИЙН АСУУДЛЫГ ГЭМТ ХЭРГИЙН СУБЪЕКТИВ ТАЛЫН ОЙЛГОЛТООС ЯЛГАМЖТАЙГААР АВЧ ҮЗЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ



З.Янжинлхам

*МУИС-ийн ХЗС-ийн магистрант,
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хурээлэнгийн судлаач*

ТОВЧЛОЛ:

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруугийн асуудал нь гэмт хэргийн субъектив талын шинжээс агуулгаараа ялгаатай ойлголт юм. Англи, Америк тэргүүтэй Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнууд, ХБНГУ-ын эрүүгийн эрх зүйн онолд гэм буруугийн ойлголтыг бие хүний чөлөөт хүсэл зоригтой холбон тайлбарладаг бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлд хамаардаг. Үүнтэй холбоотойгоор гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал ба эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл хоорондын ялгаа үүсдэг. Ийнхүү гэм буруугийн ойлголтыг бие даасан байдлаар дахин авч үзэх нь эрүү, эрүүгийн процессын эрх зүйн суурь зарчмууд болох хууль ёсны зарчмын баталгааг хангах ба гэм бурууг шүүхээр эцэслэн тогтоох зарчим бодит агуулгаараа хэрэгжих бололцоог бүрдүүлнэ.

ТҮЛХҮҮР ҮГС:

Гэм буруу, субъектив тал, гэм буруугийн зарчим, гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал, уучлах үндэслэл.

УДИРТГАЛ

Монгол Улсын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүн, түүний бүрдэл хэсгүүд нь аливаа эрх зүйн этгээдийн хууль зөрчсөн үйлдэл гэмт хэргийн шинжтэй эсэхийг тогтоох, төсөөтэй гэмт хэргүүдийг хооронд нь ялган зүйлчлэх арга зүйн гол хэрэгсэл юм. Уламжлалт гэмт хэргийн бүрэлдэхүүний 4 элементийн онолоор хүний үйлдлийн дотоод тал буюу субъектив талд гэм буруу, гэмт санааны ойлголтуудыг нэгэн зэрэг хамааруулдаг. Ийнхүү гэм буруу, субъектив талын ойлголтуудыг авч үзсэнээр практикт шүүгдэгчийн гэмт санаа болон гэм буруугийн асуудлуудыг холих асуудал үүсэж байна. Нөгөө талаас хэрэв мөрдөгч, прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхийн тулд яллагдагчийн гэм бурууг нотлох үүрэг хүлээх нь шударга ёсны зарчимд нийцэх эсэх? Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болох зарчим мөн чанараараа хэрхэн хэрэгжих вэ гэсэн асуултууд зүй ёсоор урган гарч ирнэ.

Германы философич Г.В.Гегелийн бие хүний философийн үзлээр хүн бол чөлөөт хүсэл зоригтой субъект тул өөрийн эргэн тойрон, ахуйгаа ухаалгаар танин мэдэж түүнд өөрийн үйлдлийг нийцүүлэн эрх чөлөөгөө эдлэх чадвартай. Энэхүү үзэл санаа нь гэм буруугийн талаарх ойлголтын үндсийг бүрдүүлдэг гэж хэлж болох юм. Хүн өөрийн үйлдлийг нийгмийн шаардлагад нийцүүлж шийдвэр гаргах бүрэн чадвартай оюун санааны хувьд эрх чөлөөтэй бодгаль мөн. Хэрэв гэмт этгээд гэмт хэрэг үйлдэхдээ оюун санааны бүрэн эрх чөлөөнд үндэслэн шийдвэр гаргасан бол түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах бүрэн үндэслэлтэй.

Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнууд, тухайлбал Америк, Англид, түүнчлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад /цаашид ХБНГУ гэх/ гэмт этгээдийг гэм буруутайд тооцох үндэслэлийг бие хүний автономн байдал буюу чөлөөт хүсэл зориг, хүний эрхэм чанартай нь холбон тайлбарладаг.¹ Ийнхүү гэмт хэргийн субъектив тал, гэм буруугийн ойлголтуудын ялгаа заагийг тодорхойлон судалсан судалгааны бүтээл, өгүүлэл цөөн бөгөөд хууль зүйн доктор Т.Золбоо “Гэмт хэргийн бүрэлдүүн” хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээл (2023)-дээ энэ талаар судалжээ. Судлаачийн зүгээс энэхүү өгүүлэлээр дамжуулан эх газрын болон жишгийн эрх зүйн бүлийн улс орнуудын гэмт хэргийн субъектив тал ба гэм буруугийн тухай ойлголтыг харьцуулан судалж, бодит кейст тулгуурлан гэмт хэргийн субъектив тал ба гэм буруугийн асуудлын харилцан хамаарлыг дахин авч үзэхийн ач холбогдлыг тодорхойлохыг зорилоо.

Үндсэн хэсэг

Гэмт хэрэг нь гэмт этгээд үйлдэл, түүнийхээ үр дагаврыг тусгасан оюун санааны элементтэй байх тухай санаа анх Ромын эрх зүйгээс үүсэлтэй. Эхэн үедээ зөвхөн гэмт зорилгын талаар авч үзэж, зорилгыг үйлдэлтэй хатуу холбон гэмт этгээдийн үйлдлээс оюун санааны элементийг шууд тодорхойлдог байжээ. Дундад зууны үеэс энэхүү хатуу зорилгын хандлага өөрчлөгдөж гэмт санааны төрлүүдийг хөгжүүлж, гэмт этгээдийн үйлдэлдээ хандсан сэтгэхүйн харьцаа нь мэдэж, хүсэж үйлдсэн боловч түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх нөхцөлүүдийн тухай санааг боловсруулснаар гэмт хэргийн субъектив тал, гэм буруугийн ойлголтууд бий болжээ.

Нэг. Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад

“Хохирол учруулах зорилго байхгүй бол гэмт хэрэг биш” гэх санаа МЭ-ний III дугаар зуунд Ромын эрх зүйн баримт бичгүүдэд анх тусгагдсанаас хойш аливаа гэмт үйлдэлд зөвхөн гэмт зорилготой нөхцөлд л хариуцлага хүлээлгэхийг чухалчлах болсон.² Дундад зууныг хүртэл Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад аливаа гэмт этгээдийн үйлдлээс түүний зорилго тодорхой харагддаг гэдэгт бат итгэдэг объективист хандлага үйлчилж байжээ. Гэмт этгээд анхнаасаа хохирогчийн амь насыг хохироох зорилготой байсан эсэхээс үл хамааран хохирогч нас барсан гэдэг нь түүнийг алах зорилготой байсныг илэрхийлнэ гэж үздэг. Хэрэв гэмт этгээд хохирогч руу буу барин довтолсон бол түүний бодит зорилго чухал бус буу барьж дайрах нь алах зорилгоос өөр зүйл илэрхийлэхгүй гэж хатуу тогтоодог байв. Тухайлбал, XVII-XVIII дугаар зууны үед Англид хүний амь насыг хөнөөх гэмт хэрэгт гэмт этгээдийн гэмт зорилгыг нотлох шаардлагагүй байсан бөгөөд үүнтэй адил зарим төрлийн аюултай гэмт хэргүүдэд зорилгыг нотлох баримтаар нотлохыг шаардаггүй байжээ.³

¹ Энэ хандлагыг гэмт хэргийн субъектив талыг тодорхойлох объективист хандлага гэдэг. Гэмт хэргийн дотоод тал буюу оюун санааны элементийг чухалчлах болсон цагаас орчин үеийг хүртэл объективист хандлагаас субъективист хандлага руу шилжилт хийсэн талаар судалгааны дараагийн хэсэгт тайлбарлана.

² G.Binder, *Criminal law: the Oxford introduction to U.S. Law*, (New York-Oxford University Press, 2016), 137.

³ Ibid.

Харин XVIII дугаар зууны дунд үед Английн хуульч Виллиам Блейкстөун /William Blackstone/ гэмт хэрэг бүрд ялгаатай оюун санааны элемент байх ёстойг чухалчилж, гэмт этгээдийн гэм бурууг уучилж болох үндэслэлүүдийн талаарх санааг боловсруулснаар объективист хандлагад өөрчлөлт орж эхэлсэн. Тэрээр уучлах үндэслэлийг /excuses/ 3 төрөлд хувааж үзсэн. Нэгдүгээрт, сэтгэцийн өвчин болон бага балчрын улмаас үйлдлийнхээ үр дагаврыг ухамсарлах боломжгүй байдал; хоёрдугаарт, тушаал, албадлага, шаардлагын улмаас дарамтад орж гэмт хэрэг үйлдэх; гуравдугаарт, золгүй тохиолдлоос, эсхүл нөхцөл байдлыг ухамсарлаагүй, уучлах үндэслэлийг андуурсны улмаас үйлдлийнхээ үр дагаврыг мэдэх, хүсэх боломжгүй нөхцөл байдлуудыг тус тус тодорхойлжээ.⁴ Түүний боловсруулсан уучлах үндэслэлийн талаарх санаа нь гэмт хэргийн субъектив тал /mens rea/ болон гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах үндэслэл хоорондын ялгааг тусгасан юм.

Англи, Америк тэргүүтэй Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад гэмт хэргийн субъектив талын /mens rea/ ойлголт нь гэмт үйлдэл, учруулсан хохирлын оюун санааны тусгал гэсэн агуулгаар үүсэж хөгжсөн байна.⁵ Гэмт этгээдийн үйлдэл субъектив талын шинжийг агуулсан боловч гэмт хэрэг үйлдэх үеийн гарцаагүй нөхцөл байдлуудын улмаас хохирол учруулсан бол түүнийг ялаас чөлөөлөх үндэслэлүүдийг боловсруулсан нь гэм буруугийн асуудлыг бий болгожээ. Үйлдлээс зорилгыг шууд тодорхойлох хатуу зорилгын номлол буюу объективист хандлагаас шилжсэн энэ шилжилтийг гэмт хэргийн субъектив талыг тодорхойлох объективист хандлага гэж нэрлэдэг.

Субъективист хандлагын гол цөм нь бие хүний автономи чанарын зарчим /principle of autonomy/ юм. Тус зарчмын гол агуулга нь бие хүн бүр зан үйлийн хэд хэдэн хувилбараас сонголт хийх чадамжтай автономи хувь хүн ба тэдний автономи чанарыг хүндэтгэнэ гэдэг нь хийсэн сонголтынх нь төлөө хариуцлага хүлээлгэнэ.⁶ Энэ зарчим нь гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болох гэм буруугийн тухай ойлголтоос субъектив талын ялгаа, харилцан хамаарлыг илэрхийлэхэд ач холбогдолтой.

Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудын эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг нөхцөл:

1. Actus reus буюу гэмт үйлдэл
2. Mens rea буюу оюун санааны элемент
3. Гэмт хэргийг үгүйсгэх ба эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нөхцөлүүд /a defence/
4. Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөлүүд /a mitigation/

Англи хэлний blameworthiness буюу гэм буруугийн тухай санаа нь гэмт хэргийн субъектив тал болох mens rea-аас агуулгын хувьд ялгаатай. Гэмт хэргийн субъектив тал “mens rea” гэдэг нь гэмт этгээдийн оюун санааны нөхцөлийг илэрхийлдэг гэмт хэргийн бүрдэл хэсэг юм.⁷ Гэмт хэргийн субъектив тал нь төсөөтэй гэмт хэргүүдийг ялгах нэг шалгуур болдог.⁸ Гэмт этгээд гэмт хэрэг үйлдэхдээ өөрийн үйлдэл, түүний үр дагаврын талаар урьдчилан мэдэж байсан болох нь /o.x mens rea агуулсан/ түүнийг гэм буруутай /blameworthy/ гэж үзэж ял оногдуулахад чухал нөлөөтэй боловч ял оногдуулахад баримтлах цорын ганц хүчин зүйл биш юм. Автономи чанарын зарчмын дагуу хувь хүн өөрийн үйлдэл, түүний үр дагаврыг мэдэж байсан, мэдэх боломжтой нөхцөлд оюун санааны бүрэн эрх чөлөөний үндсэн дээр сонголт хийж чадсан тохиолдолд л хариуцлага хүлээлгэнэ. Харин албадлага эрхшээлд автах, эрх зүйн зохицуулалтыг андуурах, хууртагдах зэргээр

⁴ Ibid.

⁵ XIX дүгээр зуунд Бентам гэмт хэрэг бүр хамгаалагдсан эрх ашиг, түүнийг хууль бусаар зөрчсөн зөрчил, тухайн зөрчлийг бий болгох талаарх гэмт этгээдийн хүлээлтээс бүтнэ. Гэмт этгээд өөрийн үйлдэл, хохирол учрах боломжийг мэдэж үйлдсэн нөхцөлд түүнийг гэм буруутайд тооцно. Гэмт хэргийн оюун санааны элемент нь учруулсан хохиролтойгоо яв цав тохирч байх ёстой бөгөөд оюун санааны элемент болон үйл баримтын элемент хоёрын хамаарлыг “харилцан тусгалын зарчим” /correspondence principle/-д үндэслэнэ гэж үзсэн байдаг.

⁶ M.Bonlader, *Principles of German Criminal Law*, (North America-Hart publishing, 2009), 181.

⁷ J.Herring, *Criminal law: text, cases, and materials*, 5th ed, (United Kingdom- Oxford Press, 2012), 133.

⁸ Ibid, 171.

гэмт хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдлаас хамаарч субъект бүрэн эрх чөлөөний үндсэн дээр сонголт хийх боломжгүй байдалд орсон нөхцөлд /defence/ түүнийг гэм буруутай гэж үзэхгүй.⁹

Гэмт хэргийг үгүйсгэх болон эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нөхцөлүүд буюу “defence” нь зөвтгөх болон уучлах үндэслэлүүдэд хуваагдана. Субъектийн гэм бурууг үгүйсгэх буюу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нөхцөлүүдийг уучлах үндэслэл /англ. excuses/ гэнэ. Энэ төрлийн нөхцөл байдлууд нь гэмт хэргийг үгүйсгэх буюу зөвтгөх /англ. justifications/ үндэслэлүүдээс мөн чанар, үр дагавраараа ялгаатай. Зөвтгөх үндэслэлүүд нь субъектийн үйлдэл гэмт хэргийн шинжийг хэлбэрийн хувьд хангасан хэдий ч агуулгаараа хуулиар зөвшөөрсөн үйлдэл буюу нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн үйлдэл байдаг.¹⁰ Энэ тохиолдолд эрх зүйг зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд гэм буруугийн тухай ярих нь логикийн хувьд ач холбогдолгүй. Харин уучлах үндэслэл гэдэгт субъектийн үйлдэл гэмт хэргийн шинжийг хангасан боловч түүнийг уг үйлдэлд нь буруутгах зүй ёсны шалтгаангүй нөхцөл байдлыг ойлгодог. Өөрөөр хэлбэл, энэ тохиолдолд шүүх гэмт хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдлын улмаас шүүгдэгч оюун санааны бүрэн эрх чөлөөний үндсэн дээр шийдвэр гаргах боломжтой байсан эсэхийг харгалзан гэм буруугүй гэж үзэж ялаас чөлөөлж буй явдал юм.

Дээрхээс товч дүгнэхэд, Англо-Саксоны эрх зүйн бүлийн улс орнуудад гэмт хэргийн субъектив тал болох “mens rea” нь гэмт үйлдлийн оюун санааны дотоод тусгалыг илэрхийлдэг бөгөөд үйлдэлтэйгээ харилцан тусгалын зарчмын /principle of correspondence/ дагуу тохирч байвал тухайн гэмт хэргийн субъектив талыг бүрдсэнд тооцдог. Субъектив талын шинжийг хангасан боловч бие хүний автономи чанарын зарчмын дагуу уучлах үндэслэлтэй нөхцөлд шүүхээс гэмт этгээдийг гэм буруутай гэж үзэхээс татгалзах боломжтой. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн субъектив тал болон гэмт этгээдийг гэм буруутайд тооцох нь хоорондоо харилцан хамааралтай боловч ялгаатай ойлголтууд ба гэм буруугийн асуудлыг эрүүгийн хариуцлага хүлээлгэх шатанд авч үздэг байна.

Хоёр. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-д гэм бурууг гэмт хэргийн субъектив талаас ялгаж үзэх “Норматив гэм буруугийн онол” үйлчилж байна. Доктор Т.Золбоогийн бүтээлд тусгаснаар уг онол гэм буруугийн сэтгэхүйн онолыг¹¹ шүүмжлэн бий болсон бөгөөд “гэм буруугийн ухагдахууныг гэмт санаанаас тусад нь авч үзэхийг норматив байдлаар авч үзэх гэх ба... хэм хэмжээний бүрэлдүүнд хамааруулалгүй, бие даасан элемент байхаар үзэж хэрэг хариуцах чадвар гэж тодорхойлжээ. Энэ нь мөн гэм буруугийн ухагдахууны үүрэг зорилготой холбоотой бөгөөд гэм буруу нь хэм хэмжээний ямар нэг шинжийг илэрхийлэх бус субъектийн үйл тухайн хэм хэмжээний бүрэлдүүнийг хангасан тохиолдолд хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх үүрэгтэй байгаа юм”¹² гэжээ.

ХБНГУ-д эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд tatbestand буюу “эрүүгийн хуулиар заасан тодорхой хэм хэмжээний объектив, субъектив шинжийг цогц”¹³, гэмт хэргийн хууль бус шинж, гэм буруу гэсэн гурван нөхцөлийг хангасан байна.

1. Tatbestand:

А. Субъектив шинж

Б. Объектив шинж

⁹ Ibid, 716.

¹⁰ Ibid, 714.

¹¹ Сэтгэхүйн онолоор гэм бурууг субъектийн үйлдэлдээ хандсан сэтгэхүйн харьцаа гэж үздэг.

¹² Т.Золбоо, Гэмт хэргийн бүрэлдүүн, Уб, 2023, 141 дэх тал.

¹³ Нэр томъёоны орчуулгыг Т.Золбоо, Гэмт хэргийн бүрэлдүүн бүтээлээс авав.

2. Хууль бус шинж /*Rechtswidrigkeit*/: Гэмт хэргийн хууль бус шинжийг илэрхийлнэ. Эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэргийн объектив, субъектив шинж хангагдсан нөхцөлд түүний хууль бус шинжийг шалгах бөгөөд гэмт үйлдэл /эс үйлдэхүй/-г зөвтгөх үндэслэл /*justification*/ байхгүй бол хууль бус шинжийг хангасан гэж үзнэ.

3. Гэм буруу /*Schuld*/: ХБНГУ-д гэм буруугийн тухай ойлголтыг гэмт хэргийн субъектив талын элементээс ялгаж үздэг ба хэрэг хариуцах чадвартай холбож тайлбарладаг.¹⁴ Гэм хэргийг уучлах үндэслэл байгаа нөхцөлд шүүхээс шүүгдэгчийн гэм бурууг уучлах буюу ялаас чөлөөлөх шийдвэрийг гаргаж болдог.

Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнуудын адилаар үйлдэл нь өөрөө сэтгэхүйн дотоод элементийг агуулах тухай онол хөгжсөн нь “эцсийн үйлдлийн онол” ажээ. Эцсийн үйлдлийн онол ёсоор сэтгэхүйн элемент буюу субъектив талыг “үйлтэй хамааралтайгаар тайлбарлаж сэтгэхүй нь хүний хариуцлага хүлээх байдлыг тодорхойлох бус үйлийг тодорхойлж буй шинж учир хэм хэмжээний бүтцэд урьдчилсан нөхцөл байдлаар багтах ёстой гэж үздэг”¹⁵ гэжээ. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн субъектив тал нь эрүүгийн хуулиар тодорхойлсон гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг бол гэм буруу нь хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангасан тохиолдолд эрүүгийн хариуцлага оногдуулах эсэхийг шийдвэрлэх нөхцөл болж байна.

Гэм буруугийн зарчим буюу “*Schuldprinzip*”-г ХБНГУ-д эрх зүйт төрийн зарчим, Үндсэн хуулийн 1, 2 дугаар зүйлд заасан хүний эрхэм чанар, хувь хүний чөлөөт хүсэл зоригтой холбон тайлбарладаг. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүний эрхэм чанар нь зөрчиж үл болох шинжтэй бөгөөд төрийн эрх мэдлийн бүхий л байгууллага хүний эрхэм чанарыг хүндэтгэж хамгаалах үүрэгтэй.¹⁶ Хүний эрхэм чанар нь либерал төрд хэд хэдэн хязгаарлалтуудыг тогтоож өгдөг. Тэдгээрийн нэг нь хүний эрхэм чанарын үүднээс хувь хүнийг ёс суртахуунт бодгаль буюу сайн ба мууг, хориглосныг зөвшөөрснөөс ялгах, сайныг сонгож үйл хөдлөлөө түүнд нийцүүлэх чадамжтай субъект гэж хандах ёстой. Аливаа төрийн эрүүгийн бодлого энэхүү үзэл баримтлал дээр тулгуурладаг л бол гэм буруугүй этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах, гэм буруугийн хэр хэмжээнд нийцэхгүй хүнд ял оногдуулах нь төрөөс хувь хүнийг гадаад зорилгод хүрэх арга хэрэгсэл болгож байгаатай адил гэж үздэг. (гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх эсхүл бусдад сургамж болгох гэх мэт)¹⁷

Дүгнэхэд, ХБНГУ-д норматив онолд тулгуурлан гэм буруугийн ойлголтыг гэмт хэргийн субъектив талаас ялгаж, Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнуудтай адил субъектив талыг гэмт үйлдэлд хамаарах шинж гэж үздэг байна. Тодруулбал, субъектив тал нь гэмт этгээдийн үйлдэл гэмт хэргийн шинжийг хангасан эсэхийг шалгахад баримтлах эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг хэсэгт тооцогддог. Харин гэм буруу нь гэмт хэргийн шинжийг хангасан боловч эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй эсэхийг шалгах шалгуур болж байна. Хэрэв гэм буруугийн зарчмын дагуу субъектийг уучлах үндэслэлтэй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх гурав дахь нөхцөл буюу “*schuld*” хангагдаагүй гэж үзэж ялаас чөлөөлнө.

Гэм бурууг тогтооход тухайн субъект өөрийн үйлдлийг мэдэж, үр дагаврыг хүсэж үйлдсэн боловч түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах шаардлагатай эсэхийг бие хүний автономи чанар буюу чөлөөт хүсэл зоригтоо бүрэн тулгуурлаж шийдвэр гаргах боломжтой уялдуулан авч үзэх нь гэм буруугийн асуудлыг субъектив талаас ялгах нэг үндэс болох нь дээрх харьцуулсан судалгаанаас харагдаж байна. Гэмт хэрэг үйлдэгдэх үеийн нөхцөл байдал, субъект тухайн нөхцөлд өөрөөр үйлдэл хийх бодит боломжтой байсан эсэхээс

¹⁴ M.Bonlader, *Principles of German Criminal Law*, (North America-Hart publishing, 2009), 16.

¹⁵ Ibid, 143.

¹⁶ Basic Law of the Federal Republic of Germany, (1949), art. 1(1). цахим холбоос: https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html [Сүүлд үзсэн: 2023.07.28]

¹⁷ M.Kremnitzer and T.Hornle, “Human dignity and Principle of Culpability”, *Isreal Law Review*, 44, (2011), 112.

түүнд ял оногдуулах шаардлагыг тодорхойлох явдал нь шүүхээс гэм бурууг эцэслэн шийдвэрлэх зарчмын агуулгыг илэрхийлж байна.

Манай улсад гэмт хэргийн бүрэлдэхүүний 4 элемент бүхий онолоор гэм бурууг сэтгэхүйн онолын дагуу үйлдэлдээ харьцсан сэтгэхүйн харьцаа гэсэн агуулгаар нийтлэг ойлгодог. Жишээлбэл, профессор С.Жанцан “гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал гэдэг нь нарийвчилсан утгаараа гэм буруу, сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл санааны байдал зэрэг үндсэн ба нэмэгдэл шинжүүдээр тодорхойлогддог субъектийн ухамсар, хүсэл зоригт тусгагдсан сэтгэцийн үйл явцын талаарх ухагдахууныг илэрхийлдэг гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн элемент”¹⁸ гэжээ. Ийнхүү гэм бурууг субъектив талд хамааруулж ойлгох тохиолдолд гэм бурууг шүүхийн шатанд бус мөрдөн байцаалтын шатанд тогтоох логикт хүрнэ. Ингэвэл гэм бурууг шүүхээр эцэслэн тогтоох зарчим бодитой хэрэгжих боломжгүй болно.

Мөрдөгч, прокурор гэмт хэргийн үйлдэл, оюун санааны элементүүдийг нотлох баримтаар тогтооно. Хэрэв эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэргийн объектив, субъектив шинжийг тогтоосон тохиолдолд шүүх хүлээн авч эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй эсэхийг шийдвэрлэнэ. Энд гэмт хэрэг үйлдэгдсэн үеийн нөхцөл байдлууд тухайлбал, дээр дурдсан гэмт хэргийг үгүйсгэх буюу зөвтгөх үндэслэл, субъектийн гэм бурууг уучлах үндэслэлүүдийг шалгасны эцэст гэм буруутайд тооцох эцсийн шийдвэрийг гаргана. Ингэснээр гэм бурууг шүүхээр эцэслэн тогтоох зарчим бүрэн хэрэгжинэ.

Гурав. Кейс

Өгүүллийн энэ хэсэгт гэм буруугийн ойлголтыг субъектив талын гэмт санааны ойлголтоос ялгаж үзэх, үүнтэй уялдуулан гэм бурууг уучлах үндэслэлүүдийг боловсруулахын ач холбогдлыг дараах кейсээр дамжуулан тайлбарлая.

Хэргийн үйл баримт: 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Баянхонгор аймгийн Бууцагаан сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт орших шүүгдэгчийн гэрт хохирогч нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ шүүгдэгчийн ээжийг цохих, шүүгдэгчтэй харилцан хүч хэрэглэн маргалдаж үснээс нь зулгаах, толгой руу нь цохих зэргээр биед нь халдсан. Хөндлөнгийн этгээдүүд маргааныг салгаснаас хойш хэсэг хугацааны дараа хохирогч шүүгдэгчийн гэрт дахин ирж, гэрт нь нэвтэрч дахин маргаан үүсгэн орон дээр байсан шүүгдэгчийн бага насны хүүхэд дээр суух үйлдэл хийх үед шүүгдэгч хохирогчийн үйлдлийг таслан зогсоох зорилгоор аяга шидэж, эрүүл мэндэд нь “биед тархи доржилт, хамар ясны хугарал, таславчны мурийлт, хамарт шарх, чих, хамар, мөр, цээж, хэвлий, шилбэнд зулгаралт зовхи, хамар, хацар, цээжинд цус хуралт, дух, дагзанд зөөлөн эдийн няцрал” бүхий хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр: Баянхонгор аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн №313 дугаар шийтгэх тогтоолоор “ганц удаагийн болгоомжгүй үйлдлээс хохирогчийн биед гэмтэл учруулаагүй бөгөөд олон удаагийн гэмтэл шарх учруулснаас хохирогчийн эрүүл мэндэд хөнгөн хохирол учирсан байна... Нөгөө талаар хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах нь заавал болгоомжгүй эсхүл санаатай байдлаар үүсгэсэн байхыг шаардахгүй”¹⁹ гэж дүгнэн шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн (2015) тусгай ангийн 11.6 дугаар зүйлд заасан “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэр: Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн №10

¹⁸ С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол, Уб, 2009, 466 дахь тал.

¹⁹ Баянхонгор аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, №13, 2019.12.05, 29 дэх догцолбор, шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/72018?start_date=&end_date=&id=1&court_cat=2&bb=1 [Сүүлд үзсэн: 2023.07.28]

дугаар магадлалаар анхан шатны шүүхээс шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэрийг хэвээр үлдээжээ.

Хяналтын шатны шүүхийн шийдвэр: Улсын дээд шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн №260 дугаар тогтоолоор “Орчин үеийн эрүүгийн эрх зүйд аргагүй хамгаалалтын хүрээ хязгаарыг илүү өргөн хүрээнд авч үзэж, халдагч этгээдийн зөвхөн тулгарсан довтолгооноос гадна үргэлжилсэн довтолгоон, халдлагын үед өөрийн боломжит үедээ хамгаалалт хэрэглэх боломжийг зөвшөөрсөн. Халдагч этгээдийн зүгээс халдлага, довтолгоо хийгдэх нь энгийн ухамсрын хүрээнд ойлгомжтой болсон, аюул занал бодитой оршиж халдлага үргэлжилж буй үед өрсөж хамгаалах нь аргагүй хамгаалалтын хүрээнд хийгдсэн хууль ёсны үйлдэлд тооцогдоно... үргэлжилсэн довтолгооны үед халдагч этгээдийн зүгээс дахин халдлага үйлдэх нь тухайн нөхцөл байдалд бодитоор бүрдэж, түүний нийгэмд аюултай, хууль бус үйлдлийн улмаас өөрийн эсхүл бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учрах нь нэгэнт тодорхой болсон тохиолдолд халдагч этгээдээс дахин довтолгоон эхлүүлэхийг хүлээх нь аргагүй хамгаалалтыг хэрэгжүүлэх боломжит цаг хугацаа, магадлалыг бууруулдаг бөгөөд объектив нөхцөл байдалд зөв дүгнэлт хийсний үндсэн дээр өрсөж хамгаалалт хийж буй үйлдлийг аргагүй хамгаалалтын хүрээнд хийгдсэн гэж үзнэ”²⁰ хэмээн тайлбарлаж шүүгдэгчийн үйлдлийг аргагүй хамгаалалтын нөхцөл байдалд хамааруулж, түүнд холбогдох хэргийг цагаатгаж шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэрт тусгагдсан хэргийн үйл баримтаас харахад хохирогч нь шүүгдэгчийн гэрт дахин ирж маргаан дэгдээх үед шүүгдэгч, түүний гэр бүлийн гишүүдийн эсрэг ямар нэг хүч хэрэглэсэн үйлдэл хийгдээгүй байдаг. Харин согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ орон дээр байсан хүүхдийн дээр суух үйлдэл нь санаатай довтолгооны шинжийг агуулсан гэж үзэх боломжгүй байна. Учир нь довтолгоон нь довтолгогч этгээдийн хүсэх элементийн үндсэн дээр бий болсон байх ёстой ба үүнийг довтолгооны агуулга, өөрөөр чанар ч гэж нэрлэдэг.²¹ Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх зарчмын дагуу аргагүй хамгаалалт хийх гол нөхцөл болох довтолгоон байхгүй тохиолдолд аргагүй хамгаалалтын нөхцөл байдлын талаар яригдах боломжгүй юм.

Энэ тохиолдолд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал бус өөрийн насанд хүрээгүй хүүхдийн дээрээс суух үед үйлдлийг таслан зогсоох зорилгоор аяга авч шидсэн нь эрүүгийн хуульд заасан хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргийн объектив, субъектив шинжийг хангасан боловч тухайн нөхцөлд субъект өөрөөр шийдвэр гаргах боломжгүй байсан нөхцөлийг харгалзан түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх “уучлах” үндэслэл болох юм. Өөрөөр хэлбэл, хэдийгээр шүүгдэгч хохирогчийн зүг аяга шидсэн үйлдэл, түүний улмаас учирч болох үр дагаврыг оюун санаандаа урьдчилан төсөөлж мэдэж, хүсэж үйлдсэн гэж үзэх боломжтой боловч үйлдэл хийсэн нөхцөл байдал нь түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болж байна.

ДҮГНЭЛТ

Бие хүн өөрийн үйлдлийн мөн чанар, үр дагаврыг ухамсарлах чадвартай бөгөөд чөлөөт хүсэл зоригийн үндсэн дээр гаргасан шийдвэр нь эрүүгийн хуулиар хамгаалсан үнэт зүйлд хуульд урьдчилан тодорхойлсон хэлбэрээр халдаж хохирол учруулсан бол түүний үйлдэлд эрүүгийн хариуцлага оногдуулна. Гэмт хэргийн субъектив талын ойлголт нь товчхондоо субъектийн үйлдлийг эрүүгийн хуулийн зохицуулалтын хүрээнд хамаарах эсэхийг шийдвэрлэх урьдчилсан нөхцөл болдог. Гэм буруугийн асуудал нь эрүүгийн хариуцлага оногдуулах асуудалтай холбогдон бий болсон бөгөөд гэмт хэргийн бүрэлдэхүүний гадна орших ойлголт юм. Энэ хоёр ойлголтын ялгаа заагийг олж харах нь эрүүгийн эрх зүйн

²⁰ Улсын дээд шүүхийн тогтоол, №260, 2020.05.25, 13-14 дэх цогцолбор, шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:https://shuukh.mn/single_case/2311?daterange=2017-01-01%20-%202022-09-01&id=3&court_cat=2&bb=1 [Сүүлд үзсэн: 2023.07.28]

²¹ Т.Золбоо, Гэмт хэргийн бүтэц, Уб, 2018, 95 дахь тал.

хууль ёсны зарчмын баталгааг хангах, гэм бурууг шүүхээр эцэслэн шийдвэрлэх зарчмыг бодит агуулгаар нь хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

Ийнхүү гэм буруугийн асуудлыг эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл болох талаас авч үзсэнээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх буюу уучлах үндэслэлүүдийг бий болдог. Энэ нь манай улсын Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн үгүйсгэх нөхцөл байдлуудаас үр дагавар, мөн чанараараа ялгаатай. Гэмт этгээдийн үйлдэл эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийн объектив, субъектив шинжийг хангасан, түүний нийгмийн аюулын шинж чанарыг үгүйсгэх нөхцөл байдал байхгүй боловч гэмт хэрэг үйлдэгдсэн үеийн онцгой нөхцөл байдлаас хамааран субъект оюун санааны бүрэн эрх чөлөөний үндсэн дээр шийдвэр гаргах боломжгүй нөхцөлд түүнийг эрүүгийн хариуцлагаас уучлан хэлтрүүлэх үндэслэл болно. Уучлах үндэслэлүүдийн төрлүүдийг хуульчлах, гэм буруугийн асуудлыг гэмт хэргийн бүрэлдэхүүний ойлголтоос тусад нь шалгах дарааллыг тогтоосноор хэргийн нөхцөл байдлыг зөв дүгнэх, цаашлаад хууль ёсны зарчмын хамгаалалт болно.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол, УБ, 2009.
2. Т.Золбоо, Гэмт хэргийн бүтээц, УБ, 2018.
3. Т.Золбоо, Гэмт хэргийн бүрэлдүүн, УБ, 2023.

Шүүхийн шийдвэр

4. Баянхонгор аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, №13, 2019.12.05.
5. Улсын дээд шүүхийн тогтоол, №260, 2020.05.25.

Гадаад хэл дээрх

Хууль тогтоомж

1. Basic Law of the Federal Republic of Germany, (1949).

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

2. G.Binder, Criminal law: the Oxford introduction to U.S. Law, (New York-Oxford University Press, 2016).
3. J.Herring, Criminal law: text, cases, and materials, 5th ed, (United Kingdom- Oxford Press, 2012).
4. M.Bonlader, Principles of German Criminal Law, (North America-Hart publishing, 2009).
5. M.Kremnitzer and T.Hornle, “Human dignity and Principle of Culpability”, Isreal Law Review, 44, (2011).

THE IMPORTANCE OF DISTINGUISHING BETWEEN BLAMEWORTHINESS AND SUBJECTIVE ELEMENTS OF CRIME

Yanjinkham.Z

Master's student, School of Law, NUM,

Legal researcher at Judicial Training, Research, and Information Institute of Mongolia

ABSTRACT:

By virtue of its purpose, the concept of blameworthiness varies from subjective elements of crime. In this paper, from the perception of comparative study, I examined the ideological foundation of the assumption of blameworthiness in relation to the notion of human dignity and individual autonomy with reference to the criminal law theory of the Anglo-Saxon and Roman-Germanic legal systems. As long as the assumption of blameworthiness is formed as a prerequisite to criminal responsibility, there is a distinction between justificatory defenses and excusatory defenses which could ensure the application of the principle of blameworthiness and the rule of law.

KEYWORDS:

Blameworthiness, subjective elements of crime, the principle of blameworthiness, justificatory defense, excusatory defense.

ЯЛЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГЫГ ХАРГАЛЗАН ЯЛ ОНОГДУУЛАХ НЬ (ПОЛЬШ, ГЕРМАН, МОНГОЛ УЛСЫН ЖИШЭЭН ДЭЭР)



Э.Баасанбямба

*МУИС-ийн ХЗС-ийн магистрант,
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач*

ТОВЧЛОЛ:

Ял шийтгэл оногдуулахад ялын урьдчилан сэргийлэх зорилгыг харгалзан үзэх нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх, мөн гэмт этгээдийг дахин нийгэмшүүлэхэд нөлөөлөхийн зэрэгцээ нийгмийн бусад тогтворгүй хүмүүс гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэж үздэг байна. Ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго нь эх газрын эрх зүйн системд хамаарах улс орнуудын ялын онолд чухал байр суурь эзэлдэг бөгөөд уг зорилгыг эрдэмтэд нийтлэг болон тусгай гэсэн хоёр төрөлд хуваан хөгжүүлж иржээ. Ялын нийтлэг урьдчилан сэргийлэх зорилго нь эерэг болон сөрөг гэсэн хоёр хэсэгт хуваагддаг бөгөөд Герман болон Польш улсад ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг Эрүүгийн хуульдаа тусган ял оногдуулах болон богино хугацаагаар хорих ял оногдуулах, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэхэд харгалзан үзсэнээр иргэдийн хуульд итгэх итгэлийг хамгаалж чадна гэж үздэг байна.

ТҮЛХҮҮР ҮГС:

Эрүүгийн хариуцлагын зорилго, ял шийтгэлийн онол, ял оногдуулах үндэслэл, гэмт хэрэгтнийг дахин нийгэмшүүлэх, хууль тогтоомж зөрчигдөхөөс хамгаалах.

УДИРТГАЛ

Манай улсын эрүүгийн эрх зүйд ял шийтгэл нь урьдчилан сэргийлэх зорилготой байх талаар 1934 оны Шүүх цаазын бичигт анх хуульчилсан бөгөөд үүнээс хойш батлагдсан эрүүгийн хуулиудад ялын уг зорилгыг тусгасаар иржээ. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино, 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүний нийгэмшүүлэхэд

оршино гэж тус тус зааснаас үзвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь ялын зорилго төдийгүй эрүүгийн хуулийн зорилго байхаар хуульчилсан нь энэхүү сэдвийг дэлгэрүүлэн судлах шаардлагатайг харуулж байна.

Ялын урьдчилан сэргийлэх зорилгын талаар манай улсын эрдэмтэн судлаачид өөрсдийн бүтээлдээ дурдсан байдаг. Тухайлбал академич С.Нарангэрэл Монгол Улсын эрүүгийн эрх зүй бүтээлдээ, доктор Т.Золбоо Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги бүтээлийг нэрлэж болно. Энэхүү өгүүллээр ялын урьдчилан сэргийлэх зорилгыг онолын талаас нь дэлгэрэнгүй тайлбарлахын сацуу эх газрын эрх зүйн бүлд хамаарах зарим улсад тухайлбал Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болон Бүгд Найрамдах Польш улсын эрүүгийн эрх зүйд ялын урьдчилан сэргийлэх зорилгод нийцүүлэн ял шийтгэл оногдуулдаг талаар мөн манай улсын эрүүгийн хуульд ялын урьдчилан сэргийлэх зорилгыг ямар агуулгаар тусгасан талаар хөндсөн болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүнд ял шийтгэл оногдуулах нь зүй ёсны юм. Гэхдээ ийнхүү ял шийтгэл оногдуулж байгаагийн зорилго нь эцсийн дүндээ ямар үр дүнд хүрэх вэ гэдэг асуулт тулгардаг. Ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдсэний хариу арга хэмжээ юу, эсвэл ирээдүйд гэмт хэрэг үйлдэгдэхээс сэргийлэх зорилготой юу, эсхүл хариу авах болон урьдчилан сэргийлэх гэсэн хоёр зорилгыг хоёуланг нь агуулдаг уу гэсэн асуулт эрт үеэс л маргаантай байсаар ирсэн бөгөөд эдгээр асуултад ялын үнэмлэхүй онол (лат.Absolute), ялын харьцангуй онол (лат.Relative) болон ялын нэгдмэл онолын төлөөлөгчид тус тусын хариултыг өгдөг аж. Эдгээр онолыг дэлгэрүүлэн авч үзвэл:

Ялын үнэмлэхүй онол¹: Уг онолоор ял шийтгэл нь ялын тодорхой нэг зорилгод хүрэх арга хэрэгсэл бус харин үйлдсэн гэмт хэргийн хариу арга хэмжээ болох тухай номлодог. Барууны эрдэмтдийн бүтээлд уг онолыг тайлбарлахдаа ял шийтгэл нь нийгэмд нөлөө үзүүлэхээс ангид байж зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариу шийтгэл оногдуулахад үйлчилнэ гэж үздэг байна.² Хэрэв тухайн этгээд нь гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай бол энэ онолоор заавал ялтай байх ба ял нь цээрлүүлэлт, шийтгэл, өс хонзонгийн шинж чанартай байна.³ Гэмт хэрэг үйлдсэн учраас ял оногдуулна, харин гэмт хэрэгтэнд ял оногдуулах замаар бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс эмээлгэхийн тулд ял шийтгэл оногдуулдаггүй⁴ гэх үзэл баримтлал нь тухайн онолын үндсэн сургаал болно.

Ялын харьцангуй онол: Ялын харьцангуй онолоор үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон хариу арга хэмжээ авснаар нийгэмд шударга ёс тогтохгүй бөгөөд ял шийтгэл нь ирээдүйд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгод үйлчилнэ гэж үздэг.⁵ Уг онолын анхны үндсэн санааг 1764 онд Чезаре Беккариа (1738-1794) гаргасан бөгөөд тэрээр ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг иргэдэд дахин хохирол учруулахаас сэргийлэх мөн бусад хүнийг гэм хэрэг үйлдүүлэхгүй байхад оршино” хэмээн тайлбарлаж байжээ.⁶ Дээр дурдсан ялын үнэмлэхүй онолтой харьцуулахад ялын харьцангуй онол нь гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах нь үргэлж ямар нэг зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой байдаг хэмээн үздэгээрээ ялын зорилготой холбогддог байна.⁷ Мөн ял нь өнгөрсөн рүү чиглэсэн цээрлүүлэлтийн шинж чанартай байх ёсгүй бөгөөд ирээдүй рүү чиглэсэн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэхэд нөлөөлдөг гэж үздэг бөгөөд ялын зорилго нь эцсийн дүндээ ирээдүйд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх явдал юм гэж номлодог аж.

¹ Уг онолын гол төлөөлөгчид нь Иммануал Кант (1724-1804) болон Георг Вильгельм Фридрих Гегель (1770-1831) нар болно.

² Jörg Eisele, Bernd Heinrich, *Strafrecht Allgemeiner Teil*. 2nd ed. Kohlhammer Verlag, 2020, S.17.

³ Т.Золбоо, *Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги: Гэмт хэргийн бүтэц*, Соёмбо Принтинг, 2018, 20 дахь тал.

⁴ Volker Krey, Robert Esser, *Deutsches Strafrecht Allgemeiner Teil*. 7th ed. Kohlhammer Verlag, 2022, S.53.

⁵ Volker Krey, Robert Esser, *Deutsches Strafrecht Allgemeiner Teil*. 7th ed. Kohlhammer Verlag, 2022, S.53.

⁶ Czupryniak, Radoslaw, *Berücksichtigung Generalpräventiver Gründe Bei Der Strafzumessung in Deutschland Und Polen*. 1st ed. dis-serta Verlag, 2011, S.21.

⁷ Jörg Eisele, Bernd Heinrich, *Strafrecht Allgemeiner Teil*. 2nd ed. Kohlhammer Verlag, 2020, S.17.

Ялын нэгдмэл онол: Уг онолоор ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд тохирсон ял шийтгэлийг хүлээлгээд зогсохгүй ирээдүйд гэмт хэрэг гарахаас урьдчилсан сэргийлэх зорилготой хэмээн үздэг бөгөөд энэхүү онол нь ялын үнэмлэхүй болон харьцангуй онолыг нэгтгэсний дүнд бий болжээ. Уг онолын талаар Хууль зүйн ухааны доктор Т.Золбоо Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги бүтээлдээ “Дундын онол нь ял залхаан цээрлүүлэх шинж чанар бүхий албадлагын арга хэмжээ гэсэн үзлийг дэмждэггүй, харин ял нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг нийгэмшүүлэх зорилготой албадлагын арга хэмжээ гэсэн харьцангуй онолын үзэл баримтлалд давхар суурилдаг” хэмээн бичжээ. Уг онол эх газрын эрх зүйн системд хамаарах улс орнууд өргөн тархсан ялын онол болно. Тухайлбал Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад ялын нэгдмэл онолыг баримталдаг бөгөөд тус улсын Эрүүгийн хуульд⁸ ял оногдуулах үндэслэлийг тусгахдаа үнэмлэхүй онолын үзэл баримтлал болох үйлдсэн гэмт хэргийн хариу арга хэмжээ агуулгыг “хэрэгтний гэм буруу нь ял оногдуулах үндэслэл байна” гэж, харин харьцангуй онолоор номлодог гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг “гэмт хэрэгтэнд ял оногдуулахад түүний нийгмийн амьдралд үзүүлэх нөлөөг харгалзан үзнэ” хэмээн зааснаас харж болно.

Ялын нэгдмэл онолыг баримтлан ял оногдуулахад ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг харгалзан үзэх нь чухал ба ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг нийтлэг болон тусгай гэсэн хоёр бүлэгт хуваадаг байна.

o Нийтлэг урьдчилан сэргийлэх зорилго нь ял шийтгэл нийгэмд нөлөөлөх замаар ирээдүйд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлнэ гэж үздэг бол,

o Тусгай урьдчилан сэргийлэх зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулснаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлнэ гэж үздэг байна.

Ялын урьдчилан сэргийлэх зорилгыг Эрүүгийн хуульд тусгах нь

Дэлхийн улс орнуудын эрх зүйг Англи-Америкийн, Эх газрын, Мусульманы хэмээн ангилах бөгөөд эх газрын эрх зүйн эрх зүйн тогтолцоонд хамаарах Бүгд Найрамдах Польш Улс (цаашид “Польш Улс” гэх), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид “Герман Улс” гэх) болон Монгол Улсын эрүүгийн хуулиудад ялын урьдчилан сэргийлэх зорилгыг алгаатай байдлаар тусгажээ.

Ялын урьдчилан сэргийлэх зорилгыг зарим улс орнуудад ялын зорилго хэмээн үзсэн байхад зарим улс орнуудад эрүүгийн хуулийн зорилго болон ялын зорилго хэмээн үзжээ. Эх газрын системийн баруун чиглэлийн орнуудад эрүүгийн эрх зүйн зорилгыг эрүүгийн хууль тогтоомжуудад тусгадаггүй, харин уг системийн зүүний чиглэлийн орнууд болон латин америк, төв азийн зарим орны эрүүгийн хуулиудад тухайн хуулийн зорилгыг тусгасан байдаг.⁹ Герман Улсын хувьд Эрүүгийн хуульдаа эрүүгийн хуулийн зорилгыг тусгаагүй ч ялын урьдчилан сэргийлэх зорилгыг ял оногдуулах үндэслэл хэсэгт тусгахаас гадна ялын төрөл, хэмжээг сонгоход урьдчилан сэргийлэх зорилгыг харгалзан үздэг онцлогтой байна. Польш Улсын хувьд ялын нийтлэг урьдчилан сэргийлэх зорилгыг Эрүүгийн хуульдаа тусгасан байна. Харин Монгол Улсын хувьд ялын урьдчилан сэргийлэх зорилгыг Эрүүгийн хуулийн зорилго болон ялын зорилго байхаар эрүүгийн хуульдаа тусгажээ. Тодруулбал Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт¹⁰ Эрүүгийн хуулийн зорилгыг “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино”, уг хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас

⁸ Strafgesetzbuch (StGB), 1871, Цахим холбоос: <https://www.gesetze-im-internet.de/stgb/index.html> [Сүүлд хандсан: 2023.07.28].

⁹ Д.Баарсайхан, *Харьцуулсан эрүүгийн эрх зүй*, Соёмбо Принтинг, 2022, 67 дахь тал.

¹⁰ Эрүүгийн хууль, 2015. Цахим холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/11634>, [Сүүлд хандсан: 2023.07.30].

зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино” хэмээн тус тус заажээ.

Польш, Герман, Монгол улсын эрүүгийн хуульд ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг эрүүгийн хуульдаа тусгасан байгаагаас үзвэл уг зорилго эдгээр улсын эрүүгийн ялын эрх зүйд чухал байр суурь эзэлж байгааг харуулж байна. Гэхдээ дээрх улсад ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг ял оногдуулах зарчим, ял оногдуулах үндэслэлд тулгуурлан ялгаатай байдлаар эрүүгийн хуульдаа зохицуулсан байна.

Манай улсын эрүүгийн эрх зүйн судлаачид ялын зорилгыг хэрэгжүүлэхэд ял оногдуулах зарчим, ял оногдуулах үндэслэл нь чухал нөлөөтэй болох талаар нэгдмэл байр суурьтай байна. Тухайлбал Хууль зүйн ухааны доктор Д.Баярсайхан Эрүүгийн хариуцлагын, тэр тусмаа ялын зорилгыг хэрхэн хангах нь юуны өмнө ял оногдуулах үндэслэл, журмыг яаж тогтоож, хэрхэн хэрэгжүүлэхээс шууд хамаардаг бөгөөд эх газрын системийн бүх орнууд ял оногдуулах нийтлэг нөхцөл, үндэслэлийг эрүүгийн хуулиар тогтоосон байна хэмээн үзсэн бол Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган нарын хамтран гаргасан Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал бүтээлд Ял оногдуулах нийтлэг зарчим нь ялын зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл болдог байна¹¹ хэмээн тайлбарлажээ. Иймд дээрх улсуудад ял оногдуулахад баримталдаг нийтлэг зарчим болон ял оногдуулах үндэслэлийг судалсан болно.

Ял оногдуулах нийтлэг зарчим гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох нь шүүхээр нотлогдсон этгээдэд ял оногдуулахад удирдлага болговол зохих хууль ёс, шударга ёс, ял шүүгдэгч бүрд тохирсон ялгавартай байх шаардлагыг хангасан тэргүүний үзэл санааны цогц бүрдэл юм.¹² Ялын зорилгыг тэр дундаа ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг хэрэгжүүлэх хэрэгсэл болох ял оногдуулах зарчим нь олон улсын гэрээ конвенцод тусгагдахаас гадна тухайн улсын Үндсэн хууль болон Эрүүгийн хуульд тусгагдсан байдаг. Энэхүү өгүүлэлд харьцуулан судлахаар сонгон авсан улсуудын Үндсэн хууль болон Эрүүгийн хуульдаа ял оногдуулахад баримтлах зарчмуудыг дараах байдлаар тусгажээ. Польш Улсын Үндсэн хуульд ял оногдуулахад хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх зарчим¹³, эрүүдэн шүүхийг хориглох¹⁴, шүүгч хараат бус байж зөвхөн Үндсэн Хууль болон хуульд захирагдах зарчмыг¹⁵ удирдлага болгодог байна. Харин Эрүүгийн хуульд тусгасан ял оногдуулах нийтлэг зарчимд энэрэнгүй ёсны зарчмыг тэр дундаа хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх зарчим¹⁶, гэм буруугийн зарчим, ялын төрлийг сонгох болон ялын хэмжээг тогтооход хуульд заасан хүрээнд шүүх үзэмжээрээ чөлөөтэй оногдуулах зарчим, ял болон таслан сэргийлэх арга хэмжээ нь тодорхой байх зарчим, таслан сэргийлэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ ойлгомжгүй байхыг хориглох зарчмуудыг тусгасан байна.¹⁷ Мөн үүний дээр эрүүгийн ялын санкцийг зөвхөн хувь хүнд оногдуулах зарчим,¹⁸ хорих ял нь хамгийн эцсийн албадлагын арга хэмжээ болох тухай зарчмуудыг¹⁹ удирдлага болгон ял шийтгэл оногдуулдаг байна. Герман Улсын хувьд тус улсын Үндсэн Хуулийн 1 дүгээр зүйлд Хүний нэр төр, алдар хүнд халдашгүй байна. Үүнийг хүндэтгэх, хамгаалах нь улсын үүрэг мөн, 97 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана, Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэхээс өмнө тухайн хэргийг хуульд ял шийтгэл хүлээлгэхээр заасан тохиолдолд түүнд ял оногдуулна” хэмээх хууль ёсны зарчмуудыг тус тус удирдлага болгодог байна. Харин Манай улсын

¹¹ Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган нар, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал*, 2001, 123 дахь тал.

¹² С.Жанцан, *Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол, / ялын тухай сургаал*, Ангараг технологи, 2014, 232 дахь тал.

¹³ Konstytucja, Art. 30,

¹⁴ Konstytucja, Art.40

¹⁵ Konstytucja, Art. 178 Abs. 1

¹⁶ Art. 3 pol. StGB

¹⁷ Art. 53 pol. StGB

¹⁸ Art. 55 pol. StGB

¹⁹ Art. 58 § 1 pol. StGB

хувьд Үндсэн хуульд дээрх зарчмуудыг тусгаснаас гадна Эрүүгийн хуульд хууль ёсны зарчим, Шударга ёсны зарчим, гэм буруугийн зарчмуудыг тус тус хуульчилжээ.

Харин эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг Герман Улсын Эрүүгийн хуульд “Хэрэгтний гэм буруу нь ял оногдуулах үндэслэл болно. Хэрэгтэнд ял оногдуулахдаа ял нь түүний ирээдүй нийгмийн амьдралд нөлөөг харгалзан үзнэ”²⁰ хэмээн тусгасан бол манай улсын Эрүүгийн хуульд Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүнд энэ хуулийн ерөнхий ангид заасан үндэслэл, журмын дагуу тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзнэ. Эрүүгийн хариуцлага нь хүнлэг бус, хэрцгий, хүний нэр төр, алдар хүндийг гутаах шинжгүй байна хэмээн тус тус зохицуулжээ. Ийнхүү улс орнууд ял оногдуулах нийтлэг зарчим болон ял оногдуулах үндэслэлийг удирдлага болгон ял оногдуулахдаа урьдчилан сэргийлэх зорилгыг харгалзан үздэг байна.

Дээр дурдсанчлан ялын урьдчилан сэргийлэх зорилго нь нийтлэг болон тусгай гэсэн 2 бүлэг хуваагдана. Нийтлэг урьдчилан сэргийлэлт нь ял нийгэм болоод ард иргэдэд бүхэлд нь хандах байдлыг илэрхийлэх бол тусгай урьдчилан сэргийлэл нь ял зөвхөн гэмт хэрэгтэнд хандах байдлыг илэрхийлдэг.²¹ Ялын нийтлэг урьдчилан сэргийлэх зорилго нь дотроо эерэг ба сөрөг гэсэн төрөлтэй бол ялын тусгай урьдчилан сэргийлэх зорилго нь мөн эерэг болон сөрөг гэсэн төрөлтэй байна.

Ялын нийтлэг урьдчилан сэргийлэх сөрөг зорилго нь нэн тэргүүнд ял оногдуулах замаар нийгэмд нөлөөлнө хэмээн номлодог бөгөөд гэмт хэрэгтэнд ял оногдуулснаар иргэдийг айлгах зорилгыг агуулдаг хэмээн үздэг байна. Польш Улсын хувьд ял оногдуулахад уг зорилгыг харгалзан үздэггүй. Тус улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлд Хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх зарчим, Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлд ялын хэмжээ нь (санкц) нь хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчим тэр дундаа хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх зарчмыг хуульчилсан бөгөөд гэмт хэрэгтэнд ял шийтгэл оногдуулахдаа нийгмийг айдаст автуулах зорилгоор гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд хэт өндөр ял оногдуулах нь хуульд заасан дээрх зарчмуудыг зөрчихөд хүргэх аюултай хэмээн үздэг байна.²² Харин Герман Улсын хувьд ялын нийтлэг урьдчилан сэргийлэх сөрөг зорилгыг ял оногдуулахад харгалзан үзэх тухай Эрүүгийн хуульд тусгаагүй ч онолын хувьд хүлээн зөвшөөрч хууль хэрэглэн шийдвэр гаргаж буй шүүхүүд ял оногдуулахдаа уг зорилгыг харгалзан үздэг байна. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх гэх зэрэг нийгмийн аюулын зэрэг хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүх ял оногдуулахдаа ялын нийтлэг урьдчилан сэргийлэх сөрөг зорилгыг удирдлага болгон хуульд заасан ялын дээд хэмжээгээр ял оногдуулж нийгэмд айдас төрүүлснээр ийм төрлийн гэмт хэрэг гаралтыг буулгах, тогтоон барихыг зорьдог практик тус усад байдаг байна.²³

Монгол Улсын хувьд 1934 онд баталсан Шүүх цаазын бичигт анх ялын зорилгыг тусгаж ирсэн түүхтэй бөгөөд үе үеийн Эрүүгийн хуульд ял нь урьдчилан сэргийлэх зорилготой болох тухай хуульчилж ирсэн нь манай улсын эрүүгийн эрх зүйн ялын үзэл баримтлалд ялын урьдчилан сэргийлэх зорилго чухал байр суурь эзэлсээр ирснийг харуулж байна. Ялын нийтлэг урьдчилан сэргийлэх сөрөг зорилго буюу ял оногдуулах замаар бусад иргэдийг гэмт хэрэг үйлдэхээс айлгах агуулгаар 1934 оны Шүүх цаазын бичигт²⁴ ял шийтгэх

²⁰ Ж.Эрдэнэбулган нар, *Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль*, 2021, 364 дахь тал.

²¹ Т.Золбоо, *Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээн*, Соёмбо Принтинг, 2018, 21 дэх тал.

²² Czupryniak, Radoslaw, *Berücksichtigung Generalpräventiver Gründe Bei Der Strafzumessung in Deutschland Und Polen*. 1st ed. disserta Verlag, 2011, S.427.

²³ Czupryniak, Radoslaw. *Berücksichtigung Generalpräventiver Gründe Bei Der Strafzumessung in Deutschland Und Polen*. 1st ed. disserta Verlag, 2011, S.430.

²⁴ Б.Баярсайхан нар, *Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009)*, Мөнхийн үсэг, 2011, 345 дахь тал.

явдлыг хэрэглэсэн зорилго нь бусад тогтвортой хүмүүст сануулга болгохын тулд, 1942 оны Эрүүгийн хуульд²⁵ нийгмийн бусад тогтворгүй хүмүүст сануулга болгох, 1961 оны Эрүүгийн хуульд²⁶ бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, 1986 оны Эрүүгийн хуульд²⁷ бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино, 1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд²⁸ бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хэмээн заасан байна. Харин 2002 оны Эрүүгийн хуульд өмнөх хуулиудад ялын зорилго гэж нэрлэж байсныг эрүүгийн хариуцлагын зорилго хэмээн тусгаж “...гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх”, 2015 оны Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэмээн тус тус заасан байна. Дээрх хуулийн заалтуудаас дүгнэвэл 1934, 1942, 1961, 1986 болон 1993 оны хуулиудад “нийгмийн бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх” хэмээн тусгасан нь ялын нийтлэг урьдчилан сэргийлэх сөрөг зорилгыг агуулсан зохицуулалт байна. Харин 2002 оны Эрүүгийн хууль²⁹ болон одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд³⁰ “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хэмээн ерөнхий томъёоллоор тусгажээ. Нэгтгэн дүгнэвэл польш улсад ялын нийлэг урьдчилан сэргийлэх сөрөг зорилгыг ял оногдуулах зарчмыг зөрчин хэмээн үзэж ял оногдуулахад харгалзан үздэггүй бол Герман болон Монгол Улсад уг зорилгыг харгалзан үздэг гэж дүгнэж болохоор байна.

Ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилго нь нийгэмд айдас төрүүлэх замаар бус ялын үр дагаврыг сургах, ойлгох, түүний хамгааллын байдалд итгэх байдлаар илэрдэг байна.³¹ Польш Улсын Эрүүгийн хуульд ялын нийтлэг урьдчилан сэргийлэх сөрөг зорилгыг тусгаагүй ч ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг тусгасан гэж судлаачид үздэг бөгөөд ийнхүү хуульд тусгахдаа “нийгмийн хуульд итгэх итгэлийг хамгаалах” гэсэн нэр томъёог ашигласан байна.³² Уг зорилгыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд хэт хөнгөн ял оногдуулахаас сэрэмжлэх үүднээс хэрэгжүүлэх ба богино хугацаагаар хорих ял оногдуулахад, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, ялаас татгалзахад харгалзан үздэг. Тус улсад гэмт хэргийн талаар болон тодорхой нэг гэмт хэргийн шүүхийн шийдвэрийг иргэдэд нээлтэй хүргэснээр нийгэмд нөлөөлнө гэж үздэг байна. Шүүхийн шийдвэрийг нийтэд хүргэх нь нэг талаас бусад хүмүүст гэмт хэрэг үйлдсэн бол ял шийтгэл гарцаагүй байх тухай сануулга болдог, нөгөө талаар иргэдийн хуульд итгэх итгэлийг бэхжүүлдэг хэмээн үзэх бөгөөд тус улсын эрүүгийн хуульд шүүхийн шийдвэрийг нийтэд мэдээлэх талаар тусгасан байдаг. Харин Герман Улсад эрх бүхий этгээд тухайлбал хохирогч хүсэлт гаргасан тохиолдолд буруу сэжиглэх болон доромжлох гэмт хэргийг олон нийтэд мэдээлэх замаар үйлдсэн тохиолдолд шүүх шүүхийн шийдвэрийг олон нийтэд нээлтэй болгож болдог байна.

Герман Улсын хувьд нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг Эрүүгийн хуульд тусгахдаа “хууль тогтоомж зөрчигдөхөөс хамгаалах”³³ (ger. Verteidigung der Rechtsordnung) гэсэн нэр томъёог ашигласан бөгөөд энэхүү ухагдахуун нь Швед Улсын Эрүүгийн хуульд тусгасан “иргэдийн хуульд итгэх итгэхийг хамгаалах” гэсэн ухагдахуунаас үүдэлтэй гэж тайлбарладаг.³⁴ Тус улсад гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээдэд

²⁵ Мөн тэнд, 360 дахь тал.

²⁶ Мөн тэнд, 426 дахь тал.

²⁷ Мөн тэнд, 512 дахь тал.

²⁸ Мөн тэнд, 634 дэх тал.

²⁹ Эрүүгийн хууль, 2002, Цахим холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/12172>, [Сүүлд хандсан:2023.07.30].

³⁰ Эрүүгийн хууль, 2015, Цахим холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/11634>, [Сүүлд хандсан: 2023.07.30].

³¹ Т.Золбоо, Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээл, Соёмбо Принтинг, 2018, 21 дэх тал.

³² Czupryniak, Radoslaw, *Berücksichtigung Generalpräventiver Gründe Bei Der Strafzumessung in Deutschland Und Polen*. 1st ed. disserta Verlag, 2011, S.424.

³³ Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль номд *Verteidigung der Rechtsordnung* гэх үгийг хууль тогтоомж зөрчигдөхөөс хамгаалах хэмээн орчуулсантай санал нийлж байгаа бөгөөд уг орчуулгыг энэхүү судалгаанд ашигласан болно.

³⁴ Czupryniak, Radoslaw, *Berücksichtigung Generalpräventiver Gründe Bei Der Strafzumessung in Deutschland Und Polen*. 1st ed. disserta Verlag, 2011, S.424.

оногдуулах ялын хэмжээ болон ялын төрлийг сонгоход ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг харгалзан үздэг байна. Тухайлбал Герман Улсын Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Онцгой тохиолдолд буюу гэмт этгээдэд нөлөөлөх эсвэл хууль тогтоомж зөрчигдөхөөс хамгаалах зорилгоор хорих ял оногдуулах шаардлагатай бол шүүх зургаан сараас дээшгүй хугацааны хорих ял оногдуулна”³⁵ гэсэн заалт нь ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг агуулсан зохицуулалт гэж үздэг. Зарим гэмт хэрэгт торгох ялыг хэрэглэх нь мөнгөөр бүхнийг шийдэж болно гэх ойлголтыг иргэдэд өгөхөөс гадна иргэдийн хуульд итгэх итгэлийг алдахад хүргэж болзошгүй байдаг. Иймд шүүх ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг харгалзан үзэж хорихоос өөр төрлийн ялын сонгон хэрэглэх нь хангалтгүй гэж үзсэн тохиолдолд хорих ял оногдуулдаг байна. Практикт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцон зам тээврийн осол гаргаснаар хохирогчид бие махбодын хүнд гэмтэл учруулсан эсвэл хохирогч нас барсан зэрэг тохиолдолд ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг харгалзан хорих ял оногдуулах нь бий.³⁶ Ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг тус улсын Эрүүгийн хуульд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, ялаас татгалзахад мөн харгалзан үздэг байна.

Харин манай улсын Эрүүгийн хуульд ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг тусгаагүй байна.

Ялын тусгай урьдчилан сэргийлэх зорилго нь гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэг үйлдэхийг таслан зогсоох мөн тухайн гэмт хэрэгтэнд ял оногдуулах замаар нөлөөлнө хэмээн номлодог. Ял нь гэмт хэрэгтнийг дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх зорилгыг агуулна гэж үздэгээрээ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд чиглэдэг байна. Ялын урьдчилан сэргийлэх зорилгод ял шийтгүүлэгсэд зан суртахууны шаналал, гачигдал учруулах тодорхой хязгаарлалтыг хэрэгжүүлэх замаар хүрнэ³⁷ гэж үздэг. Уг онолын гол төлөөлөгч Франц Риттер фон Лист (1851-1919) бөгөөд тэрээр “Эрүүгийн ял шийтгэл дэх зорилгын үзэл баримтлал” хэмээх бүтээлдээ ялын тусгай урьдчилан сэргийлэх зорилгыг

1. Засан хүмүүжүүлэгдэх боломжгүй гэмт хэрэгтэнд ял оногдуулах замаар айлган сүрдүүлэх,

2. Засан хүмүүжих чадвар бүхий гэмт хэрэгтнийг хүмүүжүүлэх,

3. Засан хүмүүжүүлэгдэх боломжгүй гэмт хэрэгтнийг хорих хэмээн 3 ангилжээ.³⁸

Түүний үзсэнээр ялын тусгай урьдчилан сэргийлэх зорилго нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх зорилгын гол цөм нь байна хэмээн үзсэн байдаг. Ялын тусгай урьдчилан сэргийлэх зорилго нь цэвэр ялын онол биш харин ялын зорилгын сургаал хэмээн үздэг бөгөөд ялангуяа албадлагын арга хэмжээ авахад уг зорилго үйлчилнэ гэж үздэг. Учир нь албадлагын арга хэмжээ нь эцсийн дүндээ гэмт хэрэгтэн ирээдүйд дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байхад оршино гэжээ.³⁹

Польш Улсын хувьд ял оногдуулахад ялын урьдчилан сэргийлэх болон хүмүүжүүлэх зорилгыг харгалзан үзнэ хэмээн уг зорилгыг хуульчилсан гэж үздэг байна.⁴⁰ Харин Герман Улсын хувьд Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлд заасан ял оногдуулах үндэслэлд “Хэрэгтний гэм буруу нь ял оногдуулах үндэслэл болно. Хэрэгтэнд ял оногдуулахдаа ял нь түүний ирээдүйн нийгмийн амьдралын нөлөөг харгалзан үзнэ” гэж заасан нь ялын тусгай урьдчилан сэргийлэх зорилгыг харгалзан үзэж ял шийтгэл оногдуулдгийг харуулж байна.

³⁵ Ж.Эрдэнэбулган нар, *Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль*, 2021, 364 дахь тал.

³⁶ Czupryniak, Radoslaw, Berücksichtigung Generalpräventiver Gründe Bei Der Strafzumessung in Deutschland Und Polen. 1st ed. disserta Verlag, 2011, S.424.

³⁷ С.Нарангэрэл, *Монгол Улсын эрүүгийн эрх зүй, Ерөнхий анги*, Уриа, 1999, 271 дахь тал.

³⁸ Volker Krey, Robert Esser, *Deutsches Strafrecht Allgemeiner Teil*. 7th ed. Kohlhammer Verlag, 2022, S.53.

³⁹ Volker Krey, Robert Esser, *Deutsches Strafrecht Allgemeiner Teil*. 7th ed. Kohlhammer Verlag, 2022, S.53.

⁴⁰ Malolepszy, Maciej, *Geldstrafe Und Bedingte Freiheitsstrafe Nach Deutschem Und Polnischem Recht*, 2007, S.321.

Монгол Улсын хувьд Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино хэмээн тусгаснаас харвал ялын тусгай урьдчилан сэргийлэх зорилгыг хуульд тусгасан байна хэмээн дүгнэж болохоор байна. Уг зорилгыг өмнө нь үйлчилж байсан эрүүгийн хуулиуд ч мөн тусгаж иржээ. Тухайлбал 1934 оны Шүүх цаазын бичигт⁴¹ ял шийтгэх явдлыг хэрэглэсэн зорилго нь гэмт хэрэг үйлдэгсдийг дахиж шинээр гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхийн тулд, 1942 оны Эрүүгийн хуульд⁴² ял шийтгэх зорилго нь гэмт хэрэг үйлдэгчийг дахин шинэ гэмт хэрэг үйлдэхээс өдүүлэхээс цээрлүүлэх, 1961 оны Эрүүгийн хуульд⁴³ шийтгэгчдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, 1986 оны Эрүүгийн хуульд⁴⁴ ялтныг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино, 1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд⁴⁵ ялтныг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хэмээн заасан байна. Харин 2002 оны Эрүүгийн хуульд өмнөх хуулиудад ялын зорилго гэж нэрлэж байснаа болиод эрүүгийн хариуцлагын зорилго нь ... гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, 2015 оны Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэмээн тус тус заасан байна. Дээрх хуулийн заалтуудаас дүгнэвэл 1934, 1942, 1961, 1986 болон 1993 оны хуулиудад ялын тусгай урьдчилан сэргийлэх зорилгыг тусгасан бөгөөд 2002 болон 2015 оны Эрүүгийн хуулиудад “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хэмээн ерөнхий томъёолсон байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Эх газрын эрх зүйн системд хамаарах ихэнх улс орнуудад ял шийтгэл нь үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон хариу арга хэмжээ байгаад зогсохгүй ирээдүйд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилготой байна хэмээн номлодог ялын нэгдмэл онолыг баримталдаг байна. Ялын нэгдмэл онол нь ялын урьдчилан сэргийлэх зорилгод тулгуурладаг бөгөөд ялын урьдчилан сэргийлэх зорилго нь гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг хааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгод хүрэх тухай номлодог ялын тусгай урьдчилан сэргийлэх онол, ялын бодлогоор нийгэмд нөлөөлснөөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай номлодог ялын нийтлэг урьдчилан сэргийлэх онол гэсэн 2 хэсэгт хуваагдана. Ялын нийтлэг урьдчилан сэргийлэх зорилго нь нийгмийг ялаар айлгах сөрөг зорилго болон нийгэм, ард иргэдийн хуульд итгэх итгэлийг хамгаалах эерэг зорилго гэсэн хэсгүүдтэй байна.

Ялын нэгдмэл онолыг баримталдаг улс орнуудад тухайлбал Польш, Герман, Монгол улсад ялын урьдчилан сэргийлэх зорилгыг Эрүүгийн хуульдаа хэрхэн тусгаж, хэрэгжүүлдэг талаар судлан үзвэл ялгаатай байдлаар тусгажээ. Тухайлбал ял шийтгэлээр айлгах замаар ирээдүйд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ялын зорилгыг илэрхийлдэг нийтлэг урьдчилан сэргийлэх сөрөг зорилгыг Герман улсад нийгмийн аюул их гэмт хэрэгт ял оногдуулахдаа харгалзан үзэж хуульд заасан ялын хэмжээний хамгийн дээд хэмжээгээр ял оногдуулах хандлагатай байдаг бол Польш Улсад ялын уг зорилго нь Үндсэн хууль болон Эрүүгийн хуульд заасан нийтлэг зарчимтай зөрчилдөн хэмээн үзэж ял оногдуулахад ялын нийтлэг урьдчилан сэргийлэх сөрөг зорилгыг харгалзан үздэггүй онцлогтой байна. Манай улсын хувьд 1934 оны Шүүх цаазын бичгээс эхлээд үе үеийн Эрүүгийн хуулиудад ялын уг зорилгыг тусгасаар ирсэн ч ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг тусгаагүй

⁴¹ Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), 345 дахь тал.

⁴² Б.Баярсайхан нар, *Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал* (1911-2009), Мөнхийн үсэг, 2011, 360 дахь тал.

⁴³ Мөн тэнд, 426 дахь тал.

⁴⁴ Мөн тэнд, 512 дахь тал.

⁴⁵ Мөн тэнд, 634 дэх тал.

байна. Харин Герман болон Польш улс нь Эрүүгийн хуульдаа ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг “хууль тогтоомж зөрчигдөхөөс хамгаалах” гэх нэр томъёогоор тусгасан бөгөөд уг зорилгыг ял оногдуулахад, ялын хэмжээ болон ялын төрлийг сонгоход, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэхэд харгалзан үздэг байна. Харин ялын тусгай урьдчилан сэргийлэх зорилгыг Герман, Польш, Монгол улс нь Эрүүгийн хуульдаа тусгасан байх бөгөөд ялын тусгай зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх зорилготой уялддагаараа онцлог аж.

Иймд ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг харгалзан үзэж ял оногдуулахыг эрүүгийн хариуцлага оногдуулах үндэслэл, журамд хуульчилж өгснөөр ялын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгод хүрэх нэг алхам болно гэж үзэж байна. Мөн үүний дээр Польш болон Герман улсын эрүүгийн хуульд “иргэдийн хуульд итгэх итгэлийг хамгаалах” гэсэн ухагдахууны дор ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг ял оногдуулахад, ялын төрлийг сонгоход, ялын хэмжээг тогтооход харгалзан үздэг бөгөөд энэхүү зорилгыг хэрэгжүүлснээр иргэдийн шүүхэд итгэх итгэлийг бэхжүүлнэ гэж үздэг. Харин манай улсад ялын нийтлэг урьдчилан сэргийлэх эерэг зорилгыг тусгаагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Шүүх цаазын бичиг, 1932.
2. БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1942.
3. БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1961.
4. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн хууль, 1986.
5. Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, 1993.
6. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002.
7. Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, 2015.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

8. С.Нарангэрэл, Монгол Улсын эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги, Уриа компани, 1999.
9. Д.Баярсайхан, Харьцуулсан Эрүүгийн эрх зүй, Соёмбо Принтинг, 2022.
10. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол: Ялын тухай сургаал,
11. Т.Золбоо, Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээц, Соёмбо Принтинг, 2018.
12. Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн, Ж.Энхнасан, Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), Мөнхийн үсэг, 2011.
13. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир, Б.Батбаяр, Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль, Соёмбо Принтинг, 2011.

Гадаад хэл дээрх

Хууль тогтоомж

1. Grundgesetz für die Bundesrepublik Deutschland (GG), 1949.
2. Konstytucja Rzeczypospolitej Polskiej, 1997.
3. Strafgesetzbuch (StGB), 1871.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

4. Volker Krey, Robert Esser, Deutsches Strafrecht Allgemeiner Teil. 7th ed. Kohlhammer Verlag, 2022.
5. Jörg Eisele, Bernd Heinrich, Strafrecht Allgemeiner Teil. 2nd ed. Kohlhammer Verlag, 2020.
6. Czupryniak, Radoslaw, Berücksichtigung Generalpräventiver Gründe Bei Der Strafzumessung in Deutschland Und Polen. 1st ed. disserta Verlag, 2011.
7. Malolepszy, Maciej, Geldstrafe Und Bedingte Freiheitsstrafe Nach Deutschem Und Polnischem Recht, 2007.
8. Czupryniak, Radoslaw “Berücksichtigung Generalpräventiver Gründe Bei Der Strafzumessung in Deutschland Und Polen” Phd.Diss. der Juristischen Fakultät der Freien Universität Berlin, 2011.

CONSIDERATION OF PREVENTIVE FUNCTIONS IN SENTENCING***Baasanbyamba.E****Master's student, School of Law, NUM,**Legal researcher at Judicial Training, Research, and Information Institute of Mongolia***ABSTRACT:**

The preventive nature of criminal responsibility takes an important position in the criminal theory of countries with continental legal systems. It aims to rehabilitate offenders, prevent recidivism and warn other people not to commit crimes. In addition, it is divided into general crime prevention, which is also subdivided into the positive and negative manner that it has shown through, and specific crime prevention. The positive general crime prevention has been adopted by punishment imposition, short-term imprisonment, and discharging from punishment in countries like Germany and Poland.

KEYWORDS:

Purpose of the criminal responsibility, penal theories, fixing of penalties, adjust a person committed a crime to a social life, the defence of the legal order.

МӨНГӨ ЗЭЭЛЖ, ХҮҮНД НЬ ОРОН СУУЦ ХӨЛСЛҮҮЛЭХ АГУУЛГА БҮХИЙ ГЭРЭЭНИЙ ХАРИЛЦААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ



Б.Батбаяр

МУИС-ийн ХЗС-ийн магистрант

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач

ТОВЧЛОЛ:

Энэ өгүүлэлд эн тэргүүнд “Мөнгө зээлж, хүүнд нь орон сууц хөлслүүлэх агуулга бүхий гэрээний харилцаа” манай улсад нэвтэрснээр, эрх зүйн тогтолцоо болон нийгмийн амьдралд үзүүлж буй нөлөөлөл, уг шинэ харилцаанаас үүдэлтэй бий болсон тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлохын сацуу эдгээрийг шийдвэрлэх арга замыг эрэлхийллээ. Түүнчлэн тус гэрээний түүхэн үүсэл, хөгжил, үүссэн улс орондоо хуульчлагдсан хандлага болон хууль тогтоомжийн хэрэглээний төлөв байдлыг Монгол улсын шүүхийн практиктай харьцуулан судалж, манай улсын Иргэний хуулийн холбогдох зохицуулалтад үнэлэлт өгөх, боловсронгуй болгох талаар санал, дүгнэлтээ танилцуулсан болно.

ТҮЛХҮҮР ҮГС:

Эд юмсын эрх, Үүргийн харьцангуй эрх, Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэл, Шүүхийн практик, Хууль тогтоомж.

УДИРТГАЛ

Монгол Улс шинэ ардчилсан үндсэн хуулиа баталснаар, манай улсын иргэд гадаад улс оронд нээлттэй зорчих, ажиллаж, амьдрах боломж бүрдэж, шилжилтийн үеийн эдийн засгийн хямралыг гэтлэх зорилготой иргэдийн урсгал хөгжингүй орнууд руу чиглэх болсон. Эдгээрээс Бүгд Найрамдах Солонгос Улсад (цаашид “Солонгос улс” гэх) суурьшсан иргэдийн тоо хамгийн олон байна.¹ Аливаа улсад суурьшин амьдарч буй хүмүүс “усыг нь уувал ёсыг нь дагаж” аж төрдөг учир нийгэм, соёл, эдийн засгийн шинжтэй уламжлагдан ирсэн буюу тухайн улс, үндэстний онцлог төрхийг шингээсэн үнэт зүйлс, харилцаанд суралцаж, тэдгээрийг амьдрал ахуйдаа хэрэглэх замаар хөгжүүлж, түгээн дэлгэрүүлж байдаг. Энэ жишгээр манай улсын иргэд Солонгос улсад удаан хугацаагаар суурьшин амьдарч байгаад эх орондоо эргэн ирж нийгмийн амьдралд нэвтрүүлсэн зүйлс нь цахилгаан бараа, хүнсний бүтээгдэхүүнээр хязгаарлагддаггүй билээ.

¹ 2016 оны байдлаар гаргасан Гадаад харилцаа яамнаас өгсөн мэдээлэл <https://ikon.mn/n/u9h> [Сүүлд үзсэн: 2023.07.01].

Хүний анхдагч хэрэгцээний тэргүүн эгнээнд бичигдэх зүйл бол яах аргагүй орон сууц гэдэгтэй хэн ч маргахгүй биз. Гэтэл орон сууцны хүрэлцээгүй байдал түүнийг дагасан өндөр үнэ нь хөгжиж байгаа төдийгүй хөгжингүй орнуудын иргэдийн толгойны өвчин болж байна. Үүнийг зохистойгоор шийдвэрлэхийг эрмэлзсэн олон оролдлогуудын нэг нь солонгосчуудын хөгжүүлсэн уламжлалт орон сууц хөлслөх гэрээний харилцаа бөгөөд энэ нь өмчлөлийн орон сууцгүй олон сая хүмүүсийг амьдрах орон байраар хангаад зогсохгүй, зах зээлд түгжигдсэн их хэмжээний мөнгөний урсгалыг эргэлтэд оруулах эдийн засгийн эерэг үр дагаврыг авчирсан байдаг.

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд “мөнгө зээлж хүүнд нь орон сууцанд суулгана” гэх зар ихэд гарах болсон бөгөөд энэ нь Солонгос улсаас гаралтай уламжлалт эд хөрөнгө хөлслөх гэрээний харилцаа болохыг 1 дүгээр бүлэгт өгүүлэх судалгааны үр дүнгээс төвөггүй мэдэж болно. Харин уг харилцаа нь манай улсад ямар нэгэн зохицуулалтгүйгээр иргэдийн дунд “хориглосноос бусдыг зөвшөөрөх” (Laissez-faire) зарчмын дагуу түгэн дэлгэрч, хэрэгжиж эхэлсэн ч хүн амын эрх зүйн мэдлэг дутмаг байдал, тус харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтын хийдлээс үүдэлтэйгээр иргэд цаг хугацаа, эд хөрөнгө, сэтгэл санаагаар хохирч, цаашлаад гэмт хэргийн хохирогч болж буй нь энэ төрлийн харилцаанд тулгамдаж буй гол асуудал болоод байна. Иймд энэхүү өгүүлэлд уг харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох саналыг харьцуулсан судалгааны үр дүнд түшиглэн дэвшүүлэхийг зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

I. Мөнгө зээлж, хүүнд нь орон сууц хөлслүүлэх агуулга бүхий гэрээний үүсэл, хөгжил
Жосеон улс буюу өнөөгийн Солонгос улсад 19 дүгээр зууны сүүл үеэс Сөүл хотын нутаг дэвсгэрт орон нутгаас ажил хайж шилжин ирэгсдийн урсгалаас үүдэлтэй орон сууцны хомсдол үүсэж эхэлжээ.² Эдгээр фермер, тариачдад орон сууц худалдаж авах юм уу сар бүр хөлс төлж амьдрах боломж тун хомс байж. Иймээс тухайн цаг үед Хятад улсад түгээмэл хэрэглэгддэг байсан байшин барьцаалж, зээл авах харилцааг төсөөтэй хэрэглэж, сар бүр тогтмол хөлс төлөхийг шаардахгүйгээр нэг дор их хэмжээний мөнгө авч оронд нь тохирсон хугацаандаа зээлдүүлэгчийн орон сууцанд амьдрах эрх олж авах агуулга бүхий хэлцлийг (Chonse) нийгмийн амьдралд нэвтрүүлсэн байна.

Тус хэлцэл нь анх хэрэглээнд нэвтэрсэн цагаасаа нэг талаас тогтмол хөлс төлөхгүйгээр орон сууцанд амьдрах боломжийг олгож байсан бол нөгөөтээгүүр зээлийн эргэн төлөлтийг баталгаажуулах санхүүгийн хэрэгсэл болдог хосолмол шинжтэй байжээ.³

Япон улс 1910 онд Солонгосын хойгийг эзэлж, тэдний амьдрал ахуй, зан заншлын талаар өргөн хэмжээний судалгаа хийсэн бөгөөд үр дүн нь 1913 онд нийтлэгдэхэд уг хэлцэл нь тухайн үеийн нийгмийн амьдралд өргөн тархсан байсан тухай тэмдэглэн үлдээжээ.⁴ Тухайлбал хөлслөгч нь орон сууцны үнийн дүнгийн 70-80 хувийг орон сууц хөлслөх гэрээ байгуулах үед хөлслүүлэгчид барьцаа эсхүл зээл маягаар шилжүүлдэг байсан байна (Одоо энэ дүн үл хөдлөх эд хөрөнгийн 40-60⁵ хувьтай тэнцэх хэмжээнд хүрч буурсан). Гэрээ байгуулагдахад шилжүүлдэг мөнгөн дүн ийм өндөр байгаа шалтгаан нь зээлийг хугацаандаа төлөхгүй бол хөлслөгч буюу зээлдүүлэгчид орон сууцыг захиран зарцуулах эрх үүсдэг байсантай холбоотой юм. Тухайн үеийн орон сууцыг дээрх байдлаар хөлслөх хугацаа ихэвчлэн нэг жил байсан бөгөөд хэрэв гэрээнд хөлслөх хугацааг тодорхой зааж өгөөгүй бол 100 хоног гэж үзэх нь түгээмэл байжээ.⁶ Японы дарангуйллын үед хэрэгжиж

² Youngjoon Kwon, Yong-Shik Lee, “Legal Analysis of Traditional Leasehold in Korea from a Comparative Legal Perspective”, *Arizona Journal of International & Comparative Law* Vol.29, no.2 (2012) p.262.

³ *Id.*, p.265.

⁴ *Id.*

⁵ Jewan Kim. 2022. Chonse, a real property lease transaction unique to South Korea. *Pravovedenie* 66 (3), pp.267-289. <https://doi.org/10.21638/spbu25.2022.303> [Сүүлд үзсэн: 2023.07.01]

⁶ *Id.*

байсан зохицуулалтын дагуу тус хэлцлийг орон сууц хөлслөх гэрээний төрөлд хамааруулдаг байсан бөгөөд энэ нь хөлслөгчийг өөр гуравдагч этгээдийн эсрэг шаардлага гаргах эрхгүй (гэрээний харьцангуй зарчмын дагуу) болгодог сул талтай байсан.

Дэлхийн II дайн дууссаны дараа Солонгосчууд Японы ноёрхлоос гарч эрх зүйн тогтолцоогоо өөрсдөө цогцлоох боломж бүрдсэн. Гэвч Солонгосын хойгийн дайны улмаас Иргэний хуулийн төсөл нь хойшилсоор 1958 онд анх батлагдаж, 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн байдаг⁷. Хэд хэдэн нэмэлт, өөрчлөлтийг эс тооцвол 1958 оны Иргэний хуулийн үндсэн бүтэц нь одоо ч хэвээрээ байгаа гэж судлаачид үздэг байна. Тус хуульд уг хэлцлийг эд юмсын эрхийн ангилалд оруулж баталснаар хөлслөгч нь гуравдагч этгээдийн эсрэг шаардлага гаргах боломжтой болсон юм.⁸ Ийнхүү мөнгө зээлж хүүнд нь орон сууц хөлслүүлэх хэлцэл нь Солонгосын Иргэний хуулийн тусгай ангид эд юмсын эрхэд хамаарах гэрээний төрөл болж хуульчлагдсанаар үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд заавал бүртгүүлэх хэлбэрийн шаардлага тавигдах болжээ. Гэвч хэлбэрийн шаардлага хангаагүй тохиолдолд иргэдийн эрх хамгаалагдахгүй байх сөрөг үр дагавар ихсэх болсон тул оршин суугчийн бүртгэлээр дамжуулан уг асуудлыг шийдэхийг оролдсон байна.

I. Мөнгө зээлж хүүнд нь орон сууц хөлслүүлэх агуулга бүхий гэрээний хуульчлагдсан байдал

Өдгөө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Солонгосын Иргэний хуулийн⁹ “Эд юмсын эрх” буюу 2 дахь хэсгийн “Өмчлөх эрх” гэх 3 дахь бүлгийн 6 дугаар дэд бүлэгт “Барьцаа мөнгөнд үндэслэн орон сууц хөлслөх эрхийг эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж олж авах эрх” (Chonsegwon) гэсэн нэршлээр хуульчилжээ. Тус дэд бүлэг нь 303-319 дүгээр зүйл хүртэл нийт 18 зүйлээс бүрдэх бөгөөд дараах асуудлуудыг зохицуулжээ. Үүнд:

- Эд юмсын эрхийг олгож буй тус хэлцлийн агуулга;
- Өмнө нь орон сууц, түүний газарт үүссэн узуфрукт, санхүүгийн түрээсийн гэрээнд тус хэлцлийн үзүүлэх нөлөөлөл;
- Хэлцлийн зүйл болох орон сууц болон хуулиар үүссэн узуфруктэд үзүүлэх нөлөөлөл;
- Тус хэлцлээр олж авсан шаардах эрхийг шилжүүлэх, хөрөнгийг дамжуулан хөлслөх;
- Шилжүүлэн авсан шаардах эрхийн хууль зүйн хүчин чадал;
- Шаардах эрх шилжүүлэн авсан этгээдийн хариуцлага;
- Хэлцлээр эрх олж авсан этгээдийн ердийн засвар, үйлчилгээг хариуцах үүрэг;
- Хэлцлээр эрх олж авсан этгээдийн нөхөн төлбөр гаргуулах тухай шаардлага;
- Хэлцлийг дуусгавар болгох тухай мэдэгдэл;
- Хэлцлийн үргэлжлэх хугацаа;
- Барьцааны мөнгийг нэмэгдүүлэх, буруулах тухай шаардах эрх;
- Хэлцэл дуусгавар болсныг мэдэгдээгүйн үр дагавар;
- Давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан хохирол;
- Хэлцлийн дагуу эрх эзэмшигч нь хэлцэл дуусгавар болох үед гэрээний зүйлийг анх хүлээж авсан нөхцөлөөр хүлээлгэн өгөх үүрэг болон барилгад суурилуулсан эд зүйлсээ салган авах эрх;
- Хэлцэл дуусгавар болох үед талууд харилцан хүлээх үүрэг;
- Хэлцлээр эрх олгогч барьцааны мөнгийг буцааж өгөөгүй бол барилгыг дуудлага худалдаанд оруулах зохицуулалт;
- Хэлцэлтэй холбоотой харилцааг зохицуулахад эш татан хэрэглэх бусад хэм

⁷ Korea Legislation Research Institute, Introduction to Korean Law (Heidelberg, Germany: Springer-Verlag Berlin Heidelberg, 2013), p.114.

⁸ Id, p.268.

⁹ БНСУ-ын Иргэний хууль (1958) [Statutes of the Republic of Korea \(klri.re.kr\)](http://Statutes.of.the.Republic.of.Korea(klri.re.kr)) [Сүүлд үзсэн: 2023.07.01].

хэмжээ зэрэг болно.

Хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж чадаагүй хүмүүсийн хувьд гуравдагч этгээдийн өмнө хуулиар хамгаалагдах боломжгүй болсонтой холбоотойгоор “Барилга, орон сууц хөлслөгчийн эрхийг хамгаалах тухай хууль”-ийг 1981 онд анх баталсан байдаг¹⁰. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Орон сууц хөлслөх гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй хөлслөгч орон сууцыг эзэмшилдээ авч, оршин суугчаар бүртгүүлсэн бол тухайн мөчөөс гуравдагч этгээдийн эсрэг шаардлага гаргах эрхтэй болно. Оршин суугчийн бүртгэл нүүж ирсэн тэмдэглэлд заасан цагт хийгдсэнд тооцогдоно” хэмээн тодорхой хуульчилжээ. Харин барьцааны мөнгөө авч чадаагүй бол үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлсэн хөлслөгчийн нэгэн адил эрхийг эдлэхийн тулд барьцаа мөнгө шилжүүлсэн өдрөө орон сууц хөлслөх гэрээнд эрх үүссэн хугацааг нотлох тэмдэг даруулах ёстой.¹¹ Уг тэмдгийг нотариат юм уу тухайн бүс нутгийн оршин суугчдын бүртгэлийг хариуцдаг нэгжээс дарж өгдөг байна. Энэ тэмдгийг даруулсан бол дээрх хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Доорх хүснэгтээр Иргэний хууль болон Орон сууц хөлслөгчийн эрхийг хамгаалах тухай хуулиар мөнгө зээлж, хүүнд нь орон сууц хөлслөх эрхийг олж авах агуулга бүхий гэрээг байгуулах болон хөлслөгч эрхээ хамгаалах үйл явцыг харуулав.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл бүхий хэлцэл	Оршин суугчийн бүртгэл бүхий хэлцэл
Хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах үйл явц	
<ul style="list-style-type: none"> Барьцаа мөнгөнд үндэслэн орон сууц хөлслөх гэрээ (Chonsegwon) байгуулна. Харьяалах нутаг дэвсгэрийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт гэрээний талууд хамтдаа хүсэлт гаргаж, бүртгүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> Барьцаа мөнгөнд үндэслэн орон сууц хөлслөх гэрээ (Chonsegwon) байгуулна. Харьяалах нутаг дэвсгэрийн оршин суугчдын бүртгэл хариуцсан нэгжид хөлслөгч нь хүсэлт гаргаж, гэрээнд тэмдэг даруулж, баталгаажуулна.
Хөлслүүлэгч үүргээ биелүүлээгүй бол хохирол барагдуулах арга зам	
<ul style="list-style-type: none"> Иргэний хуулийн 318 дугаар зүйлд заасны дагуу гэрээний зүйлийг дуудлага худалдаанд оруулж, үүрэг гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг шүүхэд хандан гаргана. 	<ul style="list-style-type: none"> Барилга, орон сууц хөлслөгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3-2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэрээний зүйлийг дуудлага худалдаанд оруулж, үүрэг гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг шүүхэд хандан гаргана.

II. Монголын нийгмийн амьдрал, эрх зүйн орчинд тус гэрээний улмаас тулгамдаж буй асуудал, шүүхийн практик

Өдгөө манай нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр “мөнгө зээлж хүүнд нь орон сууцанд суулгана” гэх зар маш их гарах болсон. Тухайлбал “фэйсбүүк” аппликэйшнд ийм нэртэй 3.7 мянган гишүүнтэй бүлэг байх бөгөөд энэ сэдэвтэй хамааралтай зар өдөрт 3-10 удаа ордог. Мөн цахим зарын вебсайтууд болох www.unegui.mn, www.zarsonin.mn, www.mu-zag.mn зэрэгт сүүлийн 2023 оны 04-07 сарын хооронд давхацсан байдлаар 200 гаруй зар оржээ. Үүнээс харвал энэ төрлийн харилцаа нь орон сууц хөлслөх гэрээний харилцаанд гүнзгий нэвтэрч, нийгмийн амьдралд сайтар бэхэжсэн болох нь харагдаж байна. Харин шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоог гаргахаар 2016 оноос эхлэн шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn) болон www.legaldata.mn цахим платформоос шүүж үзэхэд харьцангуй бага илэрцтэй байх боловч олдсон шүүхийн шийдвэрүүд нь энэ төрлийн харилцааны өөр өөр онцлог бүхий эрх зүйн үр дагавруудыг нөхцөлдүүлж буй

¹⁰ БНСУ-ын Барилга, орон сууц хөлслөгчийн эрхийг хамгаалах тухай хууль (1981) [Statutes of the Republic of Korea \(klri.re.kr\)](http://Statutes of the Republic of Korea (klri.re.kr)) [Сүүлд үзсэн: 2023.07.01].

¹¹ Jewan Kim, *Supra* note 5, p.282.

шалтгаан, нөхцөлийг тодорхойлоход агуулга, чанарын хувьд хангалттай гэж үзлээ.

Хэрэг 1

Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Р-ийн эсрэг З-ийн хэргийг¹² шийдсэн.

Иргэн З нь зар мэдээ сонин дээрх “мөнгө зээлж хүүнд нь байранд суулгана” гэх зарын дагуу Р-тэй холбогдож түүнд 15 сая төгрөгийг 1 жилийн хугацаатай зээлдүүлэх агуулга бүхий зээлийн гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлсэн. Харин зээлийн хүүнд Р-ийн өмчлөлийн 2 өрөө орон сууцанд хөлс төлөхгүй мөн хугацаагаар амьдрах тухай амаар тохиролцжээ. Гэрээний хугацаа дуусах үед талууд тохиролцож дахин 5 сая төгрөгийг зээлдүүлж гэрээний хугацааг 6 сараар сунгасан байна. Мөн хугацаа өнгөрөхөд Р нь зээлсэн мөнгөө өгөөгүй бөгөөд мөнгийг өгөх хүртэл орон сууцанд сууж байхыг А-аас хүссэн. Энэ маягаар дахин 1 жил өнгөрсөн ч Р мөнгийг нь өгөөгүй тул З зээлдүүлсэн мөнгө болох нийт 20 сая төгрөгийг 1 жилийн алданги 10 сая төгрөгийн хамт Р-ээс нэхэмжилсэн. Р хариуд нь зээлийн гэрээ, орон сууц хөлслөх гэрээ тусдаа байгуулагдсан бөгөөд нотариатаар батлуулсан зээлийн гэрээнд орон сууцанд хөлсгүй суулгах тухай заалт байхгүй болохыг дурдаж, орон сууцны хөлсөө өдийг болтол төлөөгүй тул нийт хөлсөнд 45,400,000 төгрөг гаргуулах сөрөг нэхэмжлэл гаргасан.

Шүүхээс талуудын хооронд Иргэний хуулийн 281.1, 287.1-д заасан гэрээ үндсэн үүргийн хувьд тус тус байгуулагдсан болохыг тогтоож, З-ийн нэхэмжилсэн 30 сая төгрөгийн нэхэмжлэлийг хангаж, Р-ийн сөрөг нэхэмжлэлийг өөрөө хугацаандаа үүргээ биелүүлээгүй бөгөөд талуудын тохиролцоонд хөлс тохирч тусдаа байгуулсан орон сууц хөлслөх гэрээ байгаагүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийджээ.

Хэрэг 2

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Ч-ийн эсрэг А-ийн хэргийг¹³ шийдсэн.

Иргэн А нь өөрийн өмчлөлийн орон сууцнаас Ч-г албадан чөлөөлүүлэх тухай болон хохирол төлүүлэх тухай нэхэмжлэл гаргасан. Ч нь тухайн үед тус орон сууцыг эзэмшиж байсан гэх Э-д 15 сая төгрөг зээлдүүлж, хүүнд нь 1 жилийн хугацаатайгаар амьдрахаар тохиролцсон. Гэвч 4 сарын хугацаа өнгөрөхөд орон сууцны өмчлөгч А нь Э-д өөрийнх нь өмчлөлийн орон сууцыг хөлслүүлэх эрх байхгүй тул Ч-ээс 4 сар амьдарсны хөлс болон түүнийг байрнаас албадан чөлөөлүүлэх шаардлага гаргажээ. Гэвч Ч нь уг байрыг хууль ёсоор эзэмшиж буй тул Э-тэй тохиролцсон хугацаанд байрыг хүлээлгэн өгөхгүй бөгөөд А-тай орон сууц хөлслөх гэрээ байгуулаагүй тул хөлс төлөхгүй гэж маргасан.

Шүүхээс хэрэгт цугласан нотлох баримтыг шалгахад Э-д эд хөрөнгийг бусдад хөлслүүлэх эрх олгосон ямар нэгэн баримт байхгүй байсан тул орон сууцыг албадан чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдсэн. Харин хохиролд шаардсан 4 сарын байрны хөлсийг орон сууц хөлслөх гэрээ байгуулагдсан болох нь нотлогдохгүй байна гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ. Э-д холбогдуулан Ч нь цагдаад гомдол гаргасан бөгөөд тус хэргийг шийдвэрлэгдэж байх явцад эрүүгийн хэрэг үүссэн байна.

Хэрэг 3

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс 2017 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр Ө-д холбогдох хэргийг¹⁴ шийдсэн.

¹² Р-ийн эсрэг З-ийн хэрэг (2022.12.23)

https://shuukh.mn/single_case/125613?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
[Сүүлд үзсэн: 2023.07.01].

¹³ Ч-ийн эсрэг А-ийн хэрэг (2018.04.16)

https://shuukh.mn/single_case/77305?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1
[Сүүлд үзсэн: 2023.07.01].

¹⁴ Ө-д холбогдох хэрэг (2017.09.19)

https://shuukh.mn/single_case/4066?start_date=&end_date=&id=2&court_cat=2&bb=1
[Сүүлд үзсэн: 2023.07.01].

Ө нь иргэн У-тай орон сууц хөлслөх гэрээ байгуулж, орон сууцыг эзэмшилдээ авсны дараа гэрээний хавсралт болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг дуурайлган хуурамчаар үйлдэж, өөрийн нэрийг тусгасан байна. Улмаар иргэн Д-д орон сууцыг өөрийнх нь гэж итгүүлэн 12 сая төгрөгийг 1 жилийн хугацаатайгаар зээлж, хүүнд нь Д-г суулгахаар тохиролцжээ. Улмаар Ө өөр хэд хэдэн газар орон сууц хөлслөөд ижил аргаар хүмүүсийг хохироосон байна.

Тулгамдаж буй асуудал ба энэ хүрээнд үүссэн нөхцөл байдал

Гэрээний эрх зүйн үүднээс авч үзвэл энэ төрлийн харилцаанд дараах эрсдэл орон сууц хөлслөгч буюу зээлдүүлэгчид үүсэж байна. Тухайлбал:

- Мөнгө зээлж хүүнд нь орон сууц хөлслүүлэх гэрээний төрөл хүлээн зөвшөөрөгдөж, баталгаажаагүйгээс иргэдийн дунд ийм төрлийн холимог шинжтэй гэрээ байгуулах дадал суугаагүй тул талууд тохиролцсон нөхцөлөө байгуулж буй гэрээндээ бүрэн тусгаж чадахгүй байх;

- Зээлийн гэрээний хүүнд орон сууцны хөлсийг тооцуулах тухай тохиролцоог нотолж чадахгүй бол зээлсэн мөнгөө орон сууц хөлслөх гэрээний төлбөрт суутгуулах;

- Орон сууц хөлслөх гэрээг дийлэнх иргэд амаар байгуулж хэвшсэнээс зээлийн гэрээг бичгээр байгуулсан ч, орон сууц хөлслөхтэй холбоотой хэсэг нь нотлоход бэрхшээлтэй үлдэх;

- Орон сууц хөлслөх эрхтэй этгээд мөн эсэхийг тогтооход хойрго хандсанаас гэрээний эрх зүйн маргааны хувьд өмчлөгчийн өмнө хууль ёсоор эзэмших эрх олж авч чадахгүй байх буюу тохирсон хугацаанаас өмнө орон сууцыг чөлөөлөх нөхцөл үүсэх зэрэг болно.

Энэ төрлийн харилцаанд эрсдэл бүхий дараах нийтлэг нөхцөл байдлууд илэрч байна. Үүнд:

- Орон сууцны жинхэнэ өмчлөгчийг шалгах үйл явц нь үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг харах төдий үйлдлээр хязгаарлагдах;

- Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг улсын бүртгэлтэй тулгаж шалгахгүй байгаагаас гэрээний эрх зүйн шаардах эрх олж авч чадахгүй болоод зогсохгүй залилах гэмт хэргийн хохирогч болох;

- Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн системийн үнэн зөв, найдвартай байдал нь энэ төрлийн харилцаанд тогтмол ашиглахад бэлэн эсэх нь тодорхойгүй.

- Мөнгө зээлж хүүнд нь орон сууц хөлслөх гэрээг тусгай төрлийн гэрээ болохыг хүлээн зөвшөөрч, бүртгэж, баталгаажуулах эрх зүйн орчин байхгүйгээс болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоо хангалттай бүрдээгүй зэрэг болно.

Тус гэрээний шинжийг агуулж буй харилцааг шүүхээс Иргэний хуулийн 281.1 буюу зээлийн гэрээ болон 287.1-д заасан эд хөрөнгө хөлслөх гэрээний харилцаа аль аль нь үндсэн үүргийн хувьд үүссэн гэж дүгнэх нь түгээмэл байна.

ДҮГНЭЛТ

Мөнгө зээлж хүүнд нь орон сууц хөлслүүлэх агуулга бүхий гэрээний харилцаа нь Солонгосын уламжлалт хэлцэл болох барьцаа мөнгөнд үндэслэж орон сууц хөлслөх гэрээнээс үүсэлтэй бөгөөд манай улсын иргэд Солонгос улсад суурьшин амьдарч байгаад, эх орондоо эргэж ирээд нийгмийн харилцаанд уг хэлцлийг нэвтрүүлсэн байх төлөв байдал ажиглагдаж байна.

Тус хэлцлийн дагуу үүсэх талуудын эрх, үүргийг тэнцвэржүүлэхийн тулд сайтар боловсруулсан эрх зүйн орчин шаардлагатай бөгөөд энэ дагуу Солонгос улс Иргэний хуульдаа хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулаад зогсохгүй, нарийвчилсан хуулийг (Барилга, орон сууц хөлслөгчийн эрхийг хамгаалах тухай хууль) тусад нь баталж, хэрэгжүүлж иржээ. Гэтэл манай улсад энэ төрлийн харилцааг зохицуулах эрх зүйн орчин нь зээлийн гэрээ болон орон сууц хөлслөх гэрээний холимог шинжийг агуулсан гэх эрх зүйн дүгнэлт бүхий хууль хэрэглээний практикаар хязгаарлагдаж байна. Тухайлбал тус харилцааг зохих ёсоор зохицуулахад зайлшгүй шаардлагатай зүйл нь нотолгооны хэрэгслийг баталгаатай бүрдүүлэх явдал юм. Ингэснээр иргэд гэрээний харилцаанаас хохирол амсахаас эхлээд гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлж чадна.

Манай улсын хувьд иргэд байгуулсан гэрээгээ үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн газар бүртгүүлэх болон шилжин ирж буй харьяалах хороо, багт оршин суугчаар бүртгүүлэхийн сацуу хэрэв тус шатны нэгжид хуулиар тус хэлцлийг бүртгэх чиг үүрэг олговол энэ үйл явц хэрэгжих бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл тус хэлцлийн эрх зүйн орчинг шууд нутагшуулахад шаардагдах бүртгэлийн тогтолцоо нь бидэнд бэлэн байна. Гэхдээ эхний ээлжинд эдгээр 2 бүртгэлийг зэрэг нэвтрүүлэх шаардлагатай эсэхийг судлах, мөн зэрэг нэвтрүүлсэн тохиолдолд үүрэг гүйцэтгэгчийн хувиар шаардлага гаргах дараалалд баримтлах эрх үүсэх эрэмбэ, эдгээр бүртгэлийн тогтолцооны ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдал зэргийг анхааралтай авч үзэж, боловсронгуй тогтолцоог бүрдүүлэх бэлтгэл ажил зайлшгүй шаардлагатай.

Хэрэглээнд нэвтрүүлэх бүртгэлийн тогтолцооны боломжит байдлыг харгалзан аль тохирох хувилбарыг тодорхойлсны дараа үл хөдлөх эд хөрөнгийн болон оршин суугчийн бүртгэлд талууд байгуулсан гэрээгээ бүртгүүлэх үйл явцыг тус хэлцэл хүчин төгөлдөр болох хэлбэрийн үндсэн шаардлага болгож хуульчлах замаар бид Солонгос улсын энэ төрлийн гэрээний харилцааг зохицуулж буй сайн туршлагыг амжилттай нэвтрүүлж, нийгмийн амьдралд тулгамдаж буй тус хэлцлээс үүдэлтэй асуудлыг шийдвэрлэх боломжтой хэмээн дүгнэж байна.

ЭХ СУРВАЛЖ**Монгол хэл дээрх*****Хууль тогтоомж***

1. Иргэний хууль, 2002.

Гадаад хэл дээрх***Хууль тогтоомж***

2. БНСУ-ын Иргэний хууль, 1958.
3. БНСУ-ын Барилга, орон сууц хөлслөгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 1981.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

4. Korea Legislation Research Institute, Introduction to Korean Law (Heidelberg, Germany: Springer-Verlag Berlin Heidelberg, 2013).
5. Youngjoon Kwon, Yong-Shik Lee, “Legal Analysis of Traditional Leasehold in Korea from a Comparative Legal Perspective”, Arizona Journal of International & Comparative Law Vol.29, no.2, 2012.
6. Jewan Kim. Chonse, A Real Property Lease Transaction Unique to South Korea. Pravovedenie 66 (3), 2022.

Шүүхийн шийдвэр

7. Р-ийн эсрэг З-ийн хэрэг (2022.12.23) https://shuukh.mn/single_case/125613?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1 [Сүүлд үзсэн: 2023.07.01]
8. Ч-ийн эсрэг А-ийн хэрэг (2018.04.16) https://shuukh.mn/single_case/77305?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1 [Сүүлд үзсэн: 2023.07.01]
9. Ө-д холбогдох хэрэг (2017.09.19) https://shuukh.mn/single_case/4066?start_date=&end_date=&id=2&court_cat=2&bb=1 [Сүүлд үзсэн: 2023.07.01]

THE FACING CHALLENGES IN MONGOLIAN SOCIO-ECONOMIC LIFE DUE TO THE CONTRACT FOR APARTMENT LEASING (RIGHT TO REGISTERED LEASE ON A DEPOSIT BASIS) AND SOLUTIONS

Batbayar.B

Master's student, School of Law, NUM, Legal researcher at Judicial Training, Research, and Information Institute of Mongolia

ABSTRACT:

The article has studied and identified facing challenges in Mongolian socio-economic life due to the contractual relationship with the content of loaning money and renting an apartment for interest. For example, studied the historical origin and development of this contract, how it is currently legalized in the country of origin and the state of application of the legislation in comparison with the legislation and judicial practice of Mongolia. Furthermore, the researcher has presented his opinions and conclusions on evaluating and improving the relevant provisions of the Civil Code of Mongolia.

KEYWORDS:

Right in Rem, Right in Personam, State Register of Real Estate, Judicial Practice, Legislation.

**2023 ОНЫ Ш УЛИРЛЫН
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ
(МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ)**

ШУА-ИЙН ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭНТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнтэй 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Тус санамж бичиг нь Монгол хэлний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой.

Санамж бичигт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор Ж.Бат-Ирээдүй нар гарын үсэг зурлаа. Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн доктор Г.Давааням, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, дэд профессор О.Шинэбаяр, тус хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын эрхлэгч, ЭШТА, доктор Н.Мөнхцэцэг нар оролцлоо.



/Баруун гар талаас ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын эрхлэгч, ЭШТА, доктор Н.Мөнхцэцэг, тус хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, дэд профессор О.Шинэбаяр, Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор Ж.Бат-Ирээдүй, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur), тус хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Давааням (LL.D) /

“ЗҮҮН ХОЙД АЗИ ДАХЬ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ: СОЛОНГОС БА МОНГОЛ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО

2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр “Зүүн хойд Ази дахь Үндсэн хуулийн шүүх: Солонгос ба Монгол” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал боллоо.

Уг эрдэм шинжилгээний хурлыг ХЗДХЯ-ны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, ОУУБИС-ийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэн болон БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн судалгааны хүрээлэн тус тус хамтран зохион байгуулсан бөгөөд ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг нээж, хурлын цаг үеэ олсон байдлыг тодотгов.



Хуралд Монгол талаас Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Мөнхсайхан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, ОУУБИС-ийн Монгол-Солонгосын хүрээлэнгийн захирал О.Амарсанаа, Солонгос талаас БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн судалгааны хүрээлэнгийн захирал И Хон Хван, мөн судлаач Хан Дун Хүн, Ажү Ис-ийн профессор Чон Гён Гин нар илтгэл тавьж, хэлэлцүүлээ.

БНСУ-ЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЯАМНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД АЙЛЧИЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur.) БНСУ-ын Хууль тогтоомжийн яамны Эрх зүйн харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дэд дарга И Ил, үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Сун Сэн Хуан, судлаач Хуан Хён Үг нарыг 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэн дээр хүлээн авч уулзлаа.



/Баруун гар талаас Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Б.Түмэндэмбэрэл, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Э.Саранцэцэг, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur.), БНСУ-ын Хууль тогтоомжийн яамны Эрх зүйн харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дэд дарга И Ил, үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Сун Сэн Хуан, судлаач Хуан Хён Үг /

Уулзалтаар Монгол Улсын эдийн засгийн тогтолцооны өөрчлөлттэй холбоотой эрх зүйн шинэчлэлийн үйл явц, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилт болон чөлөөт эдийн засгийн тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотой өмгөөлөгч, төрийн албан хаагч, иргэдийн боловсролыг сайжруулах зорилготой сургалтын талаар мэдээлэл хүргэв. Түүнчлэн Хууль тогтоомжийн яамтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр санал солилцлоо.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС ЭРХЛЭН ХҮРГЭДЭГ “1800-1202” ПОДКАСТ ДОХИОНЫ ХЭЛМЭРЧТЭЙГЭЭР ОЛОН НИЙТЭД ХҮРЧ ЭХЭЛЛЭЭ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн хүргэдэг “1800-1202” подкаст дохионы хэлмэрчтэйгээр олон нийтэд хүрч эхэллээ. Тус подкаст 2021 оны 02 сарын 08-ны өдрөөс гарч эхэлснээс хойш нийт 106 дугаар олон нийтэд хүрсэн байна.

“1800-1202” подкастыг “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор бэлтгэн хүргэж байна. Подкастад Хууль зүй, дотоод хэргийн яам, Соёлын яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв, Дотоод хэргийн их сургууль, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Цагдаагийн ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Монгол улсын их сургууль зэрэг байгууллагуудаас гадна хуулийн фирмийн өмгөөлөгч, хуульчид зочноор оролцсон байна.



*/Баруун гар талаас МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш
Н.Норовсамбуу, Л.Банзрагч нар/*

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur) Европын Холбооны Ижилсүүлэх төслийн зөвлөх Эммануэл Вэрн болон Европын Холбооны Монгол дахь Төлөөлөгчийн газрын төлөөлөгчдийг 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хүлээн авч, зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа.



/Европын Холбооны Ижилсүүлэх төслийн зөвлөх Эммануэл Вэрн болон Европын Холбооны Монгол дахь Төлөөлөгчийн газрын төлөөлөгч, орчуулагчийн хамт/

Зөвлөлдөх уулзалтын хүрээнд хууль зүйн салбар дахь өнөөгийн нөхцөл байдал, тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, мөн Европын Холбооны Төлөөлөгчийн газраас 2021-2027 оны хооронд Монгол Улсад хэрэгжүүлэх Олон жилийн баримжаат хөтөлбөрийн хүрээнд хууль зүйн салбарын шинэчлэлтэй холбогдуулан 2024 оноос хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэх Ижилсүүлэх (Twinning) төслийн талаар харилцан мэдээлэл солилцов. Ижилсүүлэх (Twinning) төсөл нь шүүхийн шинэчлэл, шүүх засаглалыг үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан сайжруулах зорилгын хүрээнд хэрэгжих юм.



*/Баруун гар талаас Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан
Э.Анударь, Эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал (PhD), Хууль зүйн үндэсний
хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur), Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
Э.Саранцэцэг/*

Тус уулзалтаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн чиг үүрэг, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагаатай танилцсан бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхэд Хууль зүйн үндэсний хүрээлэн хамтран оролцох, цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар санал солилцлоо.

АЗИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ (ALIN)-НИЙ 19 ДЭХ ЧУУЛГА УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



/Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ (ALIN) олон улсын байгууллагын гишүүн орнуудын төлөөлөл/

Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ (ALIN) олон улсын байгууллагын гишүүн орнуудын 19 дэх ээлжит чуулга уулзалтыг Бүгд Найрамдах Солонгос Улсын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (KLRI), Тайваний Үндэсний Их Сургуулийн Хууль зүйн сургууль хамтран 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Тайваний Тайбэй хотноо амжилттай зохион байгууллаа.

Гишүүн орнуудын төлөөлөгчдийн уулзалт цар тахлын нөхцөл байдлаас үүдэн сүүлийн жилүүдэд цахимаар зохион байгуулагдаж байсан бөгөөд энэ удаагийн хуралд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur) саналын эрхтэйгээр биечлэн оролцлоо.

Тус чуулга уулзалтаар Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны тайлан, ирэх онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны чиглэл, шинэ гишүүний элсэлт, 2024 онд зохион байгуулагдах 20 дахь ээлжит хурлыг зохион байгуулах орныг сонгох асуудлыг тус тус хэлэлцэв.

АЗИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ 19 ДЭХ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

“АЗИ ДАХЬ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН” СЭДВЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Азийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээний 19 дэх олон улсын эрдэм шинжилгээний хурал 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Тайваний Үндэсний Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ 2005 онд үүсгэн байгуулагдсан цагаас гишүүнээр элсэж, жил бүр зохион байгуулагддаг олон улсын эрдэм шинжилгээний хуралд тогтмол оролцож ирсэн.



/Олон улсын эрдэм шинжилгээний хурлын оролцогчид/

“Ази дахь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн орчин” сэдвээр зохион байгуулсан энэ удаагийн хуралд Хууль зүйн үндэсний хүрээлэнг төлөөлж тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь “Монгол Улс дахь аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн шинэчлэл” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээ, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсан үйл явдлыг илтгэлдээ онцолсон юм.

Уг хуралд оролцсон 20 улсын судалгааны хүрээлэн, хууль зүйн их сургуулиудын эрдэмтэн судлаачид өөрийн улс дахь цар тахлын үеийн аялал жуулчлалын салбарын хямрал, түүнийг даван туулсан туршлагаас хуваалцаж, ирээдүйд Азийн аялал жуулчлалын салбарыг хурдацтай цэцэглүүлэн хөгжүүлэх боломжийн талаар санал солилцсон байна.

“ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АМЬ НАСЫГ ХОХИРООХ ГЭМТ ХЭРГИЙГ ТАСЛАХ ЗОГСООХ НЬ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ОРОЛЦЛОО

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, Ази, Номхон далайн орнуудын Гэмт хэрэг, эрүүгийн эрх зүйн статистикийн мэргэжлийн төв хамтран “Жендерт суурилсан охид, эмэгтэйчүүдийн амь насыг хохироох гэмт хэргийг таслан зогсоох нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 09 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын нийслэл Сөүл хотноо амжилттай зохион байгууллаа.

Тус хуралд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur) “Монгол Улс дахь хүнийг алах гэмт хэргийн эмэгтэй хохирогчид холбогдох тоон мэдээллийг цуглуулах арга зүй, тулгамдаж буй асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлж оролцов.



/Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах (Dr.jur) илтгэл хэлэлцүүлэх үеэр/

Энэхүү хурлаар жендерт суурилсан охид, эмэгтэйчүүдийн амь насыг хохироох гэмт хэргийн тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, үнэлэхэд Ази, Номхон далайн орнуудад нийтлэг тулгарч буй асуудлыг хэлэлцэж, энэ төрлийн гэмт хэргийн тоон мэдээллийг цуглуулах, хэмжих арга зүйг дэмжих, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход улс орнуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх чиглэлээр харилцан санал солилцсон юм.

Монгол Улсын тухайд хүнийг алах гэмт хэргийн эмэгтэй хохирогчид холбогдох тоон мэдээллийг төрийн байгууллагууд ялгамжтай арга хэлбэрээр цуглуулдаг бөгөөд зөрүүтэй мэдээллийг нэгтгэхэд хүндрэлтэй байдаг. Иймд гэмт хэргийн статистик гаргах аргачлалыг сайжруулж, охид, эмэгтэйчүүдийн амь насыг хохироож буй гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлд чухал ач холбогдолтой хурал боллоо.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь хууль тогтоомжийн төлөв байдал, хандлага, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, эрдэм шинжилгээний зөвлөмж, аргачлал боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд шинжлэх ухааны санал, дүгнэлт өгөх, хууль зүйн бодлогын суурь болон харьцуулсан судалгааг хийх, бусдаар гүйцэтгүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Тус хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төв нь дээрх чиг үүргийн хүрээнд 2023 оны 10 сарын байдлаар дараах судалгааг гүйцэтгээд байна.

Төлөвлөгөөт:

1. Прокурорын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ
2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ
3. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ
4. Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт сэдэвт харьцуулсан судалгаа
5. Захиргааны ерөнхий хуулийн гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа
6. Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагаа сэдэвт харьцуулсан судалгаа

Захиалгат:

7. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын төслийн үр нөлөөний үнэлгээ
8. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын төслийн зардлын тооцоо
9. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа
10. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ
11. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо
12. Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ
13. Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоо
14. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зарим асуудал сэдэвт харьцуулсан судалгаа
15. Гүйцэтгэх ажилд тавих Улсын Их Хурлын хяналтын тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах судалгаа
16. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ
17. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ
18. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийн зардлын тооцоо
19. Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын төслийн үр нөлөөний үнэлгээ
20. Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын төслийн

- зардлын тооцоо
21. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдуулан гадны орны туршлагыг талаар лавлагаа
 22. Хуулийн хүчин чадлын төрөл, тэдгээрийг батлах саналын квот сэдэвт харьцуулсан лавлагаа
 23. Цахим гадаад паспортын харьцуулсан лавлагаа
 24. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэмт хэрэгт оногдуулах шийтгэл-Европын Холбоо болон Япон улсын харьцуулсан лавлагаа
 25. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг болон педофил өвчтэй хүнд авах арга хэмжээний талаарх лавлагаа
 26. Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн гадаад орнуудын харьцуулсан лавлагаа
 27. Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг Зөрчлийн тухай хуульдаа зохицуулсан байдал, гадаад орнуудын харьцуулсан лавлагаа
 28. Лицензгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодох гэмт хэргийн талаарх лавлагаа
 29. Гадаадын улс, орнууд дахь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааны талаар лавлагаа

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦЫН ТАЛААР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр “Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц”-ын талаар сургалт зохион байгууллаа. Сургалтад 34 өмгөөлөгч хамрагдлаа.

Сургалтад ХЭҮК-ын Сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга Х.Цэцгээ “Хүний эрхийн Олон Улсын гэрээ, конвенц”-ын ойлголт, Хүнийг хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц сэдвээр хичээл заав.



/"Хүний эрхийн Олон Улсын гэрээ, конвенцын ойлголт, Хүнийг хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц" сэдэвт сургалтын үеэр/

Тус сургалтын зорилго нь өмгөөлөгч нарт мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Олон Улсын холбогдох гэрээ, конвенцыг ашиглах, үндэсний хууль тогтоомж дахь зохих зүйл заалт, зохицуулалтыг эдгээртэй уялдуулж хэрэглэх талаар зохих ойлголт, мэдлэг олгох юм.



/ХЭҮК-ын Сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга Х.Цэцгээ сургалтын үеэр/



/“Хүний эрхийн Олон Улсын гэрээ, конвенцын ойлголт, Хүнийг хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц” сэдэвт сургалтын үеэр/

ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалт”-ыг 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Сургалтыг ХЗҮХ-ийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Э.Саранцэцэг, НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Бямбадулам нар нээж, үг хэллээ.

Сургалтад Хууль зүйн ухааны Доктор /Ph.D./ дэд проф. А.Алтанзул, Хууль зүйн ухааны Магистр /LL.M./ С.Ганцэцэг, Хууль зүйн ухааны Магистр /LL.M./ Ч.Энхчимэг, Хууль зүйн ухааны Магистр /LL.M./ Р.Мөнхбат, Хууль зүйн ухааны Магистр /LL.M./ Д.Цэцэгдарь нар хичээл зааж, Нийслэлийн 9 дүүргийн 50 эрх зүйн хөтөч хамрагдсан байна.



/ Хууль зүйн ухааны доктор /Ph.D./ дэд профессор А.Алтанзул сургалтын үеэр/

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРАМ БАТЛАГДЛАА

Монгол Улсын Их хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Шүүх шинжилгээний тухай хууль батлагдсан бөгөөд уг шинэчилсэн найруулгын нэг гол үзэл санаа нь гэмт хэргийн улмаас хүний сэтгэл санааны хохирол буюу хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, хохирлыг мөнгөн дүнгээр барагдуулах эрх зүйн үндсийг тогтоох юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалаар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам” болон “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт”-ийг, Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар “Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал”-ыг тус тус баталлаа.

Уншигч Та бүхэн дээрх эрх зүйн актуудтай дараагийн хуудаснаас танилцах боломжтой.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний зөрчигдсөн эрхийг сэргээхэд нэгэн чухал хууль зүйн үндэслэл бүрдэж байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч нь дан ганц материаллаг хохирлыг гэм буруутай этгээдээс нэхэмжлэн гаргуулдаг байсан бол өөрийн сэтгэл санаанд учирсан хохирол буюу сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг дээрх журмын дагуу шүүх шинжилгээний байгууллагаар тогтоолгож, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлалын дагуу хохирлоо мөнгөн дүнгээр тооцуулан авах нөхцөл бүрдэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын
2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар
хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтооход Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэгт заасан нөхцөлийг харгалзан үзнэ.

1.3.Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргахад Шүүх шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

1.4.Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад Шүүх шинжилгээний тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн акт, энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр.Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох

2.1.Гэмт хэргийн хохирогчийн хувь хүний сэтгэцийн хариу урвалын байдал болон гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл, эд хөрөнгөө алдсанаас хохирогчид учрах эрүүл мэндийн хохирол, сэтгэцийн түр зуурын, эсхүл байнгын шинжтэй эмгэг өөрчлөлт, хэвийн амьдрал алдагдсан байдал, шаардагдах эмчилгээний дундаж хугацаа, хөдөлмөрийн чадвар алдалт зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан тогтоосон энэхүү тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт”-ээр (цаашид “хүснэгт” гэх) шүүх шинжилгээний байгууллага дараах гэмт хэргийн хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох бөгөөд шинжээчийн дүгнэлттэй адилтган үзнэ:

2.1.1.Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйл (Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах);

2.1.2.Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл (Хулгайлах);

2.1.3.Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйл (Залилах);

2.1.4.Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл (Мал хулгайлах);

2.1.5.Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйл (Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих).

2.2.Энэ журмын 2.1.1-2.1.5-д заасан гэмт хэргийн хохирогч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч энэ журмын 2.1-д заасан хүснэгтээр шинжилгээг хийлгэнэ. Энэ заалтад зааснаас бусад Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг шүүх шинжилгээний байгууллага тогтооно.

2.3.Энэ журмын 2.1-д заасан хүснэгтээр сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоосныг хохирогч хүлээн зөвшөөрсөн эсэхийг мөрдөгч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/267 дугаар тушаалын зургаадугаар хавсралтаар баталсан “Сэтгэцэд

учирсан хор уршгийн зэрэглэл тогтоосныг хүлээн зөвшөөрсөн маягтын загвар” -ыг танилцуулан баталгаажуулж, хавтаст хэргийн материалд хавсаргана.

2.4. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргуулахаар шинжээч томилж болно.

2.5. Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүн нас барсан бол хохирогчоор тогтоогдсон гэр бүлийн гишүүний сэтгэцэд учирсан хор уршгийг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.4, 511.5-д заасны дагуу арилгана.

2.6. Шинжилгээ хийлгэх хохирогч нь шинжилгээнд биечлэн хамрагдана. Шаардлагатай тохиолдолд хавтаст хэргийн материал болон эмнэлгийн баримт бичиг, материалыг хамт ирүүлнэ.

2.7. Энэхүү журмын 2.1-д зааснаас бусад гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох болон энэхүү журмын 2.2, 2.4-т заасан шинжилгээг эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн сэтгэцийн эмчээр ахлуулсан, сэтгэл зүйчээс бүрдсэн шинжээчийн багаар хийлгэнэ.

2.8. Шинжилгээг шүүх шинжилгээний төв байгууллагын даргын баталсан аргачлалын дагуу хийх бөгөөд аргачлал нь албаны нууцад хамаарна.

2.9. Энэ журмын 2.2, 2.4-т заасан нөхцөлийн дагуу шинжилгээ хийлгүүлж, дүгнэлт гаргуулсан бол эрх бүхий этгээд уг шинжээчийн дүгнэлтийг хавтаст хэргийн материалд хавсаргана.

2.10. Энэ журмын 2.1.1.-2.1.5-д зааснаас бусад Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг шинжилгээний байгууллага тогтооно.

Гурав. Шинжилгээ хийх сэтгэцийн эмч, сэтгэл зүйчид тавигдах шаардлага

3.1. Хүний их эмчээр дээд боловсролын бакалаврын зэргээр төгсөж, эмчийн мэргэжлээр 2 ба түүнээс дээш жил ажилласан сэтгэцийн эмч шинжилгээ хийнэ.

3.2. Дээд боловсролын бакалаврын зэргээр төгсөж, мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажилласан клиник сэтгэл зүйч шинжилгээ хийнэ.

3.3. Шинжээч нь энэ журмын 2.7-д заасан аргачлалын дагуу хувь хүний сэтгэл зүйн онцлогийг оношлон тодорхойлох, үнэлгээ хийх, үр дүнг зөв тайлбарлах, тохирох арга зүйг сонгон хэрэглэх чадвартай байна.

3.4. Шинжээч нь мэргэжлийн ёс зүй, байгууллагын дотоод журмыг баримтлан ажиллаж, эмгэг сэтгэц судлалын болон шүүхийн сэтгэц судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байна. Эмнэлгийн мэргэжилтний хувьд мэргэжлийн чадвараа тасралтгүй хөгжүүлж, холбогдох сургалтад тогтмол хамрагдана.

Дөрөв. Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ хийх аргачлал

4.1. Шинжилгээ хийх аргачлал нь арван найман насанд хүрээгүй, насанд хүрэгчдийн, сэтгэцийн эмгэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүний гэсэн төрөлтэй, анхдагч, нэмэлт, дахин шинжилгээний гэсэн хэлбэртэй байна.

4.2. Шинжилгээний бүх төрөл, хэлбэрт ашиглах аргачлалын асуумж, сорил түүний үр дүнг боловсруулах арга зүйг нь нууцлах бөгөөд энэхүү нууцлал нь шинжээчийн дүгнэлтийн үнэн бодит байдлыг тогтоох, хувь хүний эмзэг болон эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах, тухайн хохирогч өөрийгөө урьдчилан бэлдэх ашиг сонирхолын зөрчилгүй байдлыг бүрдүүлэхэд чиглэнэ.

4.3. Шинжилгээ хийх аргачлалын асуумж, сорил, үр дүнг боловсруулах арга зүй, хэрэглэгдэх материал нь шинжээчийн хяналтад нууцлалтайгаар хадгалагдах бөгөөд 2 жил тутамд шинэчилнэ.

Тав.Шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

5.1.Шинжилгээнд хохирогчийн нас, хувь хүний сэтгэцийн хариу урвалын байдал, тухайн хэргийн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, чанар зэргийг харгалзан сэтгэцийн эмчийн үзлэг, сэтгэл зүйн болон сэтгэц физиологийн үзүүлэлт, багажийн шинжилгээ (полиграф, эгоскоп, тархины цахилгаан бичлэг гэх мэт), эмгэг сэтгэл судлалын шинжилгээ, ажиглалт, бусад арга, хэрэглэгдэхүүнийг ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон аймаг, дүүргийн сэтгэцийн тасагт байршуулж, шинжилгээг хийж болно.

5.2.Шаардлагатай тохиолдолд онош тодруулах зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, шинжилгээнд илгээж болно.

5.3.Эрүүл мэндийн байгууллагууд хохирогчийн өвчний түүх, бусад шаардлагатай баримт материалыг шинжээчид саадгүй гаргаж өгөх бөгөөд төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, шинжилгээг хийнэ.

5.4.Хохирогчид илэрсэн эмгэг өөрчлөлт, багажийн болон лабораторийн шинжилгээний хариу, эмнэлгийн баримт бичиг, бусад материалыг нэгтгэн үнэлж үзсэний үндсэн дээр сэтгэцийн шинжээч эмч сэтгэцийн өвчний олон улсын ангиллын дагуу шинжилгээний онош тавина.

5.5.Шинжилгээний дүгнэлтэд Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан гэмт хэргийн улмаас шинжилгээ хийлгэх этгээдийн сэтгэцэд учирсан эмгэг өөрчлөлт, түүний зэрэглэлийг тусгах бөгөөд цаашид сэтгэцийн болон сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд хамрагдах чиглүүлгийг дурдаж болно.

5.6.Шинжээчийн дүгнэлтэд мэргэжлийн болон орчуулах боломжгүй гадаад нэр томъёог олон улсын нэршлээр хэрэглэж болно.

5.7.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрт тусгагдсан асуулт тус бүрд шинжлэх ухааны үндэслэл бүхий хариулт өгөх ба шинжилгээ хийх үед уг хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдал шинээр илэрсэн бол энэ талаар дүгнэлтэд тусгана.

5.8.Шинжилгээг Шүүх шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан шинжилгээ хийх жишиг хугацаанд хийнэ.

5.9.Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох дахин шинжилгээ хийх болон шаардлагатай тохиолдолд шинжилгээнд төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг оролцуулах хүсэлтийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд гаргаж болно.

5.10.Дахин шинжилгээг багаар хийхдээ шинжилгээний байгууллагын нэг, түүнээс дээш шинжээчийг багийн бүрэлдэхүүнд оруулах бөгөөд бусад байгууллага, этгээдээр энэ төрлийн шинжилгээг дангаар хийлгэхгүй.

Зургаа.Хариуцлага

6.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын
2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар
хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

ТУХАЙЛСАН ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООХ ХҮСНЭГТ

Шалгуур үзүүлэлт		Сэтгэцэд учирсан гэм хорын зэрэглэл				
		Тавдугаар	Дөрөвдүгээр	Гуравдугаар	Хоёрдугаар	Нэгдүгээр
1	Гэмтлээс үүдэлтэй үлдэц	гэмт хэргийн улмаас насан туршид эргэшгүй бүтцийн өөрчлөлт бий болох	гэмт хэргийн улмаас удаан хугацаанд үргэлжлэх хэдий ч эргэн сэргэх боломж бүхий голомтот өөрчлөлт бий болох	гэмт хэргийн улмаас удаан хугацаанд үргэлжилсэн ужиг хариу урвал илрэх	гэмт хэргийн улмаас стрессийн үед үзүүлэх хариу урвал хэвийн хэмжээнээс удаан үргэлжлэх	гэмт хэргийн улмаас стрессийн үед үзүүлэх хэвийн хариу урвал илэрч, богино хугацаанд үргэлжлэх
2	Танин мэдэхүй	сэтгэц органик хам шинж, ойгүйдэл илрэх, танин мэдэхүйн үйл ажиллагааны хурд удаашрах, анхаарлын шилжилт үгүй болох	сэтгэн бодох, ярихад бэрхшээлтэй болох, хэсэгчилсэн ойгүйдэл илрэх, сэтгэлийн гэмтэл учруулсан үйл явдлын талаар бодол санаанаас гарахгүй байдал удаан үргэлжлэх	сэтгэн бодох, ярих хурд удаашрах, хэргийн нөхцөл байдалтай холбоотойгоор анхаарал төвлөрөхгүй байдал тогтвортой үргэлжлэх, ой тогтоолтын өөрчлөлт	хэргийн нөхцөл байдалтай холбоотойгоор анхаарал төвлөрөлт муудах, ой тогтоолт хоёрдогчоор буурах, сэтгэхүйд илэрхий өөрчлөлт үгүй байх	үйл явдлаас үүдэлтэй анхаарал төвлөрч чадахгүй байх, мартах, сэргээн санах оновчтой байдал түр зуур сулрах, сэтгэхүй, үг ярианд өөрчлөлт үгүй байх
3	Нийгмийн харилцаа	нийгмийн харилцаанд бие даан оролцох чадвар насан туршид болон сурч хөдөлмөрлөх насанд алдагдах	ажил эрхлэх, сурах чадвар удаан хугацаанд алдагдах	сурч хөдөлмөрлөх чадвар буурах, өөрийгөө арчлах чадвар хэсэгчлэн алдагдах	ажил эрхлэх, сурах идэвх сонирхол буурах	сурч хөдөлмөрлөх чадвар хэвийн байх

4	Төрх үйл	биеэ хянах, шийдвэр гаргах чадвар бүрэн алдагдах	органик гаралтай бие хүний эмгэг илрэх, зан байдлаа хянахад бэрхшээлтэй байх, хэт хөдөлгөөнтөх, хөдөлгөөнгүйдэх	түрэмгий авир гаргах, биеэ хянах чадвар сулрах	дасан зохицохуйн хямрал үүсэх	өөрийн зан байдлыг хянах, шийдвэр гаргах чадвар харьцангуй хэвийн, өөрийн сэтгэл санааны байдлыг бодитоор үнэлэх байдал сул байж болно
5	Сэтгэл хөдлөл	сэтгэл хөдлөлөө хянах, удирдах чадвар бүрэн алдагдах	сэтгэл хөдлөлийн тохироо алдагдах, дур хүсэл ихсэх, огт үгүй болох	гэнэтийн, хүчтэй айдас байнга төрөх, сэтгэлээр унах шинжүүд үргэлжлэх, цочмог хариу урвал үзүүлэх	сульдал, невротын хам шинж илрэх, сэтгэлээр унах, түгших	амархан гомдох, мэдрэмтийг болох
6	Биеийн талаас	нүүрний хөдөлгөөн байхгүй байх, хөдөлгөөн хязгаарлагдмал болох	гэмт хэргийн улмаас архаг нойргүйдэлд орох, зүрх судасны системийн үйл ажиллагаанд эрсдэл учрах	бэлгийн болон хооллох дур өөрчлөгдөх, нойргүйдэл, симпатик мэдрэлийн хөөрөл удаан хугацаанд үргэлжлэх	хөнгөн зэргийн нойргүйдэл, амьсгал бачуурах, булчин чангарах зэрэг симпатик мэдрэлийн хөөрөл илрэх	бага
	Зүйл, заалт	27.10.2.2.3	27.10.2.2.1; 27.10.2.2.2; 27.10.2.2.4.	11.6.2; 27.10.1; 17.2.3.3.2; 17.3.2.2.2.	11.6.1; 17.1.2.2.2 ; 17.1.2.2.3 ; 17.1.2.2.4 ; 17.2.2; 17.3.2; 17.3.2.2.1; 17.3.3.3.2 ; 17.12.2.	17.1.1; 17.1.2.2.1 ; 17.2.1; 17.3.1; 17.12.1.

Жич:

Сэтгэцийн талаас илрэх шинж тэмдгүүд нь зэрэглэл буурахад давхардан илрэхгүй болно. Жишээлбэл, гэмтлээс үүдэлтэй үлдэц гэсэн шалгуур үзүүлэлтийн 5-р зэрэглэлд байгаа шинжүүд 4-р зэрэглэлийн үед илрэхгүй.

Хялбаршуулсан хүснэгтээр хэрэглэх үед шинжлүүлэгч сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг хүлээн зөвшөөрөхгүй бол шинжилгээний байгууллагаар тогтоолгох бөгөөд шинжлүүлэгч өөрийн сэтгэл зүйн байдлыг муугаар харуулах гэсэн оролдлого, бие хүний онцлог, аргачлалын итгэгдэх чанарын үзүүлэлтүүд зэргээс хамааран зэрэглэл буурч тогтоогдож болно.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн
хуралдааны 2023 оны 07 сарын
03-ны өдрийн 25 дугаар тогтоолын
хавсралт

ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙГ АРИЛГАХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТӨЛБӨРИЙН ЖИШИГ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэмт хэргийн улмаас хохирогч, хохирогч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд учирсан сэтгэцийн хор уршгийг арилгах нөхөн төлбөрийн хэмжээг шүүхээс тогтооход энэхүү жишиг аргачлалыг харгалзан үзнэ.

1.2. Гэмт хэргийн төрөл, учирсан гэм хор, хохирогч бүрийн сэтгэл зүйн болон сэтгэцийн онцлогоос шалтгаалж шүүх төлбөрийн хэмжээг уг аргачлалд зааснаас илүү эсвэл багаар тогтоосон бол үндэслэлээ шийдвэрт тодорхой тусгана.

1.3. Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах нөхөн төлбөр нь хүний эрүүл мэндийг хамгаалах, сэтгэцийн эмгэгийг арилгах зорилгод нийцсэн байна.

Хоёр. Нэр томьёо

2.1. “Сэтгэцэд учирсан хор уршиг” гэдэгт гэмт хэргийн хохирогч гэмтлийн улмаас мэдэрч буй өвдөлт, зовуурь, шаналал, түүнчлэн гэмт хэргийн улмаас амьдралын баяр баясалгүй болох, нийгмийн байр сууриа алдах, бусадтай хэвийн харилцах чадваргүй болох, хувийн зан байдал нь сөргөөр өөрчлөгдөх зэргээр амьдралын чанар муудсаны улмаас сэтгэцийн эмгэгтэй болохыг ойлгоно.

2.2. “Сэтгэцийн эмгэг” гэдгийг Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар ойлгоно. Сэтгэцийн эмгэг учирсан нь хор уршгийг арилгах үндэслэл болно.

Гурав. Нөхөн төлбөр тогтооход баримтлах зарчим, аргачлал

3.1. Гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэцийн хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийг тогтоохдоо дараах зарчмыг баримтална:

3.1.1. Нөхөн төлбөрийн хэмжээг шударга, үндэслэл бүхий тогтоох;

3.1.2. Хохирлын нөхөн төлбөр боломжит түвшинд буюу хор уршиг ба нөхөн төлбөрийн тэнцвэрт байдлыг хангах;

3.1.3. Хохирогч өөрт учирсан хохирлоор ашиг бий болгохгүй байх.

3.2. Сэтгэцийн эмгэгийн зэргийг Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т заасны дагуу хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан журмын дагуу Шинжилгээний байгууллага тогтооно.

3.3. Хохирогч нас барсан бол Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.5-д заасны дагуу гэр бүлийн гишүүний сэтгэцэд учирсан гэм хорыг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр, эсхүл нас барсан хүний амь, хүн амын дундаж наслалтын зөрүүг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр үржүүлэн хохирогчид аль ашигтайгаар шүүхээс тогтооно.

3.4. Энэ хэсгийн 3.3-т заасан хэмжээ нь хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн болон нөхөн төлбөрийн дээд хязгаар буюу 100 хувь байна. Иймд гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан эмгэгийг таван зэрэглэлд ангилсан шалгуурын дагуу хувьчилж, хор уршгийн нөхөн төлбөрийн мөнгөөр илэрхийлэгдэх дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөс тооцох үндсэн аргачлалыг баримталсан. Сэтгэцийн хор уршгийн хэмжээ буюу 1-р зэрэглэл 0-3%, 2-р зэрэглэл 4-8%, 3-р зэрэглэл 9-15%, 4-р зэрэглэл 15-30%, 5-р зэрэглэл 31-99% гэж тогтоож, хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэн дүнгээс нөхөн төлбөрийн хэмжээг хувьчлан тус тус тогтооно. (Хүснэгт)

3.5.Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.4-т заасны дагуу гэмт хэргийн улмаас хохирогч нас барж бага насны хүүхэд бүгэн өнчин болсон бол дээрх 100 хувийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж тогтооно.

3.6.Шинжилгээний байгууллага Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дүгээр зүйлд заасан эрүүгийн гэмт хэргээс Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (Эрүүгийн хуулийн 11.6 дүгээр зүйл), Хулгайлах, (Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл), Залилах (17.3 дугаар зүйл), Мал хулгайлах (Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл), Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих (Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйл) гэмт хэргийн хохирогчид учирсан хор уршгийг “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл”-ийг хүснэгтээр тогтоож, уг хүснэгтийг шинжээчийн дүгнэлттэй адилтган үзэхээр заасан тул холбогдох нөхөн төлбөрийг тухайн зэрэглэлийг харгалзан шийдвэрлэнэ.

3.7.Сэтгэцийн хор уршгийг 1-р зэрэглэлээр сэтгэцийн эмгэгийн тодорхой босгыг тогтоож өгсөн байх тул үүнээс доогуур тохиолдолд нөхөн төлбөрийг олгохгүй.

3.8.Шүүхийн нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо дээрх журмаар баталсан сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл, тухайлсан гэмт хэрэгт хамаарах хүснэгт, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн гэмт хэргийн хүнд, хөнгөн, хүндрүүлэх нөхцөл байдал, учруулсан гэм хор, хохирогчийн эрүүл мэндэд учирсан гэмтлийн байдал, бие махбодын гэмтлээс болж учирсан өвдөлт, шаналал, хохирогчид учирсан сөрөг үр дагавар, хохирогчийн нас, хохирогчийн гэм буруутай байдал, гэм хор учруулагчийн гэм буруу, гэм буруугаа гэмшиж байгаа байдал, төлбөрийн чадвар, багадаа гэмтэл авсан хүний хохирлын тооцоо нь өндөр настай хүний хохирлын тооцооноос илүү байх, гэр бүлийн гишүүн нь хохирогчтой байнга хамт эсвэл дотно байсан эсэх зэрэг хохирлын хэмжээнд нөлөөлж болох бүх нөхцөл байдлуудыг харгалзан үзэж, доод болон дээд хэмжээний дотор нөхөн төлбөрийг олгох эсэхийг шийдвэрлэнэ.

Дөрөв. Нөхөн төлбөр тооцох жишиг аргачлал

(Хүснэгт)

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны хамтарсан тушаал		Хувь	Нөхөн төлбөрийн хэмжээ
Сэтгэцийн эмгэгийн зэрэглэл	Сэтгэцийн хор уршиг		
Тавдугаар зэрэглэл	Хохирогчийн биед учирсан хүнд гэмтэл буюу үлдэц уршиг бүхий гэмтлээс үүссэн сэтгэцийн эмгэг -мэргэжлийн хөдөлмөрийн чадварын тогтонги алдалт, энгийн хөдөлмөрийн чадвар тогтонги их хэмжээгээр буюу 35-100% алдагдсанаас хохирогчид үүссэн сэтгэцийн эмгэг.	31-99%	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 46 дахин нэмэгдүүлснээс 149 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл
Дөрөвдүгээр зэрэглэл	Хохирогчийн биед учирсан гэмтэл буюу амь насанд аюултай, амь тэнссэн байдал бүхий гэмтлийн улмаас хохирогчид үүссэн сэтгэцийн эмгэг.	15-30%	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 23 дахин нэмэгдүүлснээс 45.99 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл

Гуравдугаар зэрэглэл	Хүндэвтэр хохирлын улмаас хохирогчид үүссэн сэтгэцийн эмгэг.	9-15%	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 13 дахин нэмэгдүүлснээс 22.99 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл
Хоёрдугаар зэрэглэл	Хөнгөн гэмтлийн улмаас хохирогчид үүссэн сэтгэцийн эмгэг.	4-8%	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлснээс 12.99 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл
Нэгдүгээр зэрэглэл	Биед гэмтэл учраагүй, зөвхөн сэтгэцэд үүссэн бага зэргийн эмгэг.	0-3%	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4.99 нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл